

АРИУН СҮНС

ТҮҮНТЭЙ ТАНИЛЦАХУЙ

ЖОН БИВЭР

ХҮҮ АДДИСОН БИВЭРИЙН хамт

Эрхэм анд минь

Та бол Бурханы зүрхэнд таалалтай, мэлмийд баясалтай хүн. Тэрбээр танд Өөрийгөө мэдүүлж бас таныг мэдэхийг хүснэ. Бурхантай дотносох тусам, Тэрбээр газар дээр байгуулах хаанчлалынхаа ажилд тантай улам илүү хамтрахыг хүснэ. Элч Паулын айлдсанчлан: „бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн, Түүний бүтээл мөн. Бурхан биднийг тэдгээрийн дотор яваасай гэж урьдаас бэлтгэсэн билээ” (Ефес 2:10).

Бурханы хүүхдүүд бид Аавыгаа баярлуулахыг хүсдэг. Гэхдээ „Бурханы ажлыг Ариун Сүнсстэй тогтоох дотно нөхөрлөл харилцаагүйгээр хийх боломжгүй” хэмээн Есүсийн тов тодорхой хэлсэн үгт хэнэггүй хандах маань энүүхэнд. Бурхан таныг Өөрийнхөө төлөө мал шиг зүтгүүлээд байхыг бус, харин тантай хамтарч ажиллахыг хүсдэг. Тэрбээр таны жаргал зовлонг үүрэлцдэг анд нөхөр тань байхыг хүсдэг. Тиймээс л тантай Сүнсээрээ харилцахыг хүсдэг бөгөөд үүнээс эрхэм харилцаа энэ дэлхий дээр үгүй.

Энэ номын үг бүр Бурхан дэлхий дээрх удирдагч та бүхэнд хүргэхийн төлөө миний дотор ноцоосон галын дөлөөр бичигдсэн учраас үнэн голоосоо хүлээн авч, таньдаг мэддэг бүх хүндээ хүргээрэй. Тэгээд өөрийнхөө бөгөөд удирдаж буй хүмүүсийнхээ төлөө Бурхантай насан турш зүү орох зайгүй нөхөрлөдөг болно гэдэгт итгэж байна.

Та Бурханы хүүхэд бол, Ариун Сүнс таныг хэзээ ч орхихгүй, хаяхгүй гэж амласан. Ариун Сүнс тантай нөхөрлөхийг хүсдэг. Энэ номын үг миний амьдралыг өөрчилсөн бөгөөд Бурханы Үгийн жимээр аялж буй таны болоод таны хайртай хүмүүсийн амьдрал ч бас тэр эрс тэс илчлэлээр өөрчлөгдсөн гэдэг мэдээг чих тавин, залбиран хүлээнэм.

Христийн доторх
Жон Бивэр ахаас чинь.

John Bevere
JohnBevere@gmail.com



Messenger
International
MessengerInternational.org

АРИУН СҮНС

ТҮҮНТЭЙ ТАНИЛЦАХУЙ

ЖОН БИВЭР

Хүү АДДИСОН БИВЭРИЙН хамт

АРИУН СҮНС: ТҮҮНТЭЙ ТАНИЛЦАХУЙ
Жон Бивэр

The Holy Spirit: An Introduction (Mongolian)
© 2013 Messenger International
MessengerInternational.org

Originally published in English as The Holy Spirit: An Introduction
© 2013 Messenger International
ISBN 978-1-933185-83-5

Нэмэлт материалыг та дараах хаягаас татаж авч болно:
www.CloudLibrary.org

Энэхүү номыг Христэч удирдагч нарт ҮНЭГҮЙ ТАРААХ зорилгоор хэвлэсэн
бөгөөд худалдан борлуулахыг хатуу хориглоно.

This book is a gift from Messenger International,
the Ministry of John and Lisa Bevere.
To contact the author: JohnBevere@ymail.com

Энэхүү номыг Messenger International буюу Жон, Лиза Бивэрийн
үйлчлэлээс Монгол чуулганд бэлэг болгон өгөв.
Зохиогчтой харилцах емэйл: JohnBevere@ymail.com

Библийн ишлэл: АРИУН БИБЛИ.
© 1995, 1996, 1997, 1998, 1999, 2000 он Монголын Библийн Орчуулгын Хороо
© 2004, Ариун Бичээс Библийн Нийгэмлэг

Printed in Mongolia

АГУУЛГА

Интерактив номын тухай	6
Адисон Бивэрийн үг	7
1. Ариун Сүнс гэж Хэн бэ?	9
2. Ариун Сүнсний зан чанар	43
3. Харилцааны 3 төвшин	77
4. Сүнсний хүч чадлаар	107
5. Сүнсний хэл	147
Нэмэлт бүлэг: Жон, Лиза хоёр таны асуултад хариулж байна	187
Хавсралт: Авралыг хэрхэн хүлээн авах вэ?	208

Интерактив номын тухай

Энэ номыг бусад ном шиг л бүлэг бүлгээр нь уншина. Гэхдээ амьдралдаа хэрэгжүүлэхэд тань дөт болгох үүднээс интерактив болгосон нь тус номын онцлог гэж хэлж болно.

Ном нь нийт 5 бүлэгтэй бөгөөд бүлэг тус бүрийг дотор нь чимээгүй цаг бүхий 5 өдрийн судлал болгож хуваасан болно. Хувиараа уншиж буй хүн өдөр бүр нэг судлалыг чимээгүй цагтай нь уншсан ч болно эсвэл өөрийнхөө боломжоор хийсэн ч болно. Харин бүлгээр судлаж буй хүмүүс долоо хоног тутам нэг судлалыг чимээгүй цагтай нь хийхийг зөвлөж байна.

АМЖИЛТ!

Адиосон Бивэрийн Үг

Анх аав намайг энэ ном дээр хамтарч ажиллая гэхэд надад тэр даруй: Аав сайн залбираагүй болтой гэсэн бодол харваж, би шууд л татгалзсан юм. Үнэндээ би өөрийгөө ном бичих хүн гэж хэзээ ч бодож явсангүй. Тиймээс аавын саналыг анх сонсоход миний гэдэс брэк бүжигчид үелзэж байгаа юм шиг л мушгираад явчив.

Би аавыг (ганц хоёр жил) олигтойхон шиг залбираад, ахин сайтар бодож үзэхийг хүслээ. Гэтэл аав нэг өдрийн дараа буюу маргааш нь надтай уулзаад: “Би залбирлаа. Чи үүнийг хийх хүн мөн” гэж хэлсэн юм. Орчин үеийн залуус Ариун Сүнсэнд “жигтэй этгээд” шиг ханддаг болчих вий гэсэндээ, над шиг залуу хүний санаа бодлыг номдоо оруулах нь аавын хувьд тун чухал байв. Хөгшин залуу гэлтгүй олон хүн Ариун Сүнсийг Хэн болох, юу хийдгийг үнэндээ мэддэггүйг аав бид хоёр мэдэж байлаа.

Тиймээс би яльгүй тээнэгэлзэж байсан ч, аавдаа татгалзаж зүрхлээгүй тул арга буюу зөвшөөрөв. Дараа нь хөвөрсөн үйл явдлыг амьдрал өөрчлөх аялал л гэж хэлэх байх. Бурхан миний нүдийг нээж гайхамшигт Сүнсээ харуулж эхлэхэд, би Бичээсийг цоо шинээр харсан юм. Тэгээд Ариун Сүнс бол Чуулганд хамгийн бага танигдсан Бурхан юм байна гэдгийг ухаарсан юм. Түүнийг янз бүрээр л төсөөлж, шошголдог ч, үнэндээ Хэн болохыг нь маш цөөхөн хүн мэддэг.

Энэ ном таныг Бичээсээр аялуулж, Ариун Сүнстэй танилцуулна. Заримдаа саад тотгортой тулна. Гэхдээ та цаг зав, эрч хүчээ зориулан байж энэ аялалыг хийсэндээ хэзээ ч харамсахгүй.

Хуудас бүрийг нь уншихдаа, таныг үнэн рүү дагуулахыг Ариун Сүнснээс хүс. Түүний Үгээс үндэслээгүй эргэлзээ бүрийг Тэр танаас хөөнө. Ариун Сүнс ямар ч деноминаци, хөдөлгөөнд харъяалагддаггүйг эсвэл аль нэг үеийнхэнд хамаарагддаггүйг

та мэдэж авна. Тэрбээр Есүсийг илчилж, Христийн Биеийг хүчирхэгжүүлэхээр ирсэн юм. Тэр бидний зүрхэнд нутаглаж, бидний амьдралыг сайн сайхан болгож хувиргана гэж амласан. Бид гагцхүү Түүнд жолоогоо атгуулах ёстой.

Түүнээс сайн найзыг та хаанаас ч олохгүй. Ариун Сүнс тантай насан турш хамт байна. Та Түүний сэтгэлийг баясгадаг хайртай хүн нь учраас Тэр таныг хэзээ ч орхихгүй. Гайхамшигтай гэдэг үг Түүнд л тохирно! Тэгэхээр Түүнтэй танилцахад бэлтгээрэй!

— Адисон Бивэр, Messenger International
байгууллагын гүйцэтгэх захирал,
Жон Бивэрийн хүү

Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм.
Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг ...
(Ефес 2:18)

1

Ариун Сүнс гэж Хэн бэ?

*Харин Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх
Ариун Сүнс та нарт бүх зүйлийг заах бөгөөд Миний та нарт
хэлсэн бүгдийг сануулах болно.*

Иохан 14:26

Нэгдүгээр өдөр

Шинэ жилийн битүүний өдөр гэнэт миний дотор залбирах хүсэл бургилав. Тиймээс би Эзэнээс: “Би Библийн ямар ном унших вэ?” гэж асуутал “Үйлс ном” гэдэг хариу дуулаад гайхав.

Юунд нь гайхдаг юм гэж үү? Учир нь яг үүний өмнөхөн: “Үйлс номыг унш” гэсэн чиглүүлгээр би нилээд хугацаанд мацаг барин залбирсан юм. Энэ үед намайг хамгийн их гайхшруулсан зүйл нь элч Паулын амьдралын зорилго, чиглүүлгийн зөрчил тэмцэл, үүнийг дагалдсан зовлон байв. Ойлгохгүй байна уу? Одоо тайлбарлая.

Бурхан харь үндэстэнд Сайн мэдээг хүргүүлэхээр Паулыг сонгожээ. Тэрбээр “Үүний төлөө би тунхаглагч, элч, багшаар томилогдсон юм” (2 Тимот 1:11). Энэ бол тодорхой болоод фокустай удирдамж. Тэрбээр амьдралынхаа турш энэ үүргээ хэд хэдэн удаа давтсан буй. Элчийнхээ аяны эхэн хэсэгт тэрбээр Иүдейчүүдэд ийн хэлсэн “... бид харь үндэстнүүдэд хандаж байна. Учир нь Эзэн бидэнд ийнхүү тушаасан. ‘Би харь

үндэстнүүдэд Чамайг гэрэл болгон тавьсан. Чи дэлхийн хязгаар хүртэл авралыг авчирна’...” (Үйлс 13:46-47). Хоёрдугаар аяныхаа дундуур Паул “Үүнээс хойш би харь үндэстнүүд уруу очно” хэмээн зоригтой тунхагласан (Үйлс 18:6). Ромчуудад тэрбээр “Би харь үндэстнүүдийн элч” хэмээн тайлбарласан (11:13). Тэрбээр захидал бүртгээ үүнийгээ мэдэгдсэн.

Гэхдээ Паул элэг нэгт Иүдейчүүдээ аврагдаасай гэсэн хайр хүсэлдээ хөтлөгдөхдөө очсон газар бүртгээ синагогоор орж, харь хүмүүст хүрэхээсээ өмнө заавал Иүдейчүүд дээр очдог заншилтай байсан юм. Гэтэл үнэндээ Иүдейчүүд л Паулын хамаг хавчлага зовлонгийн эх үүсвэр болж, тэдний эсэргүүцэл л түүнийг харь үндэстэн рүү явахад хүргэсэн юм. Тэд элч Паул болоод харь үндэстэний удирдагч нарын хооронд яс хаян мөргөлдүүлж, Паулын туулсан хамаг л эсэргүүцэл, баривчилгаа, зодуур, шүүлтийн хэргийн эзэд байсан юм. Гэхдээ нэгэн зүйлийг тэмдэглэх шаардлагатай: Бурхан Иүдейчүүдэд үнэн голоосоо хайртай. Тиймээс л Иаков, Петр, Иохан нарыг Иүдейчүүд рүү илгээжээ: “надад өгсөн нигүүлслийг мэдээд, багананууд гэж хүндлэгддэг Иаков, Кеф болон Иохан нар надад болоод Барнабт нөхөрлөлийн баруун гараа сунгасан юм. Ингэснээр бид харь үндэстнүүд уруу, тэд хөвч хөндүүлсэн хүмүүс уруу явах юм” (Галат 2:9).

Намайг мацаг барин залбирах үед Бурхан надад яг энэ мессежийг илчлээд: “Миний хөө, Аавынхаа дуудсан нигүүлсэлийн хүрээнд л бай. Сэтгэл хөдлөлдөө эсвэл хайрандаа автсанаасаа болж амьдралд чинь зориулсан тэнгэрлэг даалгавраас бүү холд” хэмээн зааж айлдсан юм. Ийм тов тодорхой уулзалт ярилцлагын дараа Бурхан намайг дахиад л Үйлс номыг унш гэсэнд би мэл гайхав. Бүхэл бүтэн 66 ном дундаас дахиад л Үйлс ном!

Гэхдээ би Аавынхаа үгэнд орсондоо баярладаг. Учир нь энэ удаа би Үйлсээр аялахдаа тэс ондоо нэгэн зүйлийг олж мэдсэн юм (Бурханы Үг амьд болохоо дахин батлав). Энэ удаа би анхны чуулганы удирдагч, гишүүд Ариун Сүнснийг яаж харж, харилцаж, хамаарч байсныг олзолж харав. Ариун Сүнс тэдний үйлдэл бүрт оролцдог, амьдралынх нь салшгүй хэсэг байжээ. Илгээлт,

бүлгийн цугларалт, стратеги боловсруулах хурал зэрэг бүх үйл ажиллагаанд Ариун Сүнс оролцдог байсан. Хэдхэн жишээ л онцлон дурьдъя:

- “Ариун Сүнсэнд худал хэллээ. Чиний зүрх яагаад Сатанд автах болов?” (Үйлс 5:3)
- “Та хоёр юунд Эзэний Сүнсийг сорихоор санаа нийлэв?” (Үйлс 5:9)
- “Эдгээрийг бид төдийгүй Түүнийг дагагсдад Бурханы өгсөн Ариун Сүнс гэрчилж байна.” (Үйлс 5:32)
- “та нар Ариун Сүнсийг үргэлж эсэргүүцдэг.” (Үйлс 7:51)
- “Эргэлзэлгүйгээр тэдэнтэй явахыг Сүнс надад хэлсэн юм.” (Үйлс 11:12)
- “Тэдний нэг Агаб гэгч босож, Сүнсээр зааварчлагдан ... Бүх газрыг хамарсан их өлсгөлөн болно гэж хэлэв.” (Үйлс 11:28)
- “Ийнхүү Ариун Сүнсээр илгээгдсэн тэд...” (Үйлс 13:4)
- “Учир нь Ариун Сүнс болон бид доор бичигдсэн зайлшгүй зүйлсээс өөр илүү ачааг та нарт тохохгүй байх нь зүйтэй гэж мэдэв.” (Үйлс 15:28)
- “Азид үгийг тунхаглахыг Ариун Сүнс хориглосон тул...” (Үйлс 16:6)
- “Мусиад ирээд Битин уруу явахаар завдан байтал Есүсийн Сүнс зөвшөөрсөнгүй.” (Үйлс 16:7)
- “Паул өөрийгөө үгэнд бүрэн зориулж, иудейчүүдэд Есүс бол Христ мөн гэдгийг гэрчилж байлаа.” Үйлс 18:5
- “Та нар итгэхдээ Ариун Сүнсийг хүлээн авсан уу?” (Үйлс 19:2)
- “Энэ бүхэн дууссаны дараа Паул Македони, Ахайг дайрч Иерусалим уруу явъя гэж сүнсээр шийдэн ...” (Үйлс 19:21)
- “Зөвхөн хүлээс болон зовлон намайг хот бүрд хүлээж байгаа гэдгийг Ариун Сүнс надад гэрчилдэг.” (Үйлс 20:23)
- “Бурхан Өөрийн цусаар Өөртөө худалдаж авсан Бурханы чуулганыг хариулуулахаар Ариун Сүнс та нарыг харгалзагч болгосон бөгөөд та нар өөртөө болон бүх сүрэгт анхаарал тавь”. (Үйлс 20:28)

Эдгээр үг миний нүдийг бүлтэлж байв. Гэхдээ нөгөө талаас өнөөгийн Чуулган ийм үлгэр жишээг дагахгүй байгаа нь ёстой л гашуун үнэн байлаа. “Үйлсийн” үеийн итгэгчдийн дунд эгэл жирийн үзэгдэл байсан зүйлс өдгөө нүдний гэм болжээ. Би бусдын талаар бус, өөрийнхөө талаар л ярьж байна. Энэ бүхнийг уншиж байхдаа би өөрөө Бурханы Сүнстэй хөөрөлдөж, Түүнийг эрэн хайж, Түүнд жолоогоо атгуулж, нөхөрлөж, харилцаж, Түүний хүчирхэг нөмөр дор явахаа бараг больжээ гэдгээ ухаарсан юм. Яс махандаа шингэтэл ойлгож, голдоо ортол ухаарсан зүйлээ яаж би бусдаас нуух билээ?

Урьдчилсан мэдэгдэл

Одоо миний хэлэх зүйлийг та судлалынхаа явцад ухааж ойлгоно:

Юуны өмнө Ариун Сүнсгүйгээр Христэч амьдрал гэж үгүй.

- Ариун Сүнс үгүй бол Христэд итгэх итгэл маань хуурай, уйтай, зүгээр л газрын зүйл болно.
- Ариун Сүнс үгүй бол бидний хөдөлмөр хүнд хүчир бөгөөд дарамттай байна.
- Ариун Сүнс үгүй бол Бурхантай нөхөрлөх нөхөрлөл гэж байхгүй.

Ариун Сүнсийг Чуулганаас авчихбал:

- Чуулган зүгээр л нийтийн клуб болно.
- Эсвэл шашны байгууллага болно.

Үнэн болбоос...

- Ариун Сүнс үгүй бол илчлэл байхгүй. Үнэндээ Сүнс үгүй бол Бичээс аюултай болно. Учир нь “үсэг алдаг бол, Сүнс амьдруулдаг” гэдэг (2Коринт 3:6).
- Ариун Сүнс үгүй бол алсын хараа үгүй.
- Ариун Сүнс үгүй бол баяр хөөр үгүй.
- Ариун Сүнс үгүй бол амар тайван үгүй.
- Ариун Сүнс үгүй бол эрх чөлөө үгүй.

“Эзэн бол Сүнс мөн. Эзэний Сүнс хаана байна, тэнд эрх чөлөө байдаг.” (2Коринт 3:17)

“Эзэний Сүнс орших газар гэж хэлсэнийг харна уу. Үүнийг сайн бод. Бурханы Сүнс бол хаа сайгүй оршигч- Тэр бүх цагт бүх газар оршино. Давид “Таны Сүнснээс би хаашаа зугтах вэ? Таны оршихуйгаас би хаашаа одох вэ?” гэсэн (Дуулал 139:7). Хариулт нь: *хаашаа ч үгүй*. Давид цааш нь ийн өгүүлсэн: “Хэрэв би тэнгэр өөд очвол, Та тэнд байдаг. Хэрэв би Үхэгсдийн оронд ор дэрээ засвал, харагтун, Та тэнд байдаг. Хэрэв би үүрийн гэгээгээр жигүүрлэн, хэрэв би далайн хамгийн алсын хэсэгт суувал, тэнд ч Таны мутар намайг удирдаж, Таны баруун мутар надаас зуурах болно” (Дуулал 139:8-10). Ариун Сүнс бүх үед *бүх газар* оршдог нь тун тодорхой байна.

Тиймээс үүний араас бид “Тэгвэл эрх чөлөө бүх газар байдаг гэж үү?” гэж асуух хэрэгтэй. Паулын үгийг дахиад харъя: “Эзэн бол Сүнс мөн. Эзэний Сүнс хаана байна, тэнд эрх чөлөө байдаг.” (2Коринт 3:17). Ариун Сүнс *бүх газар* оршдог гэдгийг бид сурсан. Тэгвэл эрх чөлөө *бүх газар* байдаг гэж үү хэмээн дахиад асууя. Хариулт нь мэдээж үгүй. Дэн буудал, баар, шорон, эмнэлэгт эрх чөлөө байхгүй. Тэр бүү хэл эрх чөлөөгүй саахалт, сургууль, айл, чуулган ч байдаг. Тэгвэл Бичээс энд юу тунхаглаа вэ? Миний бодлоор:

“Сүнсийг Эзэнээ болгосон газар л эрх чөлөө оршино.”
(2Коринт 3:17 Жон Бивэрийн орчуулга)

Эзэнийг Грекээр *kyros* гэх агаад тус үг нь “туйлын дээд эрх мэдлийг” илэрхийлдэг. Дийлэнх баар, шорон, эмнэлэг, айл, тэр бүү хэл чуулган Ариун Сүнсэнд эрх мэдлийг нь өгдөггүй. Харин Түүнийг Эзэнээ болгож, туйлын дээд эрх мэдлийг нь олгосон газар жинхэнэ эрх чөлөө, шударга ёс тогтдог.

Энэ үгийн зорилго

Энэ ном нь Ариун Сүнс бол Хувь нэгэн гэдгийг л танилцуулах зорилготой. Түүний талаар хэдэн мянган зүйл бичиж, хэдэн арван жил ярьж болно.

Гэргий бид хоёр айл гэр болоод гучин жил болжээ. Гэхдээ одоо хүртэл би түүний зан чанар, хүсэл сонирхол, ааль авирыг таньж мэдсээр л байна. Саяхан бид хоёр 30 жилийнхээ ойг тэмдэглэж, хэдэн өдрийг хоёулханаа өнгөрөөхдөө би түүний урьд нь хэзээ ч сонсоогүй мөрөөдөл, таалал, чадварыг мэдэж авсан билээ. Тухайлбал Лиза маш мундаг гольфчин гэдгийг төсөөлж ч явсангүй. Лиза намайг гольфт дуртайг мэддэг учраас нэг удаа надад хань болох үед түүний гольфийн ур чадвар нээгдсэн юм.

Үдэш бүр зоог барихдаа Лиза надтай урьд нь хэзээ ч дэлгэж байгаагүй мэдлэг, цэц ухаан, сонирхол, зүрхний хүслээ хуваалцав. Товчхондоо миний гэргий ямар гайхамшигтай эмэгтэй болохыг би цоо шинээр ухаарч бишэрсэн юм.

Лизагийн тухай хэдхэн бүлгээр өгүүлэх боломжгүй. Тэр бүү хэл боть ч багадана. Гэхдээ та өөрөө түүнтэй харилцаж, ярилцбал хамаагүй дээр. Би Лизагийн сонирхол, дуртай зүйлс, түүнтэй яаж ажиллаж харилцах талаар ярьж болно. Түүний хүч чадал, сул тал, хайртай хайргүй зүйлийг нь тоочиж болно. Энэ бүх мэдээлэл таны хувьд Лизагийн талаарх мэдлэгт дусал нэмэр болж болно.

Хэдхэн арван жилийн настай Лизагийн талаар ярьж барахгүй байхад, мөнхийн мөнх настай Ариун Сүнсний тухайд бол бүр юу хэлэх билээ? Гэхдээ би Түүний талаар жаал жуул танилцуулж чадна. Түүний зан чанар, хайртай дуртай зүйлсийн талаар мөн бид Түүнтэй ямар харилцаа тогтоох, яаж харилцахыг бага сага хэлж чадна. Ариун Сүнтэй харилцах нь бидний хувьд яагаад амин чухал бөгөөд Тэр биднийг яаж Бурханы хүслийг биелүүлэх хүчтэй болгодгийг тайлбарлаж чадна. Эдгээр үндсэн ухаарал дээр дөрөөлөн та өөрөө цаашаа Ариун Сүнтэй гүн гүнзгий дотно харилцаа хөгжүүлнэ гэдэгт найднам.

Хоёрдугаар өдөр

Ноцтой эндүүрэл

Олон хүн Ариун Сүнснийг *Өөрийг* нь мэдэхгүйгээр зөвхөн *үйлс, хүчийг* нь ашиглах гэж оролддог.

Ариун Сүнс бол туйлын ариун, цэцэн, хүчирхэг боловч гайхалтай зөөлөн, мэдрэг, хайраар дүүрэн Бурхан гэдгийг бид зүрхэндээ болон тархиндаа сийлэх ёстой. Тэрбээр бидний анхаарал, хайр, итгэл, сэтгэл, дээдлэл болон бүрэн төгс зориулалтыг хүлээж авах бүрэн эрхтэй Бурхан гэдэгт та бид итгэж байна уу эсвэл Түүнийг Бурханаас гарсан тэнгэрлэг, нууцлаг хүч гэж боддог уу?

Энэ үзэл нь тун буруу бөгөөд гаж ч гэж хэлж болно. Хэрэв бид ингэж итгэж байвал, биднийг Христитгэлийн хавьгүй дээд зиндаанд харъяалагддаг юм шиг санагдуулдаг сүнслэг бардамналд амархан урхидуулах аюултай.

Харин бид Ариун Сүнсний энгүй эрхэмсэг чанар, сүр жавхлан, алдар, цэц ухаан, мэдлэг, ариун чанарыг нь харж, Тэрбээр Бурхан Аав, Хүү хоёртой хамт бидний амьдралыг захирч, сайн сайхан болгоно гэдэгт итгэж байвал, Түүний өмнө үг дуугүй сөгдөн мөргөнө.

Бурханы Сүнснийг нөлөө юмуу хүч гэж боддог хүн дандаа: “Надад илүү их Сүнс хэрэгтэй байна” гэдэг. Харин Түүнийг Бурхан гэж хардаг хүн “Би яаж Танд илүү их зориулагдах вэ?” гэдэг.

Түүний талаарх бидний үзэл бодол

Ариун Сүнснийг “юм” гэж ярьж байхыг та сонссон уу? Би 30 гаруй жил үйлчлэхдээ ийм яриа сонсох бүртээ 1 доллар хураасан бол, өдийд тун чинээлэг хүн болох байсан. Харамсалтай нь олон хүн Ариун Сүнснийг Бурхан хэмээн хүндэтгэдэггүй учраас Сүнсний бүрэн дүүрэн амьдралыг эдэлдэггүй. Түүнийг хүндэтгээгүй газар Бурханы Сүнс Өөрийгөө илчилдэггүй (Матай 13:54-58; Дуулал 89:7).

Ариун Сүнс бол Өөрийн гэсэн хувийн мөн чанар, зан чанар, шинжтэй Хувь Нэгэн юм. Энэ нь Тэрбээр хүн гэсэн үг биш. Ариун Сүнс бол Бурхан болой. Бурхан хүнийг Өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн. Бурхан бидэнтэй адилхан гэхээсээ илүү бид Бурхантай адил юм.

Чуулган Түүнийг ариунаас ариун Нэгэн гэж хандахаасаа илүү “*ариун оришгч*” гэж хандах учиртай. Тэрбээр бидний хамгийн дотно найз байхыг хүсдэг ч, бид Түүний оролцоог хязгаарладаг. Үнэндээ бид хамгийн утга учиртай, эрхэм харилцаагаа өөрийн мэдэлгүй эсэргүүцдэг нь гашуун үнэн юм.

Ариун Сүнсний мөн чанарыг төгс дүрслэсэн Бичээсийг харцгаая:

- Тэрбээр оюун ухаантай (Ром 8:27).
- Хүсэлтэй (1Коринт 12:11).
- Сэтгэл мэдрэмжтэй (Ром 15:30; Галат 5:22).
- Тайвшруулдаг (Үйлс 9:31).
- Ярьдаг (Еврей 3:7); үнэндээ маш тод ярьдаг (1Тимот 4:1).
- Заадаг (1Коринт 2:13).
- Биднийг гэмшүүлдэг (Ефес 4:30).
- Түүнийг доромжилж мэднэ (Еврей 10:29).
- Түүнийг эсэргүүцэж мэднэ (Үйлс 7:51).
- Түүнд худал хэлж мэднэ (5:1-11).

Тэгвэл Ариун Сүнсний талаар Бичээс ийм тодорхой хэлсээр байтал хүмүүс Түүнийг яагаад буруугаар ойлгоод байдаг юм бол?

Тагтаа

Ариун Сүнс гэхээр хүмүүс шууд л тагтааг боддог. Яагаад заавал тагтаа хамгийн түрүүнд орж ирдэг юм бол? Ариун Сүнс ер нь тагтааны дүрээр илчлэгдсэн үү? Хариулт нь томоос том үгүй. Сайн мэдээний 4 номд Бурханы Сүнс Есүс дээр *тагтаа мэт* буусан тухай гардаг (Матай 3:16; Марк 1:10; Лук 3:22; Иохан 1:32).

Гэхдээ бид хүнийг “салхи шиг хурдан” эсвэл “бух шиг хүчтэй”

хэмээн зүйрлэж ярихдаа тухайн хүнийг дөрвөн туурайтай мал гэсэн утгаар хэлдэггүй биз дээ? Яг үүнтэй адил Сүнс тагтаа мэт бууж ирсэн гэдэг нь Тэрбээр тагтаа шувуу болчихсон гэсэн үг биш юм.

“Гэхдээ Ариун Сүнсийг Бурханы сэнтийн өмнөх галын дөл гэж дүрслэсэн шүү дээ, Жон” (Илчлэлт 4:5) гэж хэлэх хүн гарах байх. Яг тийм. Гэхдээ Библи мөн “Тэгээд би сэнтий болоод дөрвөн амьтны хооронд, ахлагчдын дунд зогсож буй нядлуулсан мэт Хургыг харав. Тэр Хурга долоон эвэр болон долоон нүдтэй бөгөөд долоон нүд нь дэлхий даяар илгээсэн Бурханы долоон Сүнс юм” гэж хэлсэн (Илчлэлт 5:6). Иохан Есүсийг ингэж дүрслэсэн. Гэхдээ Есүс дөрвөн туурайтай адгуус биш гэдгийг та бид 2 сайн мэднэ. Үүнтэй адил Ариун Сүнс бол Бурханы сэнтийн өмнө дүрэлзэх нууцлаг гал биш юм.

Тэгвэл Тэр хэн юм бэ?

Ариун Сүнс бол Бурханы Гурвалын Нэг гэдгийг Библи тодорхой хэлдэг. Эхлэл 1:26: “Тэгээд Бурхан, —*Бид Өөрсдийнхөө* дүр төрхийн дагуу *Өөрсөдтэйгээ* адилхан хүнийг бүтээж, далайн загас, огторгуйн шувууд, мал адгуус, бүх газар дэлхий, газраар мөлхөгч бүгдийг тэдэнд захируулья хэмээн айлдав”. Бүтээлийн жүжигт гурван Гол дүр өөр өөрийн гэсэн гурван онцгой оройл бүтээсэн бөгөөд Бурхан Өөрийгөө Аав, Хүү, Ариун Сүнс хэмээсэн бүлгээ.

Аав, Хүү, Ариун Сүнсний тус тусын онцгой оройлыг Үйлс 10:38-с харъя.

Энэ нь Назарын *Есүсийн* тухай бөгөөд Бурхан хэрхэн Түүнийг *Ариун Сүнс* ба хүч чадлаар тосолсон хийгээд Тэрээр диаволд дарлагдсан бүгдийг эдгээн, сайныг үйлдэж явсан тухай юм. Учир нь *Бурхан* Түүнтэй хамт байсан.

Уг хэсэгт *Аав* нь *Есүсийг Ариун Сүнсээр* тослосон буюу тус тусын

онцлогтой 3 Дүр нэг зорилгын төлөө гар нийлэн ажиллаж байна. Бас нэгэн жишээ хэлье:

Есүс баптисм хүртээд, голын уснаас тэр даруй гарах үед тэнгэр заагдаж, *Бурханы Сүнс* тагтаа лугаа адил бууж, Түүн дээр ирэхийг тэр харав. Тэнгэрээс —Энэ бол Миний хайрт Хүү. Түүнд Миний таалал оршдог гэх дуу гарлаа. (Матай 3:16-17).

Есүсийг баптисм хийлгэхэд дахиад л Бурханы Гурвал өөр өөрийн онцгой ажлыг гүйцэтгэжээ. Нэгдүгээрт- *Есүс* Иоханаар баптисм хийлгэсэн. Хоёрдугаарт- *Бурханы Сүнс* Түүн дээр буусан. Гуравдугаарт- *Бурхан Аав* нь тэнгэрээс: “Энэ бол Миний хайртай Хүү. Түүнд Миний таалал оршдог” хэмээсэн. Дахиад л Гурвуулаа нэгэн зорилгын төлөө ажиллаж байна.

Энэ үнэнийг би маш энгийнээр тайлбарлая. Ус (H₂O) гурван төлвөөр оршдог: хатуу, шингэн, уур. Ямар хэлбэрээр оршихыг температур л шийднэ. Температурын нөлөөгөөр усны молекулын бүтэц нь бус, зөвхөн гадаад төлөв нь хувирдаг. Үүнтэй адил Бурханы төв чанар хэзээ ч хувирдаггүй. Та Хүүг харахдаа Аавыг болон Хүүг илчлэхээр илгээгдсэн Сүнсийг харна (Иохан 17:21; Ефес 1:17-18). Бурхан өөр өөрийн гэсэн онцгой оройлтой гурван Дүрээс бүтдэг, нэг зорилготой ганц Бурхан юм. Дэд хууль 6:4: “Израиль аа, сонс! ЭЗЭН бол бидний Бурхан, ЭЗЭН бол ганц.” Ром 3:30: “... итгэлээр зөвтгөх Бурхан бол үнэндээ ганц болой.” Иаков 2:19: “Бурхан бол ганц гэдэгт чи итгэдэг. Энэ чинь сайн хэрэг.”

Гуравдугаар өдөр

Нэгдүгээр Дүр

Бурханы Гурвалаас Библи дээр хамгийн түрүүнд гарсан нь Ариун Сүнс болой. Эхлэл 1:1: “Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжээ.”

Одоо 2-р ишлэлийг харъя: “Газар нь ямар ч хэлбэр дүрсгүй, эзгүй хоосон, гүний гадаргуу дээгүүр нь харанхуй бүрхэж, Бурханы Сүнс усны мандал дээгүүр элин хальж байлаа.”

“Гэхдээ Жон, 1-р ишлэлд “Эхлээд Бурхан тэнгэрс ба газрыг бүтээсэн” гэж байна шүү дээ. Бичээсийн эхний ишлэл Бурхан Аавын тухай ярьсаар байтал та яагаад Бурханы Гурвалаас Ариун Сүнс Библи дээр хамгийн эхэлж гардаг гэж хэлнэ вэ?” гэж асууж байна уу? Онцсайн асуулт байна. Гэхдээ Бурхан “Өөрсдийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээ” гэж хэлсэнийг санана уу. Нэгдүгээр ишлэлд буй Бурхан гэдэг нэр нь Бурханы Гурвалын аль нэг Дүрийг бус, харин Гурвалыг хамтад нь хэлж байгаа юм. Тиймээс Библи дээр үйл ажлаараа тодорхой нэрлэгдсэн Бурханы Гурвалын анхны Дүр нь яахын аргагүй Ариун Сүнс болой. Хоёрдугаар ишлэлд “Бурханы Сүнс усны мандал дээгүүр элин хальж байлаа” гэжээ.

Харин одоо гол асуултдаа орё: Ариун Сүнс гэж хэн бэ? Би Түүнийг дэлхий дээрх хамгийн гайхамшигтай, гайхалтай, эелдэг, зөөлөн, эмзэг агаад хүчирхэг Нэгэн гэнэ. Та “... дэлхий дээрх ий?” гэж асууж магадгүй. Тийм ээ, дэлхий дээрх. Аав дэлхий дээр бус, тэнгэрийн сэнтийдээ залран буй. Есүс ч бас дэлхий дээр байхгүй. Хүмүүс “Есүс миний зүрхэнд бий” гэж ярьдаг. Гэхдээ Есүс Бурханы баруун гарт сууж буйг Бичээс тов тодорхой хэлдэг (Марк 16:19). Үйлс 1:9-11:

Тэр ийнхүү айлдсаны дараа тэднийг харж байхад нь дээш өргөгдөж үүлэнд орж тэдэнд харагдахгүй болов. Түүний одохыг харж тэнгэр өөд гөлрөн байсан тэдний хажууд цагаан өмсгөлтэй хоёр хүн зогсоод, хэлсэн нь

—Галилын эрчүүд ээ, юунд та нар тэнгэр ширтэн зогсоно вэ? Та нараас өргөгдөн тэнгэрт аваачигдсан энэ Есүс нь та нарын Түүнийг тэнгэр өөд явсныг нь харсан лугаа адил тийн буцаж ирнэ гэв.

Есүс явсан шигээ эргэж ирэхийг хоёр хүн буюу тэнгэрэлч дагалдагч нарт тодорхой хэлсэн. Өөрөөр хэлбэл Тэрбээр үүлэн

дээр заларч ирэхээсээ өмнө газар дээр дахиж оршихгүй. Есүс үүлэн дээр заларсаар ирсэн үү? Мэдээж үгүй. Тэгэхээр Есүс одоо тэнгэрт Бурханы баруун гарт залран суугаа.

Степаныг чулуугаар нүүлгэж алахад юу болсоныг санаж байна уу? Үйлс 7:55-56: “Харин Ариун Сүнсээр дүүрсэн Стефан тэнгэр өөд ширтэн Бурханы суу алдрыг болон Бурханы баруун талд зогсож буй Есүсийг хараад, Харагтун. Тэнгэр нээгдэхийг болон Бурханы баруун талд зогсож байгаа Хүний Хүүг би харж байна гэж хэлэв.” Энэ түүх нь бид Эзэнтэйгээ дахин сүр жавхлантайгаар учран золгохын үзэсгэлэнт зураглал боловч, Есүс одоогоор Аавынхаа хажууд байгаа гэдэг баримтыг дахин сануулж буй.

Үнэндээ Есүс энэ сүр жавхлант байр сууриндаа 2000 гаруй жил болжээ. Тэр дэлхий дээр байхгүй. Бид Есүсийг зүрхэнд минь байгаа гэж хэлэх дуртайг би мэднэ. Гэхдээ үнэн болбоос Есүс Христийн Сүнс буюу Ариун Сүнс бидний зүрхэнд оршдог юм. Жишээ татъя.

Филиппой 1:19: “Та нарын залбирал болон *Есүс Христийн Сүнсний* туслалцаагаар дамжуулан би суллагдах болно гэдгийг би мэддэг.” Тэр явж, Түүний оронд Ариун Сүнс ирнэ гэдгийг Есүс тодорхой айлдсан.

Матай 10:20 дээр Есүс ийн тунхагласан: “Яригч бол та нар бус, та нарын дотор яригч *Эцэгийн чинь Сүнс* юм.” Дагалдагч нар нь Сайн мэдээний төлөө хавчигдаж, шалгагдах цаг ирэхэд Аавын Сүнс (Ариун Сүнс) тэднийг хөглөж, аманд нь зөв үгийг тавихыг Есүс айлджээ.

Би ч гэсэн ухаантайдаа эвсэл туршлагатайдаа энэ номыг бичээгүй. Эдгээр нь надаар дамжуулан Аавын Сүнс танд зааж буй үг юм. Би өөрийнхөө хүчээр хийх гэж оролдоод, үлэмж бүтэлгүйтсэн үе надад байсныг нуухгүй. Өдий зэрэгтэй яваа маань үнэхээр Түүний нигүүлсэлээр бөгөөд Ариун Сүнсний хүч чадлаар билээ. Тэр намайг хэзээ ч хаяагүй, харин хэзээд тусладаг. Нигүүлсэлийн Сүнсэнд даруугаар захирагдах үед (Еврей 10:29) Тэрбээр итгэмжтэйгээр миний дорой талыг хүч чадал болгож хувиргадаг.

Тэр Гурав яаж ажилладаг вэ?

“Нэгийн дотор Гурав” гэдэг нь хүн бидний ухаанаас давсан, ойлгоход бэрх зүйл байж мэднэ. 1Коринт 12:5-7 Бурханы Гурвал хэрхэн ажилладагийг тайлбарладаг:

Үйлчлэлүүд нь ялгаатай боловч адилхан Эзэн. Үйлдлүүд нь ялгаатай боловч бүгдийн дотор бүх юмсыг үйлдэгч нь адилхан Бурхан юм. Нийтийн тусын тулд Сүнсний илрэлийг хүн тус бүрд өгсөн аж.

Аав, Хүү, Ариун Сүнс тус бүр өөр өөрийн онцгой оройлтой нь эндээс харагдаж байна. Аав нь санаачлан, ажиллагаа эхлүүлдэг (и6), Хүү нь гүйцэтгэдэг (и5), Ариун Сүнс биелэл болгодог (и7). Тэд нэг л зорилгын төлөө хамтран ажилладаг.

Бид байшин барихдаа яадаг вэ? Бидэнд зураг төсөл гаргах хүн, барилгын даамал, барилгачид хэрэгтэй. Энэ дүрслэлээр бол, зураг төсөл гаргадаг Уран барилгач нь Бурхан Аав, барилгын даамал нь Есүс, харин байшин барих барилгачин нь Ариун Сүнс юм. Тэрбээр бүтээлийг *биелэл болгосон* Нэгэн. Энэ гурван хүн байхгүй бол байшин босохгүй.

Бурханы хуруу

Нэгэн үйл явдлыг тэмдэглэсэн хоёр Бичээсийг үзье. Есүс чөтгөрт олзлогдсон хүнийг эдгээжээ. Хүмүүс шаагилдаж, харин фарисайчууд *тэр чөтгөрийн хүчээр л чөтгөрөө зайлуулаа* гэж бодсон (Матай 12:23-24). Харин Есүс тэдэнд хэрхэн хариулсаныг 28-р ишлэлд тэмдэглэжээ: “Харин хэрвээ Би Бурханы Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулдаг бол Бурханы хаанчлал та нарт ирчихээд байна.”

Лук бас энэ түүхийг тэмдэглэсэн ч, Матайн бичвэрээс яльгүй өөр ажээ. Лук 11:20: “Харин хэрвээ Би *Бурханы хуруугаар* чөтгөрийг зайлуулдаг бол Бурханы хаанчлал та нарт ирчихээд байна”. Лук Матай хоёр хоёулаа Ариун Сүнсийг дурьджээ.

Лук зохиолч бичээч хүнийхээ зангаар Ариун Сүнсний ажлыг өөрийнхөө ажилтай жишэн дүрслэжээ. Тиймээс Ариун Сүнсийг “Бурханы хуруу” хэмээн дүрсэлж болно.

Ариун Сүнсний үйл ажиллагааг Бурханы хуруу гээд зогсохгүй, *Бурханы мутар* хэмээсэн. Бурхан хүчирхэг мутраа далайж хүмүүсээ чөлөөлсөн гэдэг (Дуулал 136:12). Дуулал 8:3: “*Таны мутрын* бүтээл болох Таны тэнгэрүүдийг, Таны цогцлоон байгуулсан сар, оддыг би тунгаан бодохдоо...” Тэнгэрт оддыг, сансарт гаригуудыг байрлуулсан Нэгэн нь Ариун Сүнс гэдгийг хүмүүс ойлгодоггүй. Бүтээлийг биелэл болгосон Нэгэн нь Ариун Сүнс юм. Эхлэл 1:2 дээр: “...Бурханы Сүнс усны мандал дээгүүр элин хальж байлаа” гэдэг. Тэрбээр Аавын санаачилгыг хүлээж байсан. Бурханы Үг болох Хүү нь “Тэрэл бий болг” хэмээн гүйцэтгэх ажлаа хийгээд, Ариун Сүнс хэлсэнийг нь биелүүлсэн.

Ариун Сүнсний сүр жавхлангийн талаар хэлсэн, миний хамгийн дуртай хэсэг бол Исаиа 40:12-15 юм:

Хэн усыг гарынхаа алганд хэмжиж, тэнгэрийг төөлсөн бэ? Хэн газрын тоосыг хэмжүүрээр тоолж, уулсыг жинлүүрээр жинлэн, толгодыг хос дэнсээр дэнсэлсэн бэ? Хэн ЭЗЭНий Сүнсийг удирдан, эсвэл Түүний зөвлөх нь болж, Түүнийг сургасан бэ? Хэнтэй Тэр зөвлөлдөн, хэн Түүнд ухаарлыг өгсөн бэ? Хэн Түүнд шударга ёсны замыг заан, мэдлэгийг сургаж, ухаарлын замыг мэдүүлсэн бэ? Үзэгтүн, үндэстнүүд бол хувин доторх дусал мэт хийгээд дэнсэн дээрх тоосны ширхэг мэт тооцогддог. Үзэгтүн, Тэр арлуудыг нарийн тоос мэт өргөнө.

Арван хоёрдугаар ишлэлд: “Хэн усыг гарынхаа алганд хэмжиж, тэнгэрийг төөлсөн бэ? Хэн газрын тоосыг хэмжүүрээр тоолж, уулсыг жинлүүрээр жинлэн, толгодыг хос дэнсээр дэнсэлсэн бэ?” гэсэн. Тэгэхээр Ариун Сүнс үйл ажлаараа тодорхойлогдож буйг харж байна уу? Бурханы Сүнс бүхэл бүтэн далайг тогтоодог. Тэрбээр ямар хүчтэйг харж байна уу? Тийм боловч маш даруугаар Аав, Хүү хоёрыг сонсон бидэн дотор суурьшжээ. Үгээр ч илэрхийлэхийн аргагүй, гайхамшигтай үнэн!

Дөрөвдүгээр өдөр:

Бурханы Ариун Сүнс

Хүн биднийг бүтээж байхад Ариун Сүнсний гүйцэтгэсэн үүргийг харъя. “ЭЗЭН Бурхан тоос шорооноос хүнийг бүтээж, амин амьсгалыг хамраар нь үлээж оруулахад, хүн амьд оршигч болжээ.” (Эхлэл 2:7). Ариун Сүнс л Адамыг хэлбэршүүлж, хамраар нь амь үлээсэн. Иов 33:4 үүнийг хэлсэн: “Бурханы Сүнс намайг бүтээсэн бөгөөд Төгс Хүчит Нэгэний амьсгал надад амь өгдөг билээ.” Ариун Сүнс Адамыг хэлбэршүүлж, амь үлээгээд зогсохгүй, та бид хоёрыг бас хэлбэршүүлж, амь өгсөн. Дуулал 139:13: “Учир нь Та миний эрхтнүүдийг хэлбэртэй болгожээ. Та эхийн минь хэвлийд намайг бүрдүүлжээ.” Үнэндээ Ариун Сүнс бидний харж буй бүхнийг бүтээснийг Сургаалт үгс 26:10 дээр хэлсэн: “Аугаа Бурхан бүхнийг хэлбэршүүлсэн ...” (Англи Библиэс орчуулав) Бидний харж буй бүхнийг Аавын хүслээр Ариун Сүнс биелэл болгожээ.

Ариун Сүнс Бурхан гэдэгт та одоо эргэлзэхгүй байгаа байх. Одоо тэгвэл Бичээст хэлсэн Түүний зарим нэрсээс үзье:

- Ариун Сүнс (96 удаа)
- Эзэний Сүнс (28 удаа)
- Бурханы Сүнс (26 удаа)
- Мөнхийн Сүнс (Еврей 9:14)
- Туслах (Иоханы Сайн мэдээнд Есүс 4 удаа ингэж дуудсан)
- Тайвшруулагч
- Ариун Нэгэн (Дуулал 78:41)
- Эзэн (2Коринт 3:17)
- Үнэний Сүнс (4 удаа)
- Христийн Сүнс (Ром 8:9; 1Петр 1:11)
- Есүсийн Сүнс (Филиппой 1:19)
- Зөвлөгч Сүнс (Исаиа 11:2)
- Мэдлэгийн Сүнс (Исаиа 11:2)
- Хүч чадлын Сүнс (Исаиа 11:2)

- Ойлголтын Сүнс (Исаиа 11:2)
- Цэц ухааны Сүнс (Исаиа 11:2)
- Эзэнээс эмээхүйн Сүнс (Исаиа 11:2)
- Таны Аавын Сүнс (Матай 10:20)
- Алдрын Сүнс (1Петр 4:14)
- Нигүүлсэлийн Сүнс (Зехариа 12:10; Еврей 10:29)
- Шүүгч Сүнс (Исаиа 4:4)
- Шатаагч Сүнс (Исаиа 4:4)
- Амийн Сүнс (Ром 8:2)
- Хайрын Сүнс (2Тимот 1:7)
- Хүч чадлын Сүнс (2Тимот 1:7)
- Эрүүл саруул ухааны Сүнс (2Тимот 1:7)
- Эш үзүүлэгч Сүнс (Илчлэлт 19:10)
- Илчлэгч Сүнс (Ефес 1:17)
- Ариун байдлын Сүнс (Ром 1:4)
- Ариун Бурханы Сүнс (Даниел номд 4 удаа)

Тэр бүрэн эрхтэй, хүчирхэг, гайхамшигтай!

Есүс Ариун Сүнснээс бүрэн хамаарсан

Есүс Ариун Сүнснээс бүрэн хамаарсан. Тэрбээр Сүнсээр олдож, Сүнсээр сургагдаж, Иордан голд Сүнсээр хүчирхэгжиж, Сүнсний баптисм хүлээж авахаасаа өмнө ямар ч гайхамшиг хийгээгүй (Есүс анхны гайхамшигаа Галилын Канаанд хийснийг Иохан бичсэн: Иохан 1:29-34; 2:1-11). Есүс Сүнсээр хөтлүүлж Сүнснээс сонссон үгээ л ярьсан.

Иохан 14:10 дээр Есүс ийн айлджээ: “Би Эцэгийн дотор, Эцэг Миний дотор байгаа гэдэгт чи итгэхгүй байна уу? Миний та нарт хэлж байгаа үгсийг Би Өөрийн санаагаар хэлээгүй. Харин *Миний дотор оршигч Эцэг* Өөрийнхөө ажлуудыг хийж байгаа юм.” Есүс “тэнгэрт орших Аавын минь” гээгүй, “Миний дотор орших Аав минь” гэсэн.

“*Жон, та чинь Есүс Ариун Сүнсийг Аав гэж дуудсан гэх гээд байна уу даа?*” Яагаад үгүй гэж? Тэнгэрэлч Иоханд юу гэснийг хар л даа: “Давидын хүү Иосеф оо, Мариаг эхнэрээ болгохоос бүү эмээгтүн. Учир нь түүнд олдоод байгаа нь Ариун Сүнснийх юм.” (Матай 1:20).

Есүс Ариун Сүнсээр олдсон учраас Тэрбээр Ариун Сүнсийг “Миний дотор орших Аав минь” хэмээн дуудах нь тийм ч утгагүй зүйл биш юм.

Үнэндээ Есүсийг газар дээр байх хугацаанд Ариун Сүнс Тэр хоёр байнга хамтарч ажилладаг байсан. Есүс Өөрөө ч үүнийг хэлсэн: “Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Эцэгийнхээ хийдгийг Хүү нь үзэхгүй бол Хүү Өөрөөсөө юуг ч хийж чадахгүй. Учир нь Эцэг юу хийнэ, Хүү нь бас эдгээр зүйлийг түүнчлэн хийдэг” (Иохан 5:19). Бурханы Хүү Есүс даалгавраа биелүүлэхдээ Ариун Сүнс тэй байнга хамтарч ажиллах шаардлагатай байсан бол, бидний хувьд бүр ч их шаардлагатай бус уу?

Ариун Сүнсийг Есүс шиг сайн мэддэг Нэгэн байхгүй. Тиймээс бидний амьдралд гүйцэтгэх Ариун Сүнсний үүрэг, зан чанар, хувь нэмэр, хүч, чадварын талаар Тэрбээр юу хэлсэнийг харъя. Иохан 14:15-18:

Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь. Би Эцэгээсээ гуйхад, Тэр та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна. Тэр бол үнэний Сүнс мөн бөгөөд Түүнийг харахгүй, мэдэхгүйгээсээ болж, ертөнц Түүнийг хүлээж авч чадахгүй. Харин та нар Түүнийг мэднэ. Яагаад гэвэл Тэр та нартай хамт үргэлж байх бөгөөд та нарын дотор байна. Би та нарыг өнчрүүлж орхихгүй. Би та нар уруу ирнэ.

Энд олон чухал зүйл байна. Нэгдүгээрт- Есүс “Надад хайртай бол, Миний тушаалыг сахь” гэсэн. Есүс Ариун Сүнсний тухай ярихдаа Өөрийнхөө онц бөгөөд бүрэн эрхийг давхар сануулжээ. Тэрбээр Түүнийг тушаалыг дагахыг л ахин дахин онцлон тэмдэглээд байна. Петр ч энэ үнэнийг батжуулсан: “Эдгээрийг бид төдийгүй Түүнийг дагагсдад Бурханы өгсөн Ариун Сүнс гэрчилж байна гэв” (Үйлс 5:32). Бурхан дуулгавартай хүмүүст Ариун Сүнсээ өгдөг.

Харин одоо Иохан 14:16 дээр хэлсэн Есүсийн үгийг тэмдэглэнэ үү: “Би Эцэгээсээ гуйхад, Тэр та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр

нь та нартай үүрд хамт байна.” *Өөр* гэдэг Грек үгийг нь харцгаая. Шинэ гэрээн дээр өөр гэдгийг хоёр янзын Грек үгээр хэлсэн байдаг. Тэдгээр нь *heteros* ба *allos* юм. *Heteros* нь “өөр нэг төрөл” гэсэн утгатай. Харин *allos* нь “ижил нэгэн төрөл” гэсэн утгатай. Есүс алийг нь хэрэглэсэн бэ?

Хариулахаасаа өмнө дээрх хоёр үгийг жишээгээр тайлбарлая. Жишээлбэл: танд нэг алим байв. Таныг алимаа идсэний дараа би танаас “өөр жимс идэх үү?” гэж асуув.

Таныг зөвшөөрөхөд, хэрэв би танд бас л жимс мөн боловч өөр төрлийн жимс буюу жүрж өгнө. Жүрж жимс мөн боловч, алимаас *өөр төрөл* юм. Энэ бол *heteros*.

Харин би танд дахиад нэг алим өгбөл би танд *ижил төрлийг* өгсөн болно. Энэ бол *allos*.

Тэгэхээр гол асуултдаа орьё. Есүс “Аав маань “өөр” Туслахыг илгээнэ” гэхдээ алийг нь хэрэглэсэн бэ? Тэрбээр *allos* гэдэг үгийг хэрэглэсэн. Тиймээс Есүс “Аав минь яг Над шиг өөр нэгэн Туслахыг илгээнэ” гэж хэлсэн юм. Өөрөөр хэлбэл Тэрбээр Ариун Сүнс Бид хоёр нэг төрөл гэжээ.

Тавдугаар өдөр

Насан туршийн маань хамтрагч

Иохан 14:16 дээр Есүсийн хэрэглэсэн өөр нэг үг нь *Туслах* юм. Үүнийг Грекээр *parakletos* гэдэг. Иоханы захидал дээр Есүсийг мөн *parakletos* гэсэн: “Бяцхан хүүхдүүд минь, та нарыг нүгэл бүү үйлдээсэй хэмээн би эдгээрийг та нарт бичиж байна. Хэрэв хэн нэгэн нь нүгэл үйлдвэл, Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй [*parakletos*] агаад тэр бол зөвт Есүс Христ мөн.” (1Иохан 2:1). Есүс ч, Ариун Сүнс ч *parakletos*-ын үүрэг гүйцэтгэдэг. Тэгвэл энэ Грек үг нь ямар утгатай вэ? Тухайн үед хүний хэрэг заргыг өмгөөлдөг хүнийг ингэж нэрлэдэг байж. Мөн хувийн зөвлөх, дасгалжуулагчийг ийнхүү нэрлэнэ.

Parakletos нь *para, kaleo* гэдэг хоёр үгээс бүтжээ. *Para* нь “маш

ойр” гэсэн утгатай. Паул Тимоттой тогтоосон харилцаагаа энэ үгээр дүрслэсэн (Филиппой 2:20-ы унш). Миний хувьд Лиза бид хоёр *para*. Учир нь энэ дэлхий дээр надад түүнээс дотно хүн байхгүй.

Kaleo хэмээх үг нь “дуудах” гэсэн утгатай. Элч нар дуудлагынхаа талаар ярихдаа энэ үгийг байнга хэрэглэдэг. Жишээлбэл Паул “Би харь үндэстэнүүдэд элч байхаар *дуудагдсан*” гэхдээ *kaleo* гэдэг Грек үгийг хэрэглэжээ. “Дуудлага” гэдэг ойлголт нь хувь тавилан ба үйлдлийг санагдуулна.

Энэ хоёр үгийг нийлүүлбэл Есүсийн хэлсэн үг хамаагүй тодорхой болно. *Тэрбээр Ариун Сүнс насан турш бидэнтэй хамгийн ойр байж, дасгалжуулж, чиглүүлж, зааварлахаар дуудагдсан гэдгийг л айлджээ.* Энэ бол Ариун Сүнсний дуудлага, даалгавар бөгөөд Тэр хэзээ ч эцэж цуцахгүйгээр бидний аялалд туслана! Ариун Сүнс мөнхөд бидний дотор байна гэж Есүс амласан (Иохан 14:16). Тэр биднийг хэзээ ч хаяж орхихгүй. Энэ бол гайхамшигтай амлалт! Эцэст нь Есүс Ариун Сүнс бидний амьдралд хийх Түүний (Есүсийн) ажил үүргийг залгамжлан хийнэ гэдгийг хэлжээ.

Хүмүүс “Есүстэй хамт байсан бол...” гэж ярьдаг. Яагаад Ариун Сүнстэй хамт байж, Түүнээс асууж лавлаж болохгүй гэж? Хэрэв бид Ариун Сүнсийг ойшоохгүй бол заавар, зөвлөгөө авахаар Түүнд хандахгүй. Тиймээс бидний ойлголтоос маш их зүйл шалтгаална. Хэрэв бид Түүний талаар айлдсан Бурхан Үгт үнэхээр итгэбэл, бидэнд заах, туслах, дасгалжуулах чадалтай, бүхнийг мэддэг чаддаг, хамгаас хүчирхэг Түүнд л хандана. Тэр бидэнтэй ярихыг үнэхээр их хүсдэг.

Харамсалтай нь Чуулган Ариун Сүнсэнд хамгийн бага анхаардаг. Бид магтан хүндэтгэхдээ Түүнийг умартаж орхих нь даанч их. “Биднийг хэзээ ч орхихгүй хамт байж, хамт алхахаар дуудагдсан Нэгэнтэй бид өглөөнөөс шөнө хүртэл хэдэн удаа үг сольдог билээ?”

Иохан 16:7 дээр Есүс нэг айхтар зүйл хэлжээ: “Харин Би та нарт үнэнийг хэлж байна ...”

Цааш үргэлжлүүлэхээсээ өмнө цөмөөрөө нэгэн зүйлийг төсөөлье. Есүс 3 жил хамт байсан дагалдагч нартаа хэлсэн. Есүсийн хэлсэн бүхэн биелсэн. Тэрбээр салхинд “намд” гэхэд салхи намдсан. “Тэндээс нэг илжиг олно” гэхэд нь илжиг олдсон. Урвагч илчлэгдэхээс ч өмнө багт нь урвагч байгааг Есүс мэдсэн. Инжрийн модонд үхэхийг тушаахад, тэр мод ганц хоногийн дотор хувхайрсан. Есүсийн хэлсэн бүхэн биелсэн. Тийм боловч Есүс одоо нэгэн чухал мэдэгдэл хийхээр “Харин Би та нарт үнэнийг хэлж байна” хэмээн байж хэлжээ. Үндсэндээ Түүний хэлэх гэж буй зүйл нь дагалдагч нарыг нь сочирдуулах учиртай байв.

Тэгэхээр Есүс юу хэлээ юм бол? “Харин Би та нарт үнэнийг хэлж байна. Миний явах нь та нарт хэрэгтэй. Хэрэв Би явахгүй бол Туслагч [*parakletos*] та нар уруу ирэхгүй. Харин Би явбал Өөрөө Түүнийг та нар уруу илгээнэ” (Иохан 16:7).

Дагалдагч нарын оронд өөрийгөө тавиад үз. Бурханы Хүү болох удирдагч тань удахгүй таныг орхиж явах болсон тухайгаа дуулгаад, ингэх нь танд л ашигтай гэж хэлэв. Миний бодлоор энэ ёстой солиотой үг. Тэр Бурханы Хүү юм чинь, тантай хамт л байвал дээр биз дээ? Дагалдагч нар ч ингэж бодсон гэдэгт эргэлзэхгүй байна. Магадгүй иймээс л Есүс мэдэгдэл хийхээсээ өмнө “Би үнэхээр үнэнийг хэлж байна шүү” гэж эхэлсэн байх.

Тэгвэл дагалдагч нарын хувьд болон бидний хувьд Есүс явах нь яагаад ашигтай байв? Бодоод үз. Хэрэв Есүс яваагүй бол Ариун Сүнс хэзээ ч бидэн дээр ирэхгүй байсан. Хэрэв би Есүсээс ямар нэг зүйл хүсбэл, хэдэн мянган бээрийг туулж байж л очиж уулзана. Аялал маань Тель-Авив руу (дэлхийн хамгийн хөл хөдөлгөөнтэй нисэх буудал болох байх) нисэхээс эхлэх байх. Тэгээд Галил руу машин хөлсөлж явахдаа, гайгүй хоосон өрөө таараасай гэж горьдоно байх (зочид буудал ч пиг байх нь тодорхой). Дараа нь Есүсийг олно. Энэ ч тийм хэцүү биш байх. Учир нь сая сая хүн түүнтэй уулзахаар хүлээж байна. Тэгээд Түүнийг олоод хүмүүсийн хөвөө хязгаар нь үзэгдэшгүй урт дараалалд алдрах байх.

Урт дараалалтай учраас Түүнтэй 60 секундээс илүү

уулзуулахгүй байх. Тиймээс урьдаас бэлтгэсэн хүсэлт гуйлтаа гялс манс танилцуулна. Тэр бас унтаж идэх шаардлагатай учраас өдөрт 14 цагаас илүү ажиллаж чадахгүй. Хэрэв нэг хүнтэй 60 секунд уулзана гэвэл өдөрт 840 хүнтэй уулзана. Тиймээс Есүс 1 сая хүнтэй уулзахын тулд 1190 өдөр буюу 3.26 жил зарцуулна. Гэхдээ дараалалд шинэ хүмүүс тасралтгүй нэгдсээр байна гэдгийг бүү мартаарай. Тэгээд магадгүй яаралтай хэрэгцээ, хүсэлттэй хүмүүс урдуур дайрахаас өөр аргагүй бол яах вэ? Ингэж бодвол Есүстэй уулзах бараг боломжгүй гэлтэй.

Гэтэл Ариун Сүнс бидэнтэй үргэлж хамт байдаг нь хамгийн сайхан мэдээ юм. Тэр идэхгүй, унтахгүй. Тэр нэгэн зэрэг хэдэн тэрбум хүнтэй харилцаж, асуудлыг нь шийдэж чадна. Бурханы Үгээр Ариун Сүнсний талаарх бодлоо эрс тэс өөрчлүүлбэл, Есүсийн “Би явах нь та нарт ашигтай” гэсэн үгийн утгыг ухаарна.

Ариун Сүнс Есүстэй адилхан гэдгийг санана уу: Тэр Есүс шиг заадаг, Бурханы юмсыг Есүс шиг тайлбарладаг, Тэр бидэнтэй хамт байдаг. Тэр ямар гайхамшигтай болохыг одоо харж байна уу? Үүнийг бичиж байхад хүртэл би Түүний дуу хоолой оршихуйг амьдралдаа хичнээн хязгаарлаж байсныг Ариун Сүнс надад харуулсаар байна. Тэр бол бидний хөтөч, зөвлөх, хамгаалагч, дасгалжуулагч- бид Түүнийг амьдралдаа байнга оролцуулах ёстой!

Удаах бүлгээр бид гайхамшигт Бурхантай ойр дотно байхыг сурна.

СҮНСИЙГ ТАНИН МЭДЭХҮЙ

Би Эцэгээсээ гуйхад, Тэр та нарт өөр Туслалчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна. 17Тэр бол үнэний Сүнс мөн бөгөөд Түүнийг харахгүй, мэдэхгүйгээсээ болж, ертөнц Түүнийг хүлээж авч чадахгүй. Харин та нар Түүнийг мэднэ. Яагаад гэвэл Тэр та нартай хамт үргэлж байх бөгөөд та нарын дотор байна.

Иохан 14:16-17

Ариун Сүнс үнэхээр гайхамшигтай! Түүнийг Христээр дамжин хүлээж авсан авралын дараах гайхамшиг гэж болно. Ариун Сүнс гэж хэн бэ? Нэрт пастор, шилдэг зохиолч Эй. Даблю. Тозер ийн хэлжээ...

“Ариун Сүнс бол эрч хүч биш, Хувь Нэгэн юм. Ариун Сүнс бол тодорхой нэг төлвөөр оршдог оршмол биет биш, харин бүх шинж чанар, хүч чадал, зан чанарыг шингээсэн Хувь Нэгэн гэдгийг том үсгээр тэмдэглэж ав. Тэр хийсвэр юм биш, бодитой Нэгэн... Ариун Сүнс яг л хувь хүн шиг хүсэлтэй, ухаантай, мэдлэгтэй, таалалтай, хайрлах харах, бодох сонсох чадвартай.”

Судлалаа эхлэхээсээ өмнө дараах асуултад хариулна уу. Та урьд нь Ариун Сүнсийг Хэн гэж боддог байсан бэ? Түүний талаарх таны бодлыг энэ бүлэг хэрхэн задалсан бэ?

Бичээс дээр тэмдэглэсэн Түүний нэрсийг нэг бүрчлэн тунгааж бод (4-р өдөр нүүр). Эдгээр нэр Түүний талаар танд юу хэлж байна?

Ариун Сүнс Аав, Хүү хоёртой эн тэгш Хувь Нэгэн гэдгийг мэдэх нь Бурхантай эрүүл саруул харилцаа тогтооход нэн чухал. Тозер цааш нь ийн хэлжээ:

“... Хүү хэн буй- Ариун Сүнс тийм буй. Аав хэн буй- Ариун Сүнс тийм буй бөгөөд Ариун Сүнс Түүний чуулганд оршино. Бид Түүнийг ямар гэж боддог вэ? Тэр яг Есүс шиг. Та Есүсийг ямар болохыг Шинэ гэрээнээс мэдсэн. Тэгвэл Ариун Сүнс яг Есүс шиг. Учир нь Есүс- Бурхан, Ариун Сүнс ч Бурхан болой. Мөн Аав нь ч яг Хүүтэйгээ адилхан. Та Аавыг нь хараад л Есүсийг ямар болохыг нь мэднэ. Мөн Есүсийг хараад Ариун Сүнс ямар болохыг нь мэднэ.”

Одоо Ариун Сүнсийг арай өөрөөр харж байна уу? Түүнийг олон талаас нь ухаарч ойлгосон бол, цаашид Түүнийг яаж амьдралынхаа тал бүрт урьж оролцуулья гэж бодож байна?

Дэлгэрэнгүй судлахыг хүсбэл:

Иохан 12:44-45; 2Коринт 4:4; Колоссай 1:15-19; Еврей 1:3.

Хоёрдугаар өдрийн чимээгүй цаг

ТЭР “ХЭН НЭГЭН ЭТГЭЭД” БИШ, ТЭР БОЛ БУРХАН

*Эзэн бол Сүнс мөн. Эзэний Сүнс хаана байна,
тэнд эрх чөлөө байдаг.
2Коринт 3:17*

Та нар бол хөвгүүд нь мөн тул, Бурхан Өөрийн Хүүгийн Сүнсийг бидний зүрхэнд илгээсэн байна. Тэр Сүнс “Аав, Эцэг” гэж дууддаг (Галат 4:6). Бурханы Сүнс бол сансраар шумбадаг үл тайлагдах хүч биш юм. Бурханы Ариун Сүнс бүхлээрээ бүрнээрээ Түүний дотор оршдог.

Арван есдүгээр зууны үйлчлэгч, 200 гаруй номын зохиолч **Эндрю Мюррэй** Ариун Сүнсийг “Аав, Хүү хоёртой хамт оршиж, Бурханы алдрыг бүрэн төгс илчилдэг Нэгэн” гэсэн:

“Хуучин гэрээнд Бурханы амласан бүхнийг, Есүсийн тэнгэрлэг нигүүлсэлээр бидэнд илэрч өгөгдсөн бүхнийг өдгөө Ариун Сүнс бидний амьдралд биелэл болгож байна.”

Бурханы амлалт бүр Ариун Сүнсээр дамжин бидний эзэмшил, туршлага болон биелж байна. Энэ бол ганц хүний санал биш, харин Бичээсийн үнэн болой. Дараах хэсгийг анхааралтай уншаад тунгаан бод.

Бидний Эзэн Есүс Христийн Эцэг ба Бурхан магтагдах болтугай. Тэрээр Христ дотор тэнгэрлэг газар дахь алив сүнслэг ерөөлөөр биднийг ерөөсөн. (Ефес 1:3)

Өөрийнхөө алдар ба давуу чанараар биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжуулан Түүний бурханлаг хүч бидэнд амь болоод сүсэглэлд хамаатай бүхнийг соёрхсон. (2Петр 1:3)

Гэвч “Нүдэнд үзэгдээгүй, чихэнд сонсогдоогүй, хүний санаанд ороогүй юмсыг Бурхан Өөрийг нь хайрладаг хүмүүст бэлджээ” гэж бичигдсэн ёсоор болжээ. Гэвч Бурхан үүнийг Сүнсээр бидэнд илчилсэн юм. Учир нь Сүнс бүх зүйлийг, тэр байтугай Бурханы гүн юмсыг ч гэсэн нэвтэлдэг ажгуу. (1Коринт 2:9-10)

Эдгээр ишлэлээс та Ариун Сүнсний талаар юу мэдэж авав?

Түүний талаарх хагас дутуу ойлголтоосоо болж та амьдралдаа Ариун Сүнсний оршихуй ба хүчийг хязгаарлаж байна уу? Тэгвэл яг одоо зогсоод, ямар бодлоо өөрчлөх ёстойг Түүнээс асууж залбир. Түүний илчилж өгсөн зүйлийг бичнэ үү.

Дэлгэрэнгүй судлахыг хүсбэл:

1Коринт 12:4-11; Галат 5:5; 2Тесалоник 2:13

Гуравдугаар өдрийн чимээгүй цаг

ТЭР БОЛ АМИЙН СҮНС

*Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг
нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ.*

Ром 8:2

Ариун Сүнс бол амийн Сүнс! Амь амьдрал гэдэг бүх зүйл. Үүнд эрүүл мэнд, өсөлт, шинэ соргог байдал, эрч хүч, тэнхээ тамир бүгд зэрэг бүх тал багтана. Амийн Сүнс дотор үхлийн сүүдэр ч байхгүй-өвчин, доройтол, ядаргаа, ялзрал- эдгээрийн аль нь ч байхгүй.

Бүтээлд амийн Сүнс гар бие оролцсон бөгөөд дэлхий өнцөг булан тохой бүрийг үлээж амилуулсан. Олон улсын илгээлтийн эзэн, сайн мэдээ дэлгэрүүлэгч **Лестер Сумраль** ч үүнийг батлан хэлжээ:

“Бичээс дээр Ариун Сүнсний үйл ажлыг анх Эхлэл 1:2 дээр бичжээ. Библийн эхний хуудас, хоёрдугаар ишлэл Ариун Сүнсний үйл ажлыг харуулсан нь тун онцгой юм. ... Тэрбээр ямар ч эмх цэгцгүй бөөнөөс сансар огторгуй, гоо үзэсгэлэн, хайр булаам байдлыг төрүүлсэн. Газар дэлхий хэлбэр дүрсгүй, хувхай хоосон байжээ. Бурхан шилмэл зүйлийг бүтээсэн, Ариун Сүнс Түүнд тусласан. Бурханы Сүнс усны гадаргуу дээгүүр хөдлөхөд, эмх цэгцгүй байдлаас амьдрал мэндэлжээ.”

Амьдралын Сүнснийг ажиллуулж, гоо үзэсгэлэн, эмх журам, эрх чөлөө авчруулах хэрэгтэй, эмх цэгцгүй тал танд байна уу? Мэдэхгүй байгаа бол Түүнээс асууж лавла. Тэгээд энэ бүх талаа залбирлаараа Ариун Сүнсэнд өргөж, бүтээлийн үеийнх шиг таны амьдралд ч бас эмх цэгц тогтоохыг гуй.

Өдөр тутмын амьдралын хэмнэл, завгүй байдал таныг ядрааж байна үү? Амийн Сүнс таныг хүчээрээ сэлбэхийг хүсч байна. Түүнтэй хамт байж, таньж мэдэх үед Тэр таныг хүчирхэгжүүлнэ. Цаг гарган, Бурханы хүчирхэг амлалтыг тунгаан бод:

Чи мэдэхгүй гэж үү? Чи сонсоогүй гэж үү? Мөнхийн Бурхан болох ЭЗЭН дэлхийн хязгаарыг Бүтээгч нь эцэж туйлдаагүй юм. Түүний ухаан нь хязгааргүй. Тэр ядарсанд тэнхээ өгч, чадал дутагдсанд нь хүч нэмдэг. (Исаиа 40:28-29)

Мөн үхэгсдээс Есүсийг амилуулсан Нэгэний Сүнс та нарын дотор оршвоос, Христ Есүсийг үхэгсдээс амилуулсан Тэр та нарын дотор оршдог Өөрийн Сүнсээр дамжуулан үхлийн биест чинь амь өгнө.
(Ром 8:11)

Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна. (Филиппой 4:13)

Эдгээр ишлэлээр Ариун Сүнс танд юу хэлж байна? Таныг дотоод хүчээр сэлгэж, Есүс газар дээр аж төрж байсан шиг л “амьд” болгохыг Амийн Сүнснээс хүссэн залбирал бич.

Дэлгэрэнгүй судлах хүсбэл: Эхлэл 1:2; Нехемиа 9:6; Исаиа 40:12-15; Дуулал 8:3-9; 104:24-30; Иов 33:4

Дөрөвдүгээр өдрийн чимээгүй цаг

БИД ТҮҮНЭЭС БҮРЭН ХАМААРАХ ЁСТОЙ

*“Хүч чадлаар ч бус, эрх мэдлээр ч бус, харин Миний Сүнсээр”
гээж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна.*

Зехариа 4:6

Бурханы Хүү Есүс Христ Ариун Сүнснээс бүрэн хамааралтай байсан. Түүний үзэл бодлоос авахуулаад, үхлээс амилах амилалт хүртэл- Түүний бүх зүйл Ариун Сүнсний үйлс байв.

Тэрбээр Сүнсээр олдсон — Матай 1:20; Лук 1:31-35

Сүнсэнд хөтлүүлсэн — Матай 4:1; Лук 4:1

Сүнсээр хүчирхэгжсэн — Лук 4:14, 18-19; Иохан 3:34

Сүнсээр сургагдаж, үгэнд нь орсон — Иохан 5:19-20, 30; 14:10

Есүс тэдэнд хандан хэлжээ:

—Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Эцэгийнхээ хийдгийг Хүү нь үзэхгүй бол Хүү Өөрөөсөө юуг ч хийж чадахгүй. Учир нь Эцэг юу хийнэ, Хүү нь бас эдгээр зүйлийг түүнчлэн хийдэг. Эцэг Хүүгээ хайрладаг бөгөөд Тэр Өөрийн хийж байгаа бүхнийг Түүнд үзүүлдэг. Та нарыг гайхуулахын тулд тэдгээрээс ч агуу ажлуудыг Тэр Түүнд үзүүлнэ ... Би Өөрийн санаагаар юуг ч үйлдэж чадахгүй. Би сонссоноороо шүүх бөгөөд Миний шүүлт шударга. Учир нь Би Өөрийнхөө хүслийг бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг.
Иохан 5:19-20,30

Ариун Сүнснээс бүрэн хамааралтай болохоо тунхагласан Есүсийн дээрх үгийг сайтар тунгаан бод. Есүс, Ариун Сүнс хоёрын харилцааны талаар энэ ишлэл танд юу зааж байна? Та нэгийг ухаарч, ямар нэгэн шийдэлд хүрэв үү?

Үйлс 5:32; Ром 8:16; Галат 4:16; 1Иохан 3:24; 4:13. Энд Ариун Сүнтэй тогтоох бидний харилцааны талаар ямар хоёр үнэнийг хэлсэн байна?

Галат чуулгантай адил бид ч бас Ариун Сүнс бидэнд ямар их хэрэгтэй болохыг мартдаг. Галат 3:2-9, Лук 11:13-г унш. Эндээс бид Ариун Сүнтэй тасралтгүй харилцах талаар юу сурах вэ?

ТЭР ТАНЫ МӨНХИЙН НАЙЗ!

Би Эцэгээсээ гуйхад, Тэр та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна. Тэр бол үнэний Сүнс мөн бөгөөд Түүнийг харахгүй, мэдэхгүйгээсээ болж, ертөнц Түүнийг хүлээж авч чадахгүй. Харин та нар Түүнийг мэднэ. Яагаад гэвэл Тэр та нартай хамт үргэлж байх бөгөөд та нарын дотор байна.

Иохан 14:16-17

Ариун Сүнс таны хамгийн сайн найз байхыг хүснэ. Тэр таны дэргэд долоо хоногийн 24 цаг байхыг хүсдэг. “Эсвэл ямар ч зорилгогүйгээр Сударт “Түүний бидний дотор нутаглуулсан сүнс нь атаархан хүсдэг” хэмээсэн гэж та нар бодож байна уу?” (Иаков 4:5)

Ариун Сүнстэй тогтоох жинхэнэ харилцааг юугаар ч үнэлэшгүй. Түүний оршихуй, хүч юугаар ч нөхөшгүй мөнхийн бүрэн дүүрэн байдлыг авчирдаг. Ариун Сүнсний талаар Есүс “Харин өөрт нь Миний өгөх уснаас уугч хэн ч хэзээ ч цангахгүй. Харин Миний өгөх ус тэр хүний дотор мөнх аминд хүртэл оргилох булаг болно” хэмээн айлдсан (Иохан 4:14). Энэ ишлэлийн тухайд сайн мэдээ дэлгэрүүлэгч, боловсролын ажилтан Ар. Эй. Торрэй ийнхүү хэлжээ:

“Ус гэж Ариун Сүнсийг хэлж буй. Энэ дэлхий хэзээ ч ханахгүй. Дэлхийн зугаа цэнгэл нь “энэ усыг уусан хүн дахиад л цангана” гэсэнтэй адил. Сүнсний хоосролыг зөвхөн Ариун Сүнс л хангана. Ганцхан Ариун Сүнс л хүний зүрхийг хангана.

Ариун Сүнсний урсгалд нээгдэж, Түүнийг зүрхэндээ оргилуулбал та хэзээ ч цангахгүй. Тэр шавхашгүй баяр хөөр, дүрслэшгүй ханамжийнхаа амийн усыг хүмүүсийн сүнсэнд юүлдэг. Энэ амийн булаг таны дотор бий юу? Булаг тань ундарсаар, мөнхийн амийг авчирсаар байна уу?”

Торрэй асуулыг бодож үз: “Миний дотор энэ амийн булаг байна

уу? Би Сүнсний юугаар ч дүрслэшгүй бүрэн дүүрэн ханамжийг мэдэрч байна уу? Мэдрэхгүй байгаа бол яагаад тэр вэ?” Ариун Сүнс тэй дотно нөхөрлөж, энэ булгийг дотроо байлгахын төлөө юу хийхийг Түүнээс асуугаад, илчилсэн зүйлийг нь бич.

Эзэний (Ариун Сүнс) өмнө чимээгүй бай. Танд Өөрийгөө урьд өмнө хэзээ ч илчлээгүйгээрээ илчлэхийг хүс. Хайр, тэвэр, амар тайвнаа таны дээр юүлэхийг гүй. Битгий яар. Чимээгүй байж, Түүнийг Бурхан гэдгийг мэд. Түүний хэлсэн зүйлийг бич.

Ариун Сүнсний өмнө өөрөөрөө бай. Тэр таныг дотор гадаргүй мэднэ. Та өөрийгөө олж чадахгүй байсан ч, Тэр таныг хаа явааг хэлж чадна. Таныг хүчирхэгжүүлж, урамшуулж, хөтлөхөөр Тэр таны дотор оршин буй. Түүн рүү хэзээ ч хаана ч очиж болно. Тэр таныг тээршаахгүй, та Түүнийг залхаахгүй. Тэр таны хамгийн сайн найз!

Залбирал: Ариун Сүнс минь, Таны талаарх бодлыг минь орвонгоор нь өөрчлөөч. Надад Өөрийгөө тайлж, миний Туслах гэдгээ ойлгуулж өгөөч. Таны оршихуй, хүч, дуу хоолойг дахиж хэзээ ч хязгаарлаж боогдуулахгүй байхад минь туслаач. Би өөрийнхөө төлөө, гэр бүлийнхээ төлөө, Таны Чуулганы төлөө залбирч байна. Есүсийн нэрээр. Амень.

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

- 1 | Ариун Сүнс үгүй бол бидний итгэлийн амьдрал хуурай, уйтай, хүчгүй болно. Тэгвэл Ариун Сүнстэй амьдрал ямар байх вэ? Аль болох олон эерэг үзүүлэлтийг нэрлэ.

*Эзэн бол Сүнс мөн. Эзэний Сүнс хаана байна,
тэнд эрх чөлөө байдаг.*

2Коринт 3:17

- 2 | Ариун Сүнс бол тэнгэрлэг, нууцлаг хүч юмуу “юм” биш. Тэрбээр Бурханы Гурвалын Нэг бөгөөд Бурхан Аав, Хүү хоёрын төгс чанарыг бүгдийг нь тээдэг. Ариун Сүнсийг “юм” мэтээр ташаа ойлгох нь ямар хор хөнөөлтэй вэ? Түүнийг жинхэнэ Бурхан гэж харах нь ямар сайн үр дагавартай вэ?

- 3 | Анхны итгэгч хүмүүсийн амьдралд Ариун Сүнс маш идэвхитэй оролцдог байсан. Харин одоо бол ховордсон. Бид Ариун Сүнсний хүчирхэг удирдамж, нөлөөнд дурлаж, эрэлхийлж, найдахаас цааргалдаг болсон нь ямар шалтгаантай гэж та бодож байна?

- 4 | Есүс яг одоо хаана байгаа вэ? Итгэгч хүмүүсийн зүрхэнд байгаа юу? Авралын үйл ажиллагааг болон Бурхан таны зүрхэнд яаж амьдардгийг яаж тодорхой тайлбарлах вэ?

Удирдагч нарт: Сануулах үүднээс ангиараа дараах ишлэлийг уншаарай: Марк 16:19; Үйлс 1:9-11; 7:55-56; Ром 8:34; Колоссай 3:1; Еврей 10:12-13 ишлэлийг эхний хэдэн асуултад харин Ром 8:9-10; 1Коринт 3:16; 6:19; 1Иохан 3:24 ишлэлийг бусад асуултад хариулахын тулд уншаарай.

Есүс

—Хэрэв хэн нэг нь Намайг хайрлавал, тэр хүн Миний үгийг сахина. Миний Эцэг түүнийг хайрлана. Бид тэр хүн уруу очиж, түүнтэй хамт Өөрсдийн орон байраа байгуулна.

Иохан 14:23

- 5 | Бидний Бурхан Эзэн нэг боловч Аав, Хүү, Ариун Сүнс гэсэн гурван онцгой Дүртэй. Бурханы Гурвалын Дүр тус бүрийн онцгой үүргийг болон Бурханы хүслийг биелүүлэхийн тулд тэд яаж хамтарч ажиллагдийг дүрслэн тайлбарла.

Удирдагч нарт: Сануулах үүднээс ангиараа дараах ишлэлийг уншаарай: 1Коринт 12:5-7; мөн Эхлэл 1 дээрх бүтээлийн тухай тэмдэглэл болон Иохан 5:17, 19-20 уншина уу.

Бурхан Аавын Сүнс=Христийн Сүнс=Ариун Сүнс

- 6 | Есүс Ариун Сүнсийг бидний Туслах буюу parakletos хэмээсэн. Энэ нь “Тэрбээр бидэнтэй дандаа хамт байж, өдөр бүр Бурхантай хамт алхахад маань дасгалжуулж, зөвлөхөөр дуудагдсан” гэсэн утгатай.
- 7 | Та Ариун Сүнсний талаар ямар нэгэн цоо шинэ зүйл мэдэж авсан уу? Түүнийг харах нүд чинь нээгдэж, Түүний талаарх ойлголт чинь задрал уу?

ТЭМДЭГЛЭЛ

Бүлгийн дүгнэлт:

- Ариун Сүнс бол Бурхан Аав, Хүү хоёрын төгс чанарыг бүрэн шингээсэн Бурханы Гурвалын гишүүн.
- Тэр нууцлаг хүч юмуу “юм” биш. Тэр бол Бурхан.
- Тэрбээр цаг, орон зайд баригдахгүй. Тэр нэгэн зэрэг хичнээн ч хүнтэй харилцаж, туслаж чадна.
- Тэрбээр анхны итгэгч нарын амьдралын салшгүй хэсэг байсан бөгөөд өнөөдөр ч бидний амьдралд зайлшгүй оролцохыг хүсдэг.
- Түүнгүйгээр Христэд итгэх итгэлийн амьдрал гэж байхгүй. Харин Түүнтэй дотно нөхөрлөсөн хүмүүс адал явдлаар бүрэн дүүрэн амьдарна.
- Түүнийг таньж мэд!

 2

АРИУН СҮНСНИЙ ЗАН ЧАНАР

Эзэн Есүс Христийн нигүүлсэл, Бурханы хайр, Ариун Сүнсний нөхөрлөл та бүгдтэй хамт байх болтугай.

2Коринт 13:13

Нэгдүгээр өдөр

Хэн нэгэнтэй дотно харилцаа тогтоохын тулд тэр хүнийг таньж мэдэх шаардлагатай. Хүний дуртай дургүй зүйлс, зорилго хүсэл, амбицийг мэдэх нь түүнтэй дотно нөхөрлөхөд тустай байдаг. Үүнтэй адилхан Ариун Сүнсгүй дотно нөхөрлөхийн тулд Түүнийг таньж мэдэх хэрэгтэй.

Есүс нэгэн сочирдмоор мэдэгдэл хийснийг бид өмнөх бүлгээр үзсэн: “Харин Би та нарт үнэнийг хэлж байна. Миний явах нь та нарт хэрэгтэй. Хэрэв Би явахгүй бол Туслагч та нар уруу ирэхгүй. Харин Би явбал Өөрөө Түүнийг та нар уруу илгээнэ.” (Иохан 16:7). Матай 13:35 дээр “Би сургаалт зүйрлэлээр ам нээнэ. Би дэлхийн сууриас эхлэн нууцлагдсан зүйлсийг хэлэх болно” гэж хэлсэн тэр Есүс л дээрх үгийг хэлсэн юм. Дэлхий бүтээгдсэн цагаас далд байсан нууцыг илчилсэн, дэлхий дээрх хамгийн шилдэг багш - Есүс “Тэр биш, харин Бурханы Сүнс тэдэнд болон тэдний залгамж үеийнхэн болох бидэнд хамгийн сайн түнш болно” гэдгийг дагалдагч нартаа ойлгуулахыг хичээжээ. Гайхалтай! Таны хувьд мэдэхгүй, харин миний хувьд Ариун Сүнсийг улам илүү мэдмээр болж байна.

2Коринт 13:13-с эхэлье. Паул ийн хэлжээ:

Эзэн Есүс Христийн нигүүлсэл, Бурханы хайр, Ариун Сүнсний нөхөрлөл та бүгдтэй хамт байх болтугай.

Паул Бурханы Гурвалын тус бүрийнх нь онцгой чанарыг цохон тэмдэглэжээ. Тэрбээр “Эзэн Есүс Христийн нигүүлсэл...” хэмээн эхэлсэн. Аврагч Эзэн Есүс Христийн маань нигүүлсэл л итгэгч бидэнд Бурхантай харилцах (энэ нь Ариун Сүнстэй тогтоох харилцааны маань тулгын чулуу) эрх олгосон гэдгийг бид мартаж болохгүй. Энэ нигүүлсэлийг юугаар ч олж авахгүй. Энэ нь уучлал, золилт, хүчийг багтаасан Түүний амийн аугаа бэлэг юм.

Паул цааш нь: “... Бурханы хайр ...” гэсэн. Би 4 хүүгийнхээ талаар бодохоор л тэдэнд ямар их хайртайгаа мэдэрч, амьдралаа тэдэнгүйгээр төсөөлж ч чаддаггүй. Гэтэл цорын ганц үрээ дайсандаа өгөх шиг ийм аймшигтай зүйлийг би зүгээр төсөөлж ч зүрхлэхгүй. Харин Бурхан “Учир нь хэрэв бид дайснууд байхдаа Хүүгийнх нь үхлээр Бурхантай эвлэрүүлэгдсэн юм бол, тэр тусмаа бид Түүний амиар аврагдах болно” хэмээжээ (Ром 5:10). Юутай аймшигтай, гайхамшигтай хайр вэ! Бурхан Аав таныг ингэж хайрладаг та баярлахгүй байна уу? Түүний дайсан байсан та өдгөө Түүний хүүхэд болжээ. Тиймээс Тэр таныг “төрсөн үр” шигээ хайрлахгүй байж чадна гэж үү?

Би хүүхдүүдээ хамаг байдгаараа хайрладаг ч, энэ маань биднийг хайрлах Бурханы хайрын хаа ч хүрэхгүй. Түүний Үг “Учир нь үхэл ч, амь ч, тэнгэр элч нар ч, эрх баригчид ч, өнөөгийн юмс ч, ирэх юмс ч, хүч ч, өндөр ч, гүн ч, өөр ямар ч бүтээл бидний Эзэн Христ Есүсийн доторх Бурханы хайраас биднийг салгаж чадахгүй гэж би бат итгэлтэй байна.” хэмээн мэдэгдсэн (Ром 8:38-39). Ямар гайхалтай амлалт вэ! Аав та хоёрыг юу ч салгахгүй гэсэнд та талархахгүй гэж үү?

Харин одоо 2Коринтын 13:14-н үлдсэн хэсгийг үзье (энэ бол Коринтод хэлсэн Паулын сүүлийн захидал гэдгийг санаарай). Энэ бол цэц ухаан, илчлэлээр дүүрэн ном (үнэндээ бол захидал). Ариун Сүнсэнд хөтлүүлсэн Паул энэ захидлаа юугаар дүгнэсэн бэ? “Ариун Сүнсний нөхөрлөл та бүхэнтэй байх болтугай” хэмээн төгсгөжээ. Паул *нөхөрлөл* гэдэг үгийг Ариун Сүнстэй

холбосныг тэмдэглээрэй. Би Католик чуулганд өссөн болохоор *нөхөрлөл* гэдэг үгийг сонсохоор л талх, дарс бодогддог байлаа. Гэхдээ Паул мэдээж үүнийг хэлээгүй. Тэгвэл тэр юуг хэлсэн юм бол? Грек эх сурвалжийг нь үзбэл *нөхөрлөл* гэхэд *koinonia* гэдэг үг хэрэглэжээ. Энэ нь *нөхөрлөл*, *ханьсал*, *харилцаа*, *дотносол*, *хуваалцах*, *нийтийн харилцаа*, *түншлэл*, *нэгдсэн оролцоо*, *харилцан нэгдэл* гэсэн утга илэрхийлнэ. Маш урт, хүчирхэг бичиг байна! Эдгээрийг 3 ангилъя:

- Нөхөрлөл
- Түншлэл
- Дотносол

Нөхөрлөл гэдэг нь нөхөрлөлийг хэлнэ

Нөхөрлөл гэж “нөхөрсөг харилцаа, нөхөрлөл, хуваалцахыг” хэлнэ. Дотно нөхөд ба андууд нөхөрлөдөг. Тэд өөр хоорондоо ажил амьдралаа хуваалцаж, ярилцдаг.

Би гольф тоглох дуртайгаа өмнө хэлсэн. Би гольф тоглохоор явахдаа, найз нөхөдтэйгээ явдаг. Бид тоглож байхдаа ярилцдаг. Энэ нь миний хувьд нөхөрлөх хамгийн сайхан цаг юм. Учир нь тэнд саад болох зүйл бараг байхгүй. Сургуульд байхдаа би теннис тоглодог байж билээ. Гэхдээ ганц асуудал нь теннис тоглож буй хүмүүс хоорондоо ярилцаж чаддаггүй. Гольфт хайртай байдгийн нэг шалтгаан нь би өрсөлдөгчтэйгээ ярилцаж болдог. Хаа хаанаас илүүтэй гольфийн талбай дээр л бид дотно харилцаа байгуулдаг. Энд л би “нөхөрлөдөг”. Иймээс л би гэргийгээ гольфийн талбай руу чирдэг юм. Учир нь энэ дэлхий дээр надад түүнээс илүү дотно хүн байхгүй!

Надад манай Messenger International байгууллагаас олон найз бий. Бид санаа бодол, асуудал, зорилгоо байнга хуваалцдаг. Би тэдний нөхөрлөл түншлэлд найддаг. Тэдгээр гайхалтай эрчүүд, бүсгүйчүүд байгаагүй бол өдгөө би хаа байхыг хэлж мэдэхгүй. Бидний энэ бат бөх харилцаа байгаагүй бол манай байгууллагын үйл ажиллагаа боломжгүй болно.

Элч нар Ариун Сүнстэй тогтоох нөхөрлөлдөө бүрэн төгс найдаж байсныг Бичээсээс харж болно. Үйлс номд “Үзтүгэй, эдүгээ би Иерусалим уруу Сүнсэнд захирагдан явж байхдаа ч намайг тэнд юу хүлээж байгааг мэдэхгүй. Зөвхөн хүлээс болон зовлон намайг хот бүрд хүлээж байгаа гэдгийг Ариун Сүнс надад гэрчилдэг.” гэдэг (Үйлс 20:22-23). Паул өөрийнх нь өмнө хүлээж буй зүйлийг Ариун Сүнстэй хуваалцсан. Паулыг хот бүрт зовлон, шорон хүлээж байгаа гэж Ариун Сүнс хэлээгүй. Харин Паул Сүнстэй дотно нөхөрлөдөг учраас түүнийг *хот бүрт* зовлон бэрхшээл угтахыг мэдэж байсан.

Таны хувьд яахыг би мэдэхгүй, харин хэрэв миний анд нөхөр надад “очсон газар бүрт чинь чамайг зовлон угтана” гээд байвал, миний дургүй хүрч түүн рүү нэг иймэрхүү үг чулуудах байх: “Чи чинь бодлоо өөрчилчихөө юу? Эсвэл зовлон гэхийн оронд ядаж таагүй байдал гэж хэлж болдоггүй юм уу?” Ариун Сүнс Паулыг зовно гэдэгт баярласандаа бус, харин тэр хоёр ойр дотно байсан учраас юу ч нууж хаалгүй анхааруулсан юм.

Ариун Сүнс надад ч гэсэн миний сонсохыг хүсээгүй зүйлийг хэлэх явдал цөөнгүй байдаг. Би Түүнийг бодлоо өөрчлөх байх гэж горьдсондоо энэ талаар Түүнээс ахин дахин асууж хоргоов ч, өдөр бүр мөнөөх хариултаа л сонсдог. Хэрэв бид Ариун Сүнсэнд ингэж хандаад байвал, тэр яваандаа зүгээр л чимээгүй болчихдог. Яг л “Би чамд тодорхой хэлсэн. Миний үгийг дагах эсэхээ чи өөрөө л шийд” гэж хэлэх шиг. Ариун Сүнстэй ойр байвал Тэр заримдаа таны сонсохыг ч хүсэхгүй зүйлсийг хэлнэ шүү.

Үйлс 10 дээр Петр Ариун Сүнснээс удирдамж хүлээж авсан түүх бий. Бурхан Петрг харь үндэстэнүүдийг аврах хүслээ илчилсэн үзэгдэл үзүүлжээ. 19-р ишлэлд “Петр үзэгдлийн тухай бодож байтал Сүнс түүнд, Үзэгтүн, гурван хүн чамайг хайж байна” гэжээ. Энэ 3 хүн Петрийг жинхэнэ еврей хүний хэзээ ч очдоггүй газар руу буюу харь хүний гэрт аваачихаар иржээ. Тиймээс Ариун Сүнс түүнд “Чам дээр зочид ирлээ. Чи тэдэнтэй хамт явахыг би чамд даалгаж байна” хэмээн маш тодорхой хэлсэн юм. Петр үүнийг сонсоод хөөрцөглөхгүй гэдгийг Ариун Сүнс мэдэж байсан ч, элдэв тайлбар тавилгүй шууд л заавар өгсөн.

Ариун Сүнснээс бүрэн хамааралтай байхыг сургасан өөр нэгэн жишээ Үйлс номын өмнөх бүлэгт бий. “Харин Эзэний *тэнгэр элч* Филипт, Босогтун. Иерусалимаас Газ уруу урууддаг замаар урагш яв гэлээ. (Энэ нь цөлийн зам)” (Үйлс 8:26). Энд Эзэний *тэнгэрэлч* Филипт *заавар өгч* байна. Энд Эзэний тэнгэрэлч Филипт *үзэгдээд* гээгүй, харин “Эзэний тэнгэрэлч Филипт *хэлэв*” гэжээ. Энэ хэсгийг бүх орчуулга баталдаг. Яагаад үүнийг онцлоод байна гэж үү? Энэ хэсгээс үзбэл Филип тэнгэрэлчийн дуу хоолойг хийгээд Ариун Сүнсний дуу хоолойг ялгаж чаддаг байжээ. Учир нь хожим нь “Сүнс Филипт “Сүнс Филипт хандаж, Тэр тэргийг гүйцэн оч гэв” (Үйлс 8:29) гэсэн байдаг. Филип Ариун Сүнсстэй бүр дуу хоолойг нь тэнгэрэлчийн дуу хоолойноос ялгаж чадах хэмжээнд хүртлээ тийм дотно танил байж!

Тухайлбал би гэргийгээ харахгүй ч шууд дуугаар нь танидаг. Бид хоёр пиг хүнтэй өрөөнд хоёр өөр газар байсан ч, би гэргийгээ дуугаар нь танина. Анхны итгэгч нар ийм маягаар л Ариун Сүнсний дууг таньдаг байжээ. Лук Үйлс номыг бичиж байхад Филип түүнд: “Лук минь, тэр үед надтай Сүнс яриагүй, харин тэнгэрэлч ярьсан. Харин Сүнс намайг сүйх тэрэг рүү яв гэж хэлсэн” гээд л яриад сууж байсан байх даа. Харин бид Ариун Сүнсний дуу хоолойг мэддэг билүү? Эсвэл тэр хэмжээнээс хол байна уу?

Филиппийг цөлд байхад Ариун Сүнс түүнийг нэгэн сүйх тэрэг рүү оч гэсэн. Энэ яагаад тийм чухал гэж? Учир нь сүйх тэргэнд Етиоп улсын дээрээсээ гурав дахь чухал албан тушаалтан сууж явжээ. Тэр хүн аврагдсан учраас л тэр үндэстэн даяар сайн мэдээ дэлгэрсэн юм. Хэрэв Филип Сүнсний удирдамжийг анхааралгүй өнгөрөөсөн бол маш том боломж алдагдах байжээ.

Хэдэн бүлгийн хойно Тимот, Паул, Силасын түүх гардаг:

Азид үгийг тунхаглахыг Ариун Сүнс хориглосон тул тэд Фруг болон Галатын дүүргээр дайран өнгөрч, Мусиад ирээд Битин уруу явахаар завдан байтал Есүсийн Сүнс зөвшөөрсөнгүй. (Үйлс 16:6-7)

Ариун Сүнс тэдэнд явахыг “хориглосон” гэж хэлсэнийг тэмдэглээрэй.

Анхны итгэгчид Ариун Сүнстэй ямар ойр дотно байсныг та харж байна уу? Тэгвэл бид ч бас тийм байх ёстой бус уу? Тухайн үед Чуулганы удирдагч нарт орчин цагийн технологийн хөгжил байгаагүй учраас тэр байх гэж үү? Үгүй. Ариун Сүнсний дуу хоолойг ямар ч технологи, арга барил орлохгүй. Тэд Сүнсийг тэр даруй амьдралдаа оролцуулж, Түүний оршихуйг урьж, хүндэтгэж байсан. Өнөөдөр юу ч өөрчлөгдөөгүй. Тэр л Сүнс өнөөдөр бидэнтэй ч бас мөр зэрэгцэн алхаж, нөхөрлөхийг хүсдэг.

Лиза бид хоёр хамт аж төрдөг атлаа юу ч дуугардаггүй бол яах вэ? Шал утгагүй болно. Хэн ийм амьдрал хүсэх билээ? Би гэргийдээ хайртай учраас аль болох ойр дотно байхыг л хүснэ. Би түүний аялгуу шиг сайхан дуу хоолойг сонсох дуртай. Хэрэв тэр ганц бие байсан бол, би түүнийг л эргүүлэх байсан. Орчлонгийн сайхан хүүхнүүд дундаас би Лизагаа л сонгоно. Яг үүнтэй адилхан Ариун Сүнс ч бидэнтэй ийм харилцааг л хүсдэг.

Би амьдралынхаа сүүлийн 24 жилийг зочид буудалд өнгөрөөсөн ч, хэзээ ч уйддаггүй юм. Цаг үргэлж Бурхантай хамт байхад уйдаах ч зав олдохгүй. Тэр бол миний өрөөний анд. Тиймээс би зочид буудлын өрөөнд байх цагтаа харам байдаг. “Би өрөөндөө багийнхантайгаа биш, Ариун Сүнстэй хамт ормоор байна” гэдгээ ч шулуухан хэлдэг. Намайг ташаа ойлгов. Би хүмүүстэй байх маш их дуртай! Гэхдээ би Ариун Сүнстэй хамт өнгөрөөх (нөхөрлөх) цагтаа бүр их хайртай!

Хоёрдугаар өдөр

Нөхөрлөл бол түншлэл

Koinonia нь бас *түншлэл* гэсэн утгатай үг юм. Түншлэлийн жишээг Лукын Сайн мэдээнээс харж болно: “Тэд тороо хаятал маш их хэмжээний загас баригдаж, тор нь урагдаж эхлэв. Тэд нөгөө завин дээрх бусад *нөхдөдөө* ирж туслахыг дохиод, тэд

ирж хоёр завийг дүүргэхэд тэд живж эхлэв” (Лук 5:6-7). Түншийг Грекээр өөрөөр бас *metochos* гэх бөгөөд энэ нь мөн л “түнш, нөхөр, хань, хамтрагч” гэсэн утгатай. Тэдгээр эрчүүд ажил хэргийн түншүүд байжээ. Эндээс бид сайн түншлэл нь харилцаа болон үйлдлийн аль алийг шаарддагийг мэдэж болно. Эрчүүд түншдээ дохио өгч, түншүүд нь ирж туслах үүрэгтэй байжээ. Харин одоо Шинэ гэрээний хамгийн биширмээр ишлэлийн нэгийг харъя: “Учир нь бид Бурханы хамтран зүтгэгчид бөгөөд та нар Бурханы тариалангийн талбай, Бурханы барилга мөн.” (1Коринт 3:9). Гайхмаар биш гэж үү? Би Weymouth орчуулгын хувилбарт хамгийн дуртай: “Бид Бурханы төлөө *Бурхантай хамт* ажиллах Бурханы *хамтран зүтгэгч нар*.” Бид тэнгэр газрын Бүтээгчийн төлөө Түүнтэй хамтарч ажиллах завшаантай хүмүүс”. Дэндүү гайхамшигтай урилга! Сайн түнш бие биеэсээ хамаарч, хамт хөвдөг.

Ариун Сүнстэй түншлэх нь багийн нэг гишүүн байна л гэсэн үг. Та Түүнтэй хамт ажиллах ёстой. Намайг анх удаа олны өмнө номлох үед миний гэргий хамгийн сайн найзтайгаа хамгийн эхний эгнээнд суугаад унтчихсан юм. Тэр үед би Ариун Сүнсний харилцан хамаарал, урсгалтай хамт хөвөөгүй ажээ. Нилээд цаг авсан боловч, яваандаа би номлохдоо Түүнтэй яаж хамт түншлэхийг сурсан юм. Ном бичихэд ч бас ялгаагүй. Би эхний номоо бичих гэж бүтэн жил үсээ зулгаасан боловч, Ариун Сүнстэй түншилсэний ачаар хялбар бөгөөд хурдан бичиж сурсан юм. Тэр үүрэгтэй, би ч бас үүрэгтэй. Тэр үүнийг л хүсдэг!

Үйлс 15 дээр түншлэлийн өөр нэг жишээ байна. Элч нар харь үндэстэнүүдэд захидал бичихдээ ийн хэлжээ: “Учир нь Ариун Сүнс болон бид доор бичигдсэн зайлшгүй зүйлсээс өөр илүү ачааг та нарт тохохгүй байх нь зүйтэй гэж мэдэв.” (Үйлс 15:28). Энд түншийн харилцаа харагдаж байна. Тодорхой нөхцөл байдлын талаар удирдагч нар Ариун Сүнсний ч санааг, өөрсдийнхөө ч санааг хэлсэн. Шийдвэрт хэн хэн нь оролцсон. Хоёр тал хоёулаа үүрэгтэй. Тэд хаанчлалын төлөө түншилж байна.

Хуучин гэрээнээс ч түншлэлийг жишээг харж болно. Бурхан Абрахамтай Содом, Гоморра хотын хувь заяаны талаар

хэлэлцсэнийг санаж байна уу? (Эхлэл 18) Бурхан Абрахамыг түншээ гэж үзэж байсан нь маш тодорхой байна. Бурхан Абрахамыг дагуулж, хавцал дээр гараад : “Би үнэхээр энэ хоёр хотыг арчмаар байна. Чи юу гэж бодож байна?” гэж асуужээ. Гэтэл дүү нь тэр хоёр хотын нэгэнд аж төрж байсан учраас Абрахам тэвджээ. Тэгээд бодож бодож, тэнд 10 зөвт хүн байвал тэр хотыг хэлтрүүлэхийг Бурханаас гуйв.

Бурхан ч саналыг нь хүлээж авсан. Эхлэл 18:17 дээр Бурхан бүр ингэж хэлсэн: “Би үйл хэргээ Абрахамаас нууна гэж үү?” Бурхан Абрахамд төлөвлөгөөгөө дэлгэхийг хүсдэг байсан нь тодорхой байна. Яагаад? Яагаад гэвэл Абрахам Бурхантай дотно нөхөрлөж *түншилдэг* байжээ.

Мосегийн амьдралаас ч ийм харилцааг харж болно. Египетээс гарсан нь 32:10 дээр Бурхан Мосед ийн айлдаж: “Одоо Миний уур хилэн тэдний эсрэг шатаж, Би тэднийг устгах учраас Намайг орхи. Би чамайг агуу үндэстэн болгоно: Харин Мосе үүнийг дуулаад, Бурханыг уураа татаж, төлөвлөгөөгөө өөрчлөхийг хүсчээ. Түр зогсоод, ингээд бодоод үз: Бурхан “Би устгана!” хэмээн айлдчихаад байхад, Мосе Бурханд “юу нь Түүнд болоод Түүний хүмүүст дээр болохыг” сануулж чадсан. Мосе Бурхантай үнэхээр дотно түншилдэг байжээ.

Бурхан Аугаа хүчирхэг бөгөөд бид Түүнийг эмээн хүндэтгэх ёстой гэдгийг бид мартаж болохгүй. Гагцхүү Түүний нигүүлсэл, хүчийн улмаас л бид Түүнтэй ийн түншлэх эрхтэй болсон. Тэрбээр Өөрөө биднийг аугаа төлөвлөгөө дизайныхаа хэсэг болгохоор сонгосон юм. Гэхдээ энэ сонголт бидэнд ямар аугаа завшаан олгоо вэ!

Эдгээр нь Хуучин гэрээний хоёр том жишээ юм. Гэхдээ үнэндээ Абрахам, Мосе хоёрт бидэнд байгаа бүхэн байгаагүй. Итгэлийн эдгээр аваргууд тодорхой эгшин, үйл явдал дээр л Бурхантай ийнхүү түншилдэг байсан бол өнөөдөр Ариун Сүнс бидний дотор долоо хоногийн 24 цаг хамт байна. Бид Түүнтэй хэзээ л бол хэзээ харилцах боломжтой. Тэгээд хамгийн гайхалтай нь Тэр Өөрөө бидэнтэй түншилж, чиглүүлж, бидний санаа бодлыг сонсохыг хүсдэг.

Сүнс бидэнтэй үргэлж хамт байхаар барахгүй, хэзээ ч унтдаггүй. Саяхан би өдрийнхөө үйлчлэлд сэтгэл догдлоод унтаж чаддаггүй. Тиймээс шөний 2 цагт босоод Түнштэйгээ ярилцлаа. Тэр надад “Яах гэж сэрээгээд байгаа юм бэ?” гэж хэлээгүй. Тэр намайг хүлээгээд л сэрүүн байж байсан. Харин гэргий минь байсан бол “Жон яагаад хүн унтуулахгүй байгаа юм бэ?” гэж хэлэх байсан. Би түүнд “Хонгор минь, би чамтай ярьмаар байна” гэвэл тэр намайг дэрээр цохих байсан даа. Тэр унтах дуртай учраас сэрээж болохгүйг нь би мэднэ (гэхдээ түүний оронд би ч бас тэгэх л байсан). Харин Ариун Сүнс надтай хэзээ л бол хэзээ хамтрах дуртай. Тэр надтай маргаашийн тухай ярьж, тэр бүү хэл айсуу үйл явдлын талаар цухуйлгадаг. Тиймээс л би өдрийг Түүнтэй уулзаж эхлэх дуртай. Тэр миний Хамтрагч бөгөөд Түүнтэй нөхөрлөх цаг маань миний амьдралын нэг өдрийн чухал хэсэг юм.

Ариун Сүнс бол миний Ахлах түнш гэдгийг мартаж болохгүй. Паул Ефесийн удирдагч нарт “Бурхан Өөрийн цусаар Өөртөө худалдаж авсан Бурханы чуулганыг хариулуулахаар Ариун Сүнс та нарыг харгалзагч болгосон бөгөөд та нар өөртөө болон бүх сүрэгт анхаарал тавь” хэмээн бичсэн (Үйлс 20:28). Паул “Есүс таныг ахлагчаар тавьсан сүрэг” гэж хэлээгүй, харин “Бурхан Өөрийн цусаар Өөртөө худалдан авсан” гэсэн нь Есүс, Ариун Сүнс хоёрын түншлэлийг харуулж буй. Есүс Бурханы Чуулганыг “Өөрийнхөө цусаар” худалдаж авсан. Харин эдүгээ Бурханы Гурвалын нэг болох, газар дээр оршин буй Ариун Сүнс Чуулганыг хариуцагч нарыг томилж, үйл ажлыг нь эрхэлж байна. Тэр гол Хариуцагч бөгөөд өөрөөр хэлбэл Ахлах түнш юм. Бидний дунд оршин буй Нэгэн нь Ариун Сүнс гэдгийг Паул ихэд чухалчилжээ.

Үйлс 13 дээр өөр нэгэн жишээ байна: “Тэднийг Эзэнд үйлчилж, мацаг барьж байх үед нь *Ариун Сүнс*, Би Өөрийнхөө ажлыг хийлгэхээр Барнаб, Саул нарыг дуудсан тул тэднийг томилогтун гэв... Ийнхүү *Ариун Сүнсээр* илгээгдсэн тэд Селюкт ирж тэндээсээ Кипр уруу усан онгоцоор явав.” (2, 4-р ишлэл). Элч нартай түншилдэг (нөхөрлөл дотор) Нэгэн нь Ариун Сүнс гэдэг нь дахиад л харагдаж байна. Есүс Аавтайгаа тэнгэрт буй. Харин дэлхий дээрх гайхамшигтай аялалын маань Хамтрагч бол Ариун Сүнс гэдгийг дахин хэлье.

Харилцан зөвшилцсөн хамтын ажиллагаа

2Коринт 13:13-г дахиад харъя: “Эзэн Есүс Христийн нигүүлсэл, Бурханы хайр, Ариун Сүнсний *нөхөрлөл* та бүгдтэй хамт байх болтугай.” Тэгэхээр бид *нөхөрлөл* гэдэг нь “нөхөрлөл” бөгөөд “түншлэл” гэдгийг мэддэг болсон болохоор уг ишлэлийг шинэ ойлголтоороо хараарай. Паулын мэдэгдлийн жинг та ойлгож эхэлж байна уу? Гэхдээ ингээд дуусахгүй. *Koinonia* гэдэг үг нь мөн “харилцан зөвшилцсөн хамтын ажиллагаа” гэсэн утга илэрхийлдэг.

Харилцан зөвшилцсөн хамтын ажиллагаа гэхээр Битлз хамтлаг санаанд буух юм. Битлз хамтлагийг салахаас бүр өмнө намайг пацан байхад Битлз гэхээр л миний санаанд Пол Маккартни, Жон Леннон, Жорж Харрисон, Ринго Старр гэдэг 4 хүн буудаг байлаа. Тэд тус тусдаа хүмүүс биш, харин *Битлз* байсан юм.

Ариун Сүнтэй хамт алхдаг хүмүүс гэхээр хамгийн түрүүнд шууд доктор Ёнги Чо орж ирнэ. Тэр бол дэлхий дээрх хамгийн том чуулганы пастор. 1980-аад онд анх түүнтэй уулзсанаа би хэзээ ч мартахгүй. Тэр миний төрөлх чуулганд анх удаа айлчилсан бөгөөд би чуулганы ажилтан байсан учраас түүнийг угтаж авах завшаан тохиосон юм. Би энэ үйлчлэлийг овоо хэдэн жил хийсэн учраас Доктор Ёнги Чогоос өмнө хэдэн арван номлогчийг угтаж авсан туршлагатай байв. Гэхдээ энэ удаагийн учрал тун онцгой байсан юм. Түүнийг миний машинд суухад Түүнтэй хамт Эзэний оршихуй хамт орж ирэв. Тэр даруй би учир зүггүй уйлж гарлаа. Би тэр мундаг хүнийг номлохоос нь өмнө саад болохыг хүсээгүй учраас чимээгүй мэгшиж байснаа эцэстээ дуугарахаас өөр аргагүйд хүрч, аяархан дуугаар: “Ёнги Чо пастор аа, Эзэн машин дотор байна” гэтэл, тэр толгой дохин инээмсэглээд: “Би мэднэ ээ” гэж хэлсэн юм. Ёнги Чо пастор Ариун Сүнтэй тогтоосон нөхөрлөлийнхөө талаар ямар их бичиж, номлосныг нь би боддог. Тэр өдөрт 2-4 цаг гол төлөв Сүнсээр залбирдаг тухай сонссон. Ёнги Чо пастор Ариун Сүнтэй өнгөрөөх цагийг юу юунаас

эрхэмлэдэг учраас амьдралдаа Бурханы тийм жинтэй оршихуйг тээдэг ажээ.

Хэдэн жилийн өмнө би нэгэн том чуулган дээр Ариун Сүнсний талаар номлосон юм. Тэр оройн чуулганд би хүндэтгэлийн цуглаан эхлэснээс хойш 45 орчим минутын дараа номлох ёстой байв. Гэтэл Ариун Сүнс хөдөлж, хүмүүс эдгэрч, аврагдаж эхлэв. Ийнхүү хоёр цагийн дараа л надад микрофон олдсон юм. Тэгж тэгж намайг тайзан дээр гаргал пастор нь (маш сул дорой болсон байв) уйлсаар хүрч ирээд “Жон, энэ чуулганыг удирдсан 8 жилийн хугацаанд би хэзээ ч Бурханы оршихуйг ийм хүчтэй мэдэрч байгаагүй!” гэж хэлэхэд нь би түүнд: “Учир нь бид өглөө Ариун Сүнсний талаар ярьсан шүү дээ. Түүний талаар ярих үед Тэр Өөрийгөө харуулдаг” гэж хариулсан юм. Жирийн итгэгч болох та бид хоёр Сүнтэй ойр дотно алхах үед юу болдогийг энэ жишээ харуулж байна.

Нөхөрлөл бол дотносол

Koinonia-гийн сүүлийн утга нь “дотносол” юм. 2Коринт 13:13 дээр Паул *koinonia*-г яг энэ утгаар хэрэглэсэн гэж болно. Дотносолыг нөхөрлөл юмуу харилцаагаар хөгжүүлдэг ч, үүнээс ч илүү гүн зүйл гэж ойлгож болно. Дотносол бодол, нууц, зүрхний хүсэл рүү гүн ордог зүйл.

“Эзэн Есүс Христийн нигүүлсэл, Бурханы хайр, Ариун Сүнсний *нөхөрлөл* та бүгдтэй хамт байх болтугай.” (2Коринт 13:13). Би дотносолыг нөхөрлөлийн хамгийн гүнзгий төвшин гэж боддог. Ариун Сүнс таны найз нөхөр байхыг хүсдэг. Тэр танаас нөхөрлөл хүсдэг. Иаков 4:5: “Эсвэл ямар ч зорилгогүйгээр Сударт “Түүний бидний дотор нутаглуулсан сүнс нь атаархан хүсдэг” хэмээсэн гэж та нар бодож байна уу?” Тэр таныг харддаг бөгөөд таны анхаарал, цагаас хүсдэг. Ариун Сүнс бүхнийг мэддэг, хардаг Бурхан. Түүний мэдлэг, цэц ухаан, ойлголт хязгааргүй бөгөөд Тэр Өөрийгөө танд илчлэхийг хүсдэг гээд бодоод үз дээ. Би ямар нэгэн үнэ цэнэтэй, чухал зүйл мэдэхээрээ хамгийн чухал хүмүүстээ дуулгах гэж яардаг. Үнэндээ Ариун Сүнс ч бас яг ингэдэг.

Итгэгч хүмүүс Ариун Сүнснийг тоолгүйгээр Есүстэй дотносох гэж зүтгэдэг. Фарисайчууд яг ийм алдаа гаргасан. Тэд Есүст “Садар самуунаас бид төрөөгүй. Бидэнд Бурхан хэмээх нэг л Эцэг байгаа” гэхэд, Есүс тэдэнд: “Хэрэв Бурхан та нарын Эцэг байсан бол, та нар Намайг хайрлах байсан. Учир нь Би Бурханаас гарч ирсэн билээ. Өөрийн санаагаар ирээгүй, харин Тэр Намайг илгээсэн юм” хэмээн хариулсан (Иохан 8:41-42). Фарисайчууд Есүсийг тоолгүй, Аавтай харилцах гэж оролдсон. Тэд Бурханы хүслийг хүлээж аваагүй. Харин Есүс тэдэнд “Аав Бид хоёр нэг юм” гэж тайлбарласан. Үнэндээ Есүс дараа нь “Хэрэв та нар Намайг мэдсэн бол Миний Эцэгийг ч мөн мэдэх байсан” хэмээн айлдсан буй (Иохан 14:7). Гэхдээ Фарисайчууд зүгээр л сонсохыг хүсээгүй. Тэд Хүүгээр дамжуулж Аав дээр очихыг хүсээгүй учраас Аав дээр ерөөсөө ч хүрээгүй.

Яг үүнчлэн Есүс цаашид дэлхий дээр байхгүй бөгөөд Аав нь бидэнд туслуулахаар Ариун Сүнснийг (яг бидний Аврагч шиг Нэгэнийг) илгээнэ гэдгийг маш тодорхой хэлсэн. Сүнс Есүсийг, Есүс Аавыгаа илчлэхээр илгээгджээ. Ариун Сүнс Есүсийг алдаршуулах дуртай. Тиймээс Есүсийг мэдмээр байвал Ариун Сүнстэй цаг өнгөрөө. Тэр танд Есүсийг илчилнэ. Гэхдээ Өөрийг нь хүндэтгэж буй газар л Ариун Сүнс Өөрийгөө илэрхийлдэг. Сүнснийг хүндэтгэбэл Тэр бидэнд Өөрийгөө илчилж, бид Түүний гайхамшигт оршихуйд дурлаж, Түүний илчилсэн Нэгэний талаар улам илүү мэддэг болно.

Би гуч гаруй жил үйлчлэхдээ энэ үнэн гуйвж байхыг хэзээ ч үзээгүй. Ариун Сүнснийг мэддэг хүмүүс л Есүсийг мэддэг. Тун ойлгомжтой. Учир нь Сүнс л Есүсийг илчилдэг.

Сүнсний зан чанарыг ойлгохуй

Хүнтэй дотносохын тулд түүний зан чанарыг мэдэх хэрэгтэй. Зан чанарыг нь мэдбэл бидний харилцаа улам хөгжиж, улам гүнзгийрнэ.

Би ихэндээ 4 хүүдээ яг адилхан ханддаг байлаа. Гэтэл үүнээс болж нилээд асуудал үүсдэг байв. Яагаад хүүхэд хүмүүжүүлэх

ийм арга тааруу байдаг вэ? Учир нь тэд чинь өөр өөрийн зан чанартай 4 өөр хүн шүү дээ. Харин гэргий маань үүнийг мэдэрдэг учраас тэдэнд тус бүр яаж хандахыг надад зааж, үүнээс хойш бидний харилцаа үнэхээр сайжирсан юм.

Би гэргийтэй маш дотно учраас түүний ааль авирыг мэднэ. Бид 30 жил ханилахдаа аяндаа гэхээсээ илүү бие биедээ өөрсдийгөө нээсэн учраас дотноссон юм. Лиза над руу ганц харахад л би түүний юу бодож байгааг бичиж чадна. Заримдаа Лиза надад юу ч хэлээгүй ч би түүний юу хүсч байгааг мэдэрдэг. Хэрэв та надад: “Би Лиза та хоёрын өглөөний цайнд гахайн мах, өндөг, эрдэнэ шиш өгье” гэвэл, би танд: “Лиза гахайн мах, эрдэнэ шишт дургүй” гэж хариулна. Би түүнийг үүнд дургүй гэдгийг мэднэ. Асуух ч хэрэггүй. Энэ бүхэн тун өнгөц жишээ л дээ. Гэхдээ гүн гүнзгий зүйлсийн хувьд ч ялгаагүй ийм л зарчмаар ажилладаг. Ганц шөнийн дотор ингэтлээ дотносно гэж байхгүй. Овоо хэдэн жил цаг хугацаа, харилцаагаа зориулан байж л ийм үр дүнд хүрнэ. Манай гэргийг над шиг мэддэг хүн байхгүй, намайг манай гэргий шиг мэддэг хүн байхгүй. Үүнтэй адил бид Ариун Сүнсний харилцах, Түүний оршихуйд байх цаг гаргаж байж л Түүнийг ойлгодог болно.

Дөрөвдүгээр өдөр

Түүний мөн чанарыг мэд

Иохан 14-16-р бүлэгт Есүс Ариун Сүнсний тухай өгүүлэхдээ *Тэр, Түүнийг, Тэрбээр* гэдэг төлөөний үгсийг нийт 19 удаа хэрэглэжээ. Ариун Сүнс Хувь нэгэн гэдэг нь тодорхой байна. Хувь нэгэн гэдэг нь хүн гэсэн үг биш гэдгийг дахиад хэлье. Хүн нь Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн. Тиймээс бидний “хувийн зан чанар” гээд байдаг зүйлс нь нэн түрүүнд Бурханы Өөрийнх нь зан чанарын тусгал гэсэн утгатай. Түүнээс биш Бурхан бидэнтэй яг адилхан биш юм. Хүн бидний “хайрцагт” хэзээ ч баригдахгүй мөн чанар Бурханд олон буй.

Би Ариун Сүнстэй харилцах талаар хэд хэдэн зүйл мэдэж авсан юм. Грек эх сурвалжаас нь харбал Ариун Сүнсний хувьд голдуу саармаг (эр ч биш, эм ч биш) төлөөний үг хэрэглэсэн байдаг. Гэхдээ энэ үгийг ганц эрэгтэй юмуу ганц эмэгтэй хүний талаар ярихдаа хэрэглэж болдог. Англи хэлд ийм төлөөний үг байхгүй. Гэтэл Грек хэлнээ саармаг төлөөний үг байдаг бөгөөд үүнийг Шинэ гэрээнд голдуу Ариун Сүнсний талаар ярихдаа хэрэглэдэг. Энэ нь амьгүй юм бус, амьтай зүйлийг дүрслэхэд хэрэглэгддэг гэдгийг дахин хэлье.

Үүнтэй төстэй зүйл Хуучин гэрээнд бас байдаг. Еврей эх сурвалж дээр Ариун Сүнсний үйл ажиллагааг олон удаа эм үйл үгээр дүрслэсэн байдаг. Еврей хэлний үгс нь голдуу үйлийн эзнээ дагаж (эрэгтэй эсвэл эмэгтэй хүн үйлдэж буй эсэхээс шалтгаалж) хувирдаг. Бичээст Ариун Сүнсийг эмэгтэй гэж хэзээ ч хэлээгүй боловч, Түүний зарим үйлсийг эм үгээр бичсэн байдаг.

Энэ нь маш өргөн сэдэв учраас цааш дэлгэрүүлж тайлбарлах боломж алга. Гэхдээ би нэг зүйлийг шууд хэлье: Ариун Сүнс эмэгтэй биш. Ариун Сүнс дарь эх, дагина биш гэдгийг сайн тогтоож аваарай.

Тэгэхээр бид хэдэн зүйлийг тогтоох ёстой. Бурхан бидний дүр төрхөөр бус, бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн. Мэдээжийн сонсдож байгааг би мэдэж байна. Гэхдээ энэ эгэл үнэн нь бидний цаашдын судалгааны амин чухал суурь болно. Эхлэл 1:27: “Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв.” Өөрөөр бас Бурхан “хүн төрөлхтөнийг” бүтээсэн ч гэж орчуулдаг. Тэгэхээр Бурхан эрэгтэй, эмэгтэй хүнийг Өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн. Хэрэв Тэрбээр эрэгтэй эмэгтэй хүнийг *Өөрийнхөө дүр төрхөөр* бүтээсэн юм бол, бидний “бүсгүйлэг” гэж хардаг шинж чанар Бурханаас Өөрөөс нь эхтэй биш үү? гэсэн асуулт ургана. Ариун Сүнс нь бидний эр, эм гэдэг ойлголтоос хол давсан Нэгэн байх боломжтой.

Би Ариун Сүнсийг эр хүйсээр ярьсаар буйг та анзаарсан байх ёстой. Ариун Сүнсний бидний нэрлэдгээр “эмэгтэйлэг шинж” гэдэг ойлголт нь англи хэлтэй хүмүүст самуурмаар байж болох юм.

Тэгэхээр би яагаад энэ бүхнийг ярина вэ? Ариун Сүнстэй тогтоох харилцааг тань хөгжүүлэх үүднээс л энэ сэдвийг хөндөөд байна.

Тэр зөөлөн бөгөөд эелдэг

Цааш ярихаасаа өмнө эхлээд өөрийнхөө тухай товч өгүүлье. Аав маань өдгөө 92 настай бөгөөд Дэлхийн II Дайны ахмад дайчин хүн юм. Би аавдаа хайртай. Аавын минь сургамж надад олон зүйлийг зааж сургасан юм. Гэхдээ тэр надад “эмэгтэй хүнтэй гэрлэсэн амьдрал” гэж юу байдгийг л зааж өгөөгүй юм. Петр “Нөхрүүд ээ, эхнэр чинь эмэгтэй хүн тул түүнийг өөрөөсөө сул дорой сав мэт үзэн та нар ч мөн адил эхнэртэйгээ ойлголцож амьдар” гэж хэлсэн (1Петр 3:7). Би Лизатай гэрлэхдээ түүнтэй “ойлголцоогүй” юм. Лизагаас өмнө би ямар ч эмэгтэйтэй ойр дотно харилцаж үзээгүй бөгөөд тэр миний анхны хайр байв. Тиймээс би түүнд яг л нэг залуу шиг ханддаг байлаа. Мэдээж энэ хандлага намайг амжилтанд хүргээгүй. Би түүнд *эмэгтэй хүн* гэж хандаж сурах ёстой байв.

Тухайлбал Лизатай зөөлөн ярьж сурах хэрэгтэй байлаа. Би гэрийнхэнтэйгээ хатуу ширүүн ярих үе олон байсан ч, Ариун Сүнс намайг сэхээрүүлж би тэднээсээ уучлал эрж, алдаагаа засдаг байв. Нэг удаа би нэг хүүтэйгээ нилээд хатуу үзэлцээд, дараа нь түүнээс уучлал гуйсан юм. Хүү минь намайг уучилж, бид тэр даруй эвлэрэв. Харин Лизагийн хувьд жаахан өөр байв. Намайг хөвгүүдтэйгээ хатуу ширүүн харилцсанд Лиза надад хэдэн өдрөөр уурлана. Энэ нь алдаа зөрчлийн асуудал биш, харин эмэгтэй хүний харилцаанд хандах эмзэг мэдрэмжийн үр дагавар байв. Хүү бид хоёр тэр даруй эвлэрсэн бол, гэргийтэйгээ харилцаагаа сэргээхийн төлөө би жаахан хүчин зүтгэл гаргах хэрэгтэй болов. Энэ явдлаас хоёр хоногийн дараа Лиза надад “Хөвгүүдтэй харилцаж байгаа занд чинь ёстой дургүй хүрч байна” гэж хэлэв. Лиза бусад эмэгтэйчүүдийн нэгэн адил харилцаа холбоогоо туйлаас чухалчилж, ойр дотныхоо хүмүүсийг аймшиггүй хамгаалдаг ажээ.

Тэгвэл Ариун Сүнс ч бас бидний “эмэгтэйлэг” гэж тооцдог

эдгээр аугаа шинжийг тээдэг байж болох уу? Библи “Бурханы Ариун Сүнснийг бүү гашуудуул” гэдэг (Ефес 4:30). *Sparkling Gems from Greek*-г бичсэн Рик Рэннэр “*гашуудуул хэмээн орчуулсан үг нь “гүн шаналал, уй гашууг” илэрхийлнэ гэжээ. Хоёр биедээ үнэн голоосоо хайртай хоёр хүний л мэдэрч болох зовиурыг дүрсэлдэг үг юм. Тиймээс Паул үндсэндээ “Чамд тийм хайртай Нэгэнийг бүү гашуудуул” л гэж хэлжээ. Энэ Бичээсийг бүрэн агуулгаар нь уншиж үзье:*

Та нарын амнаас ямар ч ялзарсан үг бүү гараг. Харин хэрэгтэй үед нь бусдыг босгон байгуулахын тулд зөвхөн тустай үг хэл. Тэгвэл энэ нь сонсож буй хүнд нигүүлслийг өгнө. Бурханы Ариун Сүнснийг бүү гомдоо. Золилтын өдрийн төлөө та нар Түүгээр тамгалуулсан билээ. Аливаа хорсол, уур, хилэн, шуугиан, гүтгэлэг нь бүх бузар муугийн хамт та нараас зайлаг. Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биеэ уучлан, нэг нэгнээ энэрэн уян зөөлөн сэтгэлээр ханд. (Ефес 4:29-32).

Ариун Сүнсний зөөлөн шинжийг харж байна уу?

Зөөлөн бол үнэхээр биширмээр шинж чанар. Паул биднийг өр зөөлөн зүрхтэй байхыг сануулсан. Хэрэв бид гэргийтэйгээ эрүүл саруул, амьд харилцаатай байхыг хүсбэл зөөлөн зүрх сэтгэлтэй байж, хөвгүүдтэйгээ зөв ярих ёстой. Үүнтэй адилхан хэрэв бид Ариун Сүнсний эрүүл, амьд харилцаатай байхыг хүсбэл Түүнийг гомдоох зүйл хийхээс сэрэмжлэх хэрэгтэй. Паул Ариун Сүнсний гомдоодог зүйлсийн тухайд: *хорсол, уур, хилэн, шуугиан, гүтгэлэг* хэмээн тоочсон нь тун сонирхолтой юм. Миний яг ийм үйлдэл гэргийг минь гомдоож шархлуулсан. Энэ чинь Ариун Сүнсэнд бидний “эмэгтэйлэг” гэж үздэг шинж байдгийн нотолгоо биш үү?

Паул “Есүсийг бүү гомдоо эсвэл Аавыг бүү гомдоо” гээгүй, харин “Ариун Сүнснийг бүү гомдоо хэмээн онцлон хэлсэн. Ариун Сүнс бидний зүрхэнд нутагладаг. Бид хаашаа ч явсан Тэр дагаж явдаг. Энэ бол маш дотно харилцаа холбоо. Тиймээс бидний амьдралдаа оруулж буй зүйлс Түүнд гүн нөлөөлдөг.

Үүнийг өөр өнцгөөс харъя. Хэн нэгэн хүн надад таагүй хандбал би тоохгүй. Харин гэргийд минь таагүй хандбал би зүгээр өнгөрөөхгүй. Есүс “Хүний Хүүгийн эсрэг үг хэлдэг хэн боловч уучлагдах болно. Харин Ариун Сүнсний эсрэг ярьдаг хэн ч энэ үед ч, ирэх үед ч уучлагдахгүй” гэж айлдахдаа яг үүнийг хэлсэн юм (Матай 12:32). (Гагцхүү Аавынхаа хүслийг ярьдаг Хүүгээрээ илчлэгдсэн) Бурхан Аав нь Ариун Сүнсийг хамгаалсан нь сонирхолтой биш гэж үү? Аав нь Түүнд болон Есүст хэрхэн хандахыг “үл тоосон ч”, харин Ариун Сүнсний тухайд өөрөөр ярьжээ.

Аав, Хүү, Ариун Сүнсний хоорондын харилцаа нь бидний хэзээ ч бүрэн ойлгошгүй нууц юм. Ариун Сүнтэй тогтоох бидний харилцаанд ч бас ийм онцлог байгааг харах нь сонирхол татмаар. Бид Түүнтэй тогтоох харилцаагаа нандигнаж, хамгаалах учиртай. Түүнийг гомдоож, бүр гүн шархлуулан гомдоож болдогийг бүү март. Яагаад энэ бүхэн чухал гэж? Яагаад гэвэл та Түүнтэй яаж харилцахыг мэдэхгүй бол, Тэрбээр таны амьдралд Өөрийгөө илэрхийлж чадахгүй.

Тавдугаар өдөр

Эмзэг атлаа хүчирхэг

Ариун Сүнсийг Тайвшруулагч гэдэг тийм үү? Хүүхдүүд уйлахаараа хэн рүү гүйдэг билээ? Ээж рүүгээ л гүйдэг. Үүнийг бодолцон улс орнууд хүүхдийн гэмт хэргийн хэсэгт голдуу эмэгтэй хүмүүсийг ажиллуулдаг. Хүүхдүүд эмэгтэй цагдаа нартай арай амархан харилцдаг ажээ. Эмэгтэйчүүд ер нь тайвшруулж тайтгаруулах төрөлхийн чадвартай байдаг. Гэхдээ үүгээрээ би Ариун Сүнсийг эмэгтэй гэж хэлэхгээгүй гэдгээ дахин давтъя.

Би Ариун Сүнсийг зарим талаараа Давид хаантай адилтгадаг юм. Давид ямар уяхан зөөлөн, халуун сэтгэлтэй, эмзэг хүн байсныг та анзаардаг уу? Давид өөрийнх нь эсрэг урван тэрсэлсэн Абсаломын цэргийг устгахаар явсан ч, Абсаломыг үхэхэд Давид

цурхиран цурхиран уйлсан (2Самуел 19). Давид ер нь уйлан хайлан, дуулал бичиж байхыг бид байнга хардаг. Ионатан тэд хоёрын нөхөрлөл Бичээс дээрх жинхэнэ нөхөрлөлийн шилдэг жишээ байв. Гэхдээ нөгөө талаасаа Давид Голиат тэргүүтэй хэдэн мянган дайсныг хядсан, магадгүй Израилийн түүхэн дэхь хамгийн Эрэлхэг Дайчдын аугаа хүчирхэг удирдагч дайчин байсныг бүү мартаарай (2Самуел 23). Нэг удаа бүр түүнд болон түүний цэргүүдэд хоол хүнс өгөөгүй хүнийг алахаар зэхсэн байдаг (1Самуел 25). Давид үлбэгэр дорой амьтан бус, дайчин байсан юм.

Ариун Сүнснийг бас Хүч чадлын Сүнс гэдэг (Исаиа 11:2). Тэр сул дорой байдлыг мэдэхгүй бөгөөд энгүй хүчтэй. Гэхдээ нөгөө талаасаа бүхнийг гүн хүлээж авдаг, эелдэг зөөлөн зүрхтэй. Бидний хахир хатуу үг үйлдэлд Тэр эмзэглэдэг. Ямар гайхамшигтай Бурхан бэ!

Түүний зан чанарыг ойлгоход жаахан бэрх байвал битгий сандчаарай. Угаасаа Тэр бидний мөхөс оюунд баригдашгүй Бурхан. Гэхдээ Түүнд ойр байгаа нэгэнд Тэрбээр Өөрийгөө илчилнэ гэсэн. Гайхалтай!

Ариун Сүнсний алдар ба нууцыг бүрэн гүйцэт дүрслэх арга байхгүй гэдгийг би өмнө хэлсэн (1Коринт 2:6-16). Би ердөө л таныг Түүнтэй танилцуулах үүрэгтэй. Харин та өөрөө Түүний оршихуйг амьдралдаа залж, Түүний үлэмжийн чанарыг нээж олоорой.

Түүнийг бүү гашуудуул

Би саяхан нэг хэсэг зурагтаас албаар хөндийрч Бурханд Үг, залбиралд илүү их зориулагдахад Бурхан бид хоёрын нөхөрлөл улам зузаарсан юм. Тэр үеэр би нэг удаа том өрөөндөө ортол хөвгүүд маань дайнтай кино үзэж байв. Намайг орох үед яг нэг хүн амь үрэгдэж таарсан бөгөөд би тэр даруй гарч явав. Би Сүнсгүй маш дотно болсон учраас дэлгэцэн дээрх үйл явдалд эмзэглэх сэтгэлийг нь мэдэрсэн юм.

Ариун Сүнс бидний дотор бүр мөсөн оршин суусан гэдгийг бүү

март. Та кино үзэхдээ ч дэлхий ертөнцийн хязгааргүй хүчирхэг бөгөөд ариун Бурханыг дагуулж явдаг. Тэр таныг орхихгүй, хаяхгүй гэж амласан учраас таныг хаа ч явсан, юу ч хийсэн хамт байна. Гэхдээ Түүнийг өвтгөж гашуудуулах юм хийх үед Тэр зүгээр л чимээгүй болдог.

Хэрэв Ариун Сүнсийг гомдообол яах ёстой вэ? Тэр даруй чин сэтгэлээсээ, үнэн голоосоо уучлал, өршөөл гуй. Би гэргийгээ гомдоочихоод “аргацаах” гэж оролдбол хэзээ ч бүтдэггүй. Бидний харилцааг эмтэлсэн асуудлыг ул суурьтай засахын оронд бушуухан шиг торгоож орхиод цаашаа явах санааг маань Лиза мэдэрдэг. Мэдээж намайг яллах санаа түүнд минь байхгүй ч, бидний харилцаанд ямар ч хуурамч, хиймэл зүйл байлгахыг тэвчихгүй. Үүнтэй адилхан Бурханы Сүнс биднийг харамладаг бөгөөд хиймэл бус, жинхэнэ харилцааг хүснэ.

Тус бүлгийн эхэнд би нэг хүүдээ хахир хатуу хандсан тухайгаа ярьсан. Дараагийн хэдэн өдөр нь Ариун Сүнс намайг Өөр рүүгээ дуудсаар байлаа. Энэ ял биш байв. Харин ч Түүнтэй нөхөрлөх нөхөрлөл байв. Анхандаа би Түүнийг ямар гүн гүнзгий гашуудуулсанаа ухаараагүй учраас ганц хоёр удаа албаны маягтай уучлал гуйсан юм. Учир нь би зүгээр л “амьдрал үргэлжилсээр” гэсэн хандлагатай байлаа. Гэхдээ Түүний тууштай, зөөлөн ятгалга намайг чин сэтгэлийн, жинхэнэ бурханлаг гэмшил рүү хөтөлж, хамаг байдгаа уудлахад хүргэсэн юм.

Паул ч бас Бурхантай харилцах харилцаагаа сэвтээсэн Коринтын итгэгчдэд ийм үг хэлсэн.

Энэхүү бурханлаг гашуудал нь та нарын дотор ямар хэрсүү байдал, зөвтгөл, эгдүүцэл, айдас, халуун хүсэл, зүтгэл, шийтгэл бий болгосныг харагтун. Та нар цэвэр гэдгээ энэ хэрэгт алив бүхнээр харууллаа.
(2Коринт 7:11)

Хурганы цусаар биднийг уучилж, цэвэрлэсэн Бурхандаа баярлалаа. Гэхдээ эдүгээ Бурхантай зогсон буй итгэгчид бид Ариун Сүнсийг гомдоосон бол заавал нөхөрлөлөө сэргээж, дахин

байгуулах ёстой. Паул Коринтынхоныг жинхэнээсээ гэмштэл нь ятгасан шиг, Ариун Сүнс бидэнтэй жинхэнэ харилцаатай байхын төлөө “улайрдаг” учраас биднийг зогсолтгүй ятгадаг юм. Бурханлаг гэмшил намайг жинхэнээсээ цэвэрлэж, жинхэнэ нөхөрлөлд хүргэв. Биднийг дэндүү амархан уучилдаг Ариун Сүнс Тандаа баярлалаа!

Ариун Сүнс нэг талаасаа бүсгүй хүн шиг өр зөөлөн, халуун сэтгэлтэй, тайтгаруулагч чанартай боловч, нөгөө талаасаа эр хүн шиг хүчирхэг, чадалтай, дайчин чанартай. Түүнтэй нөхөрлө, тэгвэл Түүнийг улам илүү танина. Бид Түүний нөхцөл болзлыг хүлээж авах ёстой.

Заримдаа би гольфын талаар гэргийтэйгээ яриа дэлгэх гээд л: “Хайр аа, би өнөөдөр 68 цохьсон!” гэдэг. Хөвгүүд маань үүнийг сонсоод хөл хөөрцөг болдог ч, харин гэргий маань гольфын талбай дээр хэнтэй нөхөрлөснийг маань илүү шохоорхдог. Түүнд харилцаа чухал. Би Лизатай түүний сонирхож буй зүйлсийн талаар ярих хэрэгтэй. Яг үүнтэй адилхан бид Ариун Сүнсний “сонирхлыг” мэдэх хэрэгтэй. Үгийг уншиж, Түүний оршихуй дотор хамт байхад Тэрбээр бидэнд Өөрийгөө итгэмжтэй илчилнэ.

Нэгдүгээр өдрийн чимээгүй цаг

ТА БУРХАНЫ ДУУ ХООЛОЙГ СОНСОНО!

*Бурханы хүн нь Бурханы үгсийг сонсдог.
Та нар Бурханых биш учир эдгээрийг сонсдоггүй гэлээ.*

Иохан 8:47

Тийм ээ, та Бурханы дуу хоолойг сонсож чадна! Бурхан өнөөдөр ч хүмүүстэйгээ хайртай Ариун Сүнсээрээ дамжуулж ярьдаг. Христэд итгэгч хүмүүсийг Бурхантай илүү гүн гүнзгий дотно харилцаанд ятгахдаа зохиолч **Хэнри Блакаби**, **Клауд Кинг** нар ийн бичжээ:

“Үйлс номд Бурхан хүмүүстэйгээ маш тод ярьдаг. Бурхан өнөөдөр ч тантай маш тод ярьдаг. Үйлс номоос өнөөдрийг хүртэл Бурхан хүмүүстэйгээ Ариун Сүнсээрээ л ярьдаг. ... Учир нь Ариун Сүнс итгэгч хүний дотор оршдог. Тэр Өөрийнхөө дуртай цагт, дуртай аргаараа тантай ярина. ”

Есүс Өөрийгөө сайн Хоньчин, харин бид Хоньчиныхоо дууг сонсож таньдаг хонин сүрэг нь гэсэн. Иохан 10:3-5, 11, 14, 27-р ишлэлийг тунгаан бод. Ариун Сүнс юу илчилж байна?

Ариун Сүнсийг **үнэний Сүнс** гэдэг. Блакаби ийн үргэлжлүүлжээ:

“... Ариун Сүнс илчлэхээс нааш та Бурханы үнэнийг ойлгохгүй. Ариун Сүнс бол багш. Тэр танд Бурханы Үгийг зааж байхад

Түүний өмнө суугаад суралц. Залбирахдаа Бурханаас ирсэн үгийг Тэрбээр зүрхэнд тань батжуулахын тулд Бурханы Үгийг хэрхэн ашиглаж байгааг хар. Таныг хүрээлэн буй нөхцөл байдалд Тэр хэрхэн ажилладгийг хар. Таныг залбирахад ярьдаг, Бурханы Үгийг уншихад Бичээсээр ярьдаг тэр л Бурхан таны нөхцөл байдалд ажилладаг. Бурхан Өөрийгөө, зорилгоо, арга замаа Ариун Сүнсээрээ дамжуулан Библи, залбирал, нөхцөл байдлаар болон чуулганд илчилдэг. Тэгэхээр Ариун Сүнс танд яг юуг илчилж өгөөсэй гэж хүсч байна? Иохан 14:26; 15:26; 16:12-15-г уншаад, Сүнс зааж буй 5 зүйлийг тодорхойл.

Бурханы дуу хоолойг таних түлхүүр юу вэ? Блакаби Кинг хоёр цааш нь ингэж бичжээ:

“... Бурханы дуу хоолойг томъёогоор мэдэхгүй, арга барилаар ч танихгүй. Түүнтэй тогтоох хайрын харилцаа л Бурханы дуу хоолойг таниулдаг юм. ...Бурхан тантай ярихад та хариулсаар байвал Түүний дуу хоолойг улам улам тодорхой сонсож сурна.”

Харилцаа бол Бурханы дуу хоолойг мэдүүлэх түлхүүр юм. Енох, Ноа, Абрахам тэргүүтэй хүмүүс Түүнийг сонссон бол та ч чадна. Амос 3:7; Даниел 2:22; Дуулал 25:14; Иохан 15:15; 1Коринт 2:9-10; Ефес 1:9-г тунгаан бод. Эдгээр ишлэл нь “эцсийн үеийн” итгэгч таныг хэрхэн урамшуулж байна?

Жишээ нь Енок (Эхлэл 5:21-24), Ноа (Эхлэл 6:9-18), Абрахам (Эхлэл 18:16-22) болон Петрийн (Үйлс 10:9-23) амьдралыг харж болно.

Хоёрдугаар өдрийн чимээгүй цаг

ТҮҮНИЙ ОРШИХҮЙ БИДЭНД АМИН ЧУХАЛ

Түмэн цэргүүд намайг бүслэвч миний зүрх айхгүй.

Миний эсрэг дайн гарсан ч,

энэ бүгдийн дунд би итгэлтэй байх болно.

Дуулал 27:8

Давид дундаж хүн байгаагүй. Түүнд бусдад байдаггүй- зүрх сэтгэлийг нь шатаадаг, оюун санааг нь сордог *нэгэн зүйл* байсан нь Бурханы оршихуй болой! “Би эрэн хайх ёстой *нэг л зүйлийг* ЭЗЭНээс гуйсан. Энэ нь ЭЗЭНий гоо сайхныг харж, Түүний сүмд бясалгахын тулд би насан туршдаа ЭЗЭНий өргөөнд суухыг гуйсан.” (Дуулал 27:4)

Бурханы оршихуй хийгээд Түүнийг Хамтрагчаа болгохоос илүү чухал зүйл гэж зүгээр л байхгүй. Аав, Хүү хоёр тэнгэрт буй учраас газар дэлхий дээр Ариун Сүнс Бурханы оршихуйг итгэгч хүн бүрийн дотор болон итгэгч хүн бүрээр дамжуулан илчлэх үүрэгтэй. **Лоренс ах** хэмээн бидний авгайлдаг Николас Хэрман гуай “Бурханы оршихуйг тээж” сурсан учраас үүнийгээ бусдад заахыг амьдралынхаа зорилго болгожээ. Арван долдугаар зууны сүмийн тахилч тэрбээр ингэж хэлжээ:

“Бидний сүнслэг амьдралын хамгийн ариун, амин чухал үйл хэрэг бол Бурханы оршихуй авай. Түүний тэнгэрлэг нөхөрлөлд үргэлжлүүлэн дурлаж, Түүнтэй цаг үргэлж даруу бөгөөд хайрын сэтгэлээр юуны ч талаар хамаагүй ярилцах юм.”

Түр зогсоод эргэцүүлээрэй: *Миний хувьд Бурханы оршихуй аль хэр чухал байдаг вэ? Түүнгүйгээр миний амьдрал ямар болох вэ?*

Маргааш өглөө сэрсэн чинь Ариун Сүнс таныг орхичихсон байвал яах вэ? Түүний нэрс болон үүргийг сэргээж унш (23-р хуудас). Шинэчлэгдсэн цоо шинэ үзэл бодлоор Түүний оршихуй танд аль хэр чухал болохыг бич.

Ариун Сүнсний оршихуйг бид хэзээ хаана тээдэг вэ? Лоренс мөн ийн бичжээ:

“Бурханы оршихуйд байна гэдэг нь чуулганд л суугаад байхын нэр биш. Бид зүрхээ хувийн сүм болгоод, Бурхантай хоёулханаа байхаар хэзээ ч хамаагүй тэндээ орж болно. Энэ нь тун зөөлөн, хайрын ярилцлага байх учиртай бөгөөд хэн ч Бурхантай ингэж ярилцаж болно. Тэгэхээр эхлэхгүй байх шалтгаан байна уу?”

Бурханы оршихуйг яаж тээх вэ? Лоренс ах түүнчлэн “Зүгээр л өөрийгөө Бурханд барьж... Түүний оршихуйд анхаарлаа тавь. Заримдаа оюун бодол тань тэнүүчилж эхэлбэл битгий зов. Зовох юм бол улам л самуурна. Зүгээр эргээд л Бурхандаа анхаар... Түүний талаар байн байн бодох ариун дадал хэвшил хөгжүүл.” хэмээжээ. Яг одоо түр зогсоод “Ариун Сүнс минь, Тан дээр анхаарахад минь тусчлаач” гэж залбир. Ариун Сүнсний хариулыг сонсоод амьдралдаа хэрэгжүүл.

Дэлгэрэнгүй судлахыг хүсбэл ...

1Шастир 16:9-11; Дуулал 22:26; 105:3-4; Сургаалт үгс 8:17-18; Исаиа 55:1-3, 6; Иерөмиа 29:11-13; Матай 6:33; Еврей 12:1-2

Гуравдугаар өдрийн чимээгүй цаг

ТЭР ТАНТАЙ ДОТНО БАЙХЫГ ХҮСДЭГ

Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно.

Илчлэлт 3:20

Бурхан Ариун Сүнсээрээ дамжуулан өөр хэнээс ч илүүтэй тантай дотно байхыг хүсдэг. Тэр тантай байж болох хамгийн гүн гүнзгий төвшиний харилцаа- дотно байдлыг хүсдэг.

Ариун Сүнс хүний хүрч чадахгүй газар хүрч, сүнсийг “өвчдөг”. Тэр цаг хугацаа орон зайд баригдахгүй. Тэр бидний зүрхэнд хайгуул хийгээд зогсохгүй мөн Бурханы зүрхэнд хайгуул хийж, Түүний гүн бодол, нууц, хүслийг илчилдэг.

ЭЗЭНий нууц Өөрөөс нь эмээгчдийн төлөө байдаг.

Тэр тэдэнд Өөрийн гэрээг мэдүүлнэ.

Дуулал 25:14

Ариун Сүнс бол үнэний сүнс бөгөөд биднийг үнэн рүү хөтөлдөг гэдгийг дахин хэлье. Бурханы эсвэл Есүсийн талаар ойлгохыг хүсч буй Бичээсийн хэсэг танд бий юу? Энэ нь ямар утгатай болох, таны аж амьдралд хэрхэн хэрэгжихийг нь Ариун Сүнснээс асуу. Тэгээд хэлсэн хариулыг нь бич.

*Тэгээд Тэр Мосегээс эхлэн бүх эш үзүүлэгчид, бүх Судар
Өөрийнх нь тухай юу хэлснийг тэдэнд тайлбарлав.
Лук 24:27*

Ариун Сүнс Бичээсийн үнэнийг илчлээд зогсохгүй, бидний талаарх үнэнийг илчилдэг.

Танд ойлгомжгүй зүйл амьдралд тань байна уу? Юу болов гэлтэй та гэнэт огцом уурлах юмуу айдаг уу? Ариун Сүнс шалтгааныг нь мэднэ. “Ариун Сүнс минь, миний энэ байдлын жинхэнэ учир шалтгаан нь юу вэ? Надад харуулж өгөөч. Би энэ байдлыг яаж ялахыг зааж өгөөч”. Түүний илчилсэн зүйлийг бич.

Танд ямар нэг ойлгомжгүй нөхцөл байдал өмнө тулгарсан юмуу эсвэл одоо тулгарч байна уу? Сүнс мэднэ. “Ариун Сүнс минь, энэ учир явдлын шалтгаан нь юу вэ? Та миний дотор юуг өөрчлөхийг хүснэ вэ? Үүний төлөө би Тантай яаж хамтарч ажиллах вэ?” Түүний илчилсэн зүйлийг бич.

Дэлгэрэнгүй судлахыг хүсбэл:

Есүс Аавтайгаа маш дотно байсан: **Матай 14:22-23; 17:1-5; Марк 1:35; 6:31, 46-47; Лук 5:16; 6:12**

Бид Бурханы Сүнсэнд ойртбол Тэр бидэнд ойртодог: **Дуулал 16:8; 34:18; 73:28; 145:18; Еврэй 10:22; Иаков 4:8**

Дөрөвдүгээр өдрийн чимээгүй цаг

ТҮҮНИЙГ БҮҮ ГОМДОО

Бурханы Ариун Сүнсийг бүү гомдоо.

Золилтын өдрийн төлөө та нар Түүгээр тамгалуулсан билээ.

Ефес 4:30

Ариун Сүнс тэй нөхөрлөнө гэдэг юу гэсэн үг вэ! Түүний оршихуй бидний амьдралын талбар бүрт амь өгдөг. **Катрин Кульманы** хувьд энэ нь амьдралын хэлбэр байсан. Түүнийг Бурханы хайр, Сүнсний хүчийн тухай ярьж, олон хүнийг Бурханы гайхамшигаар эдгээхийг хүмүүс харсан. “Дэлхий дээрх хамгийн аугаа хүч” номдоо Кульман Сүнс хэрхэн гомддог тухай өгүүлжээ:

“... Ариун Сүнс Гурвалын аугаа хүчирхэг нэгэн мөн боловч, тун эмзэг тул амархан гашууддаг. Энэ гайхамшигтай Нэгэн хорсол, уур хилэн, хорон муу үгст гашууддаг. Өөрөөр хэлбэл эв нэгдлийн холбоо дотор Сүнсний нэгдлийг сахихын төлөө номхон даруу, тэсвэртэй, бие биеэ хайрлах, хатуужилтай байхын эсрэг бүх зүйл Түүнийг гашуудуулдаг.

Сүнсийг юугашуудуулж, бидний амьдралд Өөрийгөө илэрхийлэхээс татгалзахад хүргэдгийг ойлгох нь тун чухал. Ариун Сүнсийг гашуудуулах талаар хэлсэн Ефес 4-р бүлгийг анхааралтай уншина уу. (1-6, 17-32-р ишлэлийг илүү анхаарч уншаарай).

Ямар хандлага, оюун санаа, зан үйлдэл Ариун Сүнсийг гашуудуулдаг вэ? (17-24)

Ефес 4:17-24-д Ариун Сүнсийг гомдоодог, Түүний оршихуйг илэрхийлэхээс биднийг салгадаг амьдралын хэв маяг, сэтгэлгээг бичжээ.

25-31 дээр хэлсэн Сүнснийг гомдоодог ерөнхий үйлдлийг базаж хэлнэ үү. Мөн тус хэсэгт хэлсэн бас бус тодорхой үйлдлийг бичих цаг гаргана уу.

Тийм ээ, бид Сүнснийг гомдоож чадна, гэхдээ бас баярлуулж чадна! 1-7, 14-15, 25, 29, 32-р ишлэлийг анхааралтай уншиж, Сүнснийг баярлуулдаг зүйлсийг бичнэ үү.

Ариун Сүнснийг гомдоохгүй байх түлхүүр нь цэвэр ариун байдал, эв нэгдлийн сүнснийг хадгалах юм. Бардам ба цэвэр бус байдал нь Сүнсний ажлыг хөшөөж, даруу байдал нь Сүнсний ажлыг сулладаг. Бурханы өмнө чимээгүй зогсоод “Би таныг гомдоож байна уу?” гэж асуу. Тэрбээр ямар нэг зүйл илчилбэл, гэмшиж Түүнийг баярлуулах цэвэр, даруу замаар явах нигүүлсэлийг гүй.

Тавдугаар өдрийн чимээгүй цаг

ТА АРИУН СҮНСНИЙ ГЭР

Та нар өөрсдөө Бурханы сүм мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдог гэдгийг мэддэггүй юм уу?

1Коринт 3:16

Бүхнийг мэддэг, чаддаг, хүчирхэг Бүтээлч Бурхан таны зүрхэнд нутаглахаар шийджээ! Тийм ээ, Есүсийг үхлээс амилуулсан тэр Сүнс таны дотор оршин байна!

Пастор, зохиолч, Грек судлаач эрдэмтэн **Рик Рэннэр** Бурханы Сүнсний гэр байна гэж юу болох тухай хэлжээ:

“Ариун Сүнс таны зүрхэнд дэндүү дурласандаа гэрээ болгожээ. Тэр таны дотор амьдрахдаа баяртай байсан! Тэрбээр таны зүрхэнд нүүж ирээд, шинэ гэртээ бүр мөсөн суурьшсан!

Таныг аврагдахад зүрхэнд тань туйлын гайхамшиг өрнөжээ. Ариун Сүнс зөрчил, нүгэлдээ үхсэн таны сүнснийг аваад, цоо шинэ болгож амилуулсан. Таны дотор хийсэн түүний үйлс дэндүү сүр жавхлантай байсан тул Тэрбээр ажлаа дуусгахдаа таныг Өөрийнхөө бүтээл гэсэн (Ефес 2:10). Тэр үед таны сүнс Бурханы гайхамшигт сүм гэгдсэн!

Та явсан газар, ярьсан яриа, оролцсон үйл ажил бүртээ Бурханы Сүнснийг дагуулдаг. Зогсоод энэ тухай дахин нэг бодоод үз.

Энэ үнэн танд урам, баяр хөөр, хүч хайрлаж байна уу? Тэгэхээр одоо юу гэж залбирмаар байна?

Ефес 3:14-20, Лук 12:11-12; Иохан 14:12-17; Колоссай 1:27; 2Тимот 1:13-14; Ром 8:1-17 дээрх Бурханы амлалтыг бодож үзээрэй.

Энэ үнэн танд ямар үүрэг оноож бас юуг ухааруулж байна? Хариулт тань таны залбирлыг хөтөлж байна уу?

Үзэж, сонсож зугаацах зүйлс, нөхөрлөх хүмүүс, оролцох үйл ажлаа бодож байж сонголтоо хийнэ үү.

Тэгвэл та Ариун Сүнстэй харилцах харилцаагаа юу гэж дүгнэх вэ? Та Түүнтэй дотно нөхөрлөж, түншилж байна уу? Та түүний дуу хоолойг сонсож, Түүнийг амьдралдаа жинхэнээсээ оролцуулж байна уу? Түүнийг гэртээ тав тухтай байлгахын тулд одоо их цэвэрлэгээ хийх цаг нь болсон уу? Таны зүрхний үнэн байдлыг илчлэхийг Түүнээс гуй. Тэр юу гэж байна? Ямар алхам хий гэж байна?

Иймд ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл мөн. Энэ үеийн явдалд бүү нийцэгтүн. Харин зүрх сэтгэлээ шинэчилснээр өөрчлөгдөж Бурханы хүсэл юу болохыг, тухайлбал сайн, тааламжит, төгс төгөлдөр хүслийг батлагтун.

Ром 12:1-2

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

Бид Ариун Сүнстэй нөхөрлөдөг.

Нөхөрлөл гэдэг нь нөхөрлөл, ханьсал, харилцаа, дотносол, хамтдаа хуваалцах, нийгмийн харилцаа, түншлэл, хамтын оролцоо, харилцан зөвшилцсөн нэгдэл гэсэн утга бүхий *κοινωνία* гэсэн Грек үг юм. Энэ төрлийн харилцааг 3 ангилж болно.

- 1 | Ариун Сүнс биднээс хоёрдмол бус нөхөрлөлийг (*κοινωνία*) хүсдэг. Энэ нь амьдралаа хуваалцах нөхөрсөг харилцаа юм. Ариун Сүнсний нөхөрлөлийг урьж, анхаарах нь яагаад тийм чухал вэ? Ингэж хандахгүй бол яах вэ?
- 2 | Нөхөрлөлөөс гадна Ариун Сүнс бидэнтэй түншлэхийг хүсдэг. Түншүүд бие биеэ амжилтанд хүргэх үүднээс юугаар бодитой тус хүргэж чадах вэ? Хуучин гэрээний Бурханы дагалдагч болох Абрахам юмуу Мосегээс өнөөгийн бидний Ариун Сүнстэй тогтоох түншлэл маань юугаараа онцгой вэ? Хариулт тань танд урам зориг хайрлаж байна уу?
- 3 | Ариун Сүнстэй нөхөрлөх нөхөрлөл нь нөхөрлөл юмуу түншлэлээс хавьгүй гүн гүнзгий юм. Энэ нь дотносол буюу харилцсан зөвшилцсөн ойр дотно харилцааг агуулна. Итгэгч хүнийхээ хувьд бид Ариун Сүнстэй яаж харилцаагаа хөгжүүлэх вэ?

ХҮНДЭТГЭЛ

Энэ нь хүндэтгэлийн бүх илрэл эсвэл үйлдэл, үгээрээ харуулах өндөр үнэлгээ юм. Үндсэндээ өндөр үнэлэмж өгөх, эрхэмлэх, таалан соёрхох, мэхийн ёслох юм.

- 4 | Ариун Сүнсний гол үйл ажил нь Есүсийг илчилж Түүнд алдар хүндэтгэлийг өргөх ажээ. Ариун Сүнс Христийг илчилж, Өөрийг нь үнэхээр хүндэтгэсэн газар Өөрийгөө илэрхийлдэг. Хүндэтгэл гэдэг үгийн тодорхойлолтыг анхааралтай уншина уу. Бид чуулганаараа болон ганцаараа Ариун Сүнсийг яаж хүндэтгэж болох вэ?
- 5 | Ариун Сүнс (Бурханы Сүнс) Бичээст хэзээ ч эм хүйсээр бичигдээгүй боловч, зарим үйлдэл нь эмэгтэй шинжтэй байдаг. Эхлэл 1:27-г анхааралтай уншаад, Бурханы бөгөөд Ариун Сүнсний зан чанарын талаар илчилж буй зүйлийг тайлбарла. Үнэнийг мэдэх нь Ариун Сүнс та хоёрын харилцаанд яаж нөлөөлж байна?
- 6 | Ариун Сүнс бол маш эмзэг, зөөлөн, тайтгаруулагч мөн чанартай. Болгоомжгүй зан маань Сүнсийг гашуудуулж мэдэх. Тэгвэл тэрбээр биеэ хураагаад л чимээгүй болчихдог. Ефес 4:29-32-г анхааралтай уншаад, ямар үйлдэл Сүнсийг гомдоодгийг нэрлэ. Гашуудуулах нь 1Тесалоник 5:19-22 дээр ярьсан Сүнсийг бөхөөхөөс юугаараа ялгаатай вэ? Иймэрхүү үйлдлээс яаж сэргийлэх вэ?
- 7 | Бурхан хүний ганцаас (Ариун Сүнсийг доромжлох) бусад бүх нүглийг уучилна. Матай 12:22-33 (мөн Марк 3:22-30, Лук 12:10) дээрх Есүсийн анхааруулгыг унш. Эдгээр ишлэлийн гэрлээр Ариун Сүнсийг доромжлох гэдэг нь ямар утгатай болохыг тайлбарла. Есүс яагаад үүнийг тийм хүчтэй эсэргүүцсэн гэж бодож байна?

ТЭМДЭГЛЭЛ

Бүлгийн дүгнэлт:

- Ариун Сүнс бидэнтэй тасралтгүй нөхөрлөхийг хүсдэг.
- Нөхөрлөлд нөхөрлөл, түншлэл, дотносол багтана.
- Нөхөрлөл нь амьдралаа хуваалцаж, харилцаагаар дамжуулан холбоотой байхыг хэлнэ.
- Түншлэл нь хамтын ажиллагаа бөгөөд энэ нь харилцаан дээр үйлдэл нэмэх явдал юм.
- Дотносол нь нөхөрлөлийн хамгийн гүн төвшин бөгөөд энд бид Ариун Сүнстэй, Ариун Сүнс бидэнтэй хамгийн нандин бодол, хүсэл, нууцаа хуваалцдаг.
- Бурхан Ариун Сүнс бидний зүрх сэтгэлийг гэрээ болгожээ.
- Бид Түүнийг гашуудуулахаас сэргийлэх ёстой. Учир нь Тэр эмзэг зөөлөн учраас бидний буруу зүйлд үлэмж гунигладаг.

 3

ХАРИЛЦААНЫ 3 ТӨВШИН

“тэр нь эцгээ, эсвэл эхээ хүндлэх хэрэггүй” гэдэг. Та нар ийнхүү ёс заншлынхаа төлөө Бурханы үгийг хүчингүй болголоо. Зальхай хүмүүс ээ, Исаиа та нарын тухай зөв эш үзүүлсэн юм. Ингэхдээ “Энэ ард түмэн Намайг амаараа хүндэлдэг. Гэвч тэдний зүрх Надаас алс хол байдаг. Тэд хүнээс гарсан тушаал зааврыг сургаж, Надад дэмий хоосноор мөргөж байна.”

-Есүс (Матай 15:6-9)

Нэгдүгээр өдөр

Фарисайчууд Бурханы Үгийн дээр уламжлалыг өргөмжилж байсан учраас Есүс энэ гашуун үгийг айлджээ. Толь бичигт уламжлалыг “бодол, үйлдэл, зан авирын өвлөгдсөн, тогтсон, дадсан үлгэр загвар” гэж тодорхойлжээ. Мэдээж уламжлал нь өөрөө муу зүйл биш. Сайн сайхан ёс уламжлал олон бий. Гэхдээ Фарисайчууд уламжлалыг Бурханы Үгээс дээгүүр өргөмжилсөнөөрөө Үгийг амьдралдаа амьгүй болгожээ. Энэ үнэн өнөөдөр ч хүчин төгөлдөр хэвээрээ. Үнэний ойлголт нь хүний мэдрэмж, уламжлал, гүн ухаанаар бус, Бурханы Үгээр л баталгаажих ёстой.

Фарисайчуудын уламжлал Бүтээгчтэй тогтоох харилцааг нь цуулсаныг Есүс тэдэнд тайлбарласан. Үнэндээ тэд хүний доктринд (сургаал ойлголтод) илүү итгэж байсан учраас Бурханыг хүндэтгээд ч нэмэргүй гэж мэдэгдсэн. Фарисайчууд сохор байдлаа гэмшиж, үнэнийг тэврэхээс нааш Бурхантай жинхэнэ дотнослын талаар ярих ч хэрэггүй байжээ. Үүнтэй адил бид Сүнстэй дотно

харилцаа тогтоохын тулд хүний уламжлалыг хойш тавьж, Түүний Үгт тодоос тод хэлсэн үнэнийг тэврэх ёстой ажээ. Үгүй аваас Фарисайчуудын адил Бурхантай дотносох талаар яриад ч хэрэггүй.

Шилдэг багш

Би Сүнстэй дотносохоосоо өмнө Библиэ уншаад “*Би Бурханд бүх зүрхээрээ хайртай ч, энэ бүхэн нэг л хуурай байх юм*” гэж боддог байв. Гэтэл би үнэндээ Ариун Сүнсийг залбирал судлалдаа урьдаггүй байжээ. Ариун Сүнс л Бичээсийг зүрхэнд минь амилуулдагийг би хожим сурсан юм. Түүний удирдамжаар Библи зүгээр нэг үг биш, харин амьдралын охь болдог.

2Коринт 3:6:

Тэр биднийг үсгээр бус, харин Сүнсээр *шинэ гэрээний* үйлчлэгчид байх чадвартай болгожээ. Учир нь үсэг хөнөөдөг, харин Сүнс амь өгдөг аж.

Бурханы Үгээр илэрхийлэгдсэн “Шинэ гэрээ” нь зүгээр нэг дүрэм бүтцийн жагсаалт биш, харин үүнд захирагдсан хүмүүст амьдрал хайрладаг жинхэнэ амь юм. Бид Ариун Сүнсээр дамжуулж л энэ гэрээг бүрэн дүүрэн эдлэж чадна. Учир нь Тэр л биднийг Христ дотор хэн болох гайхамшигт нууцыг илчилдэг (энэ бол Шинэ гэрээний мессеж). Тиймээс бид Библи судлахдаа шилдэг Багшаа урих учиртай.

Та заадаг хичээлдээ дургүй багштай байсан уу? Түүний хичээл хамгийн залхмаар байдаг. Энэ хичээлийг өнгөрөөж ядах нь яг л шүдээ өрөмдүүлэхтэй адил тарчилмаар байдаг сан. Түүнчлэн оюутандаа дургүй багштай байж үзсэн үү? Ой гутмаар. Харин Ариун Сүнс Бурханы Үгийн нууцыг заахдаа ч дуртай бас танд ч дуртай! Христийн танд зориулсан бэлэг бүрийг та өөрийн болгоосой гэж Ариун Сүнс хүсдэг. Бид асууж, гуйх л юм бол Тэрбээр амьдралын нууцыг бидэнд дуртайяа дэлгэнэ.

Уур амьсгал ба оршихуй

Харамсалтай нь бид энэ гайхамшигтай итгэлийн аянаа Хөтөчгүй хийхийг оролддог. Үнэндээ өнөөгийн олон чуулган Ариун Сүнснийг сайн танихгүй. Бид Түүний гайхамшигт оршихуйг өөрсдөө ч мэдэлгүй уур амьсгалаар орлуулчихжээ. Ариун Сүнсний оршихуйг “жигтэй” арга замаар үйлдвэрлэх гэж оролдсон хэдэн хүнээс болж бид Ариун Сүнсний илрэлийг хориглосонтой адил гэх үү дээ.

Намайг битгий ташаа ойлгоорой. Чуулганд сайхан уур амьсгал амин чухал гэдэгт би итгэдэг. Чуулган өнгөрсөн хэдэн арван жилд соёлын томоохон өөрчлөлт хийсний нэг нь уур амьсгалаа сайжруулсан явдал байлаа. Чуулган олон талаараа дэлхийд нэвтэрч тэдэнд илүү таатай газар болжээ. Бурхан ч үүнд дуртай гэдэгт би итгэдэг. Паул ч “Яг надтай адил байгтун. Хүмүүсийг аврагдаасай гэсэндээ би өөрийн ашгийг бус, харин олны ашгийг хайн, бүхний дотор бүх хүний таалалд нийцүүлдэг” хэмээн мэдэгдсэн (1Коринт 10:33). Бид хувь хүний бүтээлч авьяаст хөрөнгө оруулж, технологио сайжруулсан бөгөөд миний очсон хамгийн шинийг санаачлагч газруудын нэг нь чуулган л байдаг. Христийн бие шинийг санаачилж байнга шинэ төвшин рүү тэмүүлэх ёстой. Гэхдээ Чуулган Ариун Сүнснийг үйл ажилдаа урихгүй бол дэлхий дээрх эрх мэдэл, хайр, хүчийн байр суурьтаа хэзээ ч суухгүй. Ариун Сүнс бол бидний ахлах түнш гэдгийг бүү март.

Гэхдээ бид Ариун Сүнснийг ч уриад, уур амьсгалдаа ч анхаар болно. Энэ хоёрыг хослуулж чадсан чуулганд очих үнэн таатай. Ариун Сүнсний оршихуйн илрэл хүмүүсийг хаанчлалд орохоос хойш татна гэдэг ойлголтод бүү урхидуул. Элч нар Ариун Сүнсний нөхөрлөж байсныг харсан учраас л төөрсөн хүмүүс тэдэн дээр ирсэнийг бүү март. Ариун Сүнсгүйгээр хүрсэн ахиц дэвшил бүр нь хоосон болно.

Бурханы Хүү Есүс ч Өөрөө Ариун Сүнсний хүчийг хүлээж авахаасаа өмнө юу ч хийгээгүй (Лук 4:1-15-ыг уншина уу). Бичээс “Тэрбээр Сүнсний хүч дотор эргэж ирсэн” гэж хэлжээ. Есүс дөч

хоног цөл газар диаволд соригдсоныхоо дараа ийм байдалтай эргэж ирсэн. Тэгээд Назарт буцаж ирээд ийн тунхаглажээ:

—*Эзэний Сүнс Над дээр байна.*

Учир нь сайн мэдээг ядууст дэлгэрүүл гэж

Тэр Намайг тосолсон юм. Тэр Намайг илгээсэн нь

Олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглах,

Сохруудад хараа оруулах,

Дарамтанд байгсдыг чөлөөлөхийн сацуу, мөн Эзэний тааламжит жилийг тунхаглахын тулд болой.

(Лук 4:18-19).

Есүс дэлхий дээр Аавынхаа хүслийг биелүүлэхийн төлөө Бурханы Сүнсний хүч дотор ажилласан. Чуулган ч бас яг энэ хүчээр сүнсээр дорой хүмүүст сайн мэдээг номлож, эмтэрсэнд зүрхтэйг эдгээж, хоригдлуудыг чөлөөлж, Бурханы мутар аврахааргүй богино биш гэдгийг харуулах ёстой. Гэхдээ Сүнсний хүчинд найдахгүйгээр энэ тэнгэрлэг ажлыг хийхгүй. Есүст Сүнсний хүч хэрэгтэй байсан бол бидэнд хэрэггүй юу?

Хоёрдугаар өдөр

“Есүс л хэрэгтэй”

Есүс Христийн оршихуйн араас нэхэл дагал болдог байдаг хүмүүсийг би хамаг зүрхээрээ дэмжинэ. Хүмүүс “Чуулганд Есүс л хэрэгтэй” гэж ярьдаг. Би ч үүнтэй санал нийлнэ. Гэхдээ Есүсийг хэн бидэнд илчилдэг вэ? Ариун Сүнс. Яагаад бид Ариун Сүнснийг ажил үйлс бүртгээ оролцуулахыг хүсдэггүй вэ? Есүс дагалдагч нартаа ийн айлдсан:

Та нарт хэлэх зүйл Надад олон бий ч та нар одоо тэдгээрийг даахгүй. Харин *үнэний Сүнс* болох Тэр ирэхдээ *та нарыг бүх үнэн уруу удирдана*. Учир

нь Тэр Өөрийн санаагаар биш харин алив сонссон юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ. Тэр Намайг алдаршуулна. Яагаад гэвэл Тэр Минийхийг авч, түүнийгээ та нарт мэдүүлнэ. Эцэгт байгаа бүх юм Минийх. Тиймээс “Тэр Минийхийг авч, түүнийгээ та нарт мэдүүлнэ” гэж Би хэлсэн билээ. (Иохан 16:12-15).

Ариун Сүнс Есүсийг алдаршуулдаг. Ариун Сүнсээр л Есүс бидэнд илчлэгдсэн. Бурханы тогтоосныг бид өөрчлөхгүй. Хэрэв бид амьдралдаа Есүсийг улам ихээр хүсч байвал Ариун Сүнтэй дотно нөхөрлөх ёстой. Тиймээс л Түүнийг Христийн Сүнс гэсэн (1Петр 1:11; Ром 8:9). Сүнс Христ доторх бидний амьдралын “нэмэлт хачир” бус, харин дэлхий дээрх Христийн амин хүчин зүйл юм. Түүнийг хүндэтгэхгүй бол Тэр Өөрийгөө харуулахгүй. Тиймээс Сүнсийг хүндэтгээгүй газар Христийн оршихуй, хүч байхгүй. (Христийн өөрчлөлтийн хүчийн бай болсон) энэ дэлхий Чуулганыг амьгүй бөгөөд хүчгүй гэж үздэгийн шалтгаан энэ биш үү?

Бурхантай тогтоох дотно нөхөрлөл

Нөхөрлөлийн эцсийн зорилго нь хувийн дотно нөхөрлөл болой. Бурханы Сүнс тантай нөхөрлөхийг хүсдэг. Үнэндээ бүр хүслэн болдог. “Түүний бидний дотор нутаглуулсан сүнс нь атаархан хүсдэг” (Иаков 4:5). Тэр юуны төлөө тэмүүлнэ вэ? Та бид хоёртой дотно нөхөрлөхийн төлөө. Бид хамгийн дотно хүмүүстэйгээ үүнийг л хүсдэггүй гэж үү? Тэрбээр бүр *хардан* байж хүсэн тэмүүлдэг гэснийг тэмдэглэнэ үү. Энэ нь бид өөр нэгэнтэй зугаацахыг зүгээр харж суухгүй гэсэн үг.

Бурхан биднээс бүрэн зориулалт хүсдэг. “Ертөнцтэй найзлах нь Бурхантай дайсагнах явдал гэдгийг та нар мэдэхгүй юу?” (Иаков 4:4) *Дайсагнал* гэдэг үгийг толь бичигт “дайсагналын мэдрэмж юмуу нөхцөл байдал; үзэн ядалт; хорон хүсэл; хорсол” гэж тодорхойлжээ. Маш хурц үгс. Тэгвэл яагаад дэлхийтэй нөхөрлөх нь Бурхантай дайсагнасан явдал болдог юм бэ? гэж асууя.

Дэлхийтэй нөхөрлөх нь махан биеийн тачаал юм. Энэ нь олз, хэргэм зэрэг, байр суурьтай хөөцөлдсөн, махан биеэ идээшүүлсэн явдал. Энэ нь биднийг хувхайрал, хоосрол руу л хөтөлнө гэдгийг Ариун Сүнс мэддэг. Бурхан биднийг “үр харам” хэмээн хайрладаг учраас сүнсээ мөхөөх зүйлстэй аальгүйтэхийг маань үзэн яддаг. Тэр бол төгс Аав. Үр хүүхдээ буруу зүйлтэй хутгалдахыг ямар ч аав таалахгүй. Тиймээс л Бурхан биднийг дэлхийтэй нөхөрлөхийг тэвчихгүй. Есүс бидэнд бялхсан амьдрал хүсдэг (Иохан 10:10) бөгөөд Хүүгийн энэ хүслийг Ариун Сүнс илчилдэг. Бурханы Гурвал нэг л зорилготойг бүү март. Бурхан хүүхдүүдтэйгээ халуун дотно харилцаа хүсдэг. Бид дэлхийтэй явалдахдаа Бурхантай тогтоох дотно харилцаанаасаа холддог. Дэндүү эмгэнэлтэй энэ алдаа Аавын маань зүрхийг эмтэлдэг!

Авралаас том

Бурхан бидэнд авралаас том зүйл хүсдэгийг ойлгосон юм. “Аврагдах” нь бидний хувьд “хангалттай” биш. Аврал нь бидний ойлголтоос хол харвасан зүйл бөгөөд тэнгэр дэхь газар нь Бурхан бидэнд өгөхийг хүсч буй зүйлийн зөвхөн эхлэл юм. Бурхан Хүүгээ илгээсэн нь биднийг энэ дэлхий дээр гайхалтай сайхан амьдруулахын төлөө байжээ. Яагаад? Учир нь байнга энэ дэлхийн хүсэл тачаал, айдастай зөрчилдөж буй хүмүүс Бурханы хаанчлалд үр нөлөөтэй давшиж чадахгүй.

Паул нэгэн удаа “...харин одоогийн болон ирэх амийн төлөөх амлалт бүхий сүсэглэл нь бүх зүйлд тустай” (1Тимот 4:8) гэсэн. Сүсэглэл гэдэг үгийг анхаарна уу. Бурханыг мэддэг хүн сүсэгтэй байна, учир нь *сүсэглэл нь Бурхантай адил байх юм*. Бараг мэдэхгүй хүнд дуртай байх хэцүү шүү. Бид хүмүүстэй хамт байх тусам уусдаг. Тиймээс л Иаков дэлхийтэй нөхөрлөх талаар ярьсаныхаа дараа “Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. Нүгэлт хүмүүс та нар гараа цэвэрлэ. Хоёр санаатай хүмүүс та нар зүрхээ ариусга” гэж хэлсэн юм (Иаков 4:8). Бурхан таныг Өөртэйгээ адилхан болгохын тулд тантай хамт байхыг хүсдэг. Бурханыг дотно таних тусам бид сүсэгтэй болно. Харин энэ дотно харилцааг

гагцхүү Сүнсээр л дамжин тогтооно (1Коринт 2).

Зарим итгэгчид “дэлхийтэй нөхөрлөх нь Бурхантай дайсагнасан явдал” хэмээн дэлхийгээс хөндийрдөг. Энэ нь ямар ч утгагүй зүйл. Чуулган дэлхийгээс дөлөөд байвал яаж байлдан дагуулах билээ? Чуулган Есүсийг үлгэрлэн дагах ёстой. Төөрсөн ядсан хүмүүс Есүс рүү л ирсэн. Тэр татвар хураагч, янхан зэрэг шашны удирдагч нарын нүд үзүүрлэдэг хүмүүстэй хамт байж, тэр бүү хэл найр наадамд нь хүртэл оролцсон. Гэхдээ Тэр өөр байсан юм. Есүс дэлхий дээр байв ч, дэлхийн хэсэг болохгүй байхыг төгс үлгэрлэн харуулсан билээ. Тэр нүгэлтэнүүдийн төлөө элэг эмтэрсэн.”Сүсэгтэй хүмүүсийн” жигшдэг хүмүүсийг Есүс яагаад хайрласан бэ? Учир нь тэд илүү том зорилгын төлөө өлсөж цангасан, даруу байгааг Тэр мэдсэн. Есүс тэдний нэг болохоор бус, харин тэдэнд цоо шинэ зам зааж өгөхөөр хамт байсан юм.

Үүнтэй адил бид сэтгэл санааны хувьд эмгэрч цөхөрсөн хүмүүст хүрэх дуудлагатай. Чуулган Христийн гар хөл болохгүй бол хэн болох вэ? Бид Түүний Бие. Нигүүлсэлийн өөрчлөгч хүчээр өдгөө бид Христийн дотор буй. Бид газар дээр Түүнийг төлөөлөх элчин сайдууд. Бурханы үнэний гэрлийг бид дэлхийд хүргэхгүй бол хэн ч хүргэхгүй.

Гуравдугаар өдөр

Даруу Жентельмэн

Ариун Сүнстэй хамт явахдаа би Түүнийг жинхэнэ Жэнтельмэн гэдгийг мэдсэн юм. Тэр хэзээ ч биднийг албаддаггүй. Бид Түүнтэй холбогдохгүй бол Тэр дуугүй л байна.

Би хорин таван жил аялж үйлчлэхдээ намайг онгоцны буудлаас угтаж авдаг жолооч нарын талаар нэг зүйл анзаарсан юм. Тэд надад эелдэг хандаж, туслаж, миний үйлчлэлийг нэгт нэгэнгүй тайлбарлаж өгдөг. Гэхдээ би ам нээхээс нааш тэд дуугардаггүй. Учир нь пастор нь тэдэнд намайг үйлчлэхээс өмнө саад болохгүй байх заавар өгдөг. Надад үйлчилж буй тэр гайхалтай, тусч жолооч

нарт би үргэлж талархаж явдаг учраас заавал гэр бүл, чуулганых нь талаар асуудаг юм.

Ариун Сүнс ч бас адилхан гэж би боддог. Бид Түүний дуу хоолойг сонсохыг хүсэхээс нааш Тэр бидэнтэй ярихгүй. Бид Бурханд ойртбол Бурхан бидэнд ойртоно гэж Иаков хэлсэнийг санаж байна уу? Бид анхны алхам хийх үүрэгтэй. Бид Түүнтэй гайхамшигтай нөхөрлөлийг зориуд эхлүүлэх учиртай. Энгийнээр хэлбэл Тэр танд хамгийн аугаа урилга өгсөн. Харин одоо бүх зүйл танаас шалтгаална.

Энэ үнэнийг олон итгэгч мэддэггүй учраас “Бурхан надтай ярихгүй байна”, зарим нь бүр “Бурхан надтай ярихгүй бүр хэдэн арван жил болж байна” гэж ярьдаг. Гэхдээ энэ хүмүүс Библи дээр хэлсэн шиг Бурхантай нөхөрлөхийн төлөө явдаг болов уу? Бурхантай ойр баймаар байвал Түүнийг хайх хэрэгтэй. Энэ нь Ариун Сүнстэй нөхөрлөхийн төлөө явах хэрэгтэй л гэсэн үг.

Би таныг үүнийг үйлдээхэд уриалж байна. Тэр хэрхэн хариулахыг хараад та мэлэрднэ. Тэр таныг орхихгүй, хаяхгүй (Еврей 13:5). Гэхдээ та Түүнтэй ярихгүй бол Тэр дуугүй л байх учраас та Түүнтэй байхын сайхныг хэзээ ч мэдэрч, ашиг тусыг хүртэхгүй.

Бурханы гүн юмс

Иохан 16-р бүлгийг ахин нэг харъя.

Та нарт хэлэх зүйл Надад олон бий ч та нар одоо тэдгээрийг даахгүй. Харин үнэний Сүнс болох Тэр ирэхдээ та нарыг бүх үнэн уруу удирдана. Учир нь Тэр Өөрийн санаагаар биш харин алив сонссон юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ. Тэр Намайг алдаршуулна. Яагаад гэвэл Тэр Минийхийг авч, түүнийгээ та нарт мэдүүлнэ. Эцэгт байгаа бүх юм Минийх. Тиймээс “Тэр Минийхийг авч, түүнийгээ та нарт мэдүүлнэ” гэж Би хэлсэн билээ.

(Иохан 16:12-15)

Есүс цовдлуулахынхаа өмнөхөн дагалдагч нартай хамт байхдаа үүнийг хэлжээ. Тэр орой Ромын цэргүүд Түүнийг баривчилж, шүүхээр авч явсан юм. Тэгэхээр Есүс хамаг л чухал үгээ энэ үед л дагалдагч нартаа хэлсэн нь тодорхой.

Есүс “Та нарт хэлэх зүйл Надад олон бий ч та нар одоо тэдгээрийг даахгүй” гэж хэлсэнийг тэмдэглэнэ үү (и12). Тэдгээр эрчүүдийн хувьд Есүс хамаг утга учир нь байсан. Тэд Түүнийг дагахаар гэр бүл, нөхөд, ажлаа орхиж, хэдэн жил хамт амьдарсан. Тиймээс Юу яриад байгаа юм бол? гэж бодож байсан байх. Гэтэл Есүс нэгэн гайхалтай амлалт өгсөн: “Харин үнэний Сүнс болох Тэр ирэхдээ та нарыг бүх үнэн уруу удирдана. Учир нь Тэр Өөрийн санаагаар биш харин алив сонссон юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ” (и13). Өөрөөр хэлбэл “Би одоо та нартай биеэрээ байгаа ч, Миний өгөх зүйлийг та нар бүрэн хүлээн авч чадахгүй. Гэхдээ Би та нарт Ариун Сүнсийг илгээнэ. Тэр Миний үгийг хэлж, хүслийг илэрхийлж, айсуй зүйлст та нарыг бэлтгэнэ” гэж амласан. Гайхалтай амлалт! Хэдхэн цагийн өмнө Есүс юу гэж айдсаныг эргэн саная:

Харин Би та нарт үнэнийг хэлж байна. Миний явах нь та нарт хэрэгтэй. Хэрэв Би явахгүй бол Туслагч та нар уруу ирэхгүй. Харин Би явбал Өөрөө Түүнийг та нар уруу илгээнэ. (Иохан 16:7)

Энэ үгийг та одоо цоо шинээр харж байгаа байх. Бурхан ээдрээтэй тоглоом тоглодог Нэгэн биш. Харин ч энгийн Бурхан. Хайртай хүмүүс маань бидэнд нээлттэй байхад бид дуртай байдаг. Бурхан ч ялгаагүй. Есүс газар дээр алхахдаа “яг л Аав” байсан (Еврей 1:1-3; Колоссай 1:15-19). Харин одоо Есүс тэнгэрт Аавынхаа баруун гарт суугаа. Харин Ариун Сүнс газар дээр Бурханы хүмүүсийн дотор бөгөөд хамт байдаг Бурханы Гурвалын Нэг учраас Бурханыг гүн гүнзгий мэдэхийг хүсбэл, бид үнэний Сүнсийг л мэдэх хэрэгтэй.

Эргэлзэгч Томас

Есүсийг үхлээс амилсаны дараа 10 дагалдагч нь түгжээтэй өрөөндөө сууж байв. Гэтэл гэнэт Есүс тэдний дунд орж ирсэн тул дагалдагч нар мэл гайхаж, цэл хөхрөв. Тэр бүү хэл Есүс Өөрийгөө сүнс биш гэдгийг батлах хэрэгтэй болжээ. Тэр арав баярлан хөөрч, энэ баяраа хожим (тухайн үед тэнд байгаагүй) Томастай хуваалцтал тэрбээр үүнийг сонссон даруйдаа “Түүний гар дахь хадаасны сорвийг үзэж, хадаасны ормонд нь хуруугаа хийн, Түүний хажуу уруу нь гараа хийж үзэхээс нааш би итгэхгүй” гэжээ. (Иохан 20:25)

Хэдэн өдрийн дараа дагалдагч нар халуун бүлээрээ цуглаад байтал Есүс дахиад л гэнэт гарч ирээд, хамгийн түрүүнд Томас дээр очоод: “За алив Томас минь, эргэлзээгээ тайл” гэжээ. “Хуруугаа нааш нь хүргэ, Миний гарыг үз. Гараа нааш нь хүргэ, миний хажуу руу хий. Итгэлгүй биш, итгэлтэй бай” (Иохан 20:27). Харин Томас “Эзэн минь, Бурхан минь!” гэж хэлсэн юм. Харин Есүс юу хэмээв?

“Чи намайг хараад итгэв үү? Хараагүй атлаа итгэсэн хүмүүс нь ерөөлтэй еэ!” (Иохан 20:29)

Есүс үндсэндээ “Томас минь, харахгүйгээр итгэсэн ерөөгдсөн хүмүүс байдаг юм шүү” гэжээ. Би энэ талаар “Есүс жаахан хатуурхажээ. Томаст хэлэх ч үг олдохгүй гэмшиж, асар хүнд байсан байж таараа. Гэтэл Есүс түүн рүү харж байгаад л “Хараагүй ч итгэсэн хүмүүс ерөөлтэй гэж хэлж л байдаг” гэж боддог байсан юм. Есүс яагаад хөөрхийд ингэж ширүүлэхсэнийг би ойлгохгүй байв. Гэтэл нэг өдөр Эзэн надад: *“Би Томасыг зэмлээгүй, ердөө Намайг биечлэн харсан хүмүүсээс илүү Сүнсээр мэддэг хүмүүс Надтай хавьгүй дотно байна гэдэг үнэнийг л мэдэгдсэн юм”* хэмээж билээ.

Дөрөвдүгээр өдөр

Харилцааны 3 төвшин

Тэгэхээр Есүс Томаст хандаж хэлэхдээ яг юу хэлсэн бэ? Гүн гүнзгий дотносолыг хараагаар бус, итгэлээр олж авна л гэж хэлсэн.

Харилцааны 3 төвшин байна: биет харилцаа, сэтгэлийн харилцаа, сүнсний харилцаа. Хамгийн өнгөц гүехэн харилцаа нь мэдээж *төрөлхийн* буюу *биет харилцаа* юм. Ихэнх романтик харилцаа эндээс л эхэлдэг: *Хөөрхөн бүсгүй юм аа, Сайхан залуу юм аа. Бид нийлбэл ямарав?* Харамсалтай нь олон хос ийм төвшиний харилцаан дээрээ л гэрлэхдэг: *“Бидэнд зан ааш, сонирхол, харилцааны олон асуудал байгаа ч, яадаг юм. Тэр хөөрхөн, сайхан юм чинь.”* Хуримын хонх алсарч, бал сар дуусч амьдрал эхлэхэд харилцаа нь ядахнаа сэтгэлийн төвшинд хүрээ ч үгүй энэ хос нэг бол харилцаагаа хөгжүүлэх ёстойг ухаарна үгүй бол гэрлэлт нь төгсөнө. Тэд бие биедээ илүү гүн гүнзгий зориулагдахгүй бол гэргий нь найз хүүхнүүд рүүгээ, нөхөр нь найз харцуул руугаа гүйдэлтэй болж, зүгээр л хамтран аж төрж буй ганцаардмал хүмүүс болно. Бурхан гэрлэлтийг ийм байлгахыг хүсээгүй.

Удаах нь *хувь хүний ахуй сэтгэл* юмуу *хувийн зан чанарын харилцаа* юм. Давид Ионатан хоёр ийм харилцаатай байсан. “Давид Саултай ярилцаж дуусахад, Ионатаны сэтгэл Давидын сэтгэлтэй нийцэв. Ионатан Давидыг өөрийн адил хайрлалаа” (1Самуел 18:1). Ионатаныг алагдахад Давид ихэд гашуудсан “Ах Ионатан минь, таны төлөө би зовон шаналж байна. Та надад маш тааламжтай байв. Намайг гэсэн таны хайр надад бүсгүй хүний хайраас илүү гайхамшигтай байв” (2Самуел 1:26). Давид махан биеийн гаж харилцааны талаар яриагүй. Тэд бие биеийнхээ махан биед дурлаагүй, харин цэвэр зүрх сэтгэлийн холбоотой байжээ. Энэ нь зүгээр нэг махан биеийн харилцаанаас хол гүн байв (Давид “бүсгүй хүний хайр” гэхдээ энэ тухай л ярьсан).

Зүрх сэтгэлийн харилцааны төвшин дээр л гэрлэлт сүндэрлэх ёстой. Гэхдээ биеийн харилцаа ч чухал. Би гэргийнхээ гоо

үзэсгэлэнд унаж тусдаг бөгөөд миний хувьд тэр дэлхийн хамгийн гоо бүсгүй. Гэхдээ нөхөр эхнэрийн харилцаа үүнээс гүнзгий хөгжих ёстой. Яг үнэндээ бол Лизагийн дүр төрхөөс илүү зан чанар нь намайг олзолдог.

Гэтэл нэтээр танилцсан хүний төлөө ханиа хаячихдаг хүмүүс байх. Хэдэн жилийн өмнө миний номлосон чуулган дээр цуглааны дараа надтай нэг залуу уулзсан юм. Тэрбээр зургаан хүүхдээ дагуулчихсан байлаа. Хоёр нь гар дээр нь, хоёр нь аавыгаа хормойдчихсон, хоёр нь үүгээр түүгээр гүйлдэж байлаа. Тэрбээр базаахгүй харагдаж байсан тул би түүнээс: “Та зүгээр үү?” гэж асуусан юм. Тэр: “Зүгээр биш ээ. Өнөөдөр гэргий маань намайг хаяад, интернэтээр танилцсан эр дээрээ оччихлоо” гэж хэлж билээ. Тэр эмэгтэйн өөр хүнтэй тогтоосон зүрх сэтгэлийн харилцаа нь эр нөхрөө байтугай, нялх үрээ хаяхад хүргэм хүчтэй байжээ.

Зүрх сэтгэлийн харилцаа нь маш бага махан биеийн харилцаа шаардана эсвэл огт шаардахгүй. Тиймээс гэрлэхээсээ өмнө сайн найзууд байсан хос ер нь хүчтэй гэр бүл болж чаддаг.

Харилцааны дээд төвшин

Харилцааны оргил төвшин нь сүнслэг харилцаа юм. Есүс Томастай ярихдаа энэ төвшиний тухай ярьжээ. Паул “Учир нь хүний дотор буй сүнснээс нь өөр хүний бодол санааг хэн мэддэг вэ? Түүнчлэн Бурханыхыг Бурханы Сүнснээс өөр хэн ч мэддэггүй” гэжээ (1Коринт 2:11). Өөрөөр хэлбэл та тухайн хүнтэй сүнсээр холбогдохоос нааш жинхэнэ бодол, сэдлийг нь мэдэхгүй.

Лиза бид хоёр хуримынхаа 30 жилийн ойг тэмдэглэсэн тухай би ярьсан. Бид хоёр усан сангийн дэргэд суугаад л Бурханы тухай ярилцаж байснаа би хэзээ ч мартахгүй. Энэ мессежийн тухай ч их ярилцсан. Бурхан зүрхэнд минь юу суулгасан тухай ярихад Лизагийн цэц ухаан, илчлэлээр дүүрэн үг уг Сүнсний илчлэлийг улам тодорхой болгож дэлгэрүүлэв. Бид хоёр хоёулаа Сүнстэй дотно харилцдаг учраас хоорондоо гүн гүнзгий сүнслэг төвшинд харилцаж чаддаг.

Тиймээс бид бас хамт залбирдаг. Бид Сүнсний зүйлсийг тойрон нөхөрлөж буй учраас хоорондоо сүнсээр гагнагддаг. Түүнчлэн манай Messenger International байгууллагынхан ч өглөө бүр 15 минутыг нэгдсэн залбиралд зориулдаг юм. Манайхан сүнсээр холбогддог учраас л үүнийг хийдэг. Энэ цаг манай ажилчдын харилцааны төлөө юу хийснийг харах үнэхээр гайхамшигтай. Энэ үнэн бүх харилцаанд хамаатай: Үгийг тойрох нөхөрлөл ба залбирал нь сүнсээр холбодог учраас хүмүүсийн харилцааг дээд төвшинд хүргэдэг.

Сүнслэг зүйлсийн талаар оюунлагаар ярилцах нь сүнслэг нөхөрлөлөөс ялгаатай. Зөвхөн мэдээлэл дээр суурилан Библийн тухай ярьдаг хүмүүс байна. Үүнийг яаж мэдэх вэ гэж үү? Тэдний ярьж байгаа зүйл нь залхуутай бөгөөд бусдыг залхаадаг. Тэд сүнснээсээ биш, зөвхөн тархинаасаа ярьдаг. Харин сүнслэг зүйлсийг сүнснээсээ ярьдаг хүмүүс бас бий. Бид сүнсээр холбогддог учраас ийм хүмүүстэй хэдэн цаг ярьсан ч хамаагүй ядардаггүй.

Тавдугаар өдөр

Бурханы Сүнсээр мэдэхүй

Одоо 1Коринт 2:11-г харъя:

Учир нь хүний дотор буй сүнснээс нь өөр хүний *бодол санааг* хэн мэддэг вэ? Түүнчлэн Бурханыхыг Бурханы Сүнснээс өөр хэн ч мэддэггүй.

Бодол хэмээн орчуулсан Грек үгийг “ахуйн нөхцөл байдал юмуу найрлага” гэж тодорхойлбол хамгийн оновчтой. Паул үндсэндээ “Бурханы Сүнснийг мэдэхгүйгээр Бурханы найрлагыг (Түүний гүн гүнзгий ахуй сэтгэлийг) мэдэх боломжгүй” гэжээ. “Мэдэх” гэдэг нь өнгөц ойлголтоос хавьгүй гүн ойлголттой байхыг хэлэх агаад үүнийг тун бага хүчин зүтгэлээр юмуу эсвэл огт хүчин

зүтгэлгүй олж авдаг. Бидний ихэнх маань ерөнхийлөгчөө мэднэ. Гэхдээ түүнтэй харилцаа холбоотой нь тун цөөхөн. Бид Түүний гүн бодол, хүсэл, жолоо, жинхэнэ итгэлийг нь мэдэхгүй. Үүнтэй адилхан бид Бурханыг Сүнсээр таньж мэдэхгүй бол Түүний талаар ерөнхий мэдлэгтэй л хоцорно.

Паул цааш нь ийн ярьсан: “Бурханы бидэнд үнэгүй өгсөн юмсыг мэдэхийн тулд бид ертөнцийн сүнсийг бус, харин Бурханаас ирсэн Сүнсийг хүлээн авсан юм” (1Коринт 2:12). Гайхалтай мэдэгдэл аж. Бурханы бодлыг Түүний Сүнсээс өөр хэн ч мэдэхгүй (и11) бөгөөд Бурхан бидэнд тэр Сүнсээ өгчээ! Бурханы Сүнстэй харилцах харилцаагаар өдгөө бид Бүтээгчтэй харилцааны хамгийн дээд төвшинд буюу сүнслэг төвшинд харилцдаг.

Паул энэ төвшин рүү Сүнстэй хамт гарсан. Хэдийгээр тэр хэзээ ч Есүстэй биечлэн хамт яваагүй ч, “Ах дүү нар аа, миний тунхагласан сайн мэдээ нь хүний дагуу биш гэдгийг би та нарт мэдэгдэж байна. Би үүнийг хүнээс аваагүй, хүнээр ч заалгаагүй. Харин Есүс Христийн илчлэлтээр хүлээж авсан билээ” (Галат 1:11-12) гэж хэлжээ. Есүс Паулд хэрхэн илчлэгдсэн бэ? Энэ илчлэл хүнээс ирээгүйг Паул хэлсэн. Паул Есүстэй биечлэн уулзаагүй бөгөөд хүнээс илчлэлт аваагүй юм бол энэ илчлэлийг *Христийн Сүнсээр* (Ариун Сүнс) хүлээж авсан байх учиртай.

Паул Аврагчтай хэзээ ч биечлэн уулзаагүй байж Түүнтэй илүү гүн гүнзгий харилцаа тогтоох боломжтой гэж үү? Тэгвэл Есүстэй биеэр хамт байсан Петр амьдралынхаа төгсгөлд бичсэн захидалдаа ийн хэлсэн байдаг: “Бидний хайрт ах Паул өөрт нь өгөгдсөн мэргэн ухааны дагуу та нарт бичсэнчлэн ... *Захидлуудад нь ойлгоход хэцүү зарим зүйл байдаг ...*” (2Петр 3:15-16). Петр Есүстэй хэдэн жил өдөр бүр хамт байсан. Есүс Өөрчлөлтийн уулан дээр сүр жавхлангаа “гайхуулахыг” Петр нүдээрээ үзсэн. Тэр Есүсийг цовдлуулахыг харж, амилсаных нь дараа уулзаж байсан. Харин Есүстэй махан биеэр олон жил нөхөрлөсөн энэ дагалдагч “Паулын Сүнсээр хүлээж авсан зарим илчлэл нь ойлгоход үнэхээр бэрх” гэж хэлсэн байх юм. Би л хувьдаа үүнийг Петртэй харьцуулахад Паул Есүстэй хамаагүй гүн төвшинд нөхөрлөдөг байжээ гэж ойлгодог.

Паул хэзээ ч Есүстэй биеэр хамт байгаагүй боловч, Шинэ гэрээний дийлэнх номыг Сүнсний хүчээр бичсэн. Яаж тэр вэ? Есүсийг бүрэн илчилдэг Сүнсний ачаар. Есүсийн үгийг санаарай: “Та нарт хэлэх зүйл Надад олон бий ч та нар одоо тэдгээрийг даахгүй. Харин үнэний Сүнс болох Тэр ирэхдээ та нарыг бүх үнэн уруу удирдана. Учир нь Тэр Өөрийн санаагаар биш харин алив сонссон юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ.” (Иохан 16:12-13) Паул хэзээ ч Есүстэй уулзаж байгаагүй учраас махан биеийн харилцаанд найдах ч арга байгаагүй. Тэр харахгүйгээр итгэж хүлээж авах ёстой байсан. Үнэндээ тэр Сүнсний үзүүлэхийг хүсч буй зүйлстэй дайсагнагч бүхий л махан биеийн талыг зайлуулсан юм. Есүс Томаст энэ тухай л хэлсэн. Паул Эзэнтэйгээ ямар ч махан биеийн харилцаагүй байсан учраас зөвхөн *сүнслэг харилцаандаа* найдахаас өөр зам байгаагүй. Түүнд үнэндээ өөр сонголт байгаагүй.

Та ч бас Есүстэй ямар ч махан биеийн харилцаагүй байгаа. Үүнийг чинь л “Есүсийг хараагүй хүмүүс нь Түүнтэй илүү дотно байна” гээд буй юм. Есүстэй махан биеэр харилцах боломжгүй хүмүүс бид дотор маань орших Түүний Сүнсээр л дамжуулж Бурхантай дотно харилцаа тогтооно! Гайхалтай үнэн!

Түүнийг гүн гүнзгий таньж мэд

Бидний бие (одоохондоо) аврагдаагүй гэдгийг Бурхан мэднэ. Бидний сүнс аврагдсан; бидний сүнс яг Есүстэй адилхан болсон (1Иохан 4:17). Бидний сэтгэл аврагдах замдаа явна (Иаков 1:21). Харин махан бие маань хараахан аврагдаагүй.

Хүн бид юмнаас амархан залхдаг. Шинэ машин аваад хэсэг хугацааны дараа шинэ биш болдог. Энэ нь аврагдаагүй махан биеийн мөн чанар юм. Махан бие нь маш өнгөц бөгөөд богино настай. Тиймээс Бурхан “Би хүмүүстэйгээ махан биеийн төвшинд бус, харин Сүнсээрээ дамжуулан нөхөрлөнө. Тийнхүү тэд Намайг мэднэ” хэмээгсэн буй.

Чуулган бол Христийн Сүйт бүсгүй юм. Бурхан бидэнтэй нүсэр хурим хийхээр биднийг бэлтгэж буй. Бурхан бидэнд

Өөрийгөө махан биеэр харуулахаасаа өмнө хамгийн гүн сүнслэг төвшинд таниулж байна. Тиймээс л Паул “Иймд үүнээс хойш бид хэнийг ч махан биеийн дагуу үзэхгүй. Хэдийгээр бид Христийг махан биеийн дагуу мэддэг байсан ч гэсэн эдүгээ бид Түүнийг дахиад тийм байдлаар нь мэдэхгүй” гэж бичсэн (2Коринт 5:16). Бид Түүнийг амьд Бурханы Сүнсээр мэднэ. Христ махан биеэр илчлэгдсэн үе байсан. Харин одоо бидэнд Түүнийг Сүнсээр мэдэх завшаан тохиожээ.

Хэрэв бид Түүнтэй Сүнсээр нөхөрлөхгүй бол Хүүг мэдэх завшааныг түлхэж байгаа юм. Сүнс бидэнд Есүсийг илчлэхээр Бурханы зүрх ба тархин дахь бүхнийг уудалдаг. Бурхантай гүн нөхөрлөмөөр байвал Түүний талаарх өнгөц мэдлэгээс давж, Түүнийг танин мэдэх аялалд гарах ёстой. Аялалыг зөвхөн Ариун Сүнтэй л хамт хийнэ. Тиймээс л бид Ариун Сүнтэй холбогддог, Бурханы мөнхийн Үгээс үндэслээгүй янз бүрийн уламжлалыг (бодлын загварыг) тасар татах хэрэгтэй. Хэрэв бид Сүнсний талаар буруу ташаа, сөрөг ойлголтыг өөртөө зөвшөөрбөл Бурханы амлалтын сайн сайхныг бүрэн дүүрэн эдлэж чадахгүй. Бурханыг Сүнсгүйгээр мэдэх боломжгүй.

Та Ариун Сүнтэй Түүний хүсдэгийг хүсч, мэдэрдэгийг мэдрэх тийм хэмжээнд тултлаа нөхөрлөж болно гэдэгт би итгэдэг. Нөхөрлөлийн хамгийн гүн төвшин нь сүнслэг төвшин бөгөөд энэ төвшинд та Бүтээгчтэй хамгийн дотно байна. Гэхдээ Түүнтэй дотно нөхөрлөхийн тулд Ариун Сүнсийг эрэн хайх хэрэгтэй. Түүнийг яаж мэдэх вэ? Түүний Үгийг үзэж, оршихуй дотор нь хамт байснаараа. Бурхан тантай ойр байхыг хүсдэг бөгөөд та анхны алхмыг хийх учиртай юм.

Дээрх ишлэлийг тунгаан бодож, Ариун Сүнсийг зүрхэндээ ажиллуул. Та Бурхан руу эргэхдээ Түүний оршихуйтай хамт байхад саад бологч бодол санааг зайлуул. Эдгээр саадыг зайлуулбал Бурхан та хоёр зүү ч оромгүй дотносоно. Түүний царайг ширтбэл (Түүнтэй хамгийн дотно нөхөр шигээ нүүр нүүрээ харан нөхөрлөбөл) Тэр таныг Өөр шигээ болгож өөрчилнө. Танд Паулын үгийг үлдээе:

Гэвч хүн Эзэнд хандаж эргэх бүрд бүтээлэг авагддаг. Эзэн бол Сүнс мөн. Эзэний Сүнс хаана байна, тэнд эрх чөлөө байдаг. Харин бид бүгд бүтээлэггүй нүүрээр Эзэний алдрын тусгалыг хардаг. Бид энэхүү Түүний дүрд алдраас алдарт өөрчлөгддөг. Энэ нь Эзэний Сүнсээр болдог. (2Коринт 3:16-18)

ТҮҮНИЙГ БАГШАА БОЛГО

Та нарын Түүнээс авсан тосолгоо нь та нарын дотор байдаг бөгөөд өөрсдөд чинь заах хэн нэгэн та нарт хэрэггүй. Харин Түүний тосолгоо нь та нарт бүхнийг заадаг бөгөөд тэрхүү тосолгоо нь худал биш, үнэн. Та нарт заасан ёсоор та нар Түүний дотор байгтун.

1Иохан 2:27

Ариун Сүнс бидний амьдралд олон дүр гүйцэтгэдэг бөгөөд Түүний хамгийн аугаа үүрэг нь Багш юм. Тэр бидэнд үргэлж зааж байдаг. Тэр бидэнтэй үргэлж хамт оршиж, хайраараа чиглүүлж, зөөлөн засдаг хамгийн сайн Аав.

Бичээс бол Сүнсний цаг хугацаанд баригдашгүй сурах бичиг юм. Энэ бол Бурханы бодлын тэмдэглэл юм. Түүн шиг бодож, ярьж, үйлдэхийн тулд бид Түүний үгийг тээж ойлгох ёстой. Энэ бол манай Багшийн үүрэг: бүх үнэнд чиглүүлж, зааж, Бичээсийн гүн утгыг хэрэгтэй цагт нь тайлбарлаж өгөх. Пастор зохиолч **Францис Франжипани** Иаков 1:21-г иш татжээ:

“Тиймээс та нар бүх бүзар байдал, хорон санааныхаа бүх л үлдэгдлийг хаяж, өөрсдийн чинь дотор суулгагдсан үгийг даруухнаар хүлээж авагтун. Тэр үг та нарын сэтгэлийг аврах чадалтай.”

“Би Бурханы Үгт яаж ханддаг билээ?” гэж өөрөөсөө асуу. Би Багшаасаа суралцахын төлөө Түүнийг урьдаг билүү? Үгийг уншиж, үүнээс сурдаг уу? Харин одоо Ариун Сүнснээс “Үгийг амьдралдаа амьдрүүлж, амьдралынхаа хэсэг болгохын тулд би юу хийх ёстой вэ?” гэж асуу. Түүний илчилсэн зүйлийг бичээд, хэрэгжүүл.

Ариун Сүнс ганцхан чимээгүй цаг дээр л ярьдаг уу? Үгүй. Тэр цаг үргэлж ярьдаг бөгөөд Түүнийг урьбал Тэр заавал заадаг. Франжипани ийн бичсэн:

“... Биедээ байнга цаас үзэг авч яв. ... Бид Түүн дээр айлчлах бус, Түүний дотор амьдрахаар дуудагдсан. ...Таны Ариун Сүнсийг хэзээ ч хаа ч сонсож чадахуйц “дэлдэн” байх хэрэгтэй. Түүнийг хүндэтгэ, тэгвэл Тэр таныг хүндэтгэнэ.

Энэ бүхэн нь хүн хүний хувьд өөр өөр л дөө. Хүн бүр өөр өөр арга барилтай. Хамгийн гол нь та Түүний яриаг сонсож чадах нь л чухал.

Дараах ишлэлийг сайтан тунгаан бод. Таны амьдрал дахь үгийн талаар Ариун Сүнс юу илчилж байна?

2Тимот 3:16-17; 2Петр 1:12-21

Дэд хууль 6:6; 11:18; Дуулал 119:9-11; Колоссай 3:16

Дуулал 19:8, 119, 105, 130; Сургаалт үгс 4:20-23; 6:20-23

Еврей 4:12; Иаков 1:21; Иеремиа 23:28-29

Намайг дууд, Би чамд харцуулж, чиний мэдэхгүй аугаа хүчит зүйлийг Би чамд ярина. (Иеремиа 33:3)

Хоёрдугаар өдрийн чимээгүй цаг

ИТГЭЛЭЭ ЭЗЭНД ТАВЬ

Есүс

—Эхнийх нь “Сонс, Израиль аа! Бидний Бурхан Эзэн бол ганц Эзэн мөн. 30Чи өөрийн Бурхан Эзэнийг бүх зурх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүчээрээ хайрлагтун” гэсэн нь юм.

Марк 12:29-30

Эзэн- Сүнс бидэнд гал халуунаар хайрладаг бөгөөд биднээс ч тийм хайрыг хүсдэг. Тэр биднийг өөр зүйлд анхаарахад дургүй. Эзэн ийн айлдруун:

Ертөнц болон ертөнцөд байгаа зүйлсийг бүү хайрла. Хэрэв хэн нэгэн нь ертөнцийг хайрладаг бол түүний дотор Эцэгийн хайр байхгүй. Учир нь ертөнцөд байгаа бүхэн тухайлбал, махан биеийн хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардам бахдал нь Эцэгээс бус, харин энэ ертөнцөөс ирдэг юм. Ертөнц хийгээд түүний хүсэл тачаал нь өнгөрнө. Харин Бурханы хүслийг үйлддэг нэгэн нь мөнхөд оршдог.

1Иохан 2:15-17

Түүнчлэн дээрхтэй холбоо бүхий дараах Бичээсийг үзнэ үү: Матай 16: 24-26; Тит 2:12-14; Иаков 4:4-6; Иохан 15:18-21; Ром 12:2

ТАНЫ ИТГЭЛ ЮУН ДЭЭР БАЙНА ВЭ? Өөрийгөө

шударгаар шалгаарай.

Таны дийлэнх цагийг хэн эсвэл юу авч байна? Би чөлөөт цагаараа юу хийж байна?

Хэн эсвэл юу намайг баясгадаг вэ? Технологи юмуу сүүлийн үеийн чиг хандлага миний амьдралд зөв байр эзэлж байна уу?

Би мөнгөө юунд зарж байна?

Би юуны талаар хамгийн их боддог, ярьдаг вэ? Ямар сэдвээр хамгийн их залбирдаг вэ?

Бидний үг бидний санаа сэдлийг илчилдэг. Зүрхэнд буй зүйлс амаар гардаг гэж Есүс айлдсан (Лук 6:45).

Хариултаа дахин нэг хар. “Би чухал зүйлсээ дэс дараагаар нь байрлуулахын тулд юу хийх ёстой вэ? Би Танаас өөр зүйлтэй хөөцөлдөж байна уу?” гэж Ариун Сүнснээс асуу. Тэр юу гэж байна? Түүн рүү бүрэн чиглэхийн төлөө ямар алхам хий гэж байна?

Матай 6:19-21, Колоссай 3:1-17 дээрх Бурханы Үгийг тунгаан бод. Энэ ишлэлийг оролцуулан, Эзэн Бурхандаа үнэнч байхад тань туслахыг Ариун Сүнснээс гуйсан залбирал бич.

ТҮҮНИЙ НИГҮҮЛСЭЛЭЭР ААЖМААР ӨС

Харин бид бүгд бүтээлэггүй нүүрээр Эзэний алдрын тусгалыг хардаг. Бид энэхүү Түүний дүрд алдраас алдарт өөрчлөгддөг.

Энэ нь Эзэний Сүнсээр болдог.

2Коринт 3:18

Есүс загалмайд алагдахаасаа өмнө Ариун Сүнсний талаар чухал мэдэгдэл хийсэн: “Та нарт хэлэх зүйл Надад олон бий ч та нар одоо тэдгээрийг даахгүй. Харин үнэний Сүнс болох Тэр ирэхдээ та нарыг бүх үнэн уруу удирдана. Учир нь Тэр Өөрийн санаагаар биш харин алив сонссон юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ.” (Иохан 16:12-13)

Бүхнийг мэддэг Есүс дагалдагч нартаа маш олон үнэнийг тайлахдаа, тэд үүнийг хараахан ойлгохгүй гэдгийг мэдэж байсан. Тэдэнд өсөх цаг хэрэгтэй байж. Есүс үхэж, үхлээс амилж, тэнгэр өөд өргөгдөхөд Аав нь биднийг нигүүлсэлээрээ аажим өсгөхийн тулд Ариун Сүнсээ илгээжээ.

Нялх хүүхдээс үржихийн хүрд уншихыг шаарддаг эрүүл аав ээж байхгүй. Үүнтэй адил Ариун Сүнс ч бас биднийг үнэнийг даах насанд хүртэл хүлээдэг. Тэр биднийг Бичээсийн бүх үнэнд хөтлөөд зогсохгүй мөн бид болон бидний үр хүүхэд, эрүүл мэнд, нөхцөл байдал зэрэг бүх зүйл дээр үнэнд хөтлөдөг.

Бурханы Үгээс үзбэл бид нэг төвшнөөс нөгөө рүү, алдраас алдар руу Есүстэй адил болж өсдөг. Энэ үйл ажилд Ариун Сүнс ч, бид ч оролцоно. Филиппой 1:6; 2:12-13, 1Тесалоник 5:23-24, Еврей 13:20-21-г анхааралтай тунгаан бод. Эдгээр ишлэлд Ариун Сүнс Есүсийн талаар танд юуг илчилж байна. Давтагдаж буй зүйл байна уу?

Арван есдүгээр зууны Английн нэрт номлогч **Чарльз Эйч. Спаржион** ийн бичсэн байдаг:

“Бид өөрсдөө хийж чадахгүй зүйлийнхээ төлөө Есүст найддаг. Хэрэв бид чадалтай байсан бол Түүн рүү харах ямар хэрэгтэй? Эзэн Ариун Сүнс биднийг шинээр бүтээдэг гэдэгт итгэх нь бидний үүрэг. Тэр бидний төлөө итгэхгүй бас бид Түүний ажлыг хийхгүй. Бид Түүний нигүүлсэлийн тушаалыг дагах нь хангалттай. Биднийг шинээр төрүүлэх ажил нь Эзэнийх болой.”

Би сүнсээр илүү өсгөлүүн байсан сан бол гэж бүү бод. Энэ худлаа бодол юм. Энэ бодол таныг ялаж, улам л сүнслэг хүчийг тань сорно. “Ариун Сүнс минь, та миний сүнсний өсөлтийн төвшинг юу гэж харж байна?” гэж залбир. Тэр юу гэж байна?

Ариун Сүнс таныг юу гэж харна, та өөрийгөө тэгж л харах учиртай. Өөрийгөө хаана байгааг хүлээн авч, цаашдаа өсч төлөвш.

Та өөрийгөө өөрчлөх гэж хичээдэг үү? Тийм бол яаж? Та одоо өөрийгөө юу гэж харж байна?

Дөрөвдүгээр өдрийн чимээгүй цаг

ТҮҮНИЙ БҮТЭЭДЭГ ТЭНГЭРЛЭГ ХОЛБООГ ҮНЭЛ

*Хайр нь хоёр нүүргүй байг. Бузар мууг жигш, сайнаас зуурч
ав. Ах дүүсийн хайраар бие биеэ хайрла. Бие биеэ өөрсдөөсөө
дээгүүр дээдлэн хүндэл.*

Ром 12:9-10

Бид Аавтай болон бусадтай харилцахаар бүтээгдсэн. Энэ талаар бодоод үз. Харилцаа байхгүй бол таны амьдрал юу болох вэ? Хов хоосон ганцаардсан амьдрал.

Харилцааны төлөө Бурханд баярлалаа! Бурханлаг найз зүйрлэшгүй үнэтэй. Сайн найз биднийг оюун, сэтгэл зүй, сүнсээр хурцалдаг. Сайн найз хайраар алдааг маань илчилж, хэрэгцээтэй цагт засч чаддаг. Амжилтанд тань баярлаж, цаашаа тэмүүлэх урам хайрладаг.

Ганцаараа байснаас хоёул байх нь илүү дээр болой. Тэгвэл тэд ажил үйлсээ сайнаар эргүүлэх болно. Хэрэв тэд хамтдаа ойчих аваас нэг нь нөхрөө босгоно. Харин ганцаар байгч унахын цагт түүнийг босгох хүн үгүй тул хөөрхийлөлтэй.

Номлогчийн үгс 4:9-10

Харилцааны 3 төвшин байдгийг бид сурсан: махан биеийн, сэтгэлийн, сүнслэг. Үүнийг мэддэг болсон та одоогийнхоо нөхцөл байдлыг юу гэж харж байна? Танд хамгийн их тус болдог хүн хэн бэ? Яагаад?

Хамгийн гүн утга төгөлдөр харилцаа нь сүнсний төвшинд л тогтдог. Ийм харилцаа ямар байдгийг дүрслэн ярь. Сүнслэг төвшинд нөхөрлөхийн ашиг тус юунд оршдог вэ?

Гүн харилцаа тогтоохыг хүсч байгаа хүн танд бий юу? Тэгвэл “Ариун Сүнс минь, миний амьдралд өгсөн энэ хүмүүстэй гүн гүнзгий харилцаа тогтоохын тулд би юу хийх ёстой вэ?” гэж асуу. Чимээгүй байж сонс. Түүний хэлж байгаа зүйлийг бич.

Тэнгэрлэг харилцаа холбооны төлөө залбир:

Ариун Сүнс минь, надад тэнгэрлэг харилцаа холбоо өгөөч. Ионатан Давид хоёр, Рүт Наоми хоёр, Иохан Есүс хоёр шиг Таны хүссэн хүмүүстэй намайг холбож өгөөч. Бусадтай эрүүл саруул харилцаагаа сүнслэг төвшинд хүртэл хөгжүүлэхэд минь нигүүлсэлээ хайрлаач. Есүсийн нэрээр. Амень!

Дэлгэрэнгүй судлахыг хүсбэл:

Сургаалт үгс 13:20, 17:9, 17, 27:6, 10, 17, Иохан 15:13

1Иохан 1:7; 1Самуел 18:1-4

Тавдугаар өдрийн чимээгүй цаг

БУРХАНТАЙ ХАМГИЙН ГҮН ТӨВШИНД НӨХӨРЛӨ

*Миний хүү Соломон оо, өөрийн эцгийн Бурханыг таньж мэдэн,
бүх зүрх болон оюун ухаанаараа Түүнд үйлчлэгтүн. Учир нь
ЭЗЭН бүх зүрхнүүдийг шалгаж, бодол санааны хандлага бүрийг
мэддэг юм. Хэрэв чи Түүнийг хайвал, Түүнийг олно. Харин чи
Түүнийг умартах аваас, Тэр чамайг мөнхөд орхино.*

1Шастир 28:9

Бурханы хамгийн аугаа зорилго нь бидэнтэй дотно нөхөрлөх бөгөөд биднээс ч үүнийг хүсдэг. Үүнээс илүү зүйл бий гэж үү? Паул ийн өгүүлэв: “Тэр ч байтугай, би өөрийн Эзэн Христ Есүсийг таньж мэдэхийн давуу агуу байдлын төлөө бүх юмсыг гарз хохирол болгон үздэг. Би Түүний төлөө бүх юмсын гарз хохирлыг амсаж, тэдгээрийг хог гэж үздэг нь Христийг олохын тулд бөгөөд...” (Филиппой 3:8)

Есүс Христийг гадар доторгүй таньж мэдэх нь **Жиин Гёоны** хамгийн аугаа зорилго байжээ. Тиймээс тэрбээр бүр ийм ном бичсэн. Арван долдугаар зууны энэ Франц эмэгтэй Бурхантай дотносох байдлын талаар ийн бичжээ:

“Та Эзэнийг илүү гүн гүнзгий мэдмээр байна уу? гэж би танаас асуумаар байна. Бурхан үүнийг танд боломжтой болгосон. Тэрбээр үүнийг Өөрийнхөө зольж авсан бүх хүүхдүүддээ нигүүлсэлээрээ боломжтой болгосон. Тэгвэл үүнийг яаж ийм гүн төвшинд мэдэх вэ? Гол түлхүүр нь залбирал”.

Тиймээс Бурханыг илүү дотно таньж мэдэхийн төлөө та яг юу гэж залбирах вэ? Матай 6:5-15 дээрх Есүсийн залбирлыг унш. Түүнээс юу сурав, сурсан зүйлээ яаж хэрэгжүүлэх вэ?

Биднийг шинээр төрөхөд Ариун Сүнс бидний сүнс дотор амьдарч эхэлсэн гэдгийг бид сурсан. Тиймээс Сүнс бидэнтэй харилцахдаа бидний сүнстэй бас харилцдаг. Жиин Гёон цааш нь ийн бичив:

“Та Эзэнийг гагцхүү сүнснээсээ л олно. Таны бүхэл ахуй оршихуй дундаас тэнд л Эзэн оршдог. Эзэн таныг гэрээ болгож, амьдран сууна гэж амласан (Иохан 14:23). Түүнийг хүндэтгэж, хүслийг дагадаг хүмүүст Тэр үүнийг амласан. ... Таны зүрх Эзэн рүү эргэсэн даруйдаа Эзэний оршихуйг мэдэрнэ.”

Энэ үнэнийг тунгаан бодож, таны зүрхэнд утгыг нь илчилж өгөхийг Ариун Сүнснээс гүй.

Гэвч хүн Эзэнд хандаж эргэх бүрд бүтээлэг авагддаг. Эзэн бол Сүнс мөн. Эзэний Сүнс хаана байна, тэнд эрх чөлөө байдаг. Харин бид бүгд бүтээлэггүй нүүрээр Эзэний алдрын тусгалыг хардаг. Бид энэхүү Түүний дүрд алдраас алдарт өөрчлөгддөг.

Энэ нь Эзэний Сүнсээр болдог.

2Коринт 3:16-18

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

- 1 | Есүс Фарисайчуудыг Бурханы Үгийн эрх мэдлийн дээр уламжлалыг өргөмжилсөнд нь зэмлэсэн. Хүний уламжлал гэж юу вэ? Яагаад энэ нь Бүтээгчтэй тогтоох бидний харилцаанд саад болдог вэ? Орчин үед Бурханы Үгээс илүү өргөмжлөгдсөн хүний уламжлалын нэг жишээ хэлнэ үү.

- 2 | Ариун Сүнс бидний хамгийн сайн найз байхыг хүсдэг бөгөөд биднийг хардаж харамладаг. Өдгөө ямар зүйлс Чуулганы анхаарлыг Ариун Сүнснээс илүү татаж байна вэ? Бид Сүнсстэй нөхөрлөхгүй, зугаа цэнгэл байр суурийн төлөө дэлхийтэй явалдбал юу болох вэ?

- 3 | Иохан 20:29 дээр Есүс Томаст яг юу хэлэхийг хүссэн бэ? Энэ үнэн 2Коринт 5:16 дээр Паулын хэлсэн Бурханы үгтэй хэрхэн холбогдох вэ? Мөн энэ үнэн Эзэнтэй тогтоох биднийг харилцааг хэрхэн тордох вэ?

- 4 | Харилцааны 3 төвшинг нэрлэ. Аль нь хамгийн гүн төвшин бэ? Бид яаж хүмүүстэй энэ төвшинд холбогдох вэ?

- 5 | Ариун Сүнс дотор бидэнд үлэмж аугаа бэлэг өгсөн: Бурханыг дотно мэдэх чадварыг. 1Коринт 2:11-16-г анхааралтай унш. Энэ хэсэгт Бурханыг жинхэнээсээ мэдэх талаар Ариун Сүнс юу хэлж байна?

- 6 | Петр ба бусад дагалдагч нар бусдад олдоогүй завшааныг эдлэсэн хүмүүс. Тэд Есүстэй хамт байсан. Харин Паул хамт байгаагүй боловч, Бурханаар гайхамшигтай хэрэглэгдсэн. Яаж тэр вэ?

Дэлгэрэнгүй судлахыг хүсбэл: Иохан 20:29, 2Коринт 5:16, 2Петр 3:15-16-р үзнэ үү.

- 7 | Бид Ариун Сүнсний араас явахгүй бол Бурхантай тогтоох харилцаа маань яах вэ? Хүсч байвал Ариун Сүнсстэй харилцаж, Түүний гайхамшиг оршихуйг мэдрэхийн төлөө ямар практик алхам хийж болохыг ярилц.

ТЭМДЭГЛЭЛ

Бүлгийн дүгнэлт

- Бурхантай дотно харилцаатай байхыг хүсбэл Түүний Сүнсээр л Түүнийг мэдэх ёстой.
- Зөвхөн Сүнс л Бурханы зүрхний зорилго, мэдрэмж, бодлыг мэдэж илчилдэг.
- Бидэнд Бурханы Сүнс өгөгдсөн. Тэр бол биднийг бүх үнэнд хөтөлдөг шилдэг Багш.
- Дэлхийтэй нөхөрлөх нь Бурхантай дайсагнах явдал.
- Ариун Сүнс бол Жентельмэн. Тэр биднийг хэзээ ч дарамталж, албаддаггүй.
- Харилцааны 3 төвшин бий: махан биеийн (хамгийн өнгөц гүехэн харилцаа), сэтгэлийн (зүрх сэтгэлийн), сүнслэг (хамгийн гүн, хамгийн дотно).
- Есүсийг биечлэн мэдэхээсээ Бурханыг Өөрийнх нь Сүнсээр мэдэх нь илүү гүн бөгөөд дотно харилцаа юм.

4

СҮНСЭЭР ХҮЧИРХЭГЖСЭН

Нэгдүгээр өдөр

Дундад зуун. Цайз хэрэм, дуулгат баатрууд, дурлалт авхай нар, дайн тулаан, хаанчлал ба нэр алдар. Хааныг Бурхан томилдог гэж үздэг байсан учраас оройлон дээдлэж, эд баялагт умбуулдаг байжээ. Хааны үг хууль бөгөөд тушаалыг нь үг дуугүй биелүүлэх ёстой. Сайн хаан үүрэг хариуцлагаа ухаарч, эзэнт улсынхаа ард иргэдийг хамгаалж, хаант улсаа тэлж, эд хөрөнгийг нь арвижуулна.

Хаанд үлэмж үүрэг хариуцлага оноохын сацуу туйлын эрх мэдлийг нь олгодог байсан. Би орчин цагийн ардчилсан эсвэл бүгд найрамдсан засаглалын тухай яриагүй, харин туйлын монархийн тухай өгүүлж байна. Тэгвэл байр суурыг нь дагалдаж олгогдсон хүчийг огт мэдэхгүй хаан байна гээд төсөөл дөө. Хаанчлал нь яах бол? Хаант улс нь эзлэгдэж, ард иргэд нь боолчлогдож, эд хөрөнгө нь булаагдана. Тэгэхээр хааны хувьд зөвхөн “хаан” гэдэг нэртэй байх нь хангалтгүй ажээ. Тэрбээр зөвхөн түүний байр суурийн эрхээр боломжтой болсон *хааны ажил үүргээ гүйцэтгэх ёстой*. Хааны байр суурийг дагаж ирдэг хүчийг ашиглахаас нааш хааны эрх мэдэл ямар ч үр нөлөөгүй болно.

Бурханы хүүхдүүд бид Христийн хамтран залгамжлагч нар болсон. Ром ном ийн хэлдэг: “Хэрэв бид хүүхдүүд нь юм бол, өв залгамжлагчид нь бас мөн. *Христтэй хамт* алдаршуулагдахын тулд хэрэв бид үнэхээр Түүнтэй хамт зовдог юм бол, бид Бурханы өв залгамжлагчид бөгөөд Христийн хамтран залгамжлагчид юм” (Ром 8:17). Энэ байр суурийн тухай Ефес 2:6 дээр дахин тодорхой

хэлсэн: “Биднийг Түүнтэй хамт амилуулж, тэнгэрлэг газарт *Христ Есүс дотор* Түүнтэй хамт суулгасан.” Бурхан Христийн дотор ба Христээр дамжуулан биднийг дахин байршуулсан. Бид цаашид дэлхийн хүүхдүүд биш, харин Тэнгэрийн хаанчлалын язгууртнууд (өв залгамжлагч нар) болсон. Хаанчлалын өв залгамжлагч нар учраас бид Эзэнийхээ даалгаврыг биелүүлэх үүрэгтэй. Энэ бол гайхамшигтай үнэн! Гэхдээ бид ч бас энэ байр суурийг дагалдах эрх хүчийг ашиглахгүй бол мянга Хааны хүүхдүүд байгаад нэмэргүй. Энэ бүлэгт Бурхан хүүхдүүддээ ямар хүчийг өгсөн тухай ярина.

Харин та нар бол сонгогдсон угсаа, хаант тахилч нар, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн юм. Ингэснээр харанхуйгаас та нарыг Өөрийн гайхамшигт гэрэл уруу дуудсан Түүний давуу чанаруудыг та нар тунхаглах юм. (1Петр 2:9)

Үргэлжлүүлэхээсээ өмнө хүч чадлын өмнө байр суурь ордог гэдгийг сануулъя. Бид ямар нэг зүйл хийхээсээ өмнө Христийн дотор байрлах ёстой.

Бидэнд хэрэгтэй хүч чадал

Тэгээд элч нарыг нэг дор цуглуулан Иерусалимыг орхилгүйгээр Эцэгийн амласныг, Түүний “Та нар Надаас сонссоны дагуу, Иохан усаар баптисм хүртээдэг байсан бол харин та нар ойрын өдрүүдэд Ариун Сүнсээр баптисм хүртэх болно” гэснийг хүлээхийг тэдэнд тушаасан ажгуу. (Үйлс 1:4-5)

Есүс дагалдагч нартаа Амлалтыг хүлээ эсвэл Түүний зааврыг хүлээ гэж *санал болгоогүй*, харин Амлалт иртэл “Иерусалимаас бүү яв” гэж *тушаасан*. Учир нь Ариун Сүнсээр хүчирхэгжих нь хамгийн чухал гэдгийг Тэр мэдэж байв. Дагалдагч нар нь Түүнийг амилсан тухай сайхан мэдээг дуулгахаар хүлээж ядаж байсан тул

Ариун Сүнснийг хүлээхдээ тэвчээр алдарч магадгүйг Есүс мэдэж байсан. Дагалдагч нар Бурханы Хаанчлалын тухай Есүсийн номлолыг хэдэн өдрөөр ч хамаагүй сонсож байсан тухай Үйлс 1:3 дээр хэлдэг. Өөрөөр хэлбэл Тэд хэзээд бэлхэн байсан!

Харин Есүс тэднийг хараад “Ариун Сүнсний хүчийг хүлээж автлаа үйлчлэлээ бүү эхлүүл, дэлхий даяар сайн мэдээг бүү номло, чуулган бүү эхлүүл” гэсэн (Лук 24:29). Есүс үүнийгээ 500 гаруй хүнд хэлсэн (1Коринт 15:6). Үйлс 1:15 дээр дээд өрөөнд 120 хүн залбирч байсан гэдэг. Тэгвэл бусад 380 нь хаачсан бэ? Миний бодлоор өдөр өнгөрөх тусам хорогдсоор байгаад 120 нь л үлдсэн байх. Магадгүй 380 нь *Синагогдоо очиж чуулганаа эхлүүлж, Есүсийг амилсан тухай дуулгая. Энэ сайхан мэдээг чинь ганц өдрийн өмнө ч гэсэн хүмүүст дуулгах хэрэгтэй биз дээ?* гэж бодоод явчихсан байх. 120 хүн л Эзэнийхээ үгийг сонссон.

Магадгүй та яг одоо *Аргагүй шүү дээ. Дагалдагч нарт угаасаа л Ариун Сүнс байгаагүй. Тэд Ариун Сүнснийг хүлээж аваагүй байсан. Харин бид аврагдахдаа л Ариун Сүнснийг хүлээж авсан учраас өөр хэрэг* гэж бодож байж магадгүй.

Иохан 20:21-22:

Үүнийг айлдаад, Тэр тэдэнд гар, хажуугаа үзүүлэв.
Шавь нар нь Эзэнийг хараад ихэд баярлав. [Есүс]
дахиж тэдэнд
—Амар амгалан та нартай хамт байх болтугай. Эцэг
Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ гэв.

Есүс дагалдагч нараа үлээгээд “Ариун Сүнснийг хүлээж ав” гэсэн. *Хүлээж ав* гэдэг Грек үг нь “тэр даруй эсвэл яг одоо” гэсэн утгатай. Энэ нь болох зүйлийн сүүдэр байгаагүй. Дагалдагч нар Есүсийг тэнгэр өөд өргөгдөхөөс өмнө Ариун Сүнснийг яг бодитой хүлээж авсан. Гэхдээ Пентекост өдөр Сүнсээр дүүрэхээс өмнө тэд *хүчирхэгжээгүй*.

Пентекост өдөр

Пентекостын өдөр болоход тэд цөмөөрөө *нэг* газарт цугласан байлаа. Гэнэт тэнгэрээс хүчит хуй салхи мэт дуу чимээ гаран, тэдний сууцгааж байсан байр бүхэлдээ тэрхүү дуунд автагджээ. Тэгтэл гал хаялах мэт хэлүүд бий болон хүн нэг бүрийн дээр тогтохыг тэд харлаа. Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр *дүүрч*, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв. (Үйлс 2:1-4)

Хуучин гэрээнд галаар Бурханы оршихуйг төлөөлдөг. Тэгэхээр “гал хаялах мэт хэлүүд” гэдэг нь Бурханы оршихуйг төлөөлж буй. Ийнхүү Есүсийн эрэгтэй, эмэгтэй дагалдагч нар Бурханы оршихуйд баптисм хийлгэжээ. Энэ оршихуйг мөн “хуй салхи” гэж дүрсэлжээ. Ариун Сүнс “хуй салхи” биш, Хувь Нэгэн гэдгийг бид нэгдүгээр бүлэгт сурсан. Гэхдээ Тэрбээр дээд өрөөнд ирэхдээ хуй салхи шиг иржээ.

Үйлс 2:4 дээрх “дүүрч” гэдэг Грек үг нь бүхнээр хангалуун байх гэсэн утгатай үг. Толь бичгээс үзбэл дүүрсэн гэдэг нь “дүүртэл нь хангах” гэсэн утгатай. Дээд өрөөнд байсан хүмүүс Ариун Сүнсээр бүрэн дүүрэн дүүрсэн. Тэд бүгдээрээ амьдралдаа Бурханы оршихуйг *үлэмж ихээр* мэдэрсэн. Гал, салхиас гадна итгэгчид Сүнсээр дүүрсэний өөр нэг шинж нь тэд хэлээр ярьсан явдал байв.

Хоёрдугаар өдөр

Яагаад хэл гэж?

Хэл гэдэг нь хэл яриа л гэсэн үг. Жишээлбэл хэрэв би Испанид явж байгаад Испаниар ярьдаггүй хүнтэй уулзбал “Таны унаган хэл юу вэ?” гэж асууна. Харин англиар ярьдаг хүнтэй тааралдбал ийм зүйл асуух шаардлагагүй. Тиймээс миний хувьд англи хэл

миний унаган хэл, харин бусад нь харь хэл юм. Энэ талаар дараа дэлгэрэнгүй ярья.

Пентекост өдөр олон улс оронд аж төрдөг Иудейчүүд шашны баяраа тэмдэглэхээр Иерусалимд цуглажээ. Тэд өөр өөр улсаас ирсэн учраас өөр өөрийн гэсэн хэлтэй байж таараа.

Тэр цагт тэнгэрийн доорх үндэстэн бүрээс сүсэгт иудейчүүд Иерусалимд амьдарч байв. Энэхүү дуу чимээнээр үй олон хүмүүс цугларч, өөрсдийнх нь төрөлх хэлээр тэдний ярихыг сонсоод ихэд гайхжээ.

Гайхаж алмайрсан тэд

—Энэ ярьж байгаа хүмүүс чинь галилчууд биш үү? Гэтэл бид бүгдээрээ өөрсдийн төрөлх хэлээрээ тэдний ярихыг сонсож байх нь юу вэ? (Үйлс 2:5-8)

Библи “дуу чимээнээр үй олон хүн цугларч” гэж гэснийг тэмдэглэнэ үү. Тэд хэлээр ярьж буй хүмүүс дээр цуглажээ. Галилчууд (тэдний олонх нь боловсролгүй байсан) янз бүрийн гадаад хэлээр ярьж байхыг үзээд тэд нүд орой дээр гарсан. Гайхсан хүмүүс нь хараахан Есүсийн дагалдагч болоогүй хүмүүс байжээ.

кретийнхэн, арабууд болох бид Бурханы агуу үйлсийн тухай тэдний яриаг өөрсдийн төрөлх хэл дээр сонсоцгоолоо гэв. Тэд бүгд гайхшран, алмайрсаар өөр хоорондоо

—Энэ юу гэсэн үг вэ? гэцгээв. (Үйлс 2:11-12)

Сүнс цутгасны үр дүнд Петр алдарт номлолоо хэлсэн юм (Үйлс 2:32-33). Ариун Сүнсний хүчийг бүгд *харж* бас *сонсчээ*.

Тэгээд хурсан олон ийн хариу үйлдэв:

Сонссон зүйл нь тэдний зүрхийг хөндсөнд, Петр болон бусад элч нараас, “Ах дүү нар аа, бид одоо яах вэ?” гэж асууцгаав. (Үйлс 2:37)

Петр тэдэнд ийн хэлсэн:

Гэмшигтүн, хүн бүр өөрсдийн нүглийн уучлалын төлөө Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Та нар ч Ариун Сүнсний бэлгийг авах болно. 39Учир нь уг амлалт нь та нар болон та нарын хүүхдүүдийнх төдийгүй бас алсад суугч бүрийнх бөгөөд манай Бурхан Эзэнээр дуудагдсан болгоных билээ. (Үйлс 2:38-39).

Эзэний нэрийг дуудсан хүн бүр аврагдаж чадна гэдэг сайн мэдээг Петр тунхаглажээ (Ром 10:13). Түүнчлэн итгэсэн хүн бүрт Ариун Сүнсний бэлэг нээлттэй гэдгийг ч тодорхой хэлсэн. Гайхамшигтай! Энэ амлалт үе үеийн итгэгч нарт хамаатай.

Өөр дөрвөн тэмдэглэл

Үйлс номд хүмүүс Ариун Сүнсээр дүүрч буйн өөр дөрвөн тэмдэглэл бий. Энэ дөрвөн жишээг үзэхдээ би та бүхнийг хоёр зүйл дээр анхаараасай гэж хүсч байна. Нэгдүгээрт- нэгээс бусад нь бүгд авралаас тусгаар өрнөж байна. Хоёрдугаарт- Сүнсний цутгаланг гэрчлэн харсан хүмүүс нь Сүнсний оршихуй шинэ итгэгч хүмүүс дотор буйг харж бас сонссон.

Филип ба Самаричууд

Энэ 4 тэмдэглэл Үйлс 8-р бүлэгт гардаг. Филип Есүс Христийн сайн мэдээг ярихаар Самари руу явжээ. Үүний үр дүнд тэр хотод сэргэлт буусан.Өвчтэй нь эдгэрч, бузар сүнсүүд хөөгдөж, олон хүн Бурханы авралын аугаа мэдээг сонссон.

Харин Бурханы хаанчлал болон Есүс Христийн нэрийн тухай сайн мэдээг тунхагласан Филипт итгэсэн эрэгтэй, эмэгтэй олон хүмүүс баптисм хүртэцгээж байлаа. Симон хүртэл итгэсэн бөгөөд

баптисм хүртсэний дараа Филиппийг дагах болж, гайхамшгууд болон тэмдгүүд үйлдэгдэхийг харан, үргэлж гайхаж хоцордог байв. (Үйлс 8:12-13)

Самаричууд Есүс Христийн сайн мэдээнд итгэхдээ дахин төрсөн үү? Яриангүй. Хүн сайн мэдээнд итгэхдээ Есүс Христийг хүлээн авч, Бурханы хүүхэд болдог. Тэдгээр итгэгчид Христэд итгэснийхээ тэмдэг болгон усаар баптисм хийлгэсэн. Гэхдээ дараагийн ишлэлээс нь үзбэл шинээр итгэсэн хүнд итгэж усан баптисм хийлгэхээс гадна өөр нэг зүйл хэрэгтэй гэдгийг Анхны чуулганы удирдагч нар мэддэг байж: тэд Ариун Сүнсний баптисм хүлээж авах.

Самари нь Бурханы үгийг хүлээн авсныг Иерусалим дахь элч нар сонсоод Петр, Иохан нарыг тэдэн уруу явуулав. Тэд ирж, тэдэнд Ариун Сүнсийг авахуулахын төлөө залбирчээ. Учир нь тэдний хэнд ч Ариун Сүнс хараахан буугаагүй байсан бөгөөд тэд Эзэн Есүсийн нэрээр зөвхөн баптисм хүртсэн байжээ. (Үйлс 8:14-16)

Самаричууд Сайн мэдээг хүлээж авсаныг дуулаад, элч нар тэдгээр шинэ итгэгч хүмүүс рүү Петр Иохан хоёрыг илгээжээ. Яагаад элч нар Самаричуудын төлөө залбируулахаар хамгийн нэр хүндтэй хоёроо илгээсэн юм бол? Эцсийн эцэст Самаричууд хэдийнээ аврагдаж усан баптисм хүртсэн биз дээ? Петр, Иохан хоёр тэднийг Ариун Сүнсийг хүлээж авахын төлөө тусгайлан залбирсан (и15). Иерусалим Самариас 60-аад км зайтай байсныг тэмдэглээрэй. Өнөөдөр энэ зай юу ч биш л дээ. Гэхдээ тухайн үед зам тээвэр орчин цагийнх шиг хөгжөөгүй байсан учраас хөлөөрөө юмуу мал адуугаар явахад нэг, хоёр өдөр болдог байв.

Шинэ итгэгч нар Эзэн Есүс Христийн нэрээр баптисм хүлээж авч, Бурханы хүүхдүүд болсон. Гэхдээ тэдний хараахан хүлээж аваагүй авралын бэлэг байжээ. Та ингэж бодож байж магадгүй: *Гэхдээ биднийг аврагдахад Ариун Сүнс бидний зүрхэнд нутагласан*

бус уу? Яг тийм. IКоринт 12:3 дээр “Тиймээс хэн ч Бурханы Сүнсээр “Есүс харагдсан” гэж ярихгүй бөгөөд Ариун Сүнсээр бус бол өөр хэн ч “Есүс бол Эзэн” гэж хэлж чадахгүй гэдгийг би та нарт мэдэгдье” хэмээн тодорхой хэлсэн. “Бид Есүсийг Эзэн гэдгийг Ариун Сүнсгүйгээр тунхаглах боломжгүй ч, энэ нь Ариун Сүнсээр *дүүрэхээс* өөр юм.

Христ дотор байгч хүн бүрийг Ариун Сүнсээр ариусгаж, тамгалдаг гэж Библи баттай хэлдэг (1Петр 1:2; Ефес 1:13). Ариун Сүнсний *оршихуйг* хүлээн авах нь авралын салшгүй хэсэг гэдэгт эргэлзэх зүйл алга. Бурхан таныг харахдаа Хүүгийнхээ Сүнсийг хардаг. Та аврагдах үедээ Христийн дотор зөв байршуулагдаж, Түүний Хаанчлал, өвийн нэг хэсэг болдог. Гэхдээ та Ааваас асуухаас нааш Сүнсний *хүчийг* хүлээж авахгүй. Есүс ийн айлдруун:

Хэрэв та нар бузар атлаа хүүхдүүддээ хэрхэн сайн бэлэг өгөхөө мэддэг юм бол, тэгэх тусмаа тэнгэрлэг Эцэг тань Өөрөөс нь гуйдаг хүмүүст Ариун Сүнс өгөх нь дамжиггүй. (Лук 11:13)

Есүс Бурханыг “тэнгэрлэг Аав тань” гэсэн. Тиймээс Есүс итгэгч хүмүүсийн тухай ярьж байсан нь тодорхой байна. Иохан ном дээр Есүс “Тэр бол үнэний Сүнс мөн бөгөөд Түүнийг харахгүй, мэдэхгүйгээсээ болж, ертөнц Түүнийг хүлээж авч чадахгүй ...” хэмээн айлдсан (Иохан 14:17). “Ертөнц” гэдэг нь Бурханы хаанчлалын гадна байдаг хүмүүсийг хэлнэ. Эзэн Есүст захирагддаггүй хүмүүс Ариун Сүнсийг хүлээж авч чадахгүй. Тэгэхээр Сүнсийг “Ааваасаа” асуу гэдэг заавар нь аврагдаагүй хүмүүст өгөгдсөн заавар биш ажээ.

Зөвхөн аврагдсан хүмүүс л үүнийг хүлээн авна.

Тэгээд тэр хоёр тэдэн дээр гараа тавихад тэд Ариун Сүнсийг хүлээн авч байлаа. Элч нарын гар тавилтаар дамжуулан Ариун Сүнс өгөгдөж буйг ажигласан Симон тэр хоёрт мөнгө өгч,

— Энэ эрх мэдлээ бас надад өгөөч. Тэгвэл би гараа тавьсан хүн бүрийг Ариун Сүнснэй болгоно шүү дээ гэв. (Үйлс 8:17-19)

Петр Иохан хоёр итгэгч хүмүүс дээр гараа тавихад тэд Ариун Сүнснийг хүлээж авсан. Сүнсний энэ дүүрэлт нь физик мэдэрхүйд мэдэгдэхүйц байжээ. Учир нь Библи “Элч нарын гар тавилтаар дамжуулан Ариун Сүнс өгөгдөж буйг *ажигласан* Симон” гэсэн. Итгэгч Симон итгэгчдийн доторх Ариун Сүнсний *хүчийг* хараад алмайрахдаа энэ хүчийг хэрхэн бусдад дамжуулахыг өөрт нь төлбөртэй зааж өгөхийг элч нараас хүссэн. (Энэ нь буруу хандлага байсан тул Петр түүнийг тэр даруй зэмлэсэн).

Үйлс номоос үзбэл Сүнсээр дүүрэх үйл явдал нь заавал *харагдаж* бас *сонсогдож* байсан- гол төлөв хэлээр ба эш үзүүллээр. Тиймээс л элч нар Ариун Сүнс итгэгч хүмүүс “дээр ирнэ” гэж ярьдаг байсан. Самарид болсон энэ явдал Сүнсээр дүүрсэний дараа хэл бас эш үзүүлэл дагалдсан хэмээн онцлон хэлээгүй Библийн цөөн хэдэн жишээний нэг мөн боловч, ийм явдал өрнөсөн гэдэгт итгэлтэй байна. Үгүй аваас өмнө нь шидтэн байсан Симон итгэгч хүмүүсийн доторх Сүнсний оршихуйг яаж мэдэх билээ?

Гуравдугаар өдөр

Таршишийн Саул

Саул гэдэг хүний Есүст итгэсэн түүх нь Бичээсийн хамгийн гоц хэсгийн нэг юм. Би энэ үйл явдлын магадгүй хамгийн үл анзаарагддаг тал дээр төвлөрхийг хүсч байна. Үйлс 9-р бүлэг дээр Саул итгэгч нарын бодийг хөтлөхөөр Дамаск руу жолоо залж явдаг:

Саул замд явж байлаа. Тэр Дамаскт дөхөн ирж байтал гэнэт тэнгэрээс гэрэл гарч түүнийг хүрээлэн

гэрэлтгэхэд, Саул газар хөсөр унав. Тэгээд
 —Саул аа, Саул аа, юунд чи Намайг хавчина вэ? гэх
 дууг сонсоод,
 — Эзэн, Та хэн бэ? гэжээ. Тэгтэл Тэр
 —Би бол чиний хавчиж мөшгөөд байгаа Есүс байна.
 Бос, хот уруу оч. Чиний юу хийх ёстойг чамд хэлэх
 болно гэв. (Үйлс 9:3-6)

Саул Есүсийг “Эзэн” гэж дуудсаныг тэмдэглэнэ үү. Есүс Христ бидний амьдралын Эзэн болоход би тэр даруй дахин төрдөг. Саул Есүсийг Эзэн хэмээн хүлээн зөвшөөрөхдөө л итгэгч болсон гэдэгт би итгэдэг.

Саул ийнхүү Эзэнтэй уулзсанаа дараа 3 хоног хотод мацаг барьж, заавар хүлээсэн. Харин Эзэн Ананиас гэдэг дагалдагчаа Саул руу илгээв. Ананиас ч Саул итгэгч хүмүүсийг хэрхэн харгисладаг тухай өчнөөн түүх сонссон тул сэтгэл баахан зовнитол Бурхан түүнд “Яв, учир нь тэр бол харь үндэстнүүд, хаад болон Израилийн хөвгүүдийн өмнө Миний нэрийг үүрэхийн тулд Миний сонгогдсон сав бөгөөд” хэмээн айлдсан (Үйлс 9:15). Ананиас Паул дээр хүрч ирээд, түүн дээр гар тавин: “*Саул дүү минь*, ирэх замд чинь чамд үзэгдсэн Эзэн Есүс чамайг хараатай болгож, Ариун Сүнсээр дүүргэхийн тулд намайг илгээв” гэжээ (Үйлс 9:17). Саул аврагдсаныг Ананиас мэдсэн тул “Саул дүү” гэж дуудсан. Тэгэхээр хэдийгээр Саул итгэгч болсон ч Бурхан түүнийг эдгээж, Ариун Сүнсээр дүүргэхийн төлөө залбируулахаар Ананиасыг илгээжээ.

Авралыг хүлээж авсаны дараа Ариун Сүнсээр дүүрч буйн бас нэгэн жишээ. Үйлс 9-р бүлэгт Саул (Паул) хэлээр ярьж буй тухай огт гардаггүй. Гэхдээ тэрбээр хожим “Би та бүгдээс ч илүүгээр хэлээр ярьдаг тул Бурханд талархдаг” хэмээн бичсэнээс нь (1Коринт 14:18) түүнийг хэлээр ярьдаг байсныг мэдэж болно. Ананиасыг залбирахад Паул хэлээр ярьсан гэдэгт би итгэдэг. Паул аврагдсан боловч, Сүнсээр дүүрэх ёстой байсан. Учир нь Ариун Сүнсгүйгээр Паул харь хүмүүст болон хаадад бас Израилийн хүүхдүүдэд Есүсийг тунхаглаж чадахгүй байв (Үйлс 9:15).

Петр ба Корнел

Үйлс 10-р бүлэгт бид Бурханы хошин занг халт хардаг. Нэгдүгээр ишлэл дээр Корнел гэдэг Ром офицер гарна. Тэрбээр Бурханаас эмээдэг, ядуусыг нигүүлсдэг, Бурханд байнга залбирдаг бүрэн зориулалттай хүн байжээ. Энэ үед Сайн мэдээ гадаад хүмүүст хүрээгүй байсан тул Бурхан Корнел руу тэнгэрэлчээ илгээв. Тэнгэрэлч Корнел дээр ирээд Бурхан түүнийг аврах гэж буй төлөвлөгөөг танилцуулах биш, харин Петр рүү хүмүүсийг илгээхийг хэлсэн. Хөөрч догдолсон Корнел тэр даруй Петрийн байгаа газар руу хүмүүсээ илгээв.

Яг энэ үеэр Иоппад буй Петр тэнгэрээс үзэгдэл үзжээ. Бурханы цэвэр гэсэн юмсыг тэрбээр бузар гэж үзэж болохгүйг Бурхан Петрт ойлгуулахын төлөө янз бүрийн үзэгдэл харуулжээ (Үйлс 10:9-15). Бурхан энэ үзэгдлээ гурван удаа харуулсан тул Петр учрыг нь олох гэж тархиа гашилгана гэдгийг Бурхан мэдэж байв. Петрийг ийн тунгааж байх үеэр Корнелийн хүмүүс хүрэлцэн ирлээ. Ариун Сүнс Петрийг тэдэнтэй хамт яв гэв. Иудей хүн харь хүнтэй харилцахыг цээрлэдэг байсан тухайн цаг үед Бурхан яагаад Петрийг Корнел гэдэг хүн рүү илгээж буйгаа тайлбарлаагүй. Тэгээд Петр Корнелийн ирээд ингэж хэлсэн:

Тэр тэдэнд

—Иудей хүний хувьд харь үндэстэнтэй нөхөрлөх буюу тэдний гэрт зочлох нь ямар ёс бус хэрэг болохыг та нар өөрсдөө мэднэ. Гэвч ямар ч хүнийг бузар, эсвэл цэвэр бус гэж нэрлэх ёсгүйг Бурхан надад харууллаа. 29Тиймээс дуудахад чинь би түдгэлзэлгүйгээр явж ирэв. Та нар намайг дуудсан учраа хэлнэ үү? гэв (Үйлс 10:28-29).

Петр үзэгдэл нь чин сэтгэлтэй харь хүмүүстэй холбоотой байсныг ухаараад, Корнелд сайн мэдээг дуулгав. Гэтэл Петрийг ид сайхан ярьж байтал Бурханы Сүнс Өөрийгөө мэдүүлж, харь хүмүүс хэлээр ярьж эхэлсэн. Петр *урьд өмнө* ийм зүйл хараагүй тул ангайж хоцров.

Авралын бэлэгийг харь хүмүүст ч зориулсаныг Петр болон түүний Иүдей нөхөд ойлгож цөхнө гэдгийг Бурхан мэдэж байсан. Тиймээс Петр тэдгээр харь хүмүүсийн төлөө залбирч, усаар угааж ч амжаагүй байхад нь Бурхан тэдэн дээр Ариун Сүнсээ шууд цутгачихжээ. Энэ нь Израилиас бусад үндэстэн аврагдах хувьтайн баталгаа байв.

Хөвч хөндүүлсэн итгэгчид болох Петртай хамт ирсэн бүх хүмүүс харь үндэстнүүд дээр бас Ариун Сүнсний бэлэг асгарахыг хараад гайхацгаажээ. Учир нь тэд хэлүүдээр ярьж, Бурханыг дээдлэн байгаа нь *сонсдов*. Тэгтэл Петр

— Бидний авсанчлан тийнхүү Ариун Сүнсийг хүлээн авсан энэ хүмүүст баптисм хүртээхэд хэн ч уснаас татгалзаж чадахгүй биз дээ? гэлээ. Тэр тэдэнд Есүс Христийн нэрээр баптисм хүртэхийг тушаав. Дараа нь тэд түүнээс хэд хоног үлдээч гэж гуйлаа. (Үйлс 10:45-48).

Харь хүмүүсийн дунд Бурханы хүч илэрч, тэд Ариун Сүнсээр дүүрэхийг Иүдейчүүд *харж* бас *сонссон* учраас Бурханы аврал тэдний дунд буйн нотолгоог няцааж чадаагүй. Бурхан харь үндэстнийг авраад зогсохгүй, нийтийн өмнө усан баптисм хийлгэж ч амжаагүй байхад нь Сүнсээрээ дүүргэхихэнд Иүдей итгэгч нар сочирджээ. Энэ нь Бурхан ийм замаар ажиллаж буйн Бичээс дэхь цорын ганц жишээ юм. Бусад бүх тохиолдолд хүмүүс итгэсэний дараа л Бурханы Сүнс ирсэн. Бурхан авралаа харь үндэстэнд сунгасан гэдгийг Еврейчүүдэд онцгой тэмдгээр үзүүлэх шаардлагатай гэдгийг мэдэж байсан учраас л Бурхан ийм арга замаар үйлдсэн гэж би итгэдэг.

Ефесчүүд

Энэ жишээ Үйлс 19-р бүлэгт гарна. Ефест очсон нь Паулын тоймгүй олон аялалын нэг байв. Тэнд Паул Иохан баптистын

дагалдагч нартай уулзаад хамгийн түрүүд “Та нар Ариун Сүнсийг хүлээж авсан уу?” гэж л асуусан (Үйлс 19:2). Гайхалтай! Паул ингэсэн бол бид ч бас шинэ итгэгчээс нэн түрүүнд үүнийг л асуух ёстой бус уу?

Анхны Чуулганы удирдагч нарт энэ яагаад тийм чухал байв? Учир нь Христийн доторх бидний даалгаварт Ариун Сүнс амин чухал бүлгээ. Бид энэ даалгаврыг биелүүлэх хүчийг хүсэхгүй гэж үү? (Үйлс 1:8) Аавынхаа хаанчлалд үр нөлөөтэй байхын тулд бид Христийн дотор зөв байршаад (аврагдаад) дараа нь Сүнсээр хүчирхэгжих ёстой (Сүнсээр дүүрэх).

Иохан баптистын тэдгээр дагалдагч нар Есүс Христийн тухай сайн мэдээг огт дуулаагүйг мэдсэн Паул тэдэнд сайн мэдээ ярьжээ.

Эхлээд Христийн доторх байр сууриа олж байж л Сүнсээр хүчирхэгжинэ гэдгийг би өмнө хэлсэн. Корнелийнх шиг Сүнсээр дүүрэх гадаад илрэл нь итгэлээ гаднаа тунхаглах үйлсийн (усан баптисмаас) өмнө өрнөж болох ч, энэ бүхний түрүүнд гагцхүү аврал орно.

Тиймээс Паулын үгийг сонссон Ефесчүүд эхлээд “Эзэн Есүсийн нэрээр баптисм хийлгэсэн” (Үйлс 19:5). Өөрөөр хэлбэл тэд гагцхүү Есүс Христээр дамжиж ирдэг авралыг хүлээж авчээ. Гэхдээ үүгээр энэ түүх өндөрлөөгүй: “Ийнхүү Паул тэдэн дээр гараа тавихад Ариун Сүнс тэдэн дээр ирж, тэд олон хэлээр ярьж, эш үзүүлжээ” (Үйлс 19:6).

Шинэ итгэгч нар Эзэн Есүсийн нэрээр баптисм хийлгэснийхээ дараа л Ариун Сүнсээр хүчирхэгжжээ. Тэд Паултай уулзахаасаа өмнө Есүсийн талаар тун бага мэддэг байсан бол Ариун Сүнсээр хүчирхэгжсэнийхээ дараа Есүсийн тухай сайн мэдээг тунхаглан *эш үзүүлжээ*. Итгэгч хүн Бурханы Сүнсийг мэдэхгүйгээр Бурханы нууцыг эрх мэдэлтэй тунхаглах боломжгүй (1Коринт 2).

Сүнсний хүч л намайг номлогч болгосонд би талархаад ч барашгүй. Үнэндээ би сайн илтгэгч биш. Бас сайн зохиолч ч биш. Англи хэлийнхээ шалгалт дээр 800 оноогоос 370 оноо авч, унаж л явлаа. Өдгөө өдий зэрэгтэй яваа маань гагцхүү Бурханы нигүүлсэл хийгээд Сүнсний хүч чадлын ач гэдгийг надаас илүү сайн мэдэх хүн байхгүй. Сүнсний хүч байгаагүй бол энэ ном ч төрөхгүй

байлаа. Тэр бол миний чадвар, чадлын эх булаг. Түүнгүйгээр би хаанчлалынхаа даалгаврыг хийж чадахгүй. Ариун Сүнс бол Бурханы нигүүлсэлийг илэрхийлэгч юм.

Дөрөвдүгээр өдөр

Өдгөө хэлээр ярихаа больсон уу?

Хайр хэзээ ч дуусдаггүй. Харин эш үзүүлж байгаа бол, тэдгээр нь үгүй болно. Хэрэв олон янзын хэлүүд байгаа бол тэд болих болно. Хэрэв мэдлэг байгаа бол энэ ч үгүй болно. Учир нь бид хэсэгхэнийг мэддэг, хэсэгхэнийг эш үзүүлдэг. Харин төгс юм нь ирэх үед хэсэгхэн гэдэг нь үгүй болно. (1Коринт 13:8-10)

Бид Үйлс номоос Ариун Сүнсээр дүүрэх тухай сурлаа. Тэгвэл одоо би олон хүнд байдаг нэг асуултад хариулья. Өдгөө хэлээр ярих явдал байхгүй гэж ярьдаг хүмүүс олон бий. Ингэхдээ тэд 1Коринт 13-р бүлгийн хэсгийг л эшлэдэг. Ийм үзлийг хөгжөөн дэмждэг хүмүүс Паулын “төгс юм нь ирэх үед хэсэгхэн гэдэг нь үгүй болно” гэж хэлсэн үгээр түрүү барьдаг. Харин “төгс” гэдэг нь Библийг хэлж байгаа юм гэж итгэдэг. Тэгээд ингэж уншина: *“Одоо төгс нь (Библи) ирсэн болохоор, хэл алга болсон.”*

Паул үнэхээр юу хэлсэнийг мэдэхийн тулд тус хэсгийг сайтар нягтлах нь чухал юм. Хэрэв тус ишлэлийг агуулгаар нь бүрэн харбал ийм дүгнэлт гаргах боломжгүй гэдгийг мэдэж болно. Хэрэв хэл байхгүй болсон юм бол мэдлэг ба эш үзүүлэл ч ялгаагүй байхгүй болсон. Мэдлэг ба эш үзүүлэл байхгүй болсон уу? Мэдээж үгүй. Тэгвэл Паулын хэлсэн “төгс” гэдэг зүйл нь юу юм бол? Үүнд 12-р ишлэл хариулжээ:

Учир нь бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч, харин дараа нь нүүр нүүрээ харна. Би одоо хэсэгхэнийг мэддэг ч, би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ харин дараа нь би бүрэн мэдэх болно. (1Коринт 13:12)

Паул Есүстэй улаан нүүрээрээ уулзсан тухайгаа өгүүлсэн бөгөөд үүнийгээ л “төгс” зүйл гэжээ. Есүсийг сүр жавхлант, яруу алдарт дүрээр нь харсан нь Паулын хувьд “төгс” зүйл байжээ. Бид Есүстэй ингэж уулздаг уу? Түүнийг сүр жавхлан дотор нь хардаг уу? Бид газар дээр амьдрах энэ амьдралдаа Есүстэй уулзах нь яг л толин дахь тусгалтай адил юм. Харин эрин цагийн төгсгөл ирэхэд бид Есүсийг яг Тэр биднийг мэддэг шиг мэдэх болно. Есүстэй тогтоох энэ дотносол маань мөнөөх “төгс” зүйл ирсэний тэмдэг ажээ. Дэлхий дээр эхэлсэн энэ аян маань Есүстэй өнө мөнхлөлд нүүр нүүрээрээ уулзахад л төгс болно.

Хэлний дөрвөн төрөл

“Жон, тэгвэл яагаад 1Коринт 12:30 дээр “бүх хүн хэлээр ярьдаг уу?” гэж хэлсэн юм бэ? Энэ чинь бүгд хэлээр ярьдаггүй гэсэн үг биш үү?” гэж асуумаар байна уу? Тийм ээ, гэсэн үг мөн. Гэхдээ Паул энд тодорхой нэг *төрлийн* хэлийн талаар ярьсан бөгөөд энэ *төрлийн* хэлээр бүх итгэгч хүн ярихгүй. Үүнийг ойлгохын тулд Шинэ гэрээнд гардаг 4 төрлийн хэлийг үзье.

Ойлгомжтой болгохын тулд би эдгээрийг *нийтэд* зориулсан, *хувьдаа* зориулсан гэж хоёр ангилъя. Хоёр хэл нь нийтийн төлөөх үйлчлэлд зориулагдсан. “Нийтэд” гэдэг нь нэг хүн нөгөөдөө юмуу бүлэг хүмүүст Сүнсний үйлчлэлийг хийхийг хэлж байна. Харин хувьдаа хэрэглэх нөгөө хоёр хэл нь биднийг шууд Бурхантай холбож, Түүний төгс ойлголтоор хөдлөх чадвартай болгодог.

Нэг: Үл итгэгч хүмүүсийн хувьд тэмдэг болдог хэл

Энэ хэл нь нийтэд зориулагджээ.

Тиймээс хэлүүд нь итгэдэг хүмүүсийн төлөө бус, харин итгэдэггүй хүмүүсийн төлөөх тэмдэг болдог аж. Харин эш үзүүлэг нь итгэдэггүй хүмүүсийн төлөө бус, харин итгэдэг хүмүүсийн төлөө байдаг. (1Коринт 14:22)

Ариун Сүнс бидний оюуны мэдлэгийг хол даван, бидний огт мэдэхгүй, энэ дэлхийн өөр нэг хэлээр ярих чадвартай болгодог. Пентекост өдөр хүмүүс яг ийм төрлийн хэлээр ярьсан юм.

Тэр цагт тэнгэрийн доорх үндэстэн бүрээс сүсэгт иудейчүүд Иерусалимд амьдарч байв. Энэхүү дуу чимээнээр үй олон хүмүүс цугларч, өөрсдийнх нь төрөлх хэлээр тэдний ярихыг сонсоод ихэд гайхжээ.

Гайхаж алмайрсан тэд

—Энэ ярьж байгаа хүмүүс чинь галилчууд биш үү? Гэтэл бид бүгдээрээ өөрсдийн төрөлх хэлээрээ тэдний ярихыг сонсож байх нь юу вэ? Паргчууд, медечүүд, еламчууд, Месопотами, Иудей, Каппадок, Понт, Ази, Фруг, Памфул, Египет болон Курений хавийн Ливийн хэсэгт суугчид болон Ромоос ирэгсэд болох иудейчүүд болон шинэ сүсэгтнүүд, кретийнхэн, арабууд болох бид Бурханы агуу үйлсийн тухай тэдний яриаг өөрсдийн төрөлх хэл дээр сонсоцгоолоо гэв. (Үйлс 2:5-11)

Итгэгч нар өөрсдийнх нь төрөлх хэлээр ярьж байхыг тэнд байсан Иудейчүүд сонсжээ. “Харанхуй бүдүүлэг” галилчууд олон хэлээр Бурханы гайхамшгийг тунхагласан энэ үзэгдэл нь Есүсийн сайн мэдээнд итгэсэн хүмүүсийн дунд Бурхан ажиллаж буйн тэмдэг байжээ. Сүнсний хүчийн энэ илрэлийн улмаас олон хүн Есүсийг мэдэх болов.

Хэдэн жилийн өмнө би Колорадо Спрингсийн чуулганд номлосон юм. Энэ үеэр манай нэг ажилтан чуулганы арын эгнээнд сууж байв. Намайг номлох үеэр түүний дотор хэлээр аядуу залбирах хүсэл бургилжээ. Үйлчлэл дууссаны дараа түүний өмнө сууж байсан эрэгтэй манай ажилтанд: “Та Францаар онцсайн ярих юм аа. Эртний Франц аялгыг төгс эзэмшиж шүү. Би өөрөө Франц хэлний багш хүн л дээ. Гэхдээ амьдралдаа тан шиг сайн ярьдаг хүнтэй учирч явсангүй” гэжээ.

Манай ажилтан түүнд: “Би Францаар ярьдаггүй л дээ”

гэж учирлахад, мань эр мэл гайхаж “Та чинь Францаар яриад зогсохгүй, Бичээсээс ишлэж байсан. Тэр үед Жон яг тэрийг ишлэлийг гаргахыг хүмүүсээс хүссэн. Та Жоныг хэлэхээс өмнө тэдгээр ишлэлийг хэлээд байсан” гэжээ. Энэ явдал нь Бурхан надаар дамжуулж хэлсэн үгээ тэр хүнд батласан тэмдэг байв. Энэ тэмдэг-хэл нь хараахан итгээгүй байгаа хүний анхаарлыг татах зорилготой ажээ.

Хоёр: Тайлбарладаг хэл

Хоёр дахь төрлийн хэл нь бас л нийтэд зориулагджээ. Тэмдэг-хэлийг бодвол энэ нь дэлхий дээр хэрэглэгддэггүй, тэнгэрийн хэл юм. Энэ хэлний тухай Паул I Коринт 12:10 дээр ярьсан байдаг: бас өөр нэгэнд нь гайхамшигуудыг үйлдэх, нөгөөд нь эш үзүүлэх, бас нэгэнд нь сүнсүүдийг ялгах чадвар, нөгөөд нь *олон янзын хэлээр ярих чадвар*, нэгэнд нь *хэлүүдийг тайлбарлах чадварыг* өгсөн байна. Энэ тэнгэрийн хэлийг заавал тайлбарлах шаардлагатай.

Хэдэн жилийн би Сингапурын нэг чуулганд номлохоор бэлтгэж байтал чуулганы нэг хүн үл мэдэх хэлээр ярьж эхлэв. Энэ нь газрын бус, тэнгэрийн хэл гэдгийг би тэр даруй мэдлээ. Өрөөнд байсан бүх хүн Сүнсний илрэлийг бишрэв. Тэрбээр ярьж дууссанахаа дараа үүнийгээ тайлбарлав. Энэ нь тухайн чуулганд зориулж надад өгсөн Бурханы үгтэй яг таарч байлаа. Тэгэхэд би *Бурхан минь, гайхалтай баталгаанд тань баярлалаа!* гэж бодож билээ. Бурхан миний зүрхэнд өгсөн үгээ тайлбарладаг хэлээр баталгаажуулжээ. Энэ нь миний ч хувьд, хүмүүсийн ч хувьд тэмдэг болов.

Би уг хэлийг *орчуулах бус, тайлбарлах* гэж хэлсэнийг анхаарна уу. Тэнгэрийн хэл нь (Шинэ гэрээнд гардаг 4 төрлийн хэлийн гурав нь) хүний оюун ухаанаас хальсан хэл учраас орчуулагдах боломжгүй. Гэхдээ эдгээрийг тайлбарлаж болно.

Энэ ангилалд багтдаг хэл нь заавал *тайлбарлагдах* ёстой. Энэ хэл нь гагцхүү Чуулганыг босгон байгуулахын төлөө өгөгдсөн бөгөөд тайлбарлахгүй аваас Чуулган босгон байгуулагдахгүй (I Коринт 14).

Паул “Бүгд хэлээр ярьдаг уу?” гэхдээ яг энэ төрлийн хэлний талаар ярьж байсан юм. Одоо энэ ишлэлийг бүрэн агуулгаар нь харья:

Бурхан чуулганд нэгдүгээрт элч нар, хоёрдугаарт эш үзүүлэгчид, гуравдугаарт багш нар, дараа нь гайхамшгийг үйлдэх хүч, дараа нь эдгээх бэлгүүд, туслах, удирдах ба олон янзын хэлээр ярих чадварыг тавьжээ. Бүгд элч нар гэж үү? Бүгд эш үзүүлэгчид гэж үү? Бүгд багш нар гэж үү? Бүгд гайхамшгийг үйлдэгчид гэж үү? Бүгд эдгээх бэлгүүдтэй гэж үү? Бүгд олон янзын хэлээр ярьдаг гэж үү? Бүгд хэлийг тайлбарладаг гэж үү? (1Коринт 12:28-30)

Паул Чуулганы үйлчлэлийн төлөө өгсөн олон нийтийн төлөөх бэлэг авьяасын талаар ярьсан. Бүгд элч үү? Үгүй. Бүгд эш үзүүлэгч үү? Үгүй. Бүгд багш уу? Үгүй. Үүнтэй адилхан бүгд нийтийн үйлчлэлийн төлөө хэлээр ярьж, тайлбарладаг уу? Үгүй. Паул нэг л зүйлийг хэлжээ: Бурхан бидэнд өгсөн тодорхой бэлэг авьяасыг л цэцэглүүлэх ёстой. Чуулганы хүн бүр хэлийг нийтийн төлөө ашиглана гэж байхгүй.

Нийтийн төлөөх үйлчлэлд зориулагдсан хоёр хэлний ялгаа

Коринтод бичсэн захидалдаа Паул дээрх хоёр хэлний ялгааг хэлжээ:

Тиймээс хэлүүд нь итгэдэг хүмүүсийн төлөө бус, харин итгэдэггүй хүмүүсийн төлөөх тэмдэг болдог аж. Харин эш үзүүлэг нь итгэдэггүй хүмүүсийн төлөө бус, харин итгэдэг хүмүүсийн төлөө байдаг. Тиймээс хэрэв чуулган бүрэн бүтнээрээ хамтдаа цуглаад, бүгд хэлүүдээр яривал бэлэг авьяасгүй хүн,

эсвэл итгэдэггүй хүмүүс орж ирвэл тэд та нарыг галзуу гэж хэлэхгүй гэж үү? (1Коринт 14:22-23).

Хэрэв та хэл нь олон төрөлтэй гэдгийг ойлгохгүй байгаа бол, Паул үүнийг бичихдээ өөрөө өөрийгөө үгүйсгэжээ гэж бодож магадгүй. Эхлээд тэр “Хэл нь итгэдэггүй хүмүүсийн төлөөх тэмдэг” гэж хэлчихээд, харин дараагийн ишлэлдээ “итгэдэггүй хүмүүс орж ирвэл тэд та нарыг галзуу гэж хэлэхгүй гэж үү” гэж хэлсэн байх юм. Гэхдээ дээрх дөрвөн төрлийн хэлийг ялгаж мэдэж сурбал Паул хоёр өөр төрлийн хэлний тухай ярьж байсныг ойлгоно.

Эхний хэл нь итгэгч бус хүмүүсийг татдаг, тэдний хувьд тэмдэг болдог хэл. Хоёрдугаарх нь (тайлбарладаг хэл) гагцхүү Чуулганыг босгон байгуулагдахын төлөө өгөгддөг хэл. Тайлбарлахгүй аваас энэ төрлийн хэлээр ярьж буй итгэгч нарыг итгэгч бус хүмүүс галзуу гэж үзнэ хэмээн Паул хэлсэн.

Бүтэн сайны хүндэтгэлийн цуглаан дээр бүх хүн нэгэн зэрэг номлож, зааж, эш үзүүлбэл яах уу? Аймшигтай эмх замбараагүй явдал болно. Тайлбарладаг хэлийг ийм маягаар ташаа хэрэглэхгүй байхыг Паул Чуулганд заажээ. Үүнийг буруу хэрэглэбэл чуулганд эмх замбараагүй байдал тарьж, үр дүн нь хоосон болно. Тус бүлгийн эхэн хэсэгт Паул хэл нь эргэлзээ тарих бус, харин ойлголт илчлэлт авчрахын төлөө юм гэдгийг хэлсэн.

Би та бүгдээс ч илүүгээр хэлээр ярьдаг тул Бурханд талархдаг. Чуулган дотор хэлээр түмэн үг хэлснээс бусдыг ч мөн сургахын тулд чуулган дотор ухаанаараа таван үг хэлэхийг би хүсдэг. (1Коринт 14:18-19)

Тун энгийн: нийтийн үйлчлэлийн төлөөх хэлийг хэрэглэж байгаа бол үүнийг тэнд буй хүмүүсийн тусын тулд тайлбарлах хэрэгтэй. Үгүй аваас зүгээр мэддэг хэлээрээ харилцах нь хавьгүй дээр юм.

Гурав: Хувийн залбирлын хэл

Учир нь хэрэв би хэлээр залбирвал миний сүнс залбирдаг бөгөөд харин миний ухаанд үр жимс үгүй юм. Тэгвэл яах вэ? Би сүнсээр залбирах болно. Би бас ухаанаар залбирах болно. Би сүнсээр дуулах болно. Би бас ухаанаар дуулах болно. (1Коринт 14:14-15)

Эхний хоёр төрлийн хэл нь нийтийн төлөө бөгөөд Бурханы үгийг хүнд хүргэх үүрэгтэй. Тэмдэг хэл нь итгэгч бус хүмүүст хүрч үйлчлэхэд зориулагдсан бол, тайлбарладаг хэл нь итгэгч хүмүүст зориулагджээ. Дээрх ишлэлд Паул гурав дахь төрлийн хэлийг танилцуулж байна: *хувийн залбирлын хэл*. Энэ хэлийг нийтийн үйлчлэлд бус, хувийнхаа залбиралд хэрэглэнэ. Энэ нь хувь хүний босгон байгуулалт, залбирлын төлөө ажээ. Бид нэг бол англиар буюу “ухаанаар залбирч” болно эсвэл “сүнсээр” буюу үл мэдэх, тэнгэрийн хэлээр залбирч болно. Дуулахын хувьд ч ялгаагүй.

1Коринт 14:2: Хэлээр ярьдаг хүн хүмүүст бус, харин Бурханд хандаж ярьдаг. Учир нь тэр хүн сүнс дотор нууцуудыг ярьдаг боловч ямар ч хүн ойлгодоггүй ажээ. Ариун Сүнсний энэ илрэл нь тэмдэг хэлтэй хамаатай байх ёсгүй. Учир нь Пентекост өдөр элч нар Бурханы гайхамшигт үйлсийг гадаад хэлээр хүмүүст тунхагласан. Түүнчлэн энэ нь тайлбарладаг хэл байх учиргүй. Яагаад гэвэл энэ нь итгэгч хүн чуулганд хандаж ярьдаг тэнгэрийн хэл бөгөөд үүнийг заавал тайлбарлах ёстой. Паул энд сүнсээр “хүнд бус, Бурханд хандан ярьж буй” хүний талаар өгүүлж байна.

Хувийнхаа залбиралд хэлээр ярих нь залбирч буй хүн Бурхан хоёрын хувийн харилцаа юм. Энэ нь хувь хүнийг хүчирхэгжүүлэх зорилготой. “Хайртууд минь, харин та нар хамгийн ариун итгэл дээрээ өөрсдийгөө сүндэрлүүлж, Ариун Сүнсээр залбиран мөнх аминд хүргэх бидний Эзэн Есүс Христийн өршөөлийг хүлээн Бурханы хайран дотор өөрсдийгөө сахь” (Иуда 20-21). Бид Ариун

Сүнс дотор (хэлээр) залбирахдаа өөрийгөө босгон байгуулдаг, харин Чуулган дотор тайлбарладаг хэлээр ярихдаа Чуулганыг боловсруулж, босгон байгуулдаг гэж Иуда хэлжээ (1Коринт 14:5). Хоёулаа чухал бөгөөд Бурхан хоёуланг нь хүсдэг.

Ариун Сүнсээр дүүрсэн атлаа хэлээр залбирахгүй байж болох уу? Болно гэдэгт би итгэдэг. Гэхдээ Ариун Сүнсээр дүүрсэн хүн бүр хэлээр залбирах чадвартай болдог гэдгийг би нэмж хэлмээр байна. Олон итгэгч нар итгэлээр захирагддаггүй учраас л энэ бэлэгээ хэрэглэдэггүй. Бурханы бэлэг бүр итгэлээр хүлээн авагдаж, идэвхиждэг.

Ингээд бодоод үз. Хоёр хүн голд оржээ. Нэг нь зүгээр зогсоод л усны урсгалыг хажуугаараа өнгөрөөв. Харин нөгөө нь биеэ суллан хэвтээд усны урсгалд хөвөв. Хоёулаа л усанд байгаа. Гэхдээ хоёр дахь нь усны урсгалыг даган хөвжээ. Хэлээр залбирч буй хүн усны урсгалаар хөвж буй хүнтэй адил юм. Харин хэлээр залбирдаггүй хүн нь голын усанд байгаа боловч, урсгалд захирагдаагүй хүнтэй адил юм (Сүнсэнд хэрхэн захирагдахыг мэдмээр байвал энэ талаар бид дараагийн бүлэгт ярилцана).

Ариун Сүнсстэй нөхөрлөх нь Есүсийн үхэл ба амилалтаар бидэнд олдсон олон завшааны нэг мөн. Гэхдээ биднийг аврагдах эгшинд энэ нөхөрлөл дөнгөж эхэлдэг. Бурханы бидэнд зориулсан бүх зүйлийг мөшгих нь тун чухал. Биднийх болгохын төлөө Есүсийн амиа өгсөн бүхнийг таньж мэдэх нь Христ доторх аялалын маань нэжгээд том хэсэг юм. Ариун Сүнс биднийг хаанчлалын даалгаврын төлөө хүчирхэгжүүлж сургадаг гэдгийг өмнө ярьсан. Хэрэв бид Сүнсний өгч буй бэлэгийг үл хэрэгсбэл Бурхантай ч дотносож чадахгүй, Түүнд үйлчлэхэд бидэнд шаардлагатай хүчээр ч дутна.

Дөрөв: Зуучлан залбирах хэл

Үүнчлэн мөн Сүнс бидний сул дорой байдалд тусалдаг. Учир нь яаж залбирах ёстойгоо бид мэддэггүй. Харин Сүнс Өөрөө үгээр илэрхийлшгүйгээр ёолон байж

бидний төлөө зуучлан гуйдаг. Сүнсний бодол санаа юу болохыг зүрхнүүдийг Нягтлагч нь мэддэг. Яагаад гэвэл Тэр Бурханы хүслийн дагуу ариун хүмүүсийн төлөө зуучлан гуйдаг юм. (Ром 8:26-27)

Паул энэ хэсгийг “сул дорой” гэдэг үгээр эхэлжээ. Паул ямар сул талын тухай ярих? Хариулт нь: “Учир нь яаж залбирах ёстойгоо бид мэддэггүй. Харин Сүнс Өөрөө үгээр илэрхийлшгүйгээр ёолон байж бидний төлөө зуучлан гуйдаг.” Энгийнээр хэлбэл, бид энэ дэлхийд, эргэн тойронд маань юу өрнөж буй талаар мөхөс ойлголттой байдаг. Тиймээс заримдаа бид яаж залбирахаа мэддэггүй. Харин (бүхнийг мэддэг) Сүнсэнд найдаж, Түүний дотор зуучлан залбирбал Тэр биднээр дамжуулан Бурханы төгс хүслийг залбирдаг.

Би коллежд байхдаа чуулганд огт явдаггүй гэр бүлээс болон янз бүрийн деноминациас гаралтай 60 гаруй оюутантай Библи судлалын бүлгийг удирддаг байв. Тэнд хэлээр ярих эрин үе төгссөн гэж итгэдэг деноминациас гаралтай нэг охин байсан юм. Нэг орой намайг Ариун Сүнсний талаар заахыг сонсоод тэрбээр *Хэл өнөөдөр ч байгаа! Библид байгаа!* гэдгийг ухаарчээ. Тэр орой тэрбээр Ариун Сүнсээр дүүрсэн юм.

Маргааш өглөө нь 6.30-ийн утасны дуудлага намайг сэрээв-ямар оюутан ийм эрт сэрэхийг хүсэхийг билээ?! Гэтэл мөнөөх Библи судлалын охин намайг уулзъя хэмээн дуудав. Түүний аж төрдөг охидын дотуур байр манай эрчүүдийн дотуур байрны яг замын эсрэг талд байрладаг байв. Би ч дуртай дургүй орноосоо босч түүн дээр очлоо.

Нойрноосоо ч гүйцэт сэрж амжаагүй, ундууцаар хүрч очтол нөгөөх чинь бүр хөөрчихсөн зогсож байлаа. Би ч “За яасан бэ?” гэж асуулаа.

Гэтэл тэрбээр “Өнөөдөр Бурхан намайг таван цагт сэрээлээ. Надад хэлээр залбирах ятгалга төрсөн тул би залбирсан юм. Яг л хэн нэгний төлөө зуучлан залбираад байгаа юм шиг санагдсан болохоор би Бурханаас хэний төлөө ингэтлээ хэлээр залбираад байгааг асуусан чинь Эзэн “Чи нэгэн настай хүний төлөө залбирч байна” гэж хариулсан. Тэгээд би залбираад л байлаа.

Тэгтэл өглөөний 6:30 цагт манай өрөөний охин гэнэтийн утасны дуудлага хүлээн авч, өвөө нь зүрхний шигдээс болж, эмнэлэгт хүргэгдээд, амь аврагдсан тухай мэдээ сонссон.

Тэгэхэд Ариун Сүнс надад “Чи түүний төлөө залбирсан” гэж хэллээ” хэмээн өгүүлэв. Энэ бол зуучлан залбирлын төгс жишээ. Хүний амь насанд аюул тулгарсаныг тэр охин мэдээгүй боловч Ариун Сүнс мэдэж байжээ. Хэрэв тэр зөвхөн ойлгодог зүйлийнхээ төлөө залбирсан бол хэзээ ч зуучлан залбирч чадахгүй байв.

Ээж маань Флоридад аж төрдөг учраас яг одоо түүний яаж байгааг би мэдэхгүй. Калифорнид аж төрж байгаа эгч маань яаж байгааг би бас мэдэхгүй. Гэхдээ тэдэнд хандсан Бурханы төгс хүслийг Ариун Сүнс мэддэг бөгөөд Түүнд захирагдах үед Тэр надаар дамжуулж зуучлан залбирдаг. Сүнс бүхнийг нэгждэг, бүхнийг мэддэг. Ариун Сүнсэнд биднээр дамжуулан залбирахыг зөвшөөрөх үед бидний ойлголтыг аугаа амар тайван дагана!

Хувийн хэлний талаарх тодруулга

“Хувийн” гэсэн хоёр төрлийн хэлд онцлох зүйл бий. Заримдаа Сүнсээр дүүрсэн итгэгчид хамтдаа хэлээр залбирдаг. Энэ үед тэд Сүнс дотор хамтдаа залбирах нь зөв юм. Гэтэл итгэгч хүмүүс олон нийтийн дунд залбирахдаа хэлээр залбирах шаардлагагүй үе бас бий. Паул энэ талаар мэдэгджээ:

Тиймээс хэрэв чуулган бүрэн бүтнээрээ хамтдаа цуглаад, бүгд хэлүүдээр яривал бэлэг авъяасгүй хүн, эсвэл итгэдэггүй хүмүүс орж ирвэл тэд та нарыг галзуу гэж хэлэхгүй гэж үү? (1Коринт 14:23)

Энэ хэсэг хоёр бүлэг хүмүүсийг тодорхойлжээ. Нэгдүгээрт- Паул *итгэдэггүй хүмүүсийг дурьдсан*. Тэд бол Есүс Христийг хүлээж аваагүй, итгэлийн гадна оршдог хүмүүс юм. Хоёрдугаар бүлэг нь *мэдээгүй хүмүүс*. Тэд Есүс доторх итгэгч хүмүүс боловч Сүнсний хэлний талаар сураагүй хүмүүс байв. Энэ хоёр бүлэгт багтдаг хүмүүс хэлээр залбирдаг хүмүүсийн дунд таагүй байдаг.

Харамсалтай нь Бүтэн сайны хүндэтгэлийн цуглаан дээр олон хүмүүс нэгэн зэрэг хэлээр чанга залбирахыг удирдагч нь уриалан дэмжиж байхыг би ганц нэг удаа харсан юм. Үнэндээ урьд нь би өөрөө ч дутуу дулимаг ойлголтоосоо болж хүмүүсийг ингэж удирддаг байлаа. Бүтэн сайны ийм цуглаанд итгэдэггүй болон мэдээгүй гэдэг ангилалд багтах зочид гийчид олон ирдэг. Тэд Энэ хүмүүс галзуу юм байна гэж л бодно. Зарим чуулган өсч, нийгэмдээ хүрч үйлчилж чаддаггүй. Шалтгаан нь 1Коринт 14:23 дээр хэлсэн цэц ухааныг дагаагүйд байгаа биш үү? Тэд үүнийгээ хийгээд л байвал итгэдэггүй болон мэдээгүй хүмүүс эргэж ирэхгүй.

Нөгөө талаас чуулган итгэгчдийн залбирлын цуглаан хийдэг. Энэ цуглаанд бүгдээрээ итгэгч бөгөөд мэддэг хүмүүс байна. Энэ үед бүгдээрээ Эзэнд үйлчлэхээр эсвэл зуучлахаар хэлээр залбирч болно.

Энгийнээр хэлбэл “хэлээр хувьчлан” залбирахад буруу цаг юмуу буруу газар гэж байхгүй. Харин итгэдэггүй, мэддэггүй хүмүүс байж болох олон нийтийн дунд хэлээр ярих эсэхдээ мэдрэг бай.

Танд хандсан Бурханы хүсэл

Иймд ах дүүс [минь], эш үзүүлэхийн тулд хүслэн болж тэмүүл. Хэлээр ярихыг бүү хоригло. Гэвч бүх юм зохистой, эмх журмынхаа дагуу байг.
(1Коринт 14:39-40)

Чуулган хэлний энэхүү гайхамшигтай бэлэгийг буруу ташаа хэрэглэнэ гэдгийг Паул мэдэж байсан учраас л “бүх юм зохистой, эмх журмынхаа дагуу байг” хэмээн бидэнд анхааруулжээ. Харамсалтай нь Чуулган Сүнсний олон зүйлийн талаар ямар ч мэдлэггүй явдаг. Үнэхээр эмгэнэлтэй. Учир нь Ариун Сүнс Чуулганыг хүчирхэгжүүлэхээр илгээгдсэн. Бурхан хаанчлалаа тэлэх зэмсгээр Чуулганаа л сонгосон юм. Хэрэв бид Христ дотор эзлэх байр суурийг маань дагаж ирдэг хүчийг хүлээн зөвшөөрч ашиглахгүй бол хааныхаа эрх хүчийг ашигладаггүй хаантай л адил болно.

Өнөөдөр хэлээр ярих үзэгдэл байхгүй гэдэг итгэлээсээ болж хичнээн олон итгэгч хүн Сүнсний энэхүү гайхамшигтай бэлэгийг алдаж байна? Бурхан “Би та бүхнийг хэлээр яриасай гэж хүсдэг ч, эш үзүүлэхийг чинь бүр ч илүү хүсдэг. Ярьснаа тайлбарлахгүй л бол хэлээр ярьдаг хүнээс эш үзүүлдэг хүн нь илүү агуу юм. Ингэснээр чуулган нь босгон байгуулагдах юм” (1Коринт 14:5) хэмээн хүсдэг нь тодорхой байна. “Үүнийг чинь Бурхан биш, Паул бичсэн, за!” гэж маргах хүн байгаа байх. Гэхдээ “Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай” (2Тимот 3:16) гэдэг.

Хэл нь Ариун Сүнсний хүчийн чухал тал, Бурхантай тогтоох дотно нөхөрлөлийн үзэсгэлэнтэй хэсэг гэдгийг бүү мартаарай. Тиймээс би ч гэсэн Паултай адил “Та энэ гайхалтай бэлэгийг өвөртөлж, өдөр бүр Сүнсний оршихуй, хүч дотор өсөөсэй” гэж залбирья.

Нэгдүгээр өдрийн чимээгүй цаг

СҮНС АЖИЛ ХЭРЭГ БОЛГОДОГ!

*Бас Бурхан Өөрийнхөө хүслийн дагуу тэмдэг хийгээд
гайхамшигаар, янз бүрийн хүчит үйлс болон Ариун Сүнсний
бэлгүүдээр дамжуулан тэдний хамт гэрчилсэн билээ.*

Еврей 2:4

Ариун Сүнс бол олон гайхалтай арга замаар ажигладаг, ажил хэрэгч Агент. Бичээст Түүнийг тагтаа, гал, салхи, дарсаар билэгдэн дүрслэдэг. Эдгээрийг ойлгобол, Түүний зан чанарыг болон Тэр бидний дотор бас биднээр дамжуулан хэрхэн ажилладагийг ойлгоно.

Тагтаа- Ариун Сүнс. Ариун Сүнс Есүс дээр тагтаа шиг бууж ирсэнийг Сайн мэдээний 4 ном өгүүлдэг. Тагтаа бол хайрламаар, зөөлөн, номхон, үргэмтгий амьтан. Тагтаа амар тайван аюулгүй газар л буудаг. Тэд сонгосон хостойгоо насан турш байдаг. Эдгээр шинжээс та Ариун Сүнсний талаар юу ойлгож байна?

Матай 3:16-17; Марк 1:9-11; Лук 3:21-22; Иохан 1:32-33-г үзнэ үү.

Гал - Ариун Сүнс. Ариун Сүнс Мосед шатаж буй бургас мэт үзэгдэж бас Израилийг галан баганаар дагуулсан. Пентекост өдөр гал хаялах мэт хэлээр хүмүүс баптисм хүртсэн (Үйлс 2:3). Тэрбээр Есүсийн дэлхий дээр авчирсан гал бөгөөд бид Түүнийг унтраахаас болгоомжлох ёстой. Галын шинж чанарын тухай бодоод үз: гал цэвэрлэдэг, гэрэл өгдөг, халуун дулааныг бүтээдэг, юмсыг залгадаг.

Энэ бүхэн нь Бурханы Сүнсний галт шинж чанарын талаар танд юу зааж байна? Юу галыг өрдөж дүрэлзүүлдэг вэ?

Үйлс 2:3-4; Лук 12:49; 1Тесалоник 5:19-21; Лук 3:16-17; Иеремиа 20:9, 23:29; Еврей 12:29-г үзнэ үү.

Салхи- Ариун Сүнс. Ариун Сүнс Пентекост өдөр галаар төдийгүй салхин хэлбэрээр буусан. Салхи нь зөөлөн сэвшээ салхинаас авахуулаад, хуй хэлбэртэй байдаг. Салхи юу хийдэг вэ? Сүнсний салхи таны амьдралын тухайн үе бүрт яаж ажилладаг вэ? Тэр юу хийж чадах вэ?

Иохан 3:5-8-г үзнэ үү.

Дарс- Ариун Сүнс. Пентекост өдөр хүмүүс хэлээр Бурханы гайхамшигийг тунхагласан. Энэ нь маш их чанга хурц хэлбэртэй өрнөсөн учраас хүмүүс тэднийг согтуу хөлчүү гэж бодсон ч энэ бол Ариун Сүнс гэдгийг Петр хэлжээ. Архи дарс хүний сэтгэл хөдлөлд яаж нөлөөлдөг вэ? Сүнсний шинэ дарсыг уух нь танд яаж нөлөөлөх вэ?

Үйлс 2:13-18; Лук 5:37-38 (Марк 2:22; Матай 9:17); Ефес 5:18-19; Эстэр 1:10; Иеремиа 31:11-13-г үзнэ үү.

Тэнгэр Ариун Сүнсийг багтааж дийлэхгүй учраас Тэрбээр зарц нарынхаа зүрхэнд нутаглажээ. Бид Түүний сүм. Түүний нөлөө болгон бидний дотроос талархалын магтаал төрүүлдэг. Тэр салхи мэт юм бол бид салхины илбээ шиг. Тэр шүүдэр юм бол бид цэцэгстэй дэлгэрнэ. Тэр гал юм бол бид ардортой гэрэлтэнэ. Тэрбээр бидний дотор ямар ч арга замаар хөдөлсөн, бид Түүний дуу хоолойд хариулах ёстой.

-Чарльз Спаржион.

Хоёрдугаар өдрийн чимээгүй цаг

ТҮҮНИЙ ОРШИХҮЙ ИЛ ХАРАГДДАГ

Нийтийн тусын тулд Сүнсний илрэлийг хүн тус бүрд өгсөн аж.
1Коринт 12:7

Бурханы Сүнс оршин буй нь ил харагддаг! Гол мөрөн хуурай газраар урсана. Сохор дүлий нь эдгэрнэ. Хөлгүй нь явж, хэлгүй нь ярина. Айдас ялагдаж, найдвар дахин төрнө! Бурханы Сүнсстэй сүлжигдэхэд бидний амьдралын ландшафт дээр янз бүрийн гайхамшиг тэмдэглэгдэнэ.

Ариун Сүнс оршин буйн баталгааг хүмүүс харж сонсож байгааг Үйлс ном дахин дахин хэлдэг. Амьдралаа эргэн хар. Сүнсний оршихуйн ямар баталгааг та санаж байна? Ариун Сүнс буун ирж, амьдралыг тань орвонгоор нь эргүүлсэн ганц хоёр тохиолдлыг бичнэ үү.

Миний санаж буй эхний жишээ:

Миний санаж буй хоёрдугаар жишээ:

Миний санаж буй гуравдугаар жишээ:

Бүү яар. Бурханы сайн сайхныг тунгаан бод. Түүний итгэмжтэй чанарыг санахад Сүнс таныг шинэ амьдралаар сэлбэнэ.

Би ЭЗЭНий үйлсийг санана.

Би эрт үеийн Таны гайхамигуудыг үнэхээр санана.

Би Таны бүх ажлыг тунгаан,

Таны үйлсийг шимтэн бодно.

Бурхан, Таны зам бол ариун.

Ямар бурхан бидний Бурханы адил агуу вэ?

Та бол гайхамигуудыг үйлддэг Бурхан.

Та ард түмнүүдийн дунд Өөрийн хүч чадлыг мэдүүлсэн.

Дуулал 77:11-14

Ариун Сүнс танд өмнө тусласан бол одоо ч тусална! Түүгээр яаж туслуулмаар байна? Түүний өмнө чимээгүй байж, дахиад үүнийгээ хийхийг урь! Тэр бодитой учраас таны төлөө, таны эргэн тойрон дахь хүмүүсийн төлөө үнэхээр санаа тавьдагаа батлан харуулахыг Түүнээс хүсээрэй. Чимээгүй бай! Тэр тантай ярьж байна уу?

Эзэнийг магт. Түүнд талархал магтаал өргөсөн залбирал бич! Тэр магтуулах бүрэн эрхтэй!

Гуравдугаар өдрийн чимээгүй цаг

ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ДҮҮРСЭЭР БАЙХ

Дарсанд бүү согтуур. Ингэвэл дураараа дургих байдалд автагдана. Харин Сүнсээр дүүрэн байж,
Ефес 5:18

Ариун Сүнсээр үргэлжлүүлэн дүүрэхийг Паулаар дамжуулж хэлсэн Бурханы тушаал нь тун чухал юм. Дүүрэхийг Грекээр *pleroo* (“play-go-o”) гэдэг бөгөөд энэ нь хүний ахуй сэтгэлийг тэр аяар нь дүүргэх гэсэн утгатай. Гэхдээ энэ үйл үгийн цаг нь *пассив*, зайлшгүй, одоо цаг дээр байгаа нь бүр чухал. **Пассив** дуу гэдэг нь (субъект болох) таны дээр аливаа зүйл үйлдэгдэнэ гэсэн утгатай; **зайлшгүй дуу** гэдэг нь тухайн үгийг санал бус, тушаал болгодог. Харин **одоо цаг** нь үргэлжилсэн үйлдлийг илэрхийлнэ.

Ефес 5:18 энэ үнэнийг тайлдаг: “Дарсанд бүү согтуур. Ингэвэл дураараа дургих байдалд автагдана. Харин **Сүнсээр дүүрэн байж**,” Ариун Сүнсээр үргэлжлүүлэн дүүрэх нь биднийг Есүс шиг амьдрахад хэрэгцээтэй бүхнээр сэлбэх бөгөөд Бурханы хүслийг тэнгэрт шигээ газар дээр авчирдаг. Сайн мэдээ дэлгэрүүлэгч **Смит Вигельсворт** ийн хэлжээ:

“Миний амьдрал дахь Ариун Сүнсний баптисмын үнэ цэнийг би юугаар ч үнэлж чадахгүй. Сүнсээр дүүрэх нь нэг талаасаа тансаг завшаан, харин нөгөө талаасаа тэнгэрлэг тушаал юм. Тасралтгүй дүүрэх нь та өглөө, өдөр, шөнө хэлээр ярина гэсэн үг. Сүнсээр амьдрах үед та аж төрж буй гэрийнхээ шатаар буухад, чөтгөр таны өмнө явна. Та чөтгөрийг ялан дийлэгчээс ч илүү нэгэн болно!”

... Сүнс дотор амьдарч буй хүн хөдөлж, үйлдэж, идэж ууж, ер нь

юу ч хийсэн Бурханд алдрыг авчирна. “Сүнсээр дүүрэн бай.” Энэ бол Бурханаас танд зориулсан байр суурь бөгөөд тэнгэр нь газрын дээр тогтохын адил энэ нь жирийн амьдралаас хавьгүй өндөр юм. Бурханы таныг дүүргэхийг хүснэ. Харин та Түүнд захирагд.”

Петр, Иохан тэргүүтэй дагалдагч нар Пентекост өдөр Сүнсний баптисм хүлээж авсан. Төд удалгүй залбирч байхдаа Сүнсээр дахин дүүрсэн.

Үйлс 4:23-31-р ишлэлийг анхааралтай унш. Сүнсээр дандаа дүүрэн байхын тулд энэ үйл явдлаас юу сурч болох вэ?

Паулаар дамжуулан Бурхан ийн хэлжээ: “сүнслэг бэлгийг бүү үл ойшоо” (1Тимот 4:14; 2Тимот 1:6). Өөрөөр хэлбэл Ариун Сүнсээр үргэлжлүүлэн дүүр. Ефес 5:18-19; 6:18; Иуда 20-г анхааралтай унш. Түүний галыг дотроо ноцоосоор байхын төлөө юу хийхийг Сүнс харуулж байна?

Иймд ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл мөн. Энэ үеийн явдалд бүү нийцэгтүн. Харин зүрх сэтгэлээ шинэчилснээр өөрчлөгдөж Бурханы хүсэл юу болохыг, тухайлбал сайн, тааламжит, төгс төгөлдөр хүслийг батлагтун.

Ром 12:1-2

Дөрөвдүгээр өдрийн чимээгүй цаг

ТЭР ТАНД БЭЛЭГ АВЪЯАС ӨГСӨН НЬ ЗОРИЛГОТОЙ

Нийтийн тусын тулд Сүнсний илрэлийг хүн тус бүрд өгсөн аж.

1Коринт 12:11

Есүсийн эхлүүлсэн ажлыг биднээр үргэлжлүүлэхийн төлөө Ариун Сүнс бидэнд тодорхой бэлэг өгсөн. “Нийтийн тусын тулд Сүнсний илрэлийг хүн тус бүрд өгсөн аж” (1Коринт 12:11).

Эдгээр бэлэг нь өнөөдөр байгаа юу? Есүсийн хийсэн зүйлсийг бид хийх ёстой юу? Мэдээж. Африк тивд сая сая хүн Христэд итгэхийг гэрчлэн харсан Сайн мэдээ дэлгэрүүлэгч **Рэйнхард Бонк** ийн тунхаглажээ:

“Бурхан хүмүүстээ зориулж гайхамшгийг үйлдэгч гэдэгт бат итгэдэг. Есүсийг дэлхий дээр алхаж явахад дагалдаж байсан тэмдэг өнөөдөр бидний амьдралд хэрэгжих учиртай бөгөөд ёстой. Есүс дагалдагч нартаа “Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг хүн Миний хийдэг ажлуудыг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно. Яагаад гэвэл Би Эцэгтээ очно” хэмээн айлдсан.”

Ром 12:3-8-г анхааралтай уншаад, дурьдагдсан бэлэгийг нэрлэ. Та эдгээр бэлэгийг (зорилго ба үйл ажиллагааг нь) хэрхэн дүрслэн тайлбарлах вэ?

1Коринт 12:4-11-г уншаад өсөн бэлэгийг тодорхойл. Эдгээр бэлэгийг (зорилго ба үйл ажиллагааг нь) хэрхэн дүрслэн тайлбарлах вэ?

Хоёр хэсэгт буй бэлэгийг харна уу. Эдгээр бэлэгийн аль нь танд байдаг вэ?

Сайн мэдэхгүй байна уу? Эдгээр бэлэгийн аль нь таныг татаж, доглуулж байна? Ариун Сүнс танд ямар бэлэг өгсөнийг нь Түүнээс лавлаж асуу.

Бусдад хандах хандлага болон Сүнс танд ямар бэлэг өгсөн нь маш чухал юм. Бурхан “Өөр хоорондоо Христ Есүст байсан шиг бодолтой бай” хэмээн айлдсан (Филиппой 2:5). Рэйнхард ч үүнийг батлан хэлсэн.

“Бурханы ажлын амжилт бидэн дээр суурьлахгүй... Энэ нь Түүн дээр л суурилна. ...Би Бурханы дуу хоолойг бусад бүх дуу хоолойноос өргөмжилдөг учраас өөрийгөө тэг гэж боддог. ...Би өөрийгөө Бурханы аль ч зарцаас дээгүүр харахгүй.”

1Коринт 12:12-26, Ром 12:3-5-г анхааралтай уншина уу. Ариун Сүнс таны хандлагын талаар юу харуулж байна? Хүний, тэр дундаа таны бэлэг аль хэр чухал вэ? Бэлэгийг хэрэглэхээс татгалзбал Христийн Бие ях вэ?

Дэлгэрэнгүй судлахыг хүсбэл:

Зөв хандлагатай байх: Филиппой 2:1-8; 2Коринт 8:9;

Матай 23:11-12

Сүнс ямар нэг зорилгын төлөө итгэгч хүмүүсийг тодорхой байр сууринд томилдог: 1Коринт 12:28-31; Ефес 4:11-14

Тавдугаар өдрийн чимээгүй цаг

ТАНААР ДАМЖУУЛАН БУРХАНЫ ХҮСЛИЙГ ЗАЛБИРАХ БОЛОЛЦООГ АРИУН СҮНСЭНД ОЛГО

Үүнчлэн мөн Сүнс бидний сул дорой байдалд тусалдаг. Учир нь яаж залбирах ёстойгоо бид мэддэггүй. Харин Сүнс Өөрөө үгээр илэрхийлжгүйгээр ёолон байж бидний төлөө зуучлан гуйдаг.

Ром 8:26

Та амьдралын нөхцөл байдалд дарлагдсандаа болоод бүр юу гэж ч залбирахаа мэдэхгүй тийм үе байсан уу? Тэгвэл та ганцаараа тийм байдалд ороогүй. Ариун хүмүүс бүгдээрээ л үүнийг мэдэрдэг. Ийм үед Бурхан таныг Түүнээс холдох бус, Түүнд улам ойртоосой гэж хүсдэг. Дуугаа хураах бус, дотроо уудлаасай гэж хүсдэг. Таныг юу хэлж, залбирахаа мэдэхгүй үед таны дотор орших Ариун Сүнс мэддэг.

Бурханы Ариун Сүнс таны дотор оршин буйг та тархиараа бус, зүрхээрээ мэдэх нь амин чухал юм. Дараах ишлэлийг цаг гарган тунгаан бод. Ариун Сүнс танд ямар ухаарал хайрлаж байна?

Галат 4:6; Ром 8:16; 1Коринт 6:9; Иохан 14:23; 1Иохан 3:24-г тунгаан бод. Өөрийгөө улам илүү илчлэхийг Ариун Сүнснээс гуй.

Бурхан биднээс “Сүнс дотор цаг үргэлж аливаа залбирал ба гуйлтаараа залбир. Үүний тулд бүх ариун хүмүүсийн төлөөх цөхрөлтгүй бүх оролдлого, гуйлтаараа сэргэг байхыг хүсдэг (Ефес 6:18). Олон жил шоронд махан биеэр тамлагдсан **Вачман Нии** ийн бичжээ:

“Ариун Сүнсний баталгаатай тусламжийнх нь төлөө Бурханд үнэхээр талархам. Бидний дотроос ажиллагч Ариун Сүнсний оршихуйд л бид найдах ёстой. Учир нь биднийг мэдэхгүй, чадахгүй сүл дорой үед Тэр л бидэнд тусладаг. Биднийг яаж залбирахаа мэдэхгүй үед Бурханы хүслийг мэддэг Ариун Сүнс Бурханы бодлын дагуу залбирахыг зааж өгдөг.”

Түр зогсоод бод. Та тодорхой нөхцөл байдал дунд өөрийнхөө болоод бусдын төлөө яаж залбирахаа яг мэддэг үү? Бид залбирах бүртээ Бурханд яаж хандах ёстой вэ?

Сургаалт үгс 3:5-8, 28:26; Лук 18:9-14; Иаков 4:6-10-г уншина уу.

Бурханы төгс хүсэл дотор алхахыг хүсч байна уу? Сүнс таныг уйлах, санаа алдах, орь дуу тавих, тэнгэрлэг хэлээр Бурханы төгс хүслийн төлөө залбируулна. Сүнсний бодол санаа юу болохыг зүрхнүүдийг Нягтлагч нь мэддэг. Яагаад гэвэл Тэр Бурханы хүслийн дагуу ариун хүмүүсийн төлөө зуучлан гуйдаг юм (Ром 8:27). Дараах хэсгийг анхааралтай уншина уу. Үүгээр дамжуулан Ариун Сүнс юу хэлж байна?

Хэлээр ярьдаг хүн хүмүүст бус, харин Бурханд хандаж ярьдаг. Учир нь тэр хүн сүнс дотор нууцуудыг ярьдаг боловч ямар ч хүн ойлгодоггүй ажээ ... Хэлээр ярьдаг хүн өөрийгөө босгон байгуулдаг бол эш үзүүлдэг хүн чуулганыг босгон байгуулдаг аж ... Учир нь хэрэв би хэлээр залбирвал миний сүнс залбирдаг бөгөөд харин миний ухаанд үр жимс үгүй юм. Тэгвэл яах вэ? Би сүнсээр залбирах болно. Би бас ухаанаар залбирах болно. Би сүнсээр дуулах болно. Би бас ухаанаар дуулах болно.

1Коринт 14:2, 4, 14-15

Сүнсэнд бууж өгөхөд Тэрбээр таныг болон таны хэрэгцээг Бурхан Аавын өмнө танилцуулна. Ариун Сүнс Бурханы төгс оюун санаа, төгс хүслийг мэддэг. Тэр таны зүрхийг нягталж, таныг танаас ч илүү мэддэг бөгөөд тэр хэрэгцээг Бурханы сэнтийн өмнө авчирна.

Тэгээд Ариун Сүнс танаар дамжуулан
залбирч байхад та мэдэхгүй өнгөрөхгүй.”

-Катрин Кульман

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

- 1 | Аврагдах үед зүрхэнд тань Ариун Сүнс нутаглах болон Ариун Сүнсээр дүүрэх нь ялгаатай юм. Энэ хоёр ер бусын үйл явдлыг хэрхэн дүрслэх вэ?

- 2 | Есүс яагаад дагалдагч нартаа хаанчлалын төлөө ямар нэг зүйл хийхээсээ өмнө Ариун Сүнсний хүч бууж ирэхийг хүлээхийг тушаасан бэ? (Үйлс 1:4-5). “Дээрээс буух хүчийг хүлээн авахаар хүлээх” гэдэг зарчмаас бид юу сурч өнөөдөр амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх вэ?

- 3 | Ариун Сүнсний хүч биднийг хэлээр ярихад хүчирхэгжүүлдэг. Хэл нь зүгээр л бидний мэддэггүй, ойлгодоггүй хэл юм. Та өөрийгөө Пентекост өдөр гадаад улс орноос ирсэн итгэмжтэй Иүдейчүүдийн нэг гээд төсөөлөөд үз. Есүс Христээр дамжих авралын талаар таны унаган хэлээр ярьж байхыг сонсбол та яах вэ?

- 4 | Ариун Сүнс итгэгч хүмүүсийг дүүргэх тохиол бүрт ямар хоёр динамик зайлшгүй өрнөсөн бэ? Бурхан ямар учраас Корнелийн гэр бүлийг аварч, Ариун Сүнсээр цалгиасан бэ? Бурханыг чихсэн “шашны хайрцгийг” тань хэмхэлж, Түүний талаарх таны ойлголтыг тэлсэн түүхийг хуваалцана уу.

- 5 | Эш үзүүлэл ба хэл нь өнөөдөр ч хүчин төгөлдөр бөгөөд Паул “бүгд хэлээр ярьдаггүй” гэхдээ яг юуны тухай ярьсан

бэ? (1Коринт 13:8-12) Эдгээр ишлэлийг анхааралтай уншиж, тайлбарлаарай.

- 6 | Библи 4 төрлийн хэлний талаар өгүүлдэг. Дараах хэсгийг уншаад 4 төрлийн хэлийг нэрлэж, Бурхан яагаад Чуулгандаа эдгээр өөр өөр илрэлийг өгсөнийг тайлбарлана уу.
 1Коринт 14:22
 1Коринт 12:10
 1Коринт 14:14-15
 Ром 8:26-28

Эдгээр 4 төрлийн хэлний ялгааг мэдэх нь яагаад тийм чухал вэ?

- 7 | Итгэгч хүн Ариун Сүнсээр дүүрсэн атлаа хэлээр ярихгүй байж болох уу? Яагаад тийм, яагаад үгүй? Энэ зүйл болдгийн гол шалтгаан юу вэ?

ТЭМДЭГЛЭЛ

Бүлгийн дүгнэлт:

- Хаанчлалын ажилд Сүнсний хүч амин чухал.
- Ариун Сүнсээр дүүрэх нь авралын дараа өрнөдөг үйл явдал.
- Аврал биднийг Христийн дотор зөв байршуулдаг; харин Сүнсний хүч биднийг Түүн шиг амьдрах хүчээр сэлгэдэг.
- Хэлээр ярих явдал арилаагүй. Энэ нь бид Есүстэй нүүр нүүрээрээ уулзах хүртэл хүчин төгөлдөр ажиллана.
- Дөрвөн янзын хэл байна: итгэгч бус хүмүүст тэмдэг болдог тэмдэг хэл; тайлбарладаг хэл, хувийн залбирлын хэл, зуучлан залбирлын хэл. Эхний хоёр нь олон нийтийн үйлчлэлд, удаах хоёр нь хувийн хэрэглээнд хэрэгцээтэй.

5

СҮНСНИЙ ХЭЛ

Хэлээр ярьдаг хүн хүмүүст бус, харин Бурханд хандаж ярьдаг.

*Учир нь тэр хүн сүнс дотор нууцуудыг ярьдаг
боловч ямар ч хүн ойлгодоггүй ажээ.*

1Коринт 14:2

Нэгдүгээр өдөр

Бурхантай уулзах бидний уулзалтын талаар The Message Библи юу гэж хэлсэнд би их дуртай. “Хэлүүдийн хэл” хэмээх илэрхийлэл нь гагцхүү “Бурхан та хоёрын” хооронд болдог хүчирхэг харилцаа юм.

Өмнөх бүлгээр бид Шинэ гэрээнд тодорхойлсон дөрвөн төрлийн хэлийг үзсэн. Харин энэ бүлэгт бид Бурханы Сүнстэй харилцах хувийн харилцааны талаар илүү дэлгэрэнгүй үзнэ. Үүнд хэлээр ярих болон ухаанаар ярихын аль аль нь багтана. Эдгээр нь хамтдаа *Сүнсний хэлийг* бүтээдэг.

Нэгэн зүйлийг дахин тодруулмаар байна: “хувийн” гэдэг нь ганцаараа байхдаа хэрэглэх гэсэн үг биш шүү. Энэ нь хүн ганцаараа эсвэл Сүнсний илэрхийллийг ойлгодог бусад итгэгч хүмүүстэй хамт байхад болдог. Тухайлбал надад өрөөлийн өмнө ярихгүй зүйлээ гэр бүлтэйгээ ярилцах *хувийн* цаг гэж байна. Учир нь бидний хувьчлан ярих зүйлийг бусад хүмүүс ойлгохгүй (энэ талаар 2Коринт 14:22-25-с дэлгэрэнгүй үзээрэй).

Паул хэлийг “хувьчилсан хэл” гэж хэлсэнийг тэмдэглээрэй (1Коринт 14:2). Гэхдээ энэ бэлгийг хэзээ хаана хэрэглэх,

хэрэглэхгүйгээ мэддэггүй учраас Чуулган хувьчилсан хэлний энэ гайхамшигт бэлэгийг буруу ташаа ойлгож, баллаж орхидог.

Тухайлбал дурлалт хосод хайр дотнослоо хуваалцах цаг, газар гэж байна. Гэрлэхээсээ өмнө дотносож болох уу? Олны нүдэн дээр болох уу? Мэдээж болохгүй. Бэлгийн харилцаа нь гагцхүү гэрлэлтийн тангаргаа өргөсөн хоёр хүний хооронд олны нүднээс далд өрнөх ёстой зүйл. Бурхан ингэж л бүтээсэн. Үүнтэй адилхан сүнсний дотно харилцаа нь тодорхой цаг газарт өрнөх ёстой. Хүмүүс Бурханы бүтээж өгсөн сексийг бохирлосон учраас Христэд итгэгч хүмүүс сексээс татгалзах ёстой юу? Мэдээж үгүй! Үүнтэй адилхан бид хэлний бэлэгийг үл ойшоож, ад үзэж болохгүй.

Олон Чуулган хэлний бэлэгт ингэж ханддагийг би мэднэ. Гэхдээ нэг хүн тэнгэрлэг бэлэгийг буруу хэлтгий ойлгож хэрэглэсний төлөө бид бас адилхан хандах ёсгүй. Тиймээс тус бүлгээрээ энэхүү тэнгэрлэг хэлний бэлэгийн дотно мөн чанарыг тайлж ойлгуулахыг хүсч байна.

Ариун Сүнс бол үнэний Сүнс гэдгийг бүү март. Бурханы Үгийн цэц ухаанд захирагдбал Сүнс танд бүх үнэнийг илчилнэ. Тиймээс яг одоо түр зогсоод, Түүнийг багшаа болгож урь. Таны тархинд хорогдогч, Бурханы Үгтэй сөргөлдөгч бүх ташаа ойлголт, санаа сэдлийг зайлуулахыг хүс. Бурханы хязгааргүй мөн чанарыг хязгаартай ойлголтоороо бариад байх юм бол Бурханы бүрэн дүүрэнг хэзээ ч бүтэн мэдрэхгүй.

Ерөнхийлөгч бөгөөд Хаан

Ерөнхийлөгчийнхөө оройн зоогт уригдах шиг хүндэтгэл соёрхол байхгүй. Тэр бол дэлхий дээрх хамгийн нэр нөлөө бүхий алдартай хүмүүсийн нэг юм. Түүнд мэдэхгүй баримт мэдээ гэж байхгүй. Би бол жирийн иргэн, харин тэр бол улсын тэргүүн. Тиймээс тэрбээр надтай улс орны аж амьдралын талаар ярихдаа миний ойлгох төвшинд л ярина. Үгүй аваас тэр бид хоёр хэлээ олохгүй.

Үүнтэй адилхан би ертөнцийн Хаантай ярихдаа Түүний хэмжээнд хэзээ ч хүрэхгүй. Америкийн ерөнхийлөгч улс орныхоо

болон дэлхийн хэрэг явдлын талаар олон зүйл мэдэж болох ч, Бурхан бүгдийг мэддэг. Түүнээс нууц юм гэж байхгүй. Хэрэв би Бурханд өөрийнхөө ойлголтоор залбирбал маш хязгаарлагдмал зүйлийг л харж ойлгоно. Харин Бурхан хүүхдүүдтэйгээ хязгаартай харилцаа тогтоохыг хүсдэггүй. Тиймээс Тэрбээр бидэнд Өөрийнхөө төвшинд харилцах үүдийг нээжээ. Бурхан үүнийг Сүнсээрээ хийсэн. Бурхан “Би хүүхдүүдтэйгээ Өөрийнхөө мэдлэг, ойлголт, цэц ухаанаас дорд төвшинд харилцахыг хүсэхгүй байна. Би тэднийг надтай илүү гүн төвшинд харилцах чадвартай байлгахыг хүсч байна. Тиймээс би хүүхдүүддээ Сүнсээ Туслах болгож илгээнэ” гэжээ. Ариун Сүнсний оршихуй, харилцаа л биднийг Бүтээгчтэй дотно харилцахад туслдаг.

Бурханы хүсэл ба арга зам бидний хязгаарлагдмал ойлголтоос давсан боловч, Сүнсээр залбирах үедээ бид өөрийнхөө ойлголтоор залбирдаггүй, харин Бурханы Сүнсний хүслээр залбирдаг. Бид Сүнс дотор залбирахдаа *Бурханы төгс хүслийн дагуу залбирдаг!*

Тулааны хэл

Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд, тэнгэр дэх бузар муугийн сүнслэг хүчний эсрэг билээ. (Ефес 6:12)

Сатан хүн төрөлхтөнтэй нэгийгээ үзэх дайнд орсон гэдгийг бид амархан мартдаг. Сатаны стратеги нь биднийг амийн эх булаг болох Бүтээгчээс маань салгахад л оршдог. Гэхдээ Бурхан дайсны аттаг хар санааг мэддэг учраас цэц ухаанаараа Сатаны төлөвлөгөөг нураах нууц стратеги боловсруулжээ. Паул энэ тухай хэлсэн: харин нууц дотор буй Бурханы мэргэн ухааныг бид ярьдаг. Энэ нь бидний алдрын төлөө үеүдээс ч өмнө Бурханы урьдаас тогтоосон нуугдмал мэргэн ухаан мөн. Үүнийг энэ үеийн удирдагчдаас хэн нь ч мэдсэнгүй. Хэрэв тэд үүнийг мэдсэн байсан бол алдрын Эзэнийг цовдлохгүй байх байсан (1Коринт 2:7-8)

Паул “өмнө нууцлагдсан” байгаад Есүсийг үхээд амилсаны

дараа илчлэгдсэн загалмайн хүчийг дүрслэжээ. Есүсийн загалмай дээрх тахил нь дайсны төлөвлөгөөг хэмхэлж, биднийг Бурхантай дотно болох боломжтой болгосон юм.

Бурханы “загалмайн төлөвлөгөө” нь энэ үеийн захирагчдаас нууцлагдсан цорын ганц нууц биш юм. Бурханы цэц ухааны (Түүний Үгийн) олон тал нь нууцлагдсан хэвээрээ байгаа бөгөөд гагцхүү Түүний Сүнсээр л тайлагдах боломжтой. Бурхан биднийг зөвхөн “авраад” зогсохгүй, Христ дотор байр суурь эзлүүлж, дайсны дээр эрх мэдэл олгосон гэдгийг би өмнө хэлсэн. Тиймээс өдгөө бид Бурханы Хаанчлалын өв залгамжлагч, дайчид болсон бөгөөд Христийн энэ даалгаврыг үргэлжлүүлэх үүрэг хүлээсэн юм.

Дайны цагаар хүмүүс төлөвлөгөө мэдээгээ солилцох тусгай код бүхий бүхэл бүтэн “хэл” боловсруулдаг. Яагаад? Дайснаа ялах төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлж, хүн ардаа хамгаалахын тулд. Дайсан манай талын төлөвлөгөөг мэдбэл хариу цохилт хийнэ. Бурханы хүүхдүүд бид Командлагчийнхаа төлөвлөгөөг дайсанд илчлэхгүйгээр, Ариун Сүнсээр дамжин тэнгэрийн нууцад шууд нэвтэрч, Бурханы стратегийн нууцыг тайлах эрхтэй болсон. Паул цааш нь ийн хэлжээ:

Сүнс дотор цаг үргэлж аливаа залбирал ба гуйлгаараа залбир. Үүний тулд бүх ариун хүмүүсийн төлөөх цөхрөлтгүй бүх оролдлого, гуйлгаараа сэргэг бай.
(Ефес 6:18)

Бурхан бидэнд залбирахыг тушаасан нь учир шалтгаантай юм. Түүний газар дээрх дайчид бид харанхуйн хүчтэй үзэлцэх ёстой. Бидний хамгийн хүчирхэг зэвсгийн нэг нь Сүнс дотор залбирах юм. Энэ нь Бурханы төлөвлөгөө зорилгыг дайснаас нууцладаг.

Заримдаа Бурхан ээжийн зүрхэнд үр хүүхдийнхээ төлөө зуучлан залбирах хүслийг оргилуулдаг. Тэр юу болсоныг мэдэхгүй ч, Сүнсээр залбирах ёстойгоо мэдрэн шалавлан залбирна. Тэрбээр тэнгэрийн хэлээрээ зуучлан залбирахдаа сүнслэг талбарт тушааж, хүүгийнхээ дээр Бурханы төгс хүслийг залбирдаг. Тиймээс л бидэнд “Төлөвлөгөө зохиохдоо зөвлөгөө ав. Мэргэн удирдамжийн дагуу дайт” (Сургаалт үгс 20:18) хэмээн тушаажээ.

Энэ бол бидний оюун ухаанаас хальсан, цаг орон зайд баригддаггүй хэл. Сүнсээр залбирахдаа бид өөрийнхөө оюун ухаанд бус, Түүний энгүй цэц ухаанд найддаг. Тиймээс л Паул “та нар бүгдээрээ хэлээр яриасай” хэмээсэн буй.

Энэ нь Бурхан Аавын хүүхдүүдтэйгээ аминчлан ярьдаг хэл учраас дайсан үүнээс юу ч олж долоож чадахгүй. Тиймээс энэ хэлээр бидний эсрэг болон найз нөхдийн маань эсрэг төлөвлөсөн дайсны явуулгыг маш үр нөлөөтэй таслан зогсоодог.

Харагтун, Би та нарт могой, хилэнцэт хорхойнуудад халдах, дайсны хамаг хүчээс дээгүүрх эрх мэдэл өгсөн. Та нарт юу ч хор учруулахгүй. (Лук 10:19)

Итгэгчид бид газар дээр Бурханы хаанчлалыг тэлэх үүрэгтэй (Матай 11:12). Чуулган бол дэлхий дээрх Христийн бие юм. Өдгөө Есүс дэлхий дээр байхгүй. Бид бол сэргэлт, эрх чөлөө, аврал хэрэгтэй буй хүмүүст Бурханы өөрчлөгч хүчийг тээж түгээх үүрэгтэй Бурханы хаанчлалын элчин сайдууд ба дайчид юм. Гэхдээ бид үүнийг Бурханы Сүнсний хүчгүй хийж чадахгүй. Сатан ба түүний цэргүүд танаас айхгүй. Тэд Христийн дотор та хэн бэ гэдгээс тань, Хамгийн дээд Нэгэний хүү охин болохынхоо хувьд эзэмшдэг хүч чадлаас тань айдаг.

Хоёрдугаар өдөр

Дотнослын хэл

Гэргий бид хоёр олон хамт амьдарсаныхаа ачаар өөрийн гэсэн хэлтэй болсон юм. Жишээлбэл би “ОУНУ” гэвэл Лиза шууд л ойлгоод жуумалзана. Биднийг гэрлэж байх үед “олон улсын үйлчлэл” гэдэг нэр их моодонд орж байсан болохоор үйлчлэл бүр л энэ нэрийг авч байв. Тиймээс Лиза бид хоёр “Олон Улсын Нялуурах Үйлчлэл” эхлүүлэхээр шийдсэн юм. “ОУНУ” гэвэл хоёулаа жаал нялуурья л гэсэн үг. Энэ хэлийг Лиза бид хоёроос өөр хүн мэдэхгүй.

Үүнтэй адил тэнгэрийн хэлээр бид Бурхантай аминчлан ярьдаг. “Гэхдээ Жон минь, би юу ярьж байгаагаа мэдэхгүй шүү дээ. Библи “Учир нь хэрэв би хэлээр залбирвал миний сүнс залбирдаг бөгөөд харин миний ухаанд үр жимс үгүй юм” гэдэггүй билүү? (1Коринт 14:14)” гэх хүн байгаа байх. Тийм ээ, энэ үнэн. Тиймээс л өмнөх ишлэлд нь “Тиймд хэлээр яригч хүн тайлбарлахын тулд залбираг” (и13) гэж хэлсэн юм. Би Бурхантай хэлээр ярьж бас харилцахдаа, юуны тухай залбираад байгааг минь тайлж өгөхийг хүсдэг. Юу болдог гээч? Сүнсэнд минь шинэ санаа, цэц ухаан, илчлэлт ундарч эхэлдэг.

Жишээлбэл би Библи уншиж байгаад мэдэхгүй зүйл гарбал: “Ариун Сүнс минь, надад зааж өгөөч” гэж хэлээд хэлээр залбирдаг. Илчлэлт тэр даруй ч ирж болно эвсэл бүр хожим жолоо барьж, усанд орж, гольф тоглох юмуу зүгээр амарч байхад ч ирж болно. Гэнэт л нэг зүйл дэлсээд авна! Энэ нь Сүнстэй дотно нөхөрлөсний л үр дүн юм. Бурхан даруу хүнд нууцаа тайлна гэсэн учраас бид даруу болбол (Сүнсний удирдамжийг хүсбэл) Түүнтэй улам дотносож сүнсний илүү гүн илчлэлтийг хүлээж авна.

Сүнсний хүчийн тухайд ч ижил. Тэр надад “Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөс байдал дотор [Миний] хүч бүрэн төгс болно” гэж айлдсан. Иймд би ихэд баяртайгаар мөхөс байдлуудаараа илүү сайрхана. Ингэх нь Христийн хүч миний дотор оршихын тулд билээ (2Коринт 12:9). Энэ үгийг Бурхан Өөрөө Паулд хэлжээ.

Бурханы хүч болох нигүүлсэл даруу хүмүүст байдаг. Та өөрийгөө даруу болгож, Бурханы Сүнсний энгүй цэц ухаанд бууж өгбөл Бурханы яндашгүй хүч чадал бууж ирнэ. Энэ ч бас Сүнстэй дотно нөхөрлөсний л үр дүн.

Баруун бол үр дүн төвтэй нийгэм. Бид хөрөнгө оруулалтынхаа үр дүнг тэр даруй л үзэхгүй бол зорилгоосоо хазайдаг. Харин Сүнсээр залбирахдаа бид ирээдүйдээ хөрөнгө оруулж буй юм. Заримдаа бидний ухааны хөвөөн дээр илчлэлт боргилон гарч иртэл хүлээх шаардлагатай болно. Сүнс дотор залбирахад итгэл шаардлагатай. Учир нь хүний төрөлх ухаан төгсөх цэгээс л Сүнсний залбирал эхэлнэ. Сүнсний залбирал бидний итгэлийг сунгаж, Бурханы цэц ухааныг ойлгох чадварыг маань өсгөдөг.

Ухаанаар залбирах

Энэ бүлэгт бид Сүнс дотор залбирах талаар л ярих зорилготой. Гэхдээ ухаанаар залбирах нь бас л дутахгүй чухал юм. Бид Сүнсээр ч, ухаанаар ч залбирах ёстойг Паул тодорхой хэлсэн.

Тэгвэл яах вэ? Би сүнсээр залбирах болно. Би бас ухаанаар залбирах болно. Би сүнсээр дуулах болно. Би бас ухаанаар дуулах болно. (1Коринт 14:15)

Ухаанаар залбирах үед оюун ухаан маань шууд л боловсорч, үлэмж сэтгэл хөдлөл, халуун сэтгэл төрүүлдэг. Ийм залбирал нь Лиза, хөвгүүд, ажилтанууд зэрэг миний залбирч буй хүмүүстэй намайг шууд л холбодог. Ухаанаар залбирахдаа би ялгаагүй л Аавынхаа аугаа мөн чанарыг тунхаглаж, талархал, магтаалаар бялхдаг.

Түүнчлэн ухаанаар залбирахдаа бас л Ариун Сүнсний удирдамжаар хөтлүүлэх үе байдаг. Энэ ч бас Сүнсээр залбирах бас нэг хэлбэр мөн. Гэхдээ дийлэнх тохиолдолд би эхлээд Сүнс дотор залбираад, дараа нь Бурхан надад залбирлын маань тайлбарыг өгдөг.

Сүнс дотор залбирахын ач холбогдолын талаар ярихдаа би ухаанаараа залбирах залбирлыг доош хийгээгүй гэдгийг минь болгооно уу. Харин ч эрүүл залбирал нь Сүнс дотор залбирах залбирал, ухаанаар залбирах залбирлын аль алийг багтаадаг гэдгийг л хэлж байна. Аль аль нь Бурханы доторх бидний амьдралд амин чухал.

Бидний амьдралын эх булаг

“Хүний сүнс бол түүний дотоодын мухарт буйг ч нягтлан үздэг ЭЗЭНий дэнлүү билээ” (Сургаалт үгс 20:27). Бурханы Сүнсний гайхамшиг нэн түрүүнд бидний оюун ухаанд бус, харин сүнсэнд гэрэлтэж, илчлэгддэг. Тиймээс л бид Сүнсээр залбирахдаа, тайллыг нь давхар асуух ёстой юм. Бидний сүнсэнд өгдөг Ариун

Сүнсний ичлэлт нь бидний ухааны хөвөөн дээр гарч ирэх л болно.

“Хүмүүний зүрхэн дэхь төлөвлөгөө гүн ус мэт бөгөөд ухаантай хүн тэрхүү усыг гадагш гаргана.” (Сургаалт үгс 20:5). Загалмайн хүчээр дамжуулан Бурхан бидэнд шинэ зүрх өгчээ (Езекиел 36:26-г үзнэ үү). Тиймээс бид шинэчлэгдсэн зүрхнийхээ гүнээс зөвлөгөө (Ариун Сүнснийг бас Зөвлөх гэдэг) татаж авах бололцоотой болсон. Иохан 7:38-39 дээр Есүсийн үг үүнийг батладаг:

Надад итгэдэг хүн “Түүний дотроос амийн усны гол урсах болно” гэж Сударт хэлсэнчлэн байх болно гэв. Есүст итгэсэн хүмүүсийн хүлээн авах Сүнсний тухай Тэр үүнийг хэлжээ. Учир нь Есүс хараахан алдаршуулагдаагүй тул Сүнс өгөгдөөгүй байлаа.

Исаиа 12:3 ч үүнийг сануулдаг:

Тэгээд та нар авралын худгаас баяртайгаар ус татна.

Бидний зүрхнээс урсана гэж Есүсийн айлдсан “амьд ус” нь “Сүнс” юм гэдгийг Иохан тодорхой мэдэгджээ. Есүс яагаад Сүнснийг устай адилтгасан бэ? Ус амьдрал тэтгэдэг. Ус байхгүй бол амьдрал зогсоно. Тэгэхээр Сүнс бол амьдралын амь ажээ.

“Миний ард түмэн мэдлэг дутагдсанаас болж устгагдсан. Та нар мэдлэгээс татгалзсан учир Би ч бас та нарыг Миний тахилч байхаас татгалзах болно. Та нар Бурханыхаа хуулийг мартсан болохоор Би ч бас та нарын хүүхдүүдийг мартаж болно.” (Хосеа 4:6). Бурхан энд ямар мэдлэгийн талаар хэлнэ вэ? Бурхан Түүний арга зам зорилгыг мэдэх тухай онцгойлон ярьж байна. Гэхдээ Бурхан биднийг Өөрийнхөө зүрхний мэдлэгээр бүрэн дүүрэн амьдруулахын тулд Сүнсээ илгээсэн нь ёстой гайхамшигт мэдээ юм.

Бурханыг хэн болохыг мэдэхгүй байж, Түүнд үйлчлэх боломжгүй. Бурханы Үгийг уншиж, залбирах үед Сүнс бидэнд Бурханы зүрхийг илчилдэг. Баяр хөөртэй амьдрахад маань бидэнд энэ хүч хэрэгтэй. “Тэгээд тэр тэдэнд, Явцгаа. Тарганыг

идэж, чихэрлэгийг ууж, бэлтгэх юмгүй нэгэндээ хувиудыг явуул. Учир нь энэ өдөр бидний Эзэнд ариун юм. Бүү гашууд. Учир нь ЭЗЭНий баяр баясгалан бол та нарын хүч чадал юм гэсэн” (Нехемиа 8:10). Өөрөөр хэлбэл бид Түүнд баярлахдаа, цааш аж төрөх хүчээр сэлбэгддэг. Таны тухайд мэдэхгүй. Харин би лав Түүний баяр хөөргүй ганц ч өдөр аж төрөхийг хүсэхгүй байна.

Бурханы нууц

Бидний зүрхнээс ундрах ус нь Бурханы цэц ухаан, нууцыг тээдгийг Сургаалт үгс, Иоханы бичээсээс харж болох нь. Бурхан энэ нууцаа Сүнсээрээ илчилдэг. Тиймээс Паулын үгийг харцгаая: “харин нууц дотор буй Бурханы мэргэн ухааныг бид ярьдаг. Энэ нь бидний алдрын төлөө үеүдээс ч өмнө Бурханы урьдаас тогтоосон нуугдмал мэргэн ухаан мөн.” (1Коринт 2:7)

Нууц хэмээх Грек үг нь “нууцлаг, бүрхэг” гэсэн утгатай биш, харин “нуугдсан эсвэл бүрэн илчлэгдээгүй” гэсэн утгатай.

Та нэгэн тансаг ресторанд сууж байна гэж төсөөл. Ахлах тогооч нь хүрч ирээд л танд нэрийн зоогоо танилцуулна. Тэгээд таны амт таашаалд зориулж тусгай зоог бэлтгэнэ. Зоог бэлэн болмогц үйлчлэгч таны өмнө ширээн дээр тавина. Энэ үнэхээр тансаг ресторан учраас зоогийг илчлэх хүртлээ дээр нь таг тавьсан байна. Өмнө тань таны зоог байгаа ч, ямар хоол болох нь нууц хэвээрээ л байна.

Цаг нь болмогц үйлчлэгч “Хоп!” гээд л хоолны тагийг сэв хийлгэн авна. Тэгээд та ахлах тогоочийн танд зориулж урласан хоолыг харна. Хоол өмнө нь байсан уу? Байсан. Үйлчлэгч таны нууцлаг хоолыг илчилжээ. Ахлах тогооч ч мэдэж байсан. Зүгээр таны хувьд л тагийг нь автал тэр хоол “нууц” байжээ.

Бурхан нууц төлөвлөгөө “нууцаа” Сүнсээрээ илчилдэг. Сүнсээр бид одоо...

харин нууц дотор буй Бурханы мэргэн ухааныг бид ярьдаг. Энэ нь бидний алдрын төлөө үеүдээс ч өмнө Бурханы урьдаас тогтоосон нуугдмал мэргэн

ухаан мөн ... Бурханы бидэнд үнэгүй өгсөн юмсыг мэдэхийн тулд бид ертөнцийн сүнсийг бус, харин Бурханаас ирсэн Сүнсийг хүлээн авсан юм. Бид үүнийг хүний мэргэн ухааны сургасан үгсээр бус, харин Сүнсний сургаснаар ярьдаг бөгөөд сүнслэг зүйлсийг сүнслэгээр тайлбарладаг.
(1Коринт 2:7, 12-13)

Хожим тус захидалдаа Паул ийн бичжээ: “Хэлээр ярьдаг хүн хүмүүст бус, харин Бурханд хандаж ярьдаг. Учир нь тэр хүн сүнс дотор нууцуудыг ярьдаг боловч ямар ч хүн ойлгодоггүй ажээ” (1Коринт 14:2). Бид хэлээр ярихдаа Бурханы нууцыг ярьдаг. Эдгээр нууц нь зүрхний маань гүнд нуугдсан (Сургаалт үгс 20:5) бөгөөд Сүнсний цэц ухааны амьд ус бидний дотроос ундрах үед (Иохан 7:38-39) хамт гарч гарч ирдэг гэдгийг бид сурсан. Тиймээс амьдарлын амь болох “амьд усыг” ундраадаг учраас хэлээр залбирах нь биднийг гэгээрүүлж, Сүнсний гүн гүнзгий зөвлөгөөг ойлгуулдаг ажээ.

Хэрэв та Бурхантай нөхөрлөдөггүй бол зарим зүйл таны ухаанаас нууц хэвээрээ л үлдэнэ. Үүнд таны аль чуулганд явах, хэнтэй гэрлэх, ямар ажил хийх, ямар байшин авах, удирдагч нарынхаа төлөө хэрхэн залбирах, яаж сайн хань болох, үр хүүхэддээ хэрхэн хандах, ажилдаа яаж амжилт гаргах зэрэг олон асуудал багтаж болно. Гэхдээ Бурхан биднийг өөрийн маань өчүүхэн ухаан дунд орхичиогүй нь ямар гайхалтай вэ! Бурханы Сүнсээр бид Түүний шилдэг төлөвлөгөөг олж авч, Түүний амласан газар хүрнэ.

Гуравдугаар өдөр

Амар тайван: Дотносолын бэлэг

Галат 5-р бүлэгт “амар тайван бол Сүнсний оршихуй, бидний амьдрал дахь баталгааны гэрч” гэжээ. Энэ нь өдөр тутмын амьдрал

дээр бодитой хэрэгжүүлэх боломжтой гайхалтай ерөөл юм.

Ганц бие байхад ирээдүйн хань ижлээ олж мэдэх нь миний хувьд жинхэнэ нууц байлаа. Би Лиза Тоскано гэдэг бүсгүйтэй үерхэж байхдаа түүнд үнэхээр сэтгэлтэй гэдгээ мэдэж байлаа. Түүний гадаад төрх, зан чанар намайг соронздож байв. Гэхдээ би Бурханы сонгосон бүсгүйтэй л гэрлэнэ гэж шийдсэн юм. Тэр үед Лиза Аризонад, би Техаст аж төрдөг байв. Бид хоёр хоёулаа л Бурханаас хариулт хүлээж байлаа. Тиймээс би Лизад “Хоёулаа 30 хоногийн турш өдөр бүр 30 минут Сүнсээр залбирья. Зүрхээ чагна. Хэрэв дотор чинь амар тайван байхгүй бол харилцаагаа үргэлжлүүлэхээ больё. Хэрэв амар тайван байвал Ариун Сүнс бидний цаашдын харилцааг дэмжиж байна гэж мэдь” гэсэн юм. Гэтэл бид хоёр залбирахдаа амар тайвнаар халгих төдийгүй, баяр хөөрөөр цалгиж байлаа. Энэ тухайгаа мэдээж залбирч дууссанахаа дараа л ярилцсан л даа. Тэгээд бид харилцаагаа үргэлжлүүлсээр эцэстээ гэрлэсэн юм. Түүнээс хойш 30 жил өнгөрсөн бөгөөд бид хоёр хоёулаа амар тайвныг мэдэрсэнд би үнэхээр их баярладаг.

“Учир нь Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм.” (Ром 8:14). Харин цааш нь Сүнс Бурханы хүүхдүүдийг хэрхэн хөтөлдгийг тайлбарлажээ: “Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс Өөрөө бидний сүнстэй хамт гэрчилдэг.” (8:16) Сүнс биднийг голдуу амар тайвнаараа буюу гэрчээрээ хөтлөдөг.

Заримдаа шийдвэр гаргах үед бүх зүйл зөв санагдах атлаа нэг л тайван бус байдаг. Юу болоод байна аа? Бүх зүйл зөв шиг л байх юм. Яагаад ийм таагүй мэдрэмж төрөөд байна аа? Ариун Сүнстэй нөхөрлөдөг хүн бол “Ариун Сүнс үүнийг хориглож байна” гэдгийг шууд л мэдэрнэ. Би олон удаа ийм байдалд орж байсан. Заримдаа тухайн үедээ учрыг нь ч олохгүйгээр Ариун Сүнсийг дагахад бүх учир бүр хожим тайлагдах ч үе байлаа. Ийм үед би Түүнд л найдахыг сурсан юм.

Гэтэл зарим үед хамаг юм аймшигтай эрсдэлтэй харагдах хэрнээ гайхамшигтай тайван санагддаг. Энэ нь Христийн амар тайван зүрхийг дүүргэж буй нь тэр. Элч Паул энэ тухай хэлжээ:

Христийн амар тайван та нарын зүрх сэтгэлийг захираг. Үүний тулд л та нар нэгэн бие дотор дуудагдсан юм. Талархагтун. (Колоссай 3:15).

Amplified Библи Ариун Сүнснийг шүүгчтэй зүйрлэсэнд би дуртай. Сайн шүүгч ямар ч тээнэгэлзээгүй шийдвэр гаргадаг. Үүнтэй адил Ариун Сүнс ч бас таны тархинд хэрсэн бүх асуудлыг шууд шууд зохицуулдаг. Та өөрөө л зөвшөөрөх юм бол Ариун Сүнс тантай цэц ухаанаа хуваалцана. Тэрбээр ихэвчлэн хүний ухаанаар ойлгож чадахгүй амар тайвнаараа харилцдаг бөгөөд үүнийг нь Сүнсний гэрч гэдэг.

Бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар тайван нь Христ Есүс дотор та нарын зүрх сэтгэл, санаа бодлыг хамгаална. (Филиппой 4:7)

Бид Христийн дотор байр суурь эзлэсэн учраас энэ амар тайвныг эдлэх эрхтэй болсон юм. Есүс бол Амар тайвны Ханхүү бөгөөд Өөрийнхөө хүмүүст амар тайвнаа амласан билээ. Бид Ариун Сүнснийг шийдвэртээ урихад Тэр бидэнд Есүс Христийн амар тайвнаар гэрчилдэг.

Амар тайван ба шийдвэр

Миний бие Messenger International гэдэг байгууллагыг толгойлж яваа хүнийхээ хувьд Ариун Сүнс амар тайвнаараа баталсан шийдвэрийг л гаргадаг. Нөхцөл байдал ямар ч боломжгүй харагдаж байсан ч, Бурханы амар тайван намайг энэ байгууллагын хүчин чадлыг өөрийнхөө ухааны бэлээр хязгаарлахгүй байхад тусладаг юм.

Би дийлэнх шийдвэрээ Бурханы удирдамжаар гаргадаг (Түүний Үгтэй заавал зөвшилцсөн тохиолдолд). Гэхдээ заримдаа Бурханы Сүнс надтай ярьдаг. Энэ яриа нь голдуу Бурхан надад цоо шинэ чиглүүлэг өгөх үед өрнөнө.

Жишээгээр тайлбарлая. Манай Messenger International байгууллага нь нутгийн чуулганыг босгон байгуулах зорилготой.

Нутгийн чуулган нь төөрөгсөдөд найдвар түгээж, дутагдаж гачигдсан хүмүүсийг хангаж, үндэстэн бүрт дагалдагч бэлтгэх Бурханы хамгийн сайн арга зам гэдэгт бид итгэдэг. Хойд Америкийн 20,000 гаруй чуулган манай сургалтын хөтөлбөрийг ашигладаг. Бид олон жилийн турш Америк, Канад, Австрали, Английн чуулган дээр л төвлөрч ажилласан юм.

Тэгтэл 2010 оны 5 сарын 31 нд намайг Даниел номыг уншиж байтал Эзэн надтай яриу: “Чи англи хэлтэй улс үндэстэний чуулганы төлөө итгэмжтэй ажиллалаа. Тиймээс одоо би чамайг даян дэлхий рүү илгээж байна”. Амьсгаа тасарчих шиг л болов. Ийм юм яаж болохыг төсөөлж ч чадсангүй. Тэгээд би үйлчлэлийнхээ захирлуудыг цуглуулаад, зүрхэнд минь суулгасан Бурханы алсын харааг хуваалцаад, 2011 онд хөгжиж буй улс орны удирдагч нарт 250,000 ном тараахыг хүсч байгаагаа дуулгалаа. Бүгд гүн сочирдов. Бид жилийн дотор хэзээ ч, хэнд ч ийм олон ном тарааж байсангүй. Манай гүйцэтгэх захирал тэргүүтэй салбар салбарын захирлууд маань намайг энэ шийдвэрээ бодолцож үзэхийг ахин дахин шалав. Эцэстээ гүйцэтгэх захирал маань энэ шийдвэрээ Бурханаас асуубал яасийм гэж хэллээ.

Бурхан намайг даян дэлхийн удирдагч нарт хүр гэхийг би тодорхой сонссон. Гэхдээ үүний тулд эхлээд дараа жил 250,000 ширхэг ном тараа гэж тодорхой хэлээгүй. Тиймээс би залбирлаа. Гэтэл нэг л амар тайван. Энэ зорилго нь Түүнийхтэй эгнэж буйг би мэдэрсэн учраас Ариун Сүнс ч өөр юм хэлсэнгүй. Тэрбээр гэрчлэхийг би мэдрэв. Энэ тухай багтаа дуулгатад тэд тэр даруй энэ алсын харааг түрэв. Бурхан ч гайхамшигаа үйлдэж, бид ганц жилийн дотор 47 улс үндэстэний пастор удирдагч нарт 270,000 ном өгсөн юм.

2011 онд би Ойрх Дорнодод Ливаны нийслэл Бейрутад 2500 гаруй пастор удирдагч нарт номлож байхдаа нэгэн Ирак пастортай уулзсан юм. Гучин зургаан настай тэр залуу пастор тус хотын хамгийн том чуулганыг удирддаг ажээ. Тэрбээр над “Эрхэм ээ, та миний хувьд ааваас минь өөрцгүй хүн. Би таны номыг уншихыг хичээдэг. Бүр кредит карт ашиглаж танай цахим хуудаснаас материал татаж авдаг” хэмээн ярьсан юм.

Энэ үгийг сонсоод би нүүр түлэгдэв. Дайны хөлд сүйдсэн улсын ядуу тарчиг аж амьдралтай энэ залуу хүн Messenger International-н материалыг олж авахын төлөө бүгдийг хийж байна. Иймээс би нутгийн чуулганд туслаж, удирдагч нарыг нь хүчирхэгжүүлэхийн төлөө ном төдийгүй, бүх хөтөлбөрөө өгөхөд минь туслаач хэмээн Бурхан руу дахин хашхирав. Ирэх жил нь бид пастор удирдагч нарт 1 сая 300 мянган материал тараав. Энэ тоо өнөөдрийг хүртэл өссөөр байна.

Гэтэл намайг Сүнсээр залбирч байхад энэ асуудлыг бүрэн тайлсан шийдэл олдсон нь CloudLibrary.org байлаа. Эндээс пастор, удирдагч болон гишүүд төрөлх хэлээрээ ямар ч үнэ төлбөргүй сургалтын материалаа татаж авах бололцоотой болов. Тиймээс анх 2011 онд тараасан 270,000 ширхэг ном маань өдгөө сар тутам өссөөр байна! Ариун Сүнсний амар тайвны гэрчлэлийг дагах үед Бурхан ийм л ажил хийсэн юм даа.

Дөрөвдүгээр өдөр

Чиглүүлэг авах

Маш олон итгэгчийг мухардуулдаг асуудал нь Бурханы чиглүүлэг юм. Хүмүүс “Бурхан надаар юу хийлгэхийг хүсээд байгаа юм бүү мэд” гэдэг. Иаков “Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно” гэсэн (1:5). *Sophia* хэмээх энэ Грек үг нь “ойлгох чадамж ба үүнийхээ дагуу цэц ухаантай үйлдэх” гэсэн утга илэрхийлдэг. Тэгэхээр бид Бурханы цэц ухаанаар эхлээд ойлгоод дараа нь үйлддэг байх нь.

Хэн бидэнд Бурханы цэц ухааныг ойлгох чадамжийг өгч, үйлдэхэд тусладаг вэ? Ариун Сүнс. Надад чиглүүлэг ус агаар шиг хэрэгтэй үе зөндөө гардаг. Тэгээд хэлээр залбирах үед миний сүнс дотроос Бурханы цэц ухаан, чиглүүлэг хөвөрсөөр ухаанд минь хүрнэ. Хэлээр залбирахад бидний амьдралд хандсан Бурханы чиглүүлэг гэрэлтдэг.

Сургаалт үгс 20:5-г дахиад уншъя. “Хүмүүний зүрхэн дэх төлөвлөгөө гүн ус мэт бөгөөд ухаантай хүн тэрхүү усыг гадагш гаргана.” Христийн дотор ганцхан танд зориулсан даалгавар юмуу зорилго бий. Зүрхний тань цөмд орших энэ зорилго таны зүг чигийг тодорхойлно. Сүнсээр залбирч, Бурханы зөвлөгөөг авахад Тэр таны зорилгыг илчилнэ. Ганц шөнийн дотор ийм зүйл болохгүй. Тэвчээртэй бай. Бурханы Үгийг уншиж, залбирч Түүнтэй хамт байхад Тэр таны зорилгыг илчилнэ. Миний хүү ингэж хэлдэг юм: Бурханы Үг бол газрын зураг, Ариун Сүнс бол Хөтөч нь.

Бурхан бидний амьдралын бүх хэсэгт чиглүүлэг өгдөг. Хүүхэд тань болохгүй байвал, гэдрэг ухраад Сүнсээр залбир. Яахыг тань Тэр хэлж өгнө. Арилжаа наймаа тань урагшгүй байвал, ерөөнийхөө үүдийг хааж байгаад залбир. Тэр танд зүг чиг зааж өгөхийг хүсдэг! Исаиа 48:17: Чиний Аврагч, Израилийн Ариун Нэгэн, ЭЗЭН ингэж айлдаж байна. “Би бол чиний Бурхан ЭЗЭН мөн. Би чамд тустайг сурган, чамайг явах ёстой замаар чинь удирддаг. Бурхан таныг хаанчлалынхаа зорилгыг биелүүлээсэй гэж хүсдэг бөгөөд алхам алхмаар хөтөлдөг.

“Энэ чинь арай л дэндүү “сүнслэгжсэн” явдал биш үү? Ийм жаахан юм болгоныг Бурханаас асуух гэж үү? Бурхан чинь том том зүйлд л санаа тавьдаг баймаар юм” гэж зарим хүн хэлдэг. Нэгдүгээрт- Бурхан бидний аж амьдралын хэсэг бүрт оролцох нь хачин жигтэй зүйл огт биш. Хүмүүс хачин жигтэй байж болно. Харин Бурхан хачин жигтэй биш. Түүнчлэн Бурханы Сүнсний илрэлийг зарим хүн ташаа ойлгож хэрэглэсний төлөө бид Бурханы амлалтыг хэрэгсэхээ больж болохгүй.

Хоёрдугаарт- Библи биднийг “тасралтгүй залбир” (1Тесалоник 5:17) гэдэг. Олон итгэгч энэ үгийг агуулгаар нь судлаж ойлгоогүй байдаг. Паул “өдөржингөө маани уншаад бай” гэж хэлээгүй нь лавтай.

Үнэндээ Паул Бурханы Сүнс тэй тасралтгүй харилцаатай бай гэж хэлсэн юм. Яаж тэр вэ? Үүний хариултыг бас л Паул хэлсэн: “Сүнсийг бүү дорд үз” (и19). Тасралтгүй залбирах нь Ариун Сүнсний оршихуйг хэзээ ч дорд үзэхгүй байх юм. Түүний оршихуйг мэдэрч, дуу хоолойг нь сонсоно гэсэн үг. Өөрөөр хэлбэл таны амьдралд оролцохыг нь бүү хоригло. Сүнс таны амьдралын

хэсэг бүрт оролцохыг хүснэ. Тэр таныг хөтөлж, тасралтгүй харилцахыг хүснэ. Энэ харилцаанаас амар тайван, хүч, зүг чиг төрнө.

Би бизнесмэн биш. Мөн байсан бол бизнесийнхээ төлөө Сүнсээр байнга залбирах байсан. Тэгээд зүрхэн дэхь амар тайвныхаа дагуу шийдвэр гаргана. Бүтэн цагаар үйлчилдэггүй гэдэг шалтгаанаар Бүтээгчээсээ чиглүүлэг авах явдлыг бүү хойш тавь. Тэр намайг хөтөлдөг шигээ таныг хөтөлнө.

Хувьчлан залбирах цаг

Эхлээд Бичээсийг уншбал залбирал илүү үр дүнтэй байдгийг би сурсан юм. Бурханы Үг миний ухааныг тунгалагжуулж, сүнснээс оюун ухаан руу хүрэх сувгийг маань нээдэг. Уншсаныхаа дараа би Ариун Сүнстэй илүү бат бөх холбогдож, миний залбирлын цаг Түүний оршихуйн ирэлээр баяждаг.

Түүнчлэн Бурханыг хүндэтгэхэд Тэр Өөрийгөө дуртайяа илэрхийлдэгийг би сурсан билээ. Түүний аугаа байдал, сайн сайхныг бодоход Ариун Сүнс тэр даруй Өөрийгөө илчилдэг. Яагаад? “Тэр бол ариун хүмүүсийн чуулганд агуугаар эмээгдэх Бурхан, Өөрийг нь тойрч буй бүхнээс илүү сүрдэм юм” (Дуулал 89:7). Бурханы оршихуйг мэдэртэй байвал Түүнийг хүндэтгэ. Бурханы оршихуйг сарниах хамгийн хурдан арга нь Бурханы Сүнсийг байх ёстой юм шиг үзэж, үл хүндэтгэх явдал юм.

Есүс бидэнд хэрхэн залбирахыг зааж өгөхдөө “Гиймд ийнхүү залбир. “Тэнгэрт байгаа бидний Эцэг минь, Таны нэр ариунаар дуурсагдаг” (Матай 6:9) гэсэн. Өөрөөр хэлбэл бид Аав дээр ирэхдээ Түүний оршихуйд гүн бишрэл хүндэтгэлээр хөл тавих ёстой. Тэгвэл Ариун Сүнс Оршихуйгаа илчилж, оршихуй нь бидэнд үзэл бодол, цэц ухаан, мэдлэг, хүч хайрлана. Тэр бол бидний амьдралын эх булаг! Яагаад бид амьдралын эх булгаасаа саланги байх ёстой гэж?

Сүнс дотор зуучлан залбирах

Би нэгэн пастор найзтай байнга зуучлан залбирдаг байлаа. Тэгээд хэлээр зуучлан залбирна. Нэгэн удаа бид Ойрх Дорнодын тодорхой нэг газарт хандан тушааж, чиглүүлэг өгч байгаагаа мэдрэв. Гэтэл маргааш нь Туркт газар маш хүчтэй хөдөлсөнийг мэдэв. Бид хоёр Туркийн төлөө зуучлан залбирчээ. Сүнс бидний дотор нутагладаг учраас бид Сүнсээр тэдэнтэй холбогджээ. Бурхан биднээр дамжуулан Туркийн хүмүүст хүслээ мэдэгджээ.

Сүнсээр зуучлан залбирах нь дэлхий дээр Бурханы хаанчлал өргөжин тэлэхэд амин чухал юм. Дайсан биднийг алс холын ахан дүүсийнхээ дээр Бурханы хүслийг тунхаглахыг үзэн яддаг. Тэр Чуулганыг бутаргах зорилготой бөгөөд бидний зуучлан залбирлыг хүлж, зөвхөн ухаанаараа мэддэг зүйлтэй маань л үлдээхийг хүсдэг.

Та дэлхий даяарх итгэгч хүмүүстэй ямар нягт холбоотой болохоо өнөөг хүртэл ухаараагүй байж болох. Гэхдээ та ямар ч бодитой харилцаа холбоогүй, өөр газар аж төрдөг итгэгч хүний төлөө зуучлан залбирах бүрэн боломжтой.

Би нэг удаа Кенид байхдаа Масай овгийн хүнтэй уулзсан юм. Хожим тэр Америкт зочилж, Пенсильвани дахь манай найзынд сар гаруй амьдрал. Тэрбээр үе үе Африкт байгаа гэр бүлд юу болж буй талаар манай найзынханд ярьдаг байж. Эцэстээ найзын маань гэргий “Гэр бүл чинь яаж байгааг та яаж мэдэж байгаа юм? Тэд чинь утасгүй шүү дээ” гэж асуухад, тэрбээр “Паул хэдийгээр хол байсан ч, Колоссай, Коринтод юу болж буйг мэдэж байсан. Намайг Сүнсээр залбирахад Эзэн надад гэрт маань юу болж байгааг харуулдаг” гэж хариулжээ. Тэрбээр Колоссай 2:5, 1Коринт 5:3-н тухай ярьжээ. Паул тэр хоёр чуулгантай биеэр хамт байгаагүй ч, Сүнсээр холбоотой байж тэдний үйл хэргийн талаар мэдэж байсан.

Заримдаа намайг аюултай хүнд нөхцөлд орох үед Бурхан оролцож авардаг. Энэ үед манай гишүүн, ажилтан- хэн нэг нь миний хамгаалалтын төлөө Сүнсээр зуучлан залбирчээ гэдгийг би мэддэг.

Амралт эдлэх

Ах дүү нар аа, ухаанаараа хүүхдүүд байж болохгүй. Бузар мууд балчир хүүхэд болж, харин ухаанаараа төлөвшсөн хүн бай. Хуульд “«Би харь хэлээр болон харь хүмүүсийн амаар дамжуулж энэ хүмүүст ярина. Тэгсэн ч тэд Намайг сонсохгүй» гэж Эзэн айлдаж байна” гэж бичигдсэн байдаг. (1Коринт 14:20-21)

1Коринт 14 дээр Паул хэлний талаар ямар их бичсэнийг та харсан байх. Үнэндээ энд Паул Исаиа 28:11-12 дээрх үгийг иш татсан юм:

Үнэхээр Тэр энэ ард түмэнд хандаж шулганасан уруул, харь хэлээр дамжуулан ярих болно.
Тэр тэдэнд хандан, “Энд амралт байна.
Эцэж туйлдагсдад амралтыг өгөгтүн.
Энд тайван байна” гэсэн боловч тэд сонсохгүй байх юм.

Хэлээр ярих нь амралт, сэргэлт авчрахыг Бурхан Исаиагаар эш үзүүлжээ. Том чуулганы пастор болох миний нэг найз өөр нэг том чуулганы пастортай ярилцаж байжээ. Гэтэл хоёр дахь пастор нь: “Би одоо үйлчлэлээ өглөө. Би ядарч, цөхөрч, туйлдаж байна” гэж.

Харин миний найз түүнд: “Чи хэлээр залбирахаа больжээ, тийм үү?” гэтэл мөнөөх нь ээрч гарав.

Миний найз: “Чи Сүнсээр хэр их залбирч байна?” гэж асуув.

Мөнөөх нь жаал ээрч муурч байснаа: “Би зогсоо зайгүй номлол бэлтгэж байна. Энэ 15,000 хүнтэй чуулганы чинь төлөө зогсоо зайгүй л ажиллах хэрэгтэй болох юм байна шүү дээ...” хэмээн зовлон тоочжээ.

Миний найз дахиад л асуув: “Чи хэлээр залбирч байгаа юу?”

Мөнөөх пастор нь эцэстээ: “Үгүй. Би чамаас юугаа нуух вэ? Би залбирахгүй байгаа” гэжээ.

Хариуд нь түүнд найз маань: “Сүнсээр залбирч эхэл” гэв.

Төдөлгүй мөнөөх эцэж цуцсан пастор үйлчлэлээ өгөх хүсэлгүй

болжээ. Өнөөдөр тэр өөрөө ч, чуулган нь ч гялалзаж явна!

Пастор хүн хэлээр залбирах нь яагаад тийм чухал вэ? Бид Сүнсээр залбирахдаа ер бусын амралт, шинэчлэл хүлээж авдаг. Доктор Ёнги Чо шиг их ажилтай, дарамттай, үүрэг хариуцлагатай пастор энэ дэлхийд байхгүй байх. Түүний чуулган Өмнөд Солонгосыг эрс өөрчилсөн бөгөөд тэрбээр дэлхий дээрх хамгийн хүндэтгэл хүлээсэн пасторуудын нэг мөн. Ямар ч эрэгтэй, эмэгтэй хүн ийм ачааг өөрийнхөө хүчээр үүрэх боломжгүй. Гэхдээ доктор Ёнги Чо өөрийнхөө хүчинд найддаггүй гэдгийг би мэднэ. Тэрбээр өдөр бүр хэдэн цагаар ч хамаагүй Сүнсээр залбирахыг тэргүүнд тавьдаг. Залбирлын энэ цаг түүнийг аугаа хүч, амралтаар сэлбэдэг аж.

Бурханы аугаа хүн Лестер Сумраль байна. Би түүнтэй хэд хэдэн удаа уулзах завшаан тохиосон юм. Доктор Сумраль шөнө дөрөвхөн цаг унтах бөгөөд энэ үедээ 4 ном бичдэг байв! Тэрбээр өөрөөсөө хоёр дахин залуу ажилтанууд болон залуу номлогчдоос ч илүү эрч хүчтэй байж. Хаанаас ийм их эрч хүч ундарна вэ? Сумраль гуай Сүнсээр маш их залбирдаг байсан юм.

Бид биеэ гаргуунд нь хаяж хэрхэвч болохгүй. Бурхан биднийг Саббатыг хүндэтгэж сахихыг хэлсэн. Бид бие махбодоо амраах хэрэгтэй. Би гольф тоглох дуртай. Гольф миний ажлын алжаалыг тайлж, тархи толгойг минь сэргээдэг. Гольф миний амралтын том эх булаг болдог. Гэхдээ Саббатаас гадна Сүнсээр залбирах нь бидний бие сэтгэлийг сэргээдэг. Харамсалтай нь олон хүн Сүнс дотор амардаггүй учраас яагаа ч үгүй үнс нурам болтлоо шатчихдаг.

Тавдугаар өдөр

Дотоод хүн

Хэлээр ярьдаг хүн өөрийгөө босгон байгуулдаг.
(1Коринт14:4)

Босгон байгуулахыг Грекээр *oikodomeo* гэнэ. Үндсэндээ

“барьж байгуулах” л гэсэн үг. Бид Сүнсээр залбирахдаа Бурханы оршихуй, хүчийг тээж агуулах хүчин чадлаа л барьж байгуулж буй хэрэг. Есүс “Тиймд эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу үйлдэгч аливаа хүн хадан дээр байшингаа барьсан мэргэн хүнтэй зүйрлэгдэнэ” хэмээхдээ (Матай 7:24) яг энэ үгийг хэрэглэсэн юм.

Бурхан бас Иудагаар дамжуулж яг ижил зүйлийг бидэнд хэлсэн:

Хайртууд минь, харин та нар хамгийн ариун итгэл дээрээ өөрсдийгөө сүндэрлүүлж, Ариун Сүнсээр залбиран ... (Иуда 20)

Манай нэг найзын хүү маш хүнд өвчтэй байсан юм. Эмч нар ч учрыг нь олохгүй, найз маань ч учраа олохгүй байлаа. Эцэстээ бид ажил дээрээ очоод 5 цаг Сүнсээр залбирав. Тэрбээр ажлаасаа гараад, гэртээ хариад унтлагын өрөөндөө хэвтэж байсан хүү дээрээ оржээ. Юу болсон гээч? Хүү нь төгс эдгэрчээ! Яагаад? Найз маань Сүнсээр залбирахдаа хүүийнхээ төлөө зуучлан залбирч, үйлчлэх хүчин чадлаа өсгөжээ. Бурханаас хүлээн авч буй бүхнийг итгэлээр л хүлээн авна. Өөр зам байхгүй. Бид Бурханы Сүнстэй цаг өнгөрөөх үед Тэр бидний дотоод хүнийг босгон байгуулж, Бурханы оршихуйг илэрхийлж, амлалтыг хүлээж авах чадварыг маань өсгөдөг.

Үнэн голоосоо магтан хүндэтгэх

Тэнгэрийн хэлээр залбирах нь бидэнд Бурханыг илүү гүн гүнзгий төвшинд магтан хүндэтгэх чадвар хайрладаг. Паул ч үүнийг хэлсэн:

Эс бөгөөс хэрэв та нар сүнс дотор ерөөвөл билэг авъяасгүй нэг чинь та нарын талархалд “Амен” гэж яаж хэлэх вэ? Та нарын юу хэлснийг чинь ч тэр мэдэхгүй. Учир нь чи талархлаа сайн илэрхийлдэг байж болох ч бусад нь байгуулагдахгүй. Би та бүгдээс

ч илүүгээр хэлээр ярьдаг тул Бурханд талархдаг.
(1Коринт 14:16-17)

Хамтын магтаалд Бурханыг хэлээр магтахад хажуудах хүндээ ямар ч ашиг тус авчрахгүй гэдгийг Паул цохон тэмдэглэжээ. Учир нь хэлээр магтах нь хувийн илэрхийлэл бөгөөд хувь хүнийг босгон байгуулдагаас биш, хүмүүсийг бөөнд нь босгон байгуулахгүй. Паул Бурханыг хэлээр магтахыг дорд үзээгүй, ердөө л хэлээр магтах цаг ба газар гэж байдгийг л хэлж байна.

Тэрбээр үгээ “Бурханд талархдаг” хэмээн өндөрлөсөн байгааг анхаараарай. Бид Бурханыг хэлээр магтахад Ариун Сүнс биднээр дамжуулан Бурханы гайхамшиг ба нууцыг үзэсгэлэнтэй илэрхийлдэг. Бид Бурханыг тэнгэрийн хэлээр магтахдаа магтаалын илүү гүн төвшинд нэвтэрдэг. Тиймээс л Паул ухаанаар ч, Сүнсээр ч дуулсан буюу (1Коринт 14:15).

Хэн ч Сүнсээр дүүрч болно

Хэлээр ярьдаг Христэд итгэгч хүмүүс хэлээр ярьдаггүй нэгнээ доош хийх шиг адгийн зүйл үгүй. Тэд ердөө л Бурханы энэ гайхамшигт бэлэгийг хараахан хүлээж авч амжаагүй буй хүмүүс. Тэднийг доош хийж, дорд үзэж огт болохгүй. Учир нь бид бүгдээрээ Христийн дотор нэг.

Хэлээр ярих бэлэгийг хэн ч хүлээж авч болдогийг сүүлийн бүлэгт ярьсан- хэлээр ярьдаггүй хүмүүс энэ амлалтаас гадуурхагдаагүй. Есүс “Итгэгчдэд энэ тэмдгүүд дагалдана. Миний нэрээр тэд чөтгөрүүдийг зайлуулж, шинэ хэлээр ярина” хэмээн айлдсан (Марк 16:17).

Паул ч “та нар бүгдээрээ хэлээр ярьдаг ч болоосой” гэж хэлсэн (1Коринт 14:5). Бурхан бүх хүүхэддээ энэ гайхамшигт бэлэгээ эдлүүлэхийг хүсдэг.

Ариун Сүнснийг хэрхэн хүлээж авах вэ?

Үргэлжлүүлэхээсээ өмнө нэгэн зүйлийг хэлэхийг минь болгооно уу. Олон итгэгч нар машиндаа, гэртээ, ажлын газар дээрээ Сүнсээр дүүрдэг. Тиймээс бид тэнгэрийн Ааваасаа Сүнсээ бидэнд өгөхийг л гуйх хэрэгтэй.

Ариун Сүнснийг хүлээж авахаасаа өмнө та Есүс Христийг Эзэн ба Аврагчаар хүлээж авсан байх шаардлагатай. Дэлхий (авралыг хүлээж аваагүй хүмүүс) Ариун Сүнснийг хүлээж авч чадахгүй гэж Есүс айлдсан (Иохан 14:27). Хэрэв та Есүсийг амьдралынхаа Эзэн болгоогүй бол яг одоо үүнийг хийж болно (Хэрхэн аврагдах талаар Хавсралтаас харж болно).

Харин хэрэв та хэдийнээ Бурханы хүүхэд болсон атлаа Сүнсээр дүүрээгүй яваа бол таны амьдралд санаатай дуулгаваргүй байдал байна гэсэн үг. Бурхан дуулгавартай хүмүүст л Ариун Сүнсээ өгдөг (Үйлс 5:32). Та төгс байх албагүй. Зүгээр л даруу бай. Энэ нь Түүнд захирагдаж буйн тэмдэг юм. Бурхан даруу хүнд нүглийг ялан дийлэх нигүүлсэлээ хайрлаж та дахин Сүнсээр дүүрч чадна.

Олон хүмүүсийн амьдралд байдаг дуулгаваргүй байдлын хамгийн том урхи нь гомдол юм. Тиймээс танд хор хөнөөл учруулсан хүмүүсийг зориуд уучил. Гомдсон итгэгч өрөөлийг уучилсан даруйдаа Сүнсээр дүүрэхийг би олон удаа гэрчлэн харсан юм. Тиймээс таныг гомдоосон хүмүүсийг нигүүлсэн, суллан тавих сэтгэлийг Бурханаас гуй (Би гомдлын талаар “Сатаны урхи” номдоо дэлгэрэнгүй бичсэн).

Зүгээр л итгэлээр гуй...

Эцгүүд та нарын нэгээс чинь хүү нь загас гуйвал оронд нь могой өгөхгүй нь лавтай. Тийм биш гэж үү? Эсвэл хүү нь өндөг гуйвал, эцэг нь хилэнцэт хорхой өгөхгүй биз дээ? Хэрэв та нар бузар атлаа хүүхдүүддээ хэрхэн сайн бэлэг өгөхөө мэддэг юм бол, тэгэх тусмаа тэнгэрлэг Эцэг тань Өөрөөс нь гуйдаг хүмүүст Ариун Сүнс өгөх нь дамжиггүй гэв. (Лук 11:11-13)

Ариун Сүнсийг хүлээж авах гэсэн биш, муу ёрын сүнстэй болчихбол яана гэж ярьдаг хүмүүс бий. Энэ айдсыг Есүсийн Өөрийнх нь үг бүрэн сарниах учиртай: Аливаа сайн соёрхол ба аливаа төгс бэлэг... Ааваас бууж ирдэг (Иаков 1:17). Ааваас Ариун Сүнсийг гуйхад Тэр танд чөтгөр өгөхгүй нь лавтай. Бурхан бидэнд Өөрийнхөө Сүнсийг л өгнө. Тиймээс Бурханы Сүнсэнд өөрийгөө нээхээс бүү ай.

Гэхдээ Ариун Сүнс хэлийг тань угзарч байгаад л хүчээр яриулна гэж эндүүрэв. Тэр танд чөлөөт хүсэл өгсөн. Сүнс бол Жентельмэн учраас хэзээ ч таныг шахаж шаардахгүй. Сатан хүч хэрэглэдэг, харин Сүнс хөтөлж удирддаг. Сүнс танд үг (авиа, чимээ, үгийн үе зэргээр эхэлж болно) өгдөг ч, та уруул, хэл, дуу хоолой гэдэг 3 зүйлээ Түүнд захируулах ёстой. Ингэмэгц таны сүнснээс тэнгэрийн хэл ойлгодож эхэлнэ. Энэ нь зүгээр л нэг авиагаар эхэлнэ. Тэр авиаг дуулгавартай гаргасаар байвал цаанаас нь улам ундарсаар байна. Бурханы юмсыг гагцхүү итгэлээр л хүлээж авна. Зүгээр л Түүний өгсөн зүйлийг итгэлээр хэл. Анхандаа юу нь мэдэгдэхгүй байсан дуу авиа тань яваандаа бүрэн хөгжсөн хэл болно.

Илүү гүн төвшин

Сүүлийн хоёр бүлгийн турш би хэлний тухай яриад л байгаа нь учиртай. Бурхан ч бидэнд өгсөн энэ тэнгэрийн хэл нь биднийг Түүнтэй болоод бусадтай маань илүү бат бөх холбодог. Ариун Сүнс эрэгтэй эмэгтэй бүх хүнд Есүсийг л мэдүүлэхийг хүсдэг. Энэ бол Түүний чин сэтгэл юм. Бид Түүнтэй гүн гүнзгий нөхөрлөж, түншлэхэд Тэрбээр бидний нүдийг нээж, ертөнцийг цоо шинэ гэрлээр харуулна. Тэр үед бид энэ дэлхий Есүсээр дутаж буйг харна. Түүнчлэн Бурханы Сүнсээр дамжуулан бид хүн төрөлхтөнд Христийг мэдүүлэхийн төлөө юу хийхээ харж бас мэддэг.

Та энэ номоор дамжуулан Ариун Сүнсстэй дуртайяа танилцсан байх. Гэхдээ энд сурсан зүйл тань ч Түүний энгүй, хязгааргүй, мөнхийн гайхамшигтай зүйрлэхэд юу ч биш бөгөөд Ариун Сүнс таныг өдрөөс өдөрт улам өндөрт аваачихыг хүсдэг. Тиймээс

номоо үе үе сэргээн уншиж байгаарай. Тэгвээс Түүнтэй илүү дотно танилцах хүслийг тань Ариун Сүнс өрдөх болно.

Ариун Сүнс танд Есүсийг дуртайяа илчилдэг. Түүний оршихуйг хүндэтгэж амьдралынхаа талбар бүрт урь. Тэр таныг хэзээ хаяхгүй, орхихгүй гэж амласан учраас энэ гайхалтай амлалтыг бүү алд. Бурханы Үгийг уншиж, Түүнтэй оршихуйтай хамт байхдаа та Сүнтэй улам дотно танилцана. Энэ бол эцэс төгсгөлгүй аялал юм. Ариун Сүнс танд илчлэхийг хүсч буй зүйлс ч дуусахгүй. Сонссон, харсан, мэддэг зүйлдээ бүү хана. Есүс Христийн Сүнсэнд амьдралаа захируулж, ухааныхаа хязгаарыг тэл. Үүнийг хийж чадсан хүн Бурханы сүр жавхлан, алдар хүчийг харахдаа л харна.

Нэгдүгээр өдрийн чимээгүй цаг

Сүнсээр залбирах нь...

ГҮН ГҮЗГИЙ ДОТНОСОЛЫГ ТӨРҮҮЛДЭГ

Хэлээр ярьдаг хүн хүмүүст бус, харин Бурханд хандаж ярьдаг.

*Учир нь тэр хүн сүнс дотор нууцуудыг ярьдаг боловч
ямар ч хүн ойлгодоггүй ажээ.*

1Коринт 14:2

Сүнсний хэлээр залбирахын хамгийн аугаа ерөөл нь Бурхантай улам бүр дотносоход оршино. Бүх бүтээлийн Эзэн бидэнтэй нөхөрлөж харилцахыг дэндүү хүссэндээ, бидний сүнс дотор Өөрийнхөө Сүнсийг нутагшуулж, биднийг Түүнтэй Өөрийнхөө төвшинд харилцах эрх олгожээ. Гайхалтай! Пастор Кеннет Хэгин ийн өгүүлжээ:

“Бурхан бол Сүнс. Биднийг хэлээр залбирах үед сүнс маань шууд Сүнс- Бурхантай холбогддог. Бид Түүнтэй ер бусын, тэнгэрлэг төвшинд харилцан холбогддог. ...Өөр хэлээр ярих нь Ариун Сүнсний бялхалын анхдагч нотолгоо төдийгүй, насан туршид үргэлжлэх үйл явдал юм. Ямар зорилгоор? Бурханыг хүндэтгэхэд маань туслах зорилгоор.

Хэлээр тасралтгүй залбирч, магтдаг хүн Бурханы оршихуйг тасралтгүй мэдэрнэ. Өдөр бүр Ариун Сүнсний оршихуйг мэдэрдэг хүн хаа хамаагүй амьдрахгүй.”

Бид Сүнсээр залбирахдаа өөрийнхөө ухаанаар бус, Бурханы ухаанаар залбирдаг. Бурханы Сүнс биднээр дамжуулан Бурханы төгс хүслийг залбирдаг!

Өдөр бүр Сүнсээр залбирч, Үгээр хоолох нь чухал. Учир нь бид

ингэж л Түүнтэй дотно холбогддог. Өдөр бүр Бурхантай холбогддог тогтмол цаг, газар танд бий юу? Тэр танд хайртай гэдгээ яаж харуулдаг вэ?

Хэрэв танд Ариун Сүнсстэй тогтмол уулздаг газар, цаг байхгүй бол хэзээ уулзаж учирч болохыг Түүнээс асуу.

Та хэлээр ярих бэлэгийг үл тоомсорлож байсан уу? Байсан бол, яагаад? Энэ ном танд Сүнсний хэлийг хүчирхэг, зэрэг гэрлээр харуулав уу?

Хэрэв та хэлээр ярих бэлэгийг үл ойшоож, үл тоомсорлож байсан бол Бурханаас өршөөл эрж, өөрийгөө Сүнсээр дахин дүүргэ.

Зарим хүн ганц хоёрхон үг хэлдэг учраас хэлээр ярихаасаа санаа зовдог. Та бас тэгдэг үү? Хэрэв тийм бол Ариун Сүнс танд маш ээлдэг зөөлнөөр: “Би чамд хайртай. Чамд өгсөн зүйлийг минь хэрэглээрэй. Миний өгсөн үгээр Намайг хайрлаж, хүндэтгээрэй. Ганц хоёрхон ч гэсэн чи бид хоёр хоорондоо ярьж байгаа учраас тун чухал үг юм шүү” гэж хэлж байна гээд төсөөл. Түүнд заавал хариулаарай.

Өөрийнхөө хэлийг бусдынхтай бүү харьцуул. Сүнсний танд өгсөн зүйлд эзэн бол Жижиг зүйлд итгэмжтэй байвал, Эзэн илүү ихийг өгнө! Матай 25:14-23, 20-23-г анхааралтай унш.

Хоёрдугаар өдрийн чимээгүй цаг

Сүнсээр залбирах нь... БУРХАНЫ НУУЦЫГ ТАЙЛДАГ

Тэр

—Тэнгэрийн хаанчлалын нууцуудыг мэдэх нь та нарт өгөгдсөн юм. Харин тэдэнд өгөгдөөгүй. Учир нь хэнд байна, түүнд ихээр өгөгдөж, элбэг дэлбэг байх болно. Харин хэнд байхгүй байна, түүнд байгаа нь хүртэл түүнээс авагдана.

Матай 13:11-12

Танд Бурханы хаанчлалын нууцыг ойлгох эрх бий гэдгийг Есүс хэлсэн. Эдгээр нууцыг яаж хүлээн авч, ойлгох вэ? Сүнсстэй нөхөрлөснөөрөө. Сүнсээр залбирч, Түүнтэй хамт байхад, Сүнс танд Бурханы нууцыг илэрхийлдэг.

Нэрт зохиолч, илтгэгч **Освальд Чамбер** “My Utmost for His Highest” хэмээх алдарт номдоо ийн бичжээ:

“Жинхэнэ найзын шинж? Нууц зовлонгоо илчлэх үү? Үгүй, тэр танд нууц баяр хөөрөө хэлдэг. Олон хүн нууц зовлонгоо тоочдог. Харин жинхэнэ дотнэслын шинж нь нууц баяр хөөрөө дэлгэх юм.”

Сүнс танд Бурханы ямар гайхамшгийг илчилсэн бэ? Энэ нь яагаад таны хувьд чухал вэ?

Та Сүнсстэй хувийнхаа бодол, сэтгэгдэл, мэдрэмж, хүслийг хуваалцдаг үү? Том хүсэл мөрөөдөл, айдсаа хуваалцдаг үү? Найзууд хуваалцдаг. Тэгвэл яг одоо зүрхэндээ нандигнаж явдаг, урьд нь хэнд хэлж яваагүй эсвэл удаан хугацаанд ил гаргаагүй

ямар нэгэн амин чухал зүйлээ Түүнтэй хуваалцаад үз.

Ариун Сүнснэй юу ч хуваалцах хүсэлгүй байгаа бол учир нь юу вэ? Танд юу саад болоод буйг харуулж, зүрхээ нээхэд тань туслахыг Ариун Сүнснээс хүс.

Бурхантай харилцах нь зөвхөн ярих бус бас сонсох юм. Хэрэв бид чих тавихгүй бол Сүнсний үгийг сонсохгүй. Чамбер цааш нь ийн хэлжээ:

“Бид Бурханд баяр хөөрөө хуваалцах боломж олгож байна уу? Эсвэл өөдөөс нь зогсоо зайгүй өөрийнхөө түүхийг л хүүрнээд байна уу? Итгэлийн амьдралаа дөнгөж эхэлж байхдаа бид, Бурханд зогсоо зайгүй хүсэлтээ “шулганадаг” байсан бол, яваандаа Бурхантай нөхөрлөж, зорилгыг нь таньж мэддэг. Есүсийн заасан “Таны хүсэл биелэг” гэдэг залбирал бидэнд Бурханы нууцыг тайлдаг. Харин та энэ залбирлыг өөрийн болгож чадсан уу?”

Ярих цаг гэж байна, чимээгүй сонсох цаг бас байна (Номлогчийн үгс 3:1-7). Сүнснээс “Залбирлын цагаар би л яриад байна уу? Би танд нууцаа тайлах цаг олгож байна уу? Таныг ярих гээд байхад би сонсохгүй байна уу?” гэж асуу. Тэгээд дуугүй сонс. Ариун Сүнс танд юу хэлж байна?

Бидний Эзэн Есүс Христийн Бурхан болох алдрын Эцэг нь та нарт мэргэн ухаан хийгээд илчлэлийн сүнсийг өгч, Түүнийг дүүрнээр мэдүүлж, 18[Та нарын] зүрхний мэлмийг гийгүүлэх болтугай! Ийнхүү та нар дуудлагын найдварыг хийгээд ариун хүмүүс дотор Түүний өв дэх алдрын баялгийг, 19мөн итгэдэг бидэнд хандсан Түүний хүч чадлын хэмжээлшгүй сүр жавхланг мэдэх болтугай! Энэ хүч нь Түүний чадлын хүчний нөлөө билээ.

Ефес 1:17-19

Гуравдугаар өдрийн чимээгүй цаг

Сүнсээр залбирах нь...

ДОТООД АМАР ТАЙВНЫГ БҮТЭЭДЭГ

Харин Сүнсний үр жимс нь ... амар тайван

Галат 5:22

Амар тайван гэж юу вэ? Жинхэнэ амар тайвныг Есүсийн Сүнс бидэнд өгдөг. Энэ нь банк дүүрэн мөнгө, төгс эрүүл мэнд, үнэтэй байр, хөрөнгө мөнгө, асуудалгүй харилцаа гэсэн үг биш юм.

Жинхэнэ амар тайван нь Бурханы амар тайван бөгөөд гадаад нөхцөл байдлаас шалтгаалахгүй. Жинхэнэ амар тайван нь хүнд бэрх нөхцөл дундах тогтвортой байдал юм. Энэ нь асуудал дунд сэтгэл санаа, бие махбод, сүнсээр амар тайван байхыг хэлнэ.

Тиймээс өөрөөсөө “Би амар тайвныг юу гэж ойлгодог вэ? Миний амар тайван юун дээр тогтдог вэ? Амар тайвны талаарх миний ойлголт Сүнсний жинхэнэ амар тайвнаас юугаараа ялгардаг вэ? Юуг өөрчлөх шаардлагатай вэ?” гэж асуу.

Христийн тахилаар дамжуулан Бурхан бидэнтэй амар тайвнаа тогтоосон. Ариун Сүнсний дүүргэлтээр дамжуулж Бурханы амар тайван бидэнд ирсэн. Есүс Өөрөө:

Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай. (Иохан 14:27)

Энхийн Ханхүүгийн өгсөн амар тайвнаар бид яах ёстой вэ?

Христийн амар тайван та нарын зүрх сэтгэлийг захираг. Үүний тулд л та нар нэгэн бие дотор дуудагдсан юм. Талархагтун.
(Колоссай 3:15)

Ариун Сүнс биднийг амар тайвнаараа л Бурханы хүсэл рүү удирддаг. Бичээс “Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс Өөрөө бидний сүнстэй хамт гэрчилдэг” (Ром 8:16) гэхдээ энэ тухай л ярьсан. Яг одоо танд Бурханы удирдамж шаардлагатай ямар нэг асуудал байна уу? Тэгвэл Сүнснээс асуу. Тэгээд Түүний амар тайвны гэрчийг хүлээ. Тэр танд юу гэж байна?

Дөрөвдүгээр өдрийн чимээгүй цаг

Сүнсээр залбирах нь...
**ЦЭЦ УХААН, ЧИГЛҮҮЛЭГ
 АВЧИРДАГ**

*Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд
 өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг.*

Тэгээд түүнд өгөгдөх болно.

Иаков 1:5

Цэц ухаан, удирдамжийн эзэн Хэн бэ? Исаиа Түүнийг цэц ухаан, ойлголтын Сүнс, Зөвлөгч Сүнс гэсэн. Есүс Түүнийг биднийг бүх үнэн рүү хөтлөх Багш гэсэн. Тэр Багш хаана амьдардаг вэ? Түүний Сүм болох бидний дотор. Цэц ухаан дутбал зүгээр л ухаанаараа болон Сүнсээр гуй. Тэр танд удирдамж өгнө!

Эдгээр хүчирхэг амлалтыг хүлээж авахдаа, Эзэн ба Сүнс нэг гэдгийг санаарай.

Чиний Аврагч, Израилийн Ариун Нэгэн, ЭЗЭН ингэж айлдаж байна. “Би бол чиний Бурхан ЭЗЭН мөн. Би чамд тустайг сурган, чамайг явах ёстой замаар чинь удирддаг. Исаиа 48:17

Та нар баруун тийшээ эргэсэн ч, зүүн тийшээ эргэсэн ч, ард чинь дуугарах “Энэ бол зам. Үүгээр алхагтун” гэсэн үгийг та нарын чих сонсоно. Исаиа 30:21

Би чиний явах ёстой замд чамд зааварлан зааж өгнө.
 Би чамайг ширтэн, чамд зөвлөнө. Дуулал 32:8

Харин Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун Сүнс та нарт бүх зүйлийг заах бөгөөд Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно.
Иохан 14:26

Харин үнэний Сүнс болох Тэр ирэхдээ та нарыг бүх үнэн уруу удирдана. Учир нь Тэр Өөрийн санаагаар биш харин алив сонссон юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ. Иохан 16:13

ЭЗЭН, надад Өөрийнхөө замуудыг мэдүүлээч. Өөрийнхөө жимүүдийг надад зааж өгөөч. Өөрийнхөө үнэнээр намайг дагуулж, намайг сургаач. Учир нь Та бол миний авралын Бурхан юм. Таныг би бүхэл өдөржин хүсэн хүлээдэг ... Тэрээр даруу хүнийг шударгаар удирдаж, тэдэнд Өөрийн замыг сургадаг ... ЭЗЭНээс эмээдэг хүн хэн юм бэ? Тэрээр түүнд сонгох ёстой замд нь зааварчилна. Дуулал 25:4-5, 9, 12

Түүний цэц ухаан, удирдамж таны яг ямар асуудал дээр хэрэгтэй байна? Таны ажил дээр үү? Эрүүл мэнд дээр үү? Гэрлэлт дээр үү? Үр хүүхэд дээр үү? Санхүү дээр үү? Нөхөрлөл дээр үү? Асуудал тань юу ч байлаа гэсэн дараах алхмыг хийнэ үү:

1. Өнгөрсөн амьдралд тань үзүүлсээр ирсэн Бурханы удирдамжид талархаад, Түүний цэц ухааныг хүс (Филиппой 4:6-7).
2. Сүнсээр залбир. Сүнс хүсч буй хугацаагаар хэлээр залбир (Ефес 6:18; 8:26-27).
3. Сүнснээс тайлбар асуу. Тэр таны залбирсан зүйлийг тайлж өгнө (1Коринт 14:13).
4. Түүний илчилсэн зүйлийг бич (тэр даруй ирэхгүй байж болох ч, гарцаагүй ирнэ).
5. Түүний удирдамжийн дагуу үйлдэхэд тань нигүүлсэлээ хайрлахыг Ариун Сүнснээс гуй.

Миний яг юун дээр цэц ухаан удирдамж хэрэгтэй байна?

Ариун Сүнс надад дараах цэц ухаан, удирдамжийг өгч байна:

Тавдугаар өдрийн чимээгүй цаг

Сүнсээр залбирах нь...

ТАНЫГ ХҮЧИРХЭГЖҮҮЛЖ, БОСГОН БАЙГУУЛДАГ

Хэлээр ярьдаг хүн өөрийгөө босгон байгуулдаг бол эш үзүүлдэг хүн чуулганыг босгон байгуулдаг аж.

1Коринт 14:4

Дайсан яагаад таныг хэлээр залбируулахгүй гэж үзэлцдэг вэ? 1Коринт 14:4 бидэнд хүчтэй тайлбар өгч байна: дайсан таныг хүчтэй болгохыг хүсдэггүй. Та сүнсээр хүчирхэг байх тусам, Христийн төлөө төдий чинээ хүчтэй байж, тэр хэмжээгээрээ Сатаны хаанчлалд аюул занал болно.

Сүнсээр залбирах нь таны сүнсийг цэнэглэж, айдас, эргэлзээ, дарамтыг сарниадаг. Энэ нь таныг илэрхийлэхийн аргагүй арга байдлаар босгон байгуулдаг. Та хэлээр залбирахдаа Бурханы оршихуй, хүчийг тээх хүчин чадлаа өсгөдөг.

Та Сүнсээр тогтмол залбирдаг уу, хааяа залбирдаг уу? Тогтмол залбирдаг бол ямар давтамжтай? Хэр удаан? Хааяа нэг залбирдаг бол яагаад?

Хэлээр залбирах үед таны дотор юу болдог вэ? Үүний үр дүнд танаас ямар үр жимс төрсөн бэ? Эдгээр нь таныг Сүнсээр улам их залбирахыг урамшуулж байна уу?

Та стресстэй, цөхөрмөөр нөхцөлд голдуу яадаг вэ? Ийм үед Сүнсээр залбирч үзсэн үү? Түр зогсоод “Ариун Сүнс минь, хэлээр залбирах бэлэгт ханддаг миний төрөлх, сөрөг хандлагыг өөдрөг, ер бусын болгож өөрчлөөч. Намайг урьд нь хэзээ ч дүүргэж байгаагүйгээр дүүргээч!” гэж залбирна уу.

Түүнийг амьдралынхаа амин чухал хэсэг болгохын тулд юу хий гэж Ариун Сүнс танд хэлж байна? Тэдгээрийг бичээд, хэрэгжүүл.

Дайсан таныг хэлээр ярих тал дээр эргэлзүүлж самууруулсан гэдэг нь эргэлзээгүй. Тэр угаасаа үүнийгээ итгэгч хүн бүрт хийдэг. Түүний авчирдаг зарим нэг самуурлаас одоо бичье.

Энэ бүхэн чинь Бурханаас биш ээ, чи өөрөө л зохиож байна.

Би одоо ямар тэнэг юм хийгээд байна аа?

Чи хүний яриаг дууриагаад байна.

Ямар ч нэмэргүй юм хийж байна.

Би хэлээр залбирмааргүй байна.

Би хоёр үгээ л давтаад байна.

Хүмүүс сонсбол юу гэх бол?

Хайртууд минь, харин та нар хамгийн ариун итгэл дээрээ өөрсдийгөө сүндэрлүүлж, Ариун Сүнсээр залбир ... (Иуда 20).

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

- 1 | Хэлээр залбирах нь маш их ач холбогдолтой юм. Санаж байгаа ач холбогдлоосоо цээжээр нэрлэнэ үү. Энэ дундаас таны хувьд яг одоо аль нь хамгийн чухал вэ? Ичэж зовох зүйл байхгүй бол бусадтайгаа хуваалцана уу.
- 2 | Бурхан бидэнд хэл өгсөний нэг зорилго нь яриагаа дайснаас нууцлахын тулд юм. Бурхан бүгдийг мэднэ, Сатан бүгдийг мэдэхгүй. Сатан Сүнсний тэнгэрлэг хэлийн долгионыг ойлгохгүй. Таны болоод бусдын амьдралд хийх гэж байсан дайсны төлөвлөгөөг хэлээр (зуучлан) залбираад нураасан онцгой тохиолдол байгаа бол хуваалцана уу.

Удирдагч нарт: Лук 10:19; Ефес 6:10-18; 2Коринт 10:3-5; Матай 11:12; Илчлэлт 12:11-г үзнэ үү.

Сүнс дотор цаг үргэлж аливаа залбирал ба гуйлтаараа залбир. Үүний тулд бүх ариун хүмүүсийн төлөөх цөхрөлтгүй бүх оролдлого, гуйлтаараа сэргээг бай.

Ефес 6:18

- 3 | Аливаа нөхцөл байдалд Бурханы цэц ухаан хэрэгтэй байгаа бол тэнгэрлэг удирдамж хүлээж авахын тулд Сүнсээр залбирах хэрэгтэй. Сургаалт үгс 20:5; 1Коринт 14:13; Иохан 7:38-39-г уншина уу. Хэлээр залбирах нь таны зүрхэнд суулгаатай буй Бурханы зөвлөгөөг татаж гаргадаг.

- 4 | Ариун Сүнстэй харилцаатай амьдрах нь “нууцыг” илчилдэг. Эдгээр нууцад аль чуулганд явах, хэнтэй гэрлэх, ямар ажил хийх, ямар байшин авах, бусдын төлөө хэрхэн залбирах, яаж сайн хань, аав ээж байх, ажлын бэрхшээлийг хэрхэн даван туулах зэрэг бүх зүйл багтана. Хэрэв та хүсч байвал, Сүнсээр залбирсанаараа та яаж дээрх нөхцөл байдалд хариулт олсоноо бүлгийнхэнтэйгээ хуваалцана уу.
- 4 | 1Коринт 14:15 Сүнсээр болоод ухаанаар залбирахын аль алийнх нь үнэ цэнийг хэлжээ. Ухаанаар залбирахын ач холбогдолоос нэрлэнэ үү. Сүнсээр залбирах нь ухаанаар илүү зөв залбирахад тусладаг уу?
- 5 | 1Тесалоник 5:17 биднийг “тасралтгүй залбир” гэсэн. Энэ нь 24/7 залбир гэсэн үг үү? Эсвэл өөр утгатай юу?
- 6 | 1Тесалоник 5:16-19-г уншаад, Бурхан бидэнд юу хэлсэнийг ярилцана уу.
- 7 | Ариун Сүнсээр дүүрэн зарим итгэгчид Бурханы гайхамшигт Бэлэгийг хараахан хүлээж аваагүй буй нэгнээ доош хийж, хоёрдугаар зэргийн мэтээр хандах явдал гардаг. Танд ингэж хандаж байсан уу? Байсан бол энэ нь Бурхан та хоёрын харилцаанд бас бусадтай тогтоох харилцаанд тань яаж нөлөөлсөн бэ? Та өөрөө хэн нэгэнд санаатай бөгөөд санаандгүй ингэж хандаж байсан уу? Сүнсээр дүүрэх асуудалд бид яаж хандах ёстой вэ?

ТЭМДЭГЛЭЛ

Бүлгийн дүгнэлт:

- Сүнстэй дотносож (үүнд хэлээр залбирах багтана) болдог цаг хугацаа, газар гэж байна.
- Бусдын нөлөөнөөс болж хэлээр ярих бэлэгийг үл хэрэгсэж, үл тоож, дорд үзэж болохгүй.
- Та хэлээр залбирахдаа Бурханы нууцыг ярьдаг. Тиймээс Бурханаас залбирлынхаа тайллыг хүсээрэй.
- Сүнсний хүч даруу хүмүүст л ирдэг. Даруу зан байдал нь Бурханы нууц руу нэвтрэх үүд нээнэ.
- Цэц ухаан хэрэгтэй үед Бурханыг үнэн голоос хүндэтгэмээр байгаа үед эсвэл бусдын төлөө зуучлан залбирмаар байвал хэлээр залбирч болно. Сүнс бидний чадварыг бүх талбар дээр өсгөдөг.

- Бурханы удирдамж гол төлөв амар тайвнаар дамжиж ирдэг. Аливаа зүйлийн төлөө Сүнсээр залбирахад амар тайван байвал Ариун Сүнс бидний сүнс дотор гэрчилж, зөвшөөрлөө өгч байна гэсэн үг.
- Хэлээр залбирах нь бидний ахуй биеийг бүхлээр нь сэргээж, шинэчилж, босгон байгуулдаг. Өдөр бүр цаг гаргаж байгаад, Сүнсний хэлээр залбираарай!

НЭМЭЛТ БҮЛЭГ

АСУУЛТ ХАРИУЛТ

Лиза: Зарим чуулган уур амьсгал дээр хэт их төвлөрсөнөөсөө болоод Ариун Сүнсний оршихуйг үл ойшоодог тухай чирьясан. Олон чуулган Ариун Сүнсний оршихуйг дахин урихыг хүсч байна. Үүнийг яаж хийх вэ?

Жон: Зүгээр л асуух хэрэгтэй. Ариун Сүнс бол Жентельмэн гэдгийг би өмнө хэлсэн. Тэр санаачилгыг бидэнд үлдээдэг.

Чуулганд үйлчлэл хийж байхад, хүмүүс аврал хүлээж авахаар урагшаа гарахад нь би: “Ариун Сүнс минь, тэдэнд хүрээч” гэж л хэлдэг. Хэдхэн минутын дотор Түүний оршихуй үзэгдэж хүмүүс мэгшин уйлж эхэлдэг. Би үүнд дуртай. Учир нь Библи тэнгэрлэг бэлэгийг амтлах тухай ярьдаг бөгөөд (Еврей 6:1-6) Сүнсний оршихуй болох тэнгэрлэг бэлэгийг амталж үзсэн хүн итгэлээсээ бараг няцдаггүй.

Нэг удаа би хуучны карисматик үйлчлэлийг санагдуулдаг Ариун Сүнсний бүх төрлийн илрэлээс бүрэн хөндийрсэн нэгэн чуулганд үйлчилсэн юм. Нэгэн цуглаан дээр Бурханы Сүнс Өөрийнхөө оршихуйг харуулав. Чуулган даяар хүмүүс уйлалдаж, Бурханы оршихуй бялхам байв. Гэтэл Эзэн надад “Одоо тэдэнд талархал магтаал өргө гэж хэл” хэмээв. Би ч үүнийг нь дамжуулаад цуглаанаа дуусгалаа. Дараа нь пастор нь хүрч ирээд: “Гайхалтай! Би ч “одоо дахиад л нэг цаг сунжирна. Тэгээд л мөнөөх хачин хачин зүйлс нь өрнөнө дөө” гэж бодож байлаа. Бурхан таныг яаж хөтөлсөн нь надад их таалагдлаа. Бурхан үйлчлэлээ дуусгасан гэж хэлэхэд тань Тэр үнэхээр зорилгоо гүйцэлдүүлжээ гэдгийг би

мэдэрсэн. Яг тэр үед та “Чуулганаа дуусгая” гэсэн” хэмээн ярьж билээ. Ариун Сүнсний оршихуй хоёрхон минутын дотор ч хүнд гүн гүнзгий хүрч чадна.

Лиза: Жон бид хоёр саяхан энэ тухай ярилцсан л даа. Заримдаа бидэнд 35 минут номлох л цаг олддог. Тиймээс 35 минут номлохын оронд...

Жон: 30 минут номло.

Лиза: Яг үнэн, 30 минут номло. Эсвэл номлох дундаа зогсоод Ариун Сүнсэнд цаг өг. Түүнд Өөрийнхөө замаар ажиллах бололцоо олго. Заримдаа үйлчлэгч нар ажилдаа түүртсэндээ болоод Ариун Сүнсээр хөтлөгдөхөө мартдаг.

Лиза: Ариун Сүнсээр “дүүрэх” тухай чи их ярьсан. Харин Тэр бидэнд хориглох үед яах вэ? Энэ нь ямар байдаг вэ?

Жон: Колоссай ном бидэнд “Христийн амар тайван та нарын зүрх сэтгэлийг захираг. Үүний тулд л та нар нэгэн бие дотор дуудагдсан юм. Талархагтун.” гэж зааварласан (Колоссай 3:15). Ром 8-р бүлэг “Учир нь Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм.” гэсэн (и14). Хөвгүүд гэдэг үгийг Грекээр *huios* (“өсч төлөвшсөн хөвгүүд” гэсэн утгатай) гэх агаад хөвгүүд, охидын аль алийг нь хэлдэг. Итгэгч хүн бүр Сүнсээр удирдуулаад байдаггүй. Олон хүн сэтгэл хөдлөл, оюун ухаан, нөхцөл байдал, тохиолдлоороо удирдуулдаг. *Төлөвшсөн хөвгүүд охид нь Сүнсээр удирдуулдаг* гэж Бурхан хэлжээ. Сүнс биднийг хэрхэн хөтөлдөг вэ? (и16) Өөрөөр хэлбэл би аль нэг хот руу явахыг хүстэл дотор нэг л таагүй, аягүй санагддаг.

Лиза: Чи явах ёсгүй газар руугаа явсан тийм тохиолдол байсан уу?

Жон: Байсан.

Лиза: Тэгээд яасан?

Жон: Яахав би “би дахиад хэзээ ч ингэхгүй!” гэж хэлсэн. Жинхэнэ гамшиг болсон л доо. Тиймээс одоо миний дотор ямар нэг “дохио” асбал би явдаггүй.

Заримдаа надтай нэг ийм явдал тохиолддог. Тухайлбал нэг уулзалтад оролцохоор зөвшөөрчихсөн чинь дараа нь Эзэн намайг явуулахыг хүсэхгүй байгаа юм шиг санагдана. Гэтэл би амлчихсан байдаг. Тэр үед би: “Бурхан минь, Та намайг хэлсэн үгээ сахихыг хүсдэг. Тиймээс би энэ уулзалтад очих ёстой. Харин Та намайг хамгаалаач” гэж залбирдаг. Энэ үед Бурхан намайг зэмлэдэггүй. Ийм үед уулзалт маань сүртэй сайхан болдоггүй ч, би Түүний хамгаалалтыг мэдэрдэг.

Гэхдээ эхлээд явах үгүйгээ Бурханаас лавлах нь хамгийн зөв. Үнэхээр гайхамшигтай- та үүнийг хүчтэй мэдэрнэ. Та Бурхантай алхах тусам Түүний Үгт илүү мэдрэг болдог.

Лиза: Чи доктор Ёнги Чогийн гайхамшигт үйлчлэл, Ариун Сүнсээр дүүрсэн тухай гайхалтай түүх өгүүлсэн. Харин би түүний тухай бас нэг зүйл мэдэх юм байна: тэрбээр Ариун Сүнсстэй өнгөрөөх цагаа бусдаас “харамлахдаа” олон зүйлээс “татгалздаг” гэж хэлдэг. Ариун Сүнс бидний амьдралд боломжгүй зүйлсийг үйлдэхийн тулд зарим *боломжийн зүйлст* “үггүй” гэж хэлдэг.

Жон: Үйлс 2-р бүлэгт дагалдагч нар Ариун Сүнсээр дүүрсэн. Гэтэл Үйлс 4:8 дээр Петр “Ариун Сүнсээр дүүрэн” захирагч нарт хандан ярьсан бол, Үйлс 4:31 дээр итгэгч нар “Ариун Сүнсээр дүүрсэн”. Сүнсээр дүүрэх нь ганц удаагийн явдал биш ажээ. Бурхан “Дарсанд бүү согтуур. Ингэвэл дураараа дургих байдалд автагдана. Харин Сүнсээр дүүрэн байж” (Ефес 5:18) хэмээн айлддаг. Бид цоорхой гэсэн үг биш. Зүгээр л Сүнсээр байнга дүүрэх ёстой. Гэрлэсэн хоёр хүн ч гэсэн заримдаа бие биеэ ухаангүй хайрлаж, заримдаа бие биеэсээ хол хөндий болдог учраас дахин дүүрэх хэрэгтэй болдогтой л адил.

Лиза: Үүний төлөө зорих хэрэгтэй?

Жон: Тийм ээ, зорих хэрэгтэй. Тиймээс тасралтгүй дүүрэн бай. Сүнсээр дүүрэн үед энэ нь дуулал, гимн, сүнслэг дуугаар илэрдэг (Ефес 5:18-20). Та өөрийн эрхгүй дуулах болно. Би энэ долоо хоногт маш их дуулж байгаа.

Лиза: Зурагтаа унтрааж байгаад л.

Жон: Тийм, зурагтаа унтраах хэрэгтэй.

Лиза: Таныг хоослодог зүйлсийг хязгаарла.

Лиза: Бүх итгэгч нар сүнсний хэлээр ярьж болох уу эсвэл зөвхөн үйлчлэгч нар л ярьдаг юм уу?

Жон: Итгэгч хүн бүр Сүнсний аль ч бэлэгийг ашиглаж чадна гэдэгт би итгэдэг. Хэрэв хэн нэгэнд аугаа гайхамшиг хэрэгтэй бол, гайхамшиг үйлдэх бэлэг ямар ч итгэгчид ирж болно. Түүнчлэн Бурхан тодорхой хүмүүст тодорхой бэлэг өгдөг бөгөөд тэд явсан газар бүртээ энэ бэлэгээ ашиглаж чадна.

Лиза бид хоёрын таньдаг нэг хүн онцгойлон зүрхний өвчнийг эдгээдэг бэлэгтэй байсан юм. Дэлхийн өнцөг булан бүрээс зүрхний өвчтэй хүмүүс түүнийг зорьж ирээд, эдгээд буцдаг байв. Түүнд өгөгдсөн энэ бэлэг нь гүйцэтгэхээр дуудагдсан үйлчлэлээ биелүүлэхэд нь туслажээ.

Бас миний нэг найзын хүү ваннтай усанд живээд 45 минутын турш үхжээ. Найз маань надад “Жон, би хүүгийнхээ төлөө 30 минут залбирсан боловч, юу ч болоогүй. Сэхээн амьдруулахын эмч нар намайг хараад ой гутсан байх. Гэтэл гэнэт миний зулай дээр ямар нэг зүйл бууж, өөр хүн миний нүдээр харах шиг болоход, би хүүдээ: “Чи үхэхгүй, харин амьдарна” гэж хэлсэн” хэмээн ярьж билээ. Тэгээд хүү нь амилжээ. Найз маань түүн дээр “итгэлийн бэлэг” бууж ирсэн гэдэгт итгэжээ. Тухайн үед түүнд яг энэ бэлэг л хэрэгтэй байж.

Лиза: Тэр үйлчлэгч байгаагүй.

Жон: Тэр цагдаа.

Лиза: Тэр цуглаан удирддаггүй.

Жон: Түүний амьдралын цорын ганц номлол нь тэр явдал байсан юм.

Лиза: Тодруулаач?

Жон: Бүх итгэгч, ямар ч итгэгч Сүнсний бэлэгийг хэрэглэж чадна. Тэгээд заавал итгэлийн бэлэгийг хүлээх шаардлагагүй. Есүс: “Итгэгчдэд энэ тэмдгүүд дагалдана. Миний нэрээр тэд чөтгөрүүдийг зайлуулж, шинэ хэлээр ярина. Тэд могойг барина. Тэд үхүүлэх ямар ч юм уусан, тэр нь тэдэнд хор болохгүй. Өвчтэй хүн дээр тэд гараа тавивал эдгэнэ гэж айлдлаа” хэмээн айлдсан (Марк 16:17-18). Ямар ч итгэгч хүн өвчтэй хүний төлөө залбирахдаа эдгээх бэлэгийг ашиглаж чадна. Бурхан үүнийг тань хүндэтгэнэ. Учир нь Тэр өөрийнхөө үгийг хүндэтгэдэг.

Лиза: Пастор тань таныг индрийн ард гаргатай хүлээх юмуу тийм хүн гарч иртэл хүлээх шаардлагагүй. Зүгээр л өдөр тутмынхаа амьдрал дээр Бурханы хүч, амлалтыг ав. Сүнс таныг хэн нэгэнтэй ярилцуулахыг, хэн нэгэнд хүргэхийг, хэн нэгний төлөө залбируулахыг хүсч байгаа санагдбал өгөөмөр, нээлттэй бай. Энэ чинь гайхалтай зүйл. Бид үүнийг хийж чадна.

Жон: Энэ ч бас нэг бэлэг- өгөх, өгөөмөр бэлэг.

Лиза: Ариун Сүнс Есүсийг илчлэхээр ирсэн. Тэгэхээр бидний сүүлийн хэдэн арван жил харсаар ирсэн чичрэх, хөхрөх, шалан дээр өнхрөх, унах зэрэг нь бас л Есүсийг илчилж буйн шинж үү?

Жон: Тэгэхээр Библи ер бусын тэмдгийн талаар ярьдаг. Гэхдээ тэдгээр нь ахархан хугацаанд л үргэлжилдэг. Ер бусын тэмдэг, гайхамшиг өрнөх үе байх агаад тэдгээр нь хүмүүсийн анхаарлыг Есүс рүү чиглүүлдэг. Гэхдээ миний дургүйцлийг төрүүлдэг зүйл нь хүмүүс Илэрхийлэгч Эзэнд нь бус, илрэлд нь дурладаг явдал юм.

Нэг удаа намайг Сингапурын нэгэн чуулганд үйлчилж байтал тэр цуглаанд эдгээх бэлэгтэй сайн мэдээ дэлгэрүүлэгч ирсэн юм. Түүний бэлэгээр хүмүүс элгээ хөштөл инээдэг байжээ. Тэр өдөр Бурханы оршихуй тэр том цуглаан дээр юу юугүй буух нь гэдгийг би мэдэрсэн юм. Яг тэгтэл хүмүүс хөхрөлдөж эхэлсэн бөгөөд миний сүнсэнд яг л хуруугаа самбарт аваад хаячихсан юм шиг мэдрэмж төрж билээ.

Лиза: Тэгэхээр тэр нь цагаа олоогүй зөв зүйл байжээ.

Жон: Би дотроо “Боль! Та бүх илрэлийг баллачихлаа. Та Бурханы Сүнсийг дагасангүй. Тэр яг одоо ийм зүйлийг хүсэхгүй байна. Сүнс хүмүүсийг Эзэнийг хүндэтгэх гүн эмээн хүндэтгэлээр илбэхийг хүсч байна. Харин одоо хүмүүс Бурханы Сүнс буцаж ирээд үйлчлээсэй хэмээн харуулдсаар л хоцорлоо” гэж хэлсэн юм. Тэгээд би тэднийг дахин залбируулав. Бурханы Сүнс эргэн ирж, байшин доторх бүх хүн мэгшин уйлж эхлэв.

Илрэл нь буруу цагт өрнөсөн нөхцөлд хүмүүс шоу үзүүлж эхэлдэг. Тухайлбал дурлалт хос олны өмнө дотно байдалд ордоггүй. Энэ бүхэн нь яг л Бурханы өгсөн дотнослыг хүмүүст гайхуулж: “Биднийг ямар сүнслэг байгааг хараач!” гэх шиг. Үнэндээ Ариун Сүнсийг таних тусам, дорд үзсэн бус, харин хүндэтгэсэн, эрхэмлэсэн сэтгэлээр улам бүр хайрлан хамгаалахыг хүсдэг. Ариун Сүнсийг гомдоох талаар 1Тесалоник 5:19-21 дээр хэлдэг. Түүний хүч, бэлэгийг дорд үзсэн тохиолдолд Түүнийг дорд үзсэн хэрэг болно. Ийм зүйл бүү хий! Түүнийг хүндэтгэ. Өчүүхэн жаалхан нөлөө юмуу хүч мэт Түүнийг бүү харуул.

Лиза: Бид Ариун Сүнсийг хүссэн бүхнээ хийгээч хэмээн урьдаг. Заримдаа Тэрбээр бидний хувьд таагүй гэмээр үед эсвэл таагүй

гэмээр арга замаар ажилладаг ч, хэзээ ч биднийг албадаггүй, мэхлэдэггүй, залхаадаггүй. Энэ нь хүмүүсийн анхаарлыг бус, Бурханы анхаарлыг татдаг бөгөөд тэнд Түүний уур амьсгал, оршихуй байна.

Лиза: Заримдаа хүн аль нэг зүйлийн талаар амар тайван мэдэрсээр байтал энэ нь Бурханаас биш байж болох уу?

Жон: Мэдээж болно. Езекиел 14-р бүлэгт Бурхан зүрхэндээ шүтээн тахилаа залсаар Түүн дээр ирэх хүмүүсийн тухай өгүүлжээ. Тэгэхээр шүтээн тахил гэж юу вэ? Колоссай 3:5-г үз. Шинэ гэрээнд энэ нь буруу байдлаар ямар нэг зүйлийг хүсэн тачаадах явдал ажээ. Би Бурханы оршихуйд орж, Түүнээс ямар нэг зүйл хүсэхээсээ өмнө зүрхэндээ бэлэн байдал зарлах ёстой. Үүнийг хийгээгүй үе надад олон бий. Зүрх маань бэлэн бус бол Бурханаас ирээгүй амар тайвнаар дүүрч, энэ нь эцэстээ маш их уй зовлон дагуулдаг.

Тиймээс л Лиза бид хоёр болзож байхдаа хоёр өөр хотод байсандаа би талархдаг. Бид цаашид үерхэлээ үргэлжлүүлэх эсэхээ шийдэхээсээ өмнө 30 хоног залбирсан юм. Би Лизад унаж тусталаа дурлаад байсан болохоор энэ дур хүслээ бүхэл бүтэн 25 хоногийн дараа л ялсан юм. Гэхдээ 30 хоногийн дараа Бурхан надад “Үгүй” гэж хэлбэл, би Түүний үгэнд орох хэмжээнд хүрэв. Энэ нь Бурхан надад болоод Лизад илүү дээр хүнийг өгнө гэсэн үг. Зүрх сэтгэлээр “бэлэн” болох тэр үедээ л би үнэхээр Бурханыг сонсдог болсон юм. Би Бурхантай хоёулханаа байхаар явахдаа зүрх сэтгэл минь бэлэн байдалд ороогүйг мэдэрбэл, эхлээд бэлэн болтол нь Бурханы үг ба залбирлаар “ажилладаг”. Би Бурханаас “тийм” “үгүй” гэсэн хариултын алийг нь ч сонсоход бэлэн байх ёстой. Эс бөгөөс худлаа амар тайвантай болно.

Лиза: Ер нь бид дандаа л “бид тэгнэ, ингэнэ, тэгээд тийм болно” гэж тооцолдог ч, эцэстээ аль нь ч бүтдэггүй. Би самбар дээрх бичгээ бүгдийг нь арчаад Бурхан минь, хүссэн зүйлээ л хий гэж хэлэх хэрэгтэй.

Чи Сүнснээс ирдэг мэдлэгийн талаар ярьсан. Би Тордох гэдэг ном уншиж байхдаа зөн совин гэдэг үгийг харсан юм л даа. Энэ нь “доторх сургагч” гэх утгай бүхий “In”, “tueog” гэдэг хоёр Латин үгээс гаралтай юм билээ. Ариун Сүнс бол дотоод сургагч. Тэр бидэнд шинэ зүрх өгч (Езекиел 36:26), бидэнд заадаг.

Лиза: Заримдаа амьдралд бүх зүйл зөв юм шиг атлаа нэг л биш санагдах үе байдаг. Энэ талаар?

Жон: Бүх юм гаднаа зөв харагдах атлаа дотроо буруу санагдах тохиолдол нь голдуу урхи л байдаг. Тэр анхны хариу үйлдэл буюу мэдрэмж нь Бурханы Сүнс л байдаг. Түүнчлэн гэргийнхээ зөвлөгөөг сонсоогүй үед бас яг ийм байдалд ордог.




Би нөхөр, эхнэрүүдэд нэгэн зүйлийг хэлмээр байна. Лиза бид хоёр дөнгөж гэрлэж байхад, би өдөрт цаг хагас залбирдаг байсан, харин Лиза шүршүүрт орж байхдаа 10 минут л залбирдаг байсан.

Лиза: Би чинь бүтэн цагаар ажилладаг байсан шүү дээ!

Жон: Тэгээд би “Лиза, хоёулаа ингэх, тэгэх хэрэгтэй юм шиг байна” гэхэд Лиза “Мэдэхгүй ээ, надад тэгж санагдахгүй байна” гэж хэлээд л ихэнхдээ зөв байж таардаг байсан нь намайг гонсойлгодог байлаа.

Нэг удаа би Бурханд “Бурхан минь, би өглөө хагас цаг, өдөрт нэг цаг залбирдаг, Лиза шүршүүрт 10 минут залбирдаг. Гэтэл тэр ихэнхдээ зөв байж таарах юм” гэж гомдоллосон юм.

Гэтэл Эзэн надад “Тойрог зур” гэж хэлэв. Би нэг цаасан дээр тойрог зурлаа. Бурхан “Одоо тойргоо дүүртэл нь “х” бич” гэлээ. Би зурлаа. Тэр “одоо тэг дундуур нь шугам тат” гэлээ. Би татлаа.



“Тал “х” нь шугамын нэг талд, тал “х” нь шугамын нөгөө талд байгааг харж байна уу? Жон, чи ганц бие байхдаа Миний дотор болон өөрийнхөө дотор бүтэн байсан. Харин одоо чи Лизатай нэг бие болсон тул наад тойрог чинь Лиза та хоёр юм. Чи зүүн хагас нь, Лиза баруун хагас нь. Харин “х” нь юу болохыг чи мэдэх үү? Тэдгээр нь чамд Надаас хэрэгтэй мэдээлэл юм. Мэдээллийнхээ тал хувь дээр сууржилж шийдвэр гаргаад буй чинь л чиний гол асуудал болоод байна. Чи гэргийд чинь Миний өгсөн мэдээллийг олж, бүрэн мэдээлэл дээрээ шийдвэр гаргаж сурах хэрэгтэй.”

Хэдийгээр би сэтгэлийнхээ гүнд Лизагийн үг нь Сүнсний үг гэдгийг (Сүнс юу хийдэг билээ? Тэр гэрчилдэг.) мэдэрсэн ч, түүний саналыг ойшоохгүй өнгөрөх үе байсан.

Заримдаа Лизагийн хэлсэн үгс нь хэдэн жилд нэг удаа биелэх тохиолдол байна. Тэр үед би түүний үг итгэлээр эрчлэгдсэн үгс бус, харин эмэгтэй хүний зовнилоос төрсөн айдсын үг тул би хүлээж авахгүй гэдгээ мэддэг. Гэхдээ ихэнх тохиолдолд Лизаг ярих үед, түүний зөв гэдгийг би сүнсэндээ мэдэрдэг. Энэ үгийг үл тообол би өөрөө л төлөөсийг нь төлнө.

Лиза: Жон чи их “эелдэг загнаж” байна. Гэхдээ Бурханы хэлсэн үгт хүмүүст итгэж болно. Сүнс бидний бодсоноос ч илүү тодорхой ярьдагийг судлаачид хэлдэг. Бид өөрийнхөө бодлоор үсчиж, хоёрдогч зүйлийг таамаглаж эхэлмэгцээ өөртөө эргэлзэх бус, Бурханд эргэлзэж эхэлдэг. Бурхан бидэнд хэлж байхад зүгээр л хийх ёстой.

Би саяхан багийнхантай автобусаар явсан юм. Би автобусанд үнэн голоосоо дургүй л дээ. Бид багийнхаа нэг эмэгтэйг хүлээгээд нисэх онгоцны буудал дээр автобусанд маш удаан суусан юм. Бид түүн рүү зөндөө залгасан боловч, ерөөсөө олохгүй байв.

Тэгж тэгж, тээр тэнд нэг хүн дээшээ доошоо цовхчиж, гараа далдаж байхыг олж үзэв. Би тэр эмэгтэйд аймаар их уур хүрч байсан боловч, түүнийг харсан даруйдаа, хайр хүрсэн юм. Энэ бол зүрх сэтгэлийн холбоо. Хичнээн уур хүрч байсан ч харсан даруйдаа хайрлах сэтгэл төрсөн.

Бурхан бидэнд ийм холбоо харилцаа өгдөг. Уг нь надад түүнийг

хайрлах шалтгаан байхгүй. Гэтэл миний дотор хайр төрсөн. Гэхдээ заримдаа Жон надад “Лиза, надад тэр хүн таалагдахгүй байна” гэдэг. Харин би түүнд “Хонгор минь, чи чинь эрэгтэй хүн шүү дээ. Тиймээс зарим юмыг эмэгтэй хүн шиг мэдэрч чадахгүй ш дээ” гэдэг. Жон надад анхааруулсаар байтал би түүнийг сонсохгүй бол эцэст нь өөрөө л уйлсаар хоцордог.

Жон: Үйлс 15 дээр Паул Барнаб хоёрт нэг асуудал тулгарсан. “Харь үндэстэн Мосегийн хуулийг сахих уу, үгүй юу?” Чуулган тэр хоёрыг элч нар болон ахлагч нартай уулзуулахаар Иерусалим руу илгээв. Паул Барнаб хоёр яагаад дур мэдэн шийдвэр гаргаагүй вэ? Тэд яагаад Иерусалимд очиж, бусадтайгаа хамт шийдэх ёстой байв? Яагаад гэвэл хүч ба чиглүүлэг нь эв нэгдэлтэй хоршдог. Тиймээс л эхнэр нөхөр нэгдэлтэй байхын төлөө бүхнийг хийх хэрэгтэй. Ийм эв нэгдэл нь Бурханаас тодорхой хариулт авахад тусладаг.

Лиза: Сүнсний бэлэг ба үр жимс ямар ялгаатай вэ?

Жон: Сүнсний бэлэг нь Бурхан хүний амьдралд өгдөг зүйл юм. Үүнийг боловсруулж, хөгжүүлэх шаардлагагүй. Энэ нь автоматаар ажилладаг. Хөгжүүлэх ёстой ганц зүйл нь тухайн хүн бэлэг дотроо хэрхэн ажиллах асуудал юм. Харин Сүнсний бэлэгийг хөгжүүлэх хэрэгтэй. Тэгэхээр бэлэг нь өгөгддөг, харин үр жимс нь хөгжин боловсордог.

Сүнсний бэлэг нь Сүнсээр удирдуулсан амьдралын үр жимс юм. Сүнс дотор явахад үр жимс боловсорч, та илүү баяр хөөртэй, амар амгалан, тэвчээртэй, хайртай... хүн болж хувирдаг (Галат 5:22-23-г үзнэ үү). Та Сүнс дотор явж байгаа учраас танаас хайр, баяр хөөр, амар тайван ундарна. Энэ бүхэн нь таны хувийн амьдралд хамаатай. Сүнсний үр жимс таныг үйлчлэлд тань аюулгүй байлгах суурь бол, Сүнсний бэлэг нь үйлчлэлийнхээ амьдралд хандах хандлага юм. Харамсалтай нь олон хүн үр жимсний араас бус, бэлэгийн араас явдаг.

Би нэг удаа “Бурхан минь, Таны надад өгсөн бэлэгийг би хэзээ

ч Та миний дотор хөгжүүлсэн үр жимсээс илүүд үзэхийг хүсэхгүй байна” гэж залбирч билээ. Библи “Та нар хайрыг мөшгөгтүн. Сүнслэг бэлгүүдийг авахыг хүсэж тэмүүл. Ялангуяа эш үзүүлэх бэлгийг хүс” гэж хэлдэг (1Коринт 14:1). Хүмүүс бэлэгийн араас яваад үр жимсээ (хайраа) мартчихдаг.

Бэлэг хүмүүсийг тээгээд явахгүй бөгөөд сүйрэлд хүргэх аюултай. Иудас чөтгөрийг хөөсөн, өвчтэйг эдгээсэн ч, там руу явсан. Матай ном “Хүний Хүү Өөрийнх нь тухай бичигдсэнчлэн явна. Харин Хүний Хүүг бариулах тэр хүн золгүй еэ! Тэр хүн төрөөгүй байсан бол дээр байх байсан гэлээ” гэж хэлсэн (Матай 26:24). Иудаст бэлэг нь байсан. Гэхдээ тэр үр жимсээ хөгжүүлээгүй.

Лиза: Хүчирхэг бэлэгтэй хүмүүс байдаг ч, үр жимс нь өчүүхэн байдаг. Яагаад тэр вэ?

Жон: Балаамыг л хар. Балаамд эш үзүүлэх бэлэг байсан. Түүний эш үзүүлсэн зүйлс нь бүгд Библид байдаг! Тэр Бурханы үгсийг хэлсэн. Гэвч тэрбээр дуулгаваргүй бөгөөд муу ёрын байсан учраас Бурхан түүнийг илдээр хөнөөсөн. Саул хаан галзуур атаархан Давидыг ангуучилж байсан. Гэхдээ тэр ч бас эш үзүүлж байсан (1Самуел 19).

Үнэндээ сүнслэг бэлэг нь заавал ч үгүй Бурханы тааллыг илэрхийлэхгүй. Есүс ч үүнийг хэлсэн: “Тэр өдөр Надад олон хүн “Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгуудыг үзүүлж байсан биш билүү?” гэж хэлэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд “Би та нарыг огт танихгүй юм байна. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ.” (Матай 7:22-23). Эзэн нэг өдөр надад “Эдгээр хүмүүс бид Таны нэрээр ядуусыг хооллосон, хоригдлуудыг эргэсэн гэж хэлэхгүй байгааг чи анзаарсан уу? Учир нь ийм зүйл хийхэд зан чанар, үр жимс хэрэгтэй байдаг юм” хэмээн айлдаж билээ. Сүнсний үр жимсийг хөгжүүлэх нь бүхнийг сайн төгсгөх байр сууринд маань байлгах хамгаалалт юм.

Би үүнийг анх дэлхийд алдартай том чуулганд ажиллаж байхдаа

сурсан юм. Тэр чуулганд олонд танигдсан бас сайн танигдаагүй олон хүн уригдаж үйлчилдэг байлаа. Харин би тэднийг онгоцны буудлаас тосч аваад, манайд байх хугацаанд нь үйлчлэх үүрэгтэй байв. Зарим үйлчлэгч машинд орж ирэхэд яг л Есүс Өөрөө ороод ирчихсэн юм шиг.

Босоод номлох нь яг л Есүс Өөрөө босоод номлох шиг санагдана.

Гэтэл зарим нь орж ирэхэд Энэ чинь юу вэ? Яагаад надад ийм бохир мэдрэмж төрнө вэ? Тэдний яриа яагаад ийм заваан байна? гэж бодогдоно. Тэднийг тайзан дээр гарахад хүмүүс аврагдаж, эдгэрч, гайхамшиг үздэг. Эдгээр нь хуурамч аврал, эдгэрэл биш, Ариун Сүнсний хүч мөнөөс мөн байв. Тэгээд би Бурхан минь, би ойлгохгүй байна. Энэ чинь юу болоод байна? гэхэд Бурхан надад ийн хариулав: “Иудас хаанчлалыг тунхаглаж, чөтгөрийг хөөж, өвчтэйг эдгээж, гайхамшиг үйлдсэн ч, тамд явсан. Балаам эш үзүүлсэн ч, Бурхан түүнийг илдээр хөнөөсөн. Саул эш үзүүлсэн ч, амьдралаа сайн төгсгөөгүй. Хүний амьдралд ажилладаг бэлэг-Бурханы тосолгоо нь яг ч Бурханы тааллыг илэрхийлэхгүй.” Тэднийг үр жимсээр нь танина (Матай 7:16).

Лиза: Тэгэхээр бэлэг бол хүний амьдрал дээр буудаг зүйл, харин үр жимс нь хүмүүсийн амьдрал дотор боловсрон хөгждөг- тэдний дотоод зан чанар мөн үү?

Жон: Тийм ээ, яг зөв.

Лиза: Чи дотоод амар тайвнаар хөтлүүлэх тухай бас Ариун Сүнс хориглох үед төрдөг тайван бус, таагүй мэдрэмжийн тухай ярьсан. Гэхдээ Бурхан өнөөдөр ч ярьдаг гэдэгт эргэлздэг хүмүүс байдаг. Магадгүй Бурхан гагцхүү Бичээсээр л ярьдаг гэж итгэдэг байх л даа. Харин Бурхан өнөөдөр ч ярьдаг гэдэгт чи итгэдэг үү? Мөн Тэр гагцхүү Үгийнхээ дагуу ярьдаг уу?

Жон: Юуны түрүүнд Паул Коринтод “Та нар Эзэнд итгээгүй байхдаа хэлгүй шүтээнүүдэд хөтлөгдөж, төөрөлдсөн байснаа мэдэх

билээ” гэж хэлжээ (1Коринт 12:2). Мунхаг гэдэг нь одоогийнхоор бол “тэнэг” биз дээ? Харин энэ агуулгад мунхаг гэдгийг “хэлгүй” гэсэн утгаар хэрэглэжээ. Өөрөөр хэлбэл Коринтчуудын үйлчилж байсан бурхад нь ярьж чаддаггүй байжээ. Паул “Харин бидний Бурхан ярьдаг” хэмээв. Тэр бүр тодорхой ярьдаг.

Бурхан яаж ярьдаг вэ? Бурхан бидэнтэй ярьдаг олон арга замыг Шинэ гэрээ хэлдэг. Нэн түрүүнд мөнөөх амар тайван мэдрэмж буюу дотоод гэрчлэл юм. Энэ бол Бурханы ярьдаг тэргүүний арга зам.

Лиза: Бүр Үгээрээ ярихаас ч илүүтэй юу?

Жон: Үгүй, Бурханы үг дотоод гэрчтэй үргэлж эгнэдэг. Хэрэв таны дотор амар тайван атал тэр нь Бурханы үгтэй эгнэхгүй байвал үүнийг бүү сонс. Таны зүрхэнд буруу санаа сэдэл байгаа нь тодорхой учраас зүрхээ “бэлэн байдалд” аваачих хэрэгтэй. Үг хэзээд эцсийн шийдвэр юм.

Лиза: Үг бол суурь бөгөөд бүтэц.

Жон: Яг үнэн. Тэгэхээр дотоод гэрч нь номер нэг. Харин номер хоёр нь Библийн ярьдаг мөнөөх намуухан сул дуу хоолой юм. Есүс “Миний хонин сүрэг дууг минь сонсдог. Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг юм” хэмээн айлдсан (Иохан 10:27). Бурханы Сүнс Есүсийн айлдсан зүйлийг өгүүлэх бөгөөд тэр нь мөнөөх намуухан сул дуу хоолой ажээ.

Олон хүн ямар ч дотоод гэрчгүй дуу хоолойг дагадаг учраас яваандаа гинжлэгддэг. Бурханы дуу хоолойг сонсох бүрий дотоод гэрч дагалддаг бөгөөд энэ нь Үгтэй эгнэдэг. Бид энд суурь цутгаж байна: Үг, гэрч, дуу хоолой. Хэрэв таны сонссон дуу хоолойг дотоод гэрч гэрчлэхгүй бол бүү сонс. Заримдаа цуглаан дээр хүмүүс миний дээр эш үзүүлэхэд, би Бурханы оршихуйг мэдрэхгүй бол тэр үгийг нь хүлээж авдаггүй.

Гуравдугаарт- Бурхан бидэнтэй зүүдээр ярьдаг гэсэн. Үйлс 16 дээр Паул зүүдлэсэн тухай гардаг. Паулын зүүдэнд нэг Македони хүн үзэгдээд “Бидэн дээр ирж туслаач” гэжээ. Бурхан зарим

хүнтэй нөгөөгөөс нь арай илүү зүүдээр ярьдаг. Бурхан миний гэргийтэй зүүдэнд нь маш хүчирхэг ярьдаг. Харин надтай бол дотоод гэрч ба намуухан сул дуугаар ярьдаг.

Дөрөвдүгээрт- Бурхан хүмүүстэйгээ үзэгдлээр ярьдаг. Паул ч үзэгдэл үзсэн бөгөөд “Би Христ доторх нэгэн хүнийг мэднэ. Тэр арван дөрвөн жилийн өмнө гурав дахь тэнгэрт аваачигдсан юм. Бие дотроо юу, эсвэл биеийнхээ гадна уу гэдгийг нь би мэдэхгүй, харин Бурхан мэднэ” гэж хэлсэн (2Коринт 12:2). Үзэгдлээр та биеэсээ гарсан үгүйгээ мэдэхгүй ч, сүнслэг ертөнцийг бодитой хардаг. 1989 онд манай пастор Лиза бид хоёрыг үйлчлэлд томилохдоо үзэгдэл үзсэн учраас ингэж байна гэж хэлсэн юм. Тэрбээр ажилчдын хурал дээр ирээд “Би өчигдөр шөнө үзэгдэл үзлээ. Яг л зурагтын дэлгэцээр харж байгаа юм шиг. Та нарын нэг нь цаашид пастор байхаа больж, дэлхий даяар аялан үйлчилж, Христийн биед ерөөл болно. Тэр хүн бол Жон Бивэр чи” гэж хэлсэн юм. Харин яг 8 сарын өмнө Бурхан надад адилхан зүйл хэлсэн тул энэ үг надад баталгаа болов.

Хамгийн сүүлд нь Бурхан бидэнтэй транс байдлаар ярьдаг. Петр үүнийг Үйлс 10-р бүлэгт үзсэн. Транс гэдэг нь мэдэрхүйгүй болсон гэсэн үг. Энэ нь үзэгдлээс өөр. Учир нь үзэгдэлд мэдэрхүй ажилласан хэвээрээ байдаг учраас хүн хөдлөж чадна. Паул Иохан хоёр тэнгэрт гарахдаа хөдлөж чадаж байсан. Харин транс байдалд хүн ямар нэгэн зүйл харж, Бурханы дуу хоолойг сонсох боловч, бүх мэдэрхүй нь ажилладаггүй.

“Тэгвэл хонины ноосоор ярьдаг байсан аргын тухайд?” Хуучин гэрээнд Бурханы хүслийг мэдэхийн тулд энэ аргыг ашиглаж байсан. Та Хуучин гэрээний бүх зүйлийг аваад загалмай дундуур гаргах хэрэгтэй. Загалмай эдгээрийг нэг бол үлдээнэ эсвэл шинэчлэнэ үгүй бол устгана. Би хонины ноосны энэ аргыг аваад загалмай дундуур гаргасан чинь загалмай үүнийг устгачихав. Библи “Учир нь Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм” (Ром 8:14) гэж хэлсэнээс биш, “хонины ноосоор хөтлүүлсэн нь” гэж хэлээгүй. Хуучин гэрээний хүмүүст Бурханы Сүнс байгаагүй учраас Бурхан хонины ноос зэрэг аргаар ярьдаг байжээ. Харин Шинэ гэрээнд ийм зүйл хэрэггүй. Хамгийн

чухал нь Бурханы үг ба дотоод гэрчлэлээр л хөтлөгдөх ёстой. Та Сүнс дотор амьдарч, алхахаар дуудагдсан.

Лиза: Би чиний үг дээр хэдэн зүйл нэммээр байна. Бурханы хариулт ямагт сүнслэг талбарын дагуу байсан. Түүнчлэн бидэнд маш тодорхой үүрэг байдаг: найзад чинь хэрэгцээ гарах үед зүрхээ бүү хаа (1Иохан 3:16-18). Заримдаа тэнгэрээс дуу гарахыг хүлээх хэрэггүй, зүгээр л аливаа хэрэгцээг харах нүдтэй, сонсох чихтэй л байх хэрэгтэй. Хүмүүс манай номыг хуудас хуудсаар нь салгаж, хоорондоо сольж уншиж буй талаар сонсохдоо “Бид яаж зүрхээ хаах билээ? Бид үүнийг нүдээрээ үзээгүй ч гэсэн, сонссон учраас заавал нэг юм хийх ёстой” гэдгээ мэдсэн юм.

Жон: Би хүний наймааны талаар сонсохдоо Бурханд надад хэлээгүй боловч, би Лизад “Хоёулаа ямар нэг зүйл хийх хэрэгтэй!” гэж хэлсэн юм.

Лиза: Энэ тухай бид сонсдог бүр нүдээрээ ч хардаг. Хүмүүс тэнгэрээс л үг, тэмдэг, үзэгдэл, зүүд хүлээдэг байдаг. Гэтэл Библи “Та нар... харбал” гэдэг шүү дээ.

Жон: “Ах дүүд чинь хэрэгцээ гарсаныг харбал.”

Лиза: Бид ах дүүгийнхээ хэрэгцээнээс эхэлнэ. Христигэлийн хэрэгцээнээс эхэлнэ. Бид харж, сонсож, хүрч чадах бодит хүмүүсээс эхлэх бөгөөд тэднээс зүрхээ хааж болохгүй. Бодит талбар дээр харж буй зүйлдээ хариулж чадаж байвал, Бурхан бидэнд илүү их сүнслэг зүйлийг даатгадаг гэдэгт би итгэдэг.

Жоны нэмэлт хариулт

Асуулт: Юу Ариун Сүнсийг доромжилсон явдал болох вэ?

Жон: Матай 12:33-32; Марк 3:22-30 Лук 12:10 дээр Есүс Ариун Сүнсийг доромжлох тухай ярьжээ. Ялангуяа Матай, Марк дээр

маш тодорхой хэлсэн. Шашны удирдагч нар Есүсийг Беелзебубын хүчээр чөтгөрийг хөөдөг гэхэд нь Есүс “Тиймээс Би та нарт хэлье. Хүмүүсийн аливаа нүгэл хийгээд доромжлол нь уучлагдана. Харин Сүнсний эсрэг доромжлол уучлагдахгүй” гэжээ (Матай 12:31). Тиймээс Ариун Сүнсний талаар ёрын муухай зүйлс ярих буюу Ариун Сүнсний илрэлийг муу ёрын сүнсний ажил гэх нь Түүнийг доромжилсон хэрэг аж.

Асуулт: Аав, Хүү хоёрт дуулдаг шигээ Ариун Сүнсэнд залбирч дуулж болох уу?

Жон: Мэдээж болно. Ариун Сүнс Бурхан учраас Бурхан шиг хүндэтгэл хүлээх ёстой. Иохан 4:24 дээр “Бурхан бол сүнс, Түүнд мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр мөргөх ёстой гэж айлдлаа” гэдэг. Тиймээс Ариун Сүнсийг Аав, хүү хоёр шиг л хүндэтгэх ёстой.

Асуулт: Аль залбирал, дуу хүрэхийг нь яаж мэдэх вэ?

Жон: Есүс дагалдагч нартаа ийн айлдсан:

Та нарт хэлэх зүйл Надад олон бий ч та нар одоо тэдгээрийг даахгүй. Харин үнэний Сүнс болох Тэр ирэхдээ та нарыг бүх үнэн уруу удирдана. Учир нь Тэр Өөрийн санаагаар биш харин алив сонссон юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ. Тэр Намайг алдаршуулна. Яагаад гэвэл Тэр Минийхийг авч, түүнийгээ та нарт мэдүүлнэ ... Тун удахгүй та нар Намайг цаашид харахгүй. Мөн дахин тун удахгүй та нар Намайг харна гэж айлдлаа ... Тэр өдөр та нар Надаас юуны ч тухай асуухгүй. Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Миний нэрээр Эцэгээс минь юу ч гуйвал Тэр түүнийг чинь өгнө.
(Иохан 16:12-14,16,23)

Бид Есүсийн нэрээр (эрх мэдлээр) Бурхан Аваас гуйдаг.

Тэгээд бид Ариун Сүнстэй харилцдаг (харилцаж, ярилцаж, асуулт асуудаг).

Асуулт: Ариун Сүнс нэгэн зэрэг газар сайгүй оршдог. Гэтэл цуглаан, уулзалт дээр Түүнийг ирээч хэмээн гуйх нь зөв үү?

Жон: Зөв. Библи Бурханы газар сайгүй оршигч мөн чанарын талаар ч, тодорхой газар айлчилдаг мөн чанарын талаар ч өгүүлдэг. Бурханы газар сайгүй оршигч мөн чанарын тухай Давид өгүүлжээ:

Таны Сүнснээс би хаашаа одож чадах вэ?
 Эсвэл Таны оршихуйгаас би хаашаа зугтаж чадах вэ?
 Хэрэв би тэнгэр өөд очвол, Та тэнд байдаг.
 Хэрэв би Үхэгсдийн оронд ор дэрээ засвал, харагтун,
 Та тэнд байдаг.
 Хэрэв би үүрийн гэгээгээр жигүүрлэн,
 Хэрэв би далайн хамгийн алсын хэсэгт суувал,
 Тэнд ч Таны мутар намайг удирдаж,
 Таны баруун мутар надаас зуурах болно.
 (Дуулал 139:7-10)

Түүнчлэн Бурхан биднийг хэзээ ч хаядаггүй, орхидоггүйг Библи хэлдэг (Еврей 13:5). Энэ бол Түүний нэгэн зэрэг газар сайгүй оршигч мөн чанар.

Нөгөөтэйгүүр Бурхан оршихуйгаа тодорхой нэг газар илчлэн харуулдаг. Илчлэн харуулах гэдэг нь харагддаггүй зүйлийг харагдуулж, сонсогдоогүй зүйлийг сонсуулж, мэдэгдээгүй зүйлийг мэдүүлэхийг хэлнэ. Бурхан бидний мэдэрхүйд Өөрийгөө илэрхийлэх үедээ оршихуйгаа илчлэн харуулдаг. (Иохан 14:19-24)

Асуулт: Бид яагаад Бурханаас Сүнсээ асгахыг гуйдаг вэ? Бурхан хэдийнээ цуггачихсан юм биш үү?

Жон: Зехариа 10:1: “Хаврын борооны үед ЭЗЭНээс бороо гуйгтун.

Аянгат үүлсийг бүтээгч нь ЭЗЭН юм. Тэр хүн бүрд талбайд нь ногоо ба шиврээ бороог тэдэнд өгнө.” Бичээст бороогоор Ариун Сүнсний цутгаланг илэрхийлдэг. Бид Бурханаас Сүнсээ асгахыг гуйх нь нийгэм, хот, улс дээрээ шинэ цутгаланг хүсэхтэй адил гэж би итгэдэг. Энэ бол Түүний оршихуйн үлэмж хүчирхэг илчлэлт бөгөөд биднийг ажиллах хүчээр сэлбэж, Бурханы хаанчлалд улам арвин сүнсний ургацыг авчирдаг.

Асуулт: Ариун Сүнс тэй яаж гүн гүнзгий нөхөрлөх вэ? Түүний оршихуй, хүчийг яаж улам илүү мэдрэх вэ?

Жон: Бурхантай, Түүний үгтэй хамт байснаараа. Бурхантай яаж дотносохыг 2, 3-р бүлэгт дэлгэрэнгүй өгүүлсэн.

Асуулт: Ариун Сүнс бүгдийг мэддэг. Тэгвэл бид Библи унших шаардлагатай гэж үү?

Жон: Бурхан бидэнд “Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай. Энэ нь Бурханы хүн аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм” гэсэн (2Тимот 3:16-17). Ариун Сүнс бидэнд аман үгээ (thema) өгөхийн тулд бичмэл Үгээ (logos) хэрэглэдэг. Сүнс logos-г ёвроход энэ нь бидэнд thema болж ирдэг. Бид Сүнсэнд зүрхээ нээж logos дотор цаг өнгөрөөхгүй бол thema ч бараг ирэхгүй. Та Библиэ унших нь тун чухал. Бурханы Үг, Бурханы Сүнс хоёр түнш шиг хамтран ажилладаг.

Библид Бурханы нууц орших бөгөөд энэ нууцыг Ариун Сүнс бидэнд илчилдэг гэдгийг бүү мартаарай. Хэрэв та Бичээсийг Сүнсний ямар ч нөлөөгүй зүгээр л уншбал та ердөө хүний хэлээр хэлсэн текстийг нь л уншина. Харин Сүнсээр дамжбал та тухайн текстийн сүнслэг угтыг ойлгоно. Учир нь Сүнс дотор бидэнд Христийн оюун санаа байх болно.

... харин нууц дотор буй Бурханы мэргэн ухааныг бид ярьдаг. Энэ нь бидний алдрын төлөө үеүдээс ч өмнө Бурханы урьдаас тогтоосон нуугдмал мэргэн ухаан мөн. Үүнийг энэ үеийн удирдагчдаас хэн нь

ч мэдсэнгүй. Хэрэв тэд үүнийг мэдсэн байсан бол алдрын Эзэнийг цовдлохгүй байх байсан. Гэвч “Нүдэнд үзэгдээгүй, чихэнд сонсогдоогүй, Хүний санаанд ороогүй юмсыг Бурхан Өөрийг нь хайрладаг хүмүүст бэлджээ” гэж бичигдсэн ёсоор болжээ. Гэвч Бурхан үүнийг Сүнсээр бидэнд илчилсэн юм. Учир нь Сүнс бүх зүйлийг, тэр байтугай Бурханы гүн юмсыг ч гэсэн нэвтэлдэг ажгуу. Учир нь хүний дотор буй сүнснээс нь өөр хүний бодол санааг хэн мэддэг вэ? Түүнчлэн Бурханыхыг Бурханы Сүнснээс өөр хэн ч мэддэггүй. Бурханы бидэнд үнэгүй өгсөн юмсыг мэдэхийн тулд бид ертөнцийн сүнсийг бус, харин Бурханаас ирсэн Сүнсийг хүлээн авсан юм. Бид үүнийг хүний мэргэн ухааны сургасан үгсээр бус, харин Сүнсний сургаснаар ярьдаг бөгөөд сүнслэг зүйлсийг сүнслэгээр тайлбарладаг. Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Учир нь тийм хүнд эдгээр нь мунхаг явдал бөгөөд эдгээрийг ойлгож чадахгүй. Яагаад гэвэл эдгээр нь сүнслэгээр үзэгддэг. Харин сүнслэг хүн бүхнийг олж хардаг байхад, түүнийг хэн ч олж хардаггүй. “Учир нь Эзэний оюун ухааныг хэн мэдсэн бэ? Хэн Түүнд заавар өгөх вэ?”. Харин бидэнд Христийн оюун ухаан бий. (1Коринт 2:7-16).

Асуулт: Манай чуулган нэг л хуурай байна. Чуулгандаа Сүнсийг илүү ихээр авчрахын төлөө хувь хүнийхээ хувьд би юу хийж чадах вэ?

Жон: Та Чуулганыхаа удирдагч биш бол, залбирах нь л хамгийн зөв. Нэгдүгээрт- тантай хамт орших Түүний оршихуйг илчлэн харуулахын тулд Сүнснийг амьдралдаа урь. Хоёрдугаарт- удирдагч нар тань Ариун Сүнсний оршихуйд нээлттэй байж, амьдралдаа тээхийн төлөө Бурханаас гуй.

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

- 1 | Итгэгч хүн бүр сүнслэг бэлэгийг ашиглаж чадна. Эдгээр бэлэгээр хөдлөх нь албан ёсны “үйлчлэлийн” заслаас юугаараа ялгаатай вэ?

- 2 | Бурхан танд тодорхой шийдвэр дээр зөвшөөрлөө өгч, амар тайвнаар ерөөхийг мэдрэх үедээ энэ нь чухам Бурханаас гэдгийг яаж мэддэг вэ?

- 3 | Ариун Сүнс тантай ярихын оронд гэр бүлийн тань хүнтэй ярих тохиолдол байсан үү? Бурхан яагаад ийм арга замаар ажилладаг вэ? Ер нь Бурханаас яаж чиглүүлэг авах вэ?

- 4 | Та маш том шийдвэр гаргах хэрэгтэй байдаг. Гэтэл Бурхан чиглүүлэг өгдөггүй. Энэ үед яах вэ?

Сургаалт үгс 11:14; 15:22; 24:6; Ром 8:26-27-г үзнэ үү.

- 5 | Ариун Сүнс өнөөдөр хүмүүстэй ярьдаг гэдгийг та мэдэх үү? Ариун Сүнс тантай ярьдаг үү?

ХАВСРАЛТ

Авралыг хэрхэн хүлээн авах вэ?

Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ.

Ром 10:9-10

Сүнс тантай цаг үргэлж харилцаж, Бурханыг таниулж, Түүний хаанчлалд өсгөж дэвшүүлэхийг хүсдэг. Гэхдээ Бурханы Сүнстэй дотно болохын тулд эхлээд Түүний Хүү Есүс Христээр дамжин аврагдах ёстой.

Есүсийн үхэл амилалаар дамжуулан Бурхан таныг хаанчлалдаа оруулж, хайртай хүү охиноо болгох замыг нээсэн. Загалмай дээрх Есүсийн үхэл нь мөнхийн дүүрэн амьдралыг танд нээж өгсөн юм. Аврал бол бидэнд өгсөн Бурханы бэлэг бөгөөд та үүнийг олж авахын тулд юу ч хийж чадахгүй.

Энэ үнэт бэлэгийг хүлээж авахын тулд эхлээд Бүтээгч Эзэнээсээ тусгаар дур мэдэн амьдарсан нүглээ гэмш (таны үйлдсэн бүх нүглийн үндэс нь энэ юм). Гэмшил нь авралын амин чухал хэсэг. Петр үүнийг 5,000 хүн аврагдсан өдөр тодорхой хэлсэн: (Үйлс 3:19). Хүн бүр нүглийн боол болж төрдөгийг Бичээс тодорхой хэлдэг. Энэ боолчлол нь санаатай дуулгаваргүй авирласан Адамын нүглээс язгууртай юм. Өөртөө болон Сатанд дуулгавартай байхаас танд шинэ амьдрал хайрласан Эзэн Есүс Христэд дуулгавартай байх байдал руу эргэхийг гэмшил гэнэ.

Та Эзэн Есүст эрх мэдлийг өгөх ёстой. Есүсийг “Эзэн” болгоно гэдэг нь амьдралаа (сүнс, сэтгэл, биеэ) болоод танд байгаа бүхнийг

Түүний мэдэлд өгнө гэсэн үг. Тэр таны амьдрал дээр бүрэн эрхтэй болно. Үүнийг хиймэгц Бурхан таныг харанхуйгаас чөлөөлж Хаанчлалынхаа гэрэл ба алдар руу шилжүүлдэг. Та шууд л үхлээс амьдрал руу шилжиж, Түүний хүүхэд болно!

Та Есүсээр дамжин аврагдахыг хүсбэл дараах залбирлыг хэлнэ үү:

Тэнгэрт байдаг Бурхан минь, Би нүгэлтэй хүн учраас Таны зөвт байдлын жишигт хүрэхгүй. Би нүглээсээ болж мөнхийн шийтгэл авах ёстой байсан. Гэхдээ Та намайг ийм байдалд орхиогүйд баярлалаа. Та миний төлөө онгон Мариас мэндэлж, загалмай дээр миний нүглийг үүрч нас барсан, Өөрийнхөө цорын ганц хайртай Хүү Есүс Христийг илгээсэн гэдэгт би итгэж байна. Тэр гурав дахь өдрөө үхлээс амилж, өдгөө Таны баруун гарт Миний Эзэн бөгөөд Аврагч болж заларсан гэдэгт би итгэж байна. Тиймээс энэ өдөр би Танаас тусгаар дур мэдэн амьдарсанаа гэмшиж, амьдралаа Эзэн Есүст бүрэн өргөж байна.

Есүс ээ, би Таныг миний Эзэн бөгөөд Аврагч гэдгийг тунхаглаж байна. Сүнсээрээ амьдралд маань буун ирж, намайг Бурханы хүүхэд болгож өөрчлөөч. Өнөөг хүртэл холбоотой байсан бүх харанхуйн зүйлсийг би тасар татаж, өнөөдрөөс эхлэн би өөрийнхөө төлөө бус, харин нигүүлсэлээрээ намайг мөнхөд амьдруулахын тулд миний төлөө Өөрийгөө өгсөн Таны төлөө амьдарна.

Эзэн минь Тандаа баярлалаа. Миний амьдрал бүрэн эхээрээ Таны мэдэлд. Та намайг хэзээ ч ичгүүрт орохгүй гэж хэлсэн.

Бурханы гэр бүлд тавтай морилно уу! Энэ баярт мэдээгээ бусад итгэгч нартай хуваалц. Түүнчлэн Библид итгэдэг нутгийн чуулганд явж, таны шинэ итгэлийг урамшуулах хүмүүстэй холбогдоорой. Дөнгөж сая та Хамгийн Дээд Бурхантай тогтоох дотно харилцаагаа эхлүүллээ. Та хоёрын нөхөрлөл өдөр бүр өсч хөгжих болтугай!

Та Жон, Лиза хоёрын өөр сургаал номлолоос
сурмаар байна уу?

Та болон таны найз нөхөд гадаад хэлээр
материал судламаар байна уу?

Та Бурханыг илүү их
таньж мэдмээр байна уу?

Тэгвэл 40 гаруй орны хэл дээр буй
материал, видеог



CloudLibrary.org

хаягаас үнэгүй татаж, сурах боломжтой!

Та болон таны найз нөхөд, удирдагч нар,
сүм чуулган энд буй материалыг татаж
ашиглаарай.

Дэлгэрэнгүйг
CloudLibrary.org
хаягаас!



САТАНЫ УРХИ

Дайсны үхлийн урхиаас булт! Энэ бол итгэгч хүмүүсийг Бурханы хүслээс төөрүүлэгч Сатаны хамгийн том заль мэхийг илчилсэн ном. Ихэнх хүмүүс Сатаны урхинд орчихсоноо ч мэддэггүй. Тиймээс бүү мэхлэгд! Та ийм урхитай заавал тааралдана. Гэхдээ таны шийдвэрээс л Бурхан та хоёрын ирээдүйн харилцаа хэрхэх нь шийдэгдэнэ. Ирээдүй чинь таны үйлдлээс л шалтгаална. Зөв алхам хийвэл та дордох бус, улам л гялалзана.

Тус номоос та дараах асуултад хариулт олно:

- Тухайн үйл явдлын талаар би яагаад „өөрийнхөө хувилбарыг” хэлэх ёстой вэ?
- Бусдад үл итгэсэн, хардаж сэрдсэн бодолтой хэрхэн тэмцэх вэ?
- Өнгөрсөн үеийн шархаа яаж „тордохоо” болих вэ?
- Хүнд шархадсаныхаа дараа яаж дахиж хүмүүст итгэж сурах вэ?

Энэ ном таныг дайсны „хавхнаас” зайлж, Бурхантай ямар ч саадгүй, эрх чөлөөтэй харилцаатай аж төрөхөд тань туслана.



МЯТРАШГҮЙ

Хүч чадал бол таны хувь тавилан! „Мятрашгүй” номоос та ялагч хүн хүнд бэрхэд хэрхэн ханддагийг мэдэж, танд нүүрлэх зовлон сорилыг даван туулахыг сурна.

- Христийн дотор танд баталгаажуулсан амлалт, хүч чадлаас атга.
- Асуудлынхаа эх үүсвэрийг олж мэд.
- Сүнслэг жолоогоо ялагч хүн шиг л атга.

Дэлгэрэнгүй эх сурвалж:

www.CloudLibrary.org



Want more?
Scan here

ТА ТҮҮНИЙ ТУХАЙ МЭДНЭ - ГЭХДЭЭ ТҮҮНИЙГ ҮНЭХЭЭР МЭДЭХ ҮҮ?

Дагалдагч нар гурван жил Есүстэй хамт алхаж, аж төрж, үгийг нь сонссон. Харин Есүс тэдэнд Тэрбээр удахгүй явж, оронд нь Ариун Сүнс ирэх бөгөөд энэ нь тэдэнд ашигтай хэмээн айлдсан (Иохан 16:7; 13-14). Есүс өдөр бүр хамт байж, Өөрийн гараар сургасан дагалдагч нарт Ариун Сүнс хэрэгтэй байсан юм бол, бидний аж амьдрал Ариун Сүнсний хүчирхэг ажилгүйгээр юу болох вэ?

Харамсалтай нь бид Түүнийг хэн болох, Өөрийгөө бидэнд яаж илчилдэг талаар ихэвчлэн буруу хазгай ойлголт тээж, голдуу нэг тийм „бүрхэг этгээд” шиг л төсөөлдөг. Гэтэл Сүнс юм биш, харин таныг хэзээ ч орхихгүй *Нэгэн* гэдгийг Библи маш тодорхой хэлжээ. Энэ интерактив номд Жон Бивэр таныг Чуулган дотор хамгийн их үл ойлгогдож, үл ойшоогддог Нэгэн болох Ариун Сүнсстэй дотносон танилцах аянд урьж байна.

Түүнтэй танилцах гайхамшигт үйл явдлаас бүү хоцроорой.

Тус интерактив номд дараах зүйлс багтсан болно:

- Өдөр тутмын чимээгүй цаг
- Бүлгийн асуулт хариулт, ярилцлага
- Ариун Сүнсний талаарх хамгийн бэрх асуултад хариулсан нэмэлт бүлэг



ЖОН ба ЛИЗА БИВЭР (гэргий) - Бурханы үнэнч зарц бөгөөд Messenger International байгуулмагь үндэслэн байгуулагч. Тэрбээр үнэний хувирашгүй үгийг эрмэг зоригтой тунхагладаг бөгөөд түүний бичсэн ном байнга шилдэг борлуулалттай номоор шалгардаг юм. Жон номлол, номоороо дэлхий даяарх нутгийн чуулган, удирдагч нарыг дэмжих чин сэтгэлтэй. Өдгөө түүний ном, сурах бичиг жар гаруй хэл дээр хөрвүүлэгджээ. Харин гэртээ бол Жон гэргийтэйгээ гольф тоглож, 4 хүү, бэр, ач нартайгаа цаг өнгөрөөх дуртай.

Дэлгэрэнгүй эх сурвалж: www.CloudLibrary.org

Messenger
International
MessengerInternational.org

Энэ ном бол номын зохиогчоос Монгол чуулганд бэлэглэж буй бэлэг бөгөөд худалдахыг хориглоно.

